

Д.Эрдэнэсан, М.Базаррагчаа, А.Цог-Очир,
Д.Наранцэцэг, Д.Оюун

МОНГОЛ ХЭЛ XII

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн
12 дугаар ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын
Яамны зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2019 он

НАА 74.2
ДАА 373
М-692

Монгол хэл XII: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 12 дугаар ангийн сурах бичиг. (Эрдэнэсан Д., ба бус; Ред. Шинэбаяр О., Тех.ред. Хүрэлтогоо М. УБ. 2018. -148х)

ТАНИХ ТЭМДЭГ



Дасгал 1



Бүтээлч даалгавар



Үгсийн тайлбар



Өөрийгөө сорьё



Тайлбар, тодорхойлолт

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал хүсэлтийг textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99978-61-89-4

БИД 12 ДУГААР АНГИДАА ЮУ СУДЛАХ ВЭ?

Бүлэг сэдэв	Нэгж хичээл	Эзэмших чадвар	Суурилах эх, хэрэглэгдэхүүн
	МЭДЛЭГ, ЧАДВАРАА БАТАТГАХ	Мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо баримтад тулгуурлан илэрхийлэх	Эргэцүүлсэн эсээ
I. ӨГҮҮЛБЭР	ӨГҮҮЛБЭРИЙГ "ГЭ-", "ХЭМЭЭ-" ХОЛБОХ ҮГЭЭР ХОЛБОН НАЙРУУЛАХ	<ul style="list-style-type: none"> • “Гэ” холбох үг бүхий өгүүлбэрийг тайлбарлах • Өгүүлбэрийг гишүүн, гишүүн өгүүлбэр, “гэ” холбох үгтэй өгүүлбэр, хэлц зэргээр дэлгэрүүлэн найруулах 	Нийлмэл өгүүлбэр
	ХЭЛЦ ӨГҮҮЛБЭРИЙН ГОЛ БА ҮҮДЭЛ САНАА	<ul style="list-style-type: none"> • Хэлц ба хэлц бус өгүүлбэрийг ялган таних • Хэлцийн үүдэл ба гол санааг тайлбарлах • Хэлц бус өгүүлбэрийг хэлц үгээр солин найруулах • Ойролцоо ба эсрэг санаат хэлцийг эх, өгүүлбэрт сонгон найруулах 	Хэлц өгүүлбэр
II. НИЙТЛЭЛ	НИЙТЛЭЛ УНШИХ	<ul style="list-style-type: none"> • Нийтлэл дэх зохиогчийн мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодол, үнэлэмжийг уран дүрслэлийн талаас задлан шинжилж тайлбарлах • Нийтлэлийг уншиж, бүтэц, агуулга, утга хэлбэрийн уялдаа холбоог хам сэдвийн хүрээнд тайлбарлах • Уран нийтлэлийг сэдвээр нь ангилах • Уран нийтлэлийн онцлогийг тодорхойлох • Уран нийтлэл эсээнээс ялгаатай болохыг тайлбарлах 	Уран нийтлэл
	НИЙТЛЭЛ БИЧИХ	<ul style="list-style-type: none"> • Уншигч, зорилго, нөхцөл байдалд тохируулан бүтэц, хэв маягийг сонгон бичих 	
III. ЯТГАСАН ЭСЭЭ	ЯТГАСАН ЭСЭЭ УНШИХ	<ul style="list-style-type: none"> • Эхийг уншиж, ярилцах • Итгүүлэн үнэмшүүлэх аргад суралцах • Эхийн бүтэц, агуулгыг задлан тайлбарлах • Үзэл бодлоо илэрхийлэх 	<ul style="list-style-type: none"> • Эсээ • Нийтлэл
	ЯТГАСАН ЭСЭЭ БИЧИХ	<ul style="list-style-type: none"> • Асуудал дэвшүүлж, итгүүлэн үнэмшүүлж бичих • Дүрслэл ашиглаж, итгүүлэн үнэмшүүлж бичих • Баримт нотолгоо, эшлэл зүүлт ашиглан, итгүүлэн үнэмшүүлж бичих 	
IV. ИЛТГЭЛ	ЯРИХ, СОНСОХ	<ul style="list-style-type: none"> • Илтгэлийн бүтэцтэй танилцах • Илтгэлийг задлан тайлбарлах • Илтгэл бичих 	Уран илтгэл



МЭДЛЭГ,
ЧАДВАРАА
БАТАТГАХ

МЭДРЭМЖ, СЭТГЭГДЭЛ, ҮЗЭЛ БОДЛОО
БАРИМТАД ТУЛГУУРЛАН ИЛЭРХИЙЛЭХ

- Мэдрэмж, сэтгэгдэл
- Баримт нотолгоо
- Үзэл бодол

МЭДЛЭГ, ЧАДВАРАА БАТАТГАХ

Мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо баримтад
тулгуурлан илэрхийлэх



Дасгал 1

Эргэцүүлсэн эсээг уншиж, задлан шинжлээрэй.

Аавын минь нэр

...Амьдралын минь зам мөрийг заасан аав минь!

“Аавын минь нэр

Адуу шиг сайхан...” гэж нэгэн яруу найрагч жигтэйхэн сайхан онож бичсэн.

...Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, авьяас билигт яруу найрагч Дан.Нямаа “Аавын нэр” эсээ таталбартаа:... Аавын минь алдрыг асуухлаар нь нэрийг нь хэллээ. Мөнөөх хүн “Аа, чи чинь Данзангийн банди юм биз дээ” гээд танимхайрч байна. Анх удаагаа би гурван дугуйтад сууж үзэх нь энэ дээ. Аяа! Аавын минь нэр. Алдрай багад минь намайг ийн унаатай залгуулсныг дурснам. Эдүгээ би энэ нэрийг дээдлэн авч явахын учрыг тунгаан бодлогоширном. Хүүгийн нэр бүрэн бүтэн бол аавын алдар бүтэн буюу” гэж гайхалтай онож хэлсэн байдаг.

Би дөрөвдүгээр ангийн сурагч байхдаа ааваа дагаж, мод хийх цагаалах ажилд анх явж билээ. Таван сайхан ат *хомнож* хөтлөөд л, *сум сунган* алхуулсаар Жаргалант сумын нутаг- “Эмгэнт” хэмээх нэгэн сайхан модот ууланд очив. Бараг хоёр өдөрчийн газар бурантаг сунган явсан тэмээд маань ч ойн захын өвдөг тулсан өвс рүү орчихлоо. Аав өнөө “*Гоожин*” гээч юмаа ойн цагдаад өгч, бид ажилдаа орлоо. Хоёр бүтэн өдөр ноцолдон байж таван тэмээ модоо бэлтгэн, цагаалж, ойн захад гаргах, тэмээн тэнд тохируулан хэрчих, тайрах,...гээд зарим нь сонирхолтой ч зарим нь над шиг бага ангийн бандид ахадсан ажил болдог юм байна.

Зарим мод уулын уруу хар эрчээр буугаад, талийж өгнө, зарим нь бууж өнхөрч өгөхгүй, бүдүүн талынхаа бөгсөөр эргэж шарваад л, хоргодоо морь шиг, ургаа модонд очиж цохиж хөндөлсөөд л, хүчрэгдэхгүй “зөрүүдлээд л”, хачин сүрхий байлаа.

Аав, юм л бол “Хөшүүрэг! Хөшүүрэг!, уртхан шиг хөшүүрэг!” гэнэ. “Хөшүүрэг” хэмээх нэг сайн нөхөртэй хамжиж хамтарсаар байгаад л, модоо зэхээд авлаа даа, хөөрхий.

Гурав дахь өдрийн өглөөн нарнаар ачаалах ажил эхэллээ. Би гэдэг амьтан талаа даахгүй, бойтоглоно, аав миний талын модыг өргөж гаргаад л, доогуур нь тайрдас шургуулж, эсвэл нөгөө “хөшүүрэг” хэмээх “модон хүн”-ээр түшүүлж орхиод, надаар өргүүлнэ, өөрийн талыг өргөж гаргана....

Тэнцээ татлага сурны үзүүр хүрэхтэй үгүйтэй зайд л нэг муу өргөхчөө болно. Аав: “Үзүүр хүрвэл уяа хүрдэг юм” яльгүй өргө л гэнэ. Нээрээ л үзүүр хүрэнгүүт л аав эв хавыг нь олоод л уяад, бөхлөөд, тэгшлээд хаячихна. Тэг тэгсээр байж, таван тэмээ модтой, намрын мөнгөн хяруунаар буцаж байж билээ. Одоо бодоход “Ар давж хүлэг болдог, ажил хийж хүн болдог” гэдгийг аав минь бодож, надаар “хүн хийж” явсан байх. Буцахдаа бурантаг хөтөлсөн аав хүү хоёр бодолд автан, их л сэтгэл өөг явж билээ. Энэ сонин ажил, тэр олон бодролоос надад хожмоо хоёр зүйл гойд тодхон үлджээ.

Нэгд, “Хөшүүрэг” гэдэг “модон хүн”-ий учир, эрдэм чадал. Дунд сургуульд

ороод, физикийн хичээл дээр “хөшүүргийн хууль”-ийн тухай багшийг заахад тэртээ ууланд үзсэн нөгөө “хөшүүрэг”-ийн ач тус, аавын зааж эчнээгээр сургасан “ажил ба хөшүүрэг” гэдэг зүйл санаанд ороод л байж билээ. Аавын минь ухаан айхавтар холч байсан. Үнэндээ, мод хийх ажилд аав бид хоёр биш, **Аав, Би, Хөшүүрэг** найз гурвуул явж, мод чулууны хатуу хөтүү ажлыг нугалсан байдаг юм.

Аавын минь нэртэй хамт
 Ажлын арга амтагдана
 Аавын минь ачтай хамт
 Амьдралын хөшүүрэг бодогдоно.

Хоёрт, одоо бодоод явахад “Үзүүр хүрвэл уяа хүрдэг” гэдэг хэлцийг ааваас минь өөр хүн бараг хэлсэнгүй. Өдий хүртлээ би энэ хэлцийг толь бичгээс олж харсангүй. Аавын хэлсэн энэ хэлц үгэнд маш гүн утга оршиж байна. “Болно, болно, болохгүй юм гэж байхгүй” гэх утга, “Эв эеийг эелдүүлэн бүтээх” санаа, “Алив юмыг хийхэд арга, билгийг хослуулах”, “Аливаа юмыг аргаар эдлэх” монгол ухаан гээд л...

Аав минь их зөөлөн хүн байсан. Юмыг дандаа болох талаас нь харна, өнгөрөөж чадна, хаттай, их тэвчээртэй хүн байсан даа.

Заг-Байдрагийн голынхон манай аавын хатуужил тэвчээрийг гайхдаг байсан. Аав минь юмыг жижиг гэхгүй, аргыг нь олохдоо гарамгай, “эрдэм”-тэй байж. Нэгэн дууны шүлэгт:

Аавын минь мөртэй шороонд

Есөн эрдэнэ үелээстэй... гэж байдаг. Энэ сайхан үг. Эх орноо эцэг эхтэйгээ хайрлахад ухаан нэмдэг. Гэхдээ бидний монголчууд өдөр шөнөгүй “нуугдсан эрдэнэ” хайгаад байх шиг санагддаг, харин эсрэг ухахуйяа,

Аавын минь үг сургаалд

Есөн эрдэм шингээстэй байдгийг бид төдий л эргэцүүлж боддоггүй, хожим ухаарч байх шиг. Наад захын жишээ бол “Үзүүр хүрвэл уяа хүрдэг” гэдэг хэлцийн чинад утга санаа нь намайг үг, өгүүлбэрийн үзүүр нийтгэн зангидаж, утгын найруулгаар оролдоход минь ухааруулж сэнхрүүлж өгсөн юм даа. Ингээд бодохлоор:

Эцгийн минь үг сургаалд

Эелдэн найруулах, эв эеийг хичээхүйн ухаан байсаан. Б.Пүрэв-Очир

Асуулт, даалгавар	Хариулт
Эхийн эхлэл, төгсгөлийн цогцолборын утга, үүргийг тодорхойлоорой.
Гол хэсэгтээ өгүүлэгч нь ямар баримтыг чухалчилж, ямар дүгнэлт гарган, сэтгэл хөдлөлөө хэрхэн илэрхийлснийг тайлбарлаарай.
Цогцолборуудын гол санааг агуулсан хөтөч өгүүлбэрийг тодруулна уу.
“Эцгийн минь үг сургаалд Эелдэн найруулах, эв эеийг хичээхүйн ухаан байсан.” гэсэн дүгнэлтийг баримтаар нотлон тайлбарлана уу.
“Мод цагаалах, чинад утга, бойтоглоно, гурван дугуйт, гоожин, хоргодоо морь шиг” гэсэн үг хэллэг ямар утгатай байна вэ?
“Монгол ухаан” гэж юуг хэлж байна вэ?
Ямар эшлэл, баримтыг яагаад хэрэглэсэн байна вэ?

Ааруул

Тавгийн ёроолд үлдсэн ааруулаас нэг хурууд авч, амандаа хүлхлээ. Тагалцагтаа тулсан шүдтэй би байтугай хөрөө, цүүцнээс дутахааргүй араа соёотой идэр хүдэр эр ч элтлэх нь хол, хад чулуу шиг хатуу хурууд таарчээ. Монголын халцгай түлцгэй халуун нар, хавсарга шороо, хайруу хөрүү жаварт хатаж гүйцсэн ааруул аа гэж!

Даагдах янзгүй болохоор нь дэмий л нэг хүлхэж, нэг долоож, дээр доороос нь мэрж шүлтстэж суугаад аягатай цайндаа хийчихлээ.

Хаврын зэвэргэн хавсарга салхи дээвэр дэлдэхийг чагнаж, галдаа аргал нэмж, тонон дээрээс дарах бүргэр тэнгэрийг ширтэлхийлэн хэсэг суугаад, цайгаа уухаар авлаа... **Аагтай бор цайнаас ааруулын үнэр ханхална...** Амаа ангалзуулж, ходоодоо холхогнуулаагүй ч, аягатай цайнд ааруул хөдлөх нь сэтгэлд өөг, бараа нь хүртэл нүд өллөнө. Зөвхөн үнэр нь л бор цайг минь сүлж, бодлын дэмээр гэдэс цатгах шиг..

Хаврын зэвэргэн салхи дээвэр дэлдэхийг чагнаж, ааруулын үнэртэй бор цайгаа оочилж, тонон дээрээс дарах бүргэр тэнгэрийг ширтэлхийлэн санааширч, хэсэг зуурыг эс анзаарчээ.

Аягаа хөнтрөхөд ам руу нэг зөөлөн юм айргийн тос шиг гулсахыг мэдэрлээ!...

Өнөө хурууд! Санаандгүй хазаж үзлээ.

Тагалцаг болсон ч тавтай (шүдний) би хэмхчээд зажилчих байтугай улаан буйлаараа эмчих эмгэн буурай ч элтэлж эмтлээд идчихээр үйрэнгэ зөөлөн бөгөөд аман дотор хэлний үзүүрээр умбарч улбараад байхаар дэвтчихжээ, хөөрхий!

Юун өнөө хад чулуу шиг хатуутай манатай. Хад чулуу сан бол юунд ингэж дэвтэх вэ, их л сайндаа норно биз, хална биз.

Гэтэл энэ хурууд!...

Монголын халцгай түлцгэй халуун нар, хавсарга шороо, хайруу хөрүү жаварт хатаж гүйцсэн дэлхийн хишиг, дэлэнгийн шим, хүний сэтгэлийн үр болохоор ийм амархан дэвтэж, ийм түргэн зөөлшиж, өлдсөн улдсан хүний аманд өл тэжээл болох гэж яардаг юм байх даа!

Хаврын зэвэргэн салхи дээвэр дэлдэхийг чагнаж, тонон дээрээс дарах бүргэр бүүдгэр тэнгэрээ ширтэлхийлж, аагтай бор цайгаа оочин, бодлогошронгоо хуруудынхаа дэвтмэгийг амтархан зажиллаа.


Юун өнөө чихэр, чавга! Чихэр чавга, алим жимс ч гэлээ ийм сайхан зөөлөнхөн, ийм их өл шимтэй нь хаа билээ!

Бууралхан нутгийн минь хөрсний хишиг, буянт малын дэлэнгийн шим, хүндээ амьсах хүний сэтгэлийн үр болохоор л ийн цагийн уртад, цас нарны ээлжид хатахын чанадаар хатавч өлдсөн улдсанд өгөөж өл болох хатан чанараа эс алддаг увдистай юм байх даа, хөөрхий.

Хан тэнгэрийн халцгай түлцгэй халуун нар, хавсарга шороо, хайруу хөрүү жаварт хатахын цаагуур хатаж ханасан ч монгол хүний сэтгэл нэвчсэн “Монгол гар”-ын ааруул хурууд аа гэж!..

Д.Урианхай

а. Эхийг уншаад, дараах асуултад хариулт хэлнэ үү.



б. Ааруулын “хатан чанар”-ыг тоочин бичээрэй.

в. Монгол хүн, идээ цагаа, ааруул хуруудаа эрхэмлэж байгаа нь

- ямар бүтээвэр
- ямар үг
- ямар өгүүлбэр
- ямар цогцолбороор тод илэрч байна вэ?

г. Ялган онцолсон гурван өгүүлбэрийн бүтцийг тодорхойлно уу.

д. Дараах цогцолборуудыг ажиглаж, харьцуулаад, ойролцоо ба эсрэг утгатай бүтээвэр, үг, өгүүлбэрийг ялгаж, өгүүлэгчийн мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодол хэрхэн өөрчлөгдсөнийг тайлбарлаарай.

Тагалцагтаа тулсан шүдтэй би байтугай хөрөө, цүүцнээс дутахааргүй араа соёотой идэр хүдэр эр ч элтлэх нь хол, хад чулуу шиг хатуу хурууд таарчээ.

Тагалцаг болсон ч тавтай (шүдний) би хэмхчээд зажилчих байтугай улаан буйлаараа эмчих эмгэн буурай ч элтэлж эмтлээд идчихээр үйрэнгэ зөөлөн бөгөөд аман дотор хэлний үзүүрээр умбарч улбараад байхаар дэвтчихжээ, хөөрхий!

“Монголын халцгай түлцгэй халуун нар, хавсарга шороо, хайруу хөрүү жаварт хатаж гүйцсэн ааруул аа гэж!

Хан тэнгэрийн халцгай түлцгэй халуун нар, хавсарга шороо, хайруу хөрүү жаварт хатахын цаагуур хатаж ханасан ч монгол хүний сэтгэл нэвчсэн “Монгол гар”-ын ааруул хурууд аа гэж!

Юун өнөө хад чулуу шиг хатуутай манатай. Хад чулуу сан бол юунд ингэж дэвтэх вэ, их л сайндаа норно биз, хална биз.

Юун өнөө чихэр, чавга!
 Чихэр чавга, алим жимс ч гэлээ ийм сайхан зөөлөнхөн, ийм их өл шимтэй нь хаа билээ!

Хаврын зэвэргэн хавсарга салхи дээвэр дэлдэхийг чагнаж, галдаа аргал нэмж, тоонон дээрээс дарах бүргэр тэнгэрийг ширтэлхийлэн хэсэг суугаад, цайгаа уухаар авлаа.

.....

Хаврын зэвэргэн салхи дээвэр дэлдэхийг чагнаж, ааруулын үнэртэй бор цайгаа оочилж, тоонон дээрээс дарах бүргэр тэнгэрийг ширтэлхийлэн санааширч, хэсэг зуурыг эс анзаарчээ.

.....

Хаврын зэвэргэн салхи дээвэр дэлдэхийг чагнаж, тоонон дээрээс дарах бүргэр бүүдгэр тэнгэрээ ширтэлхийлж, аагтай бор цайгаа оочин, бодлогошронгоо хуруудынхаа дэвтмэгийг амтархан зажиллаа.

.....

...дэлхийн хишиг, дэлэнгийн шим, хүний сэтгэлийн үр болохоор ийм амархан дэвтэж, ийм түргэн зөөлшиж, өлдсөн улдсан хүний аманд өл тэжээл болох гэж яардаг юм байх даа.!?

.....

Бууралхан нутгийн минь хөрсний хишиг, буянт малын дэлэнгийн шим, хүндээ амьсах хүний сэтгэлийн үр болохоор л ийн цагийн уртад, цас нарны ээлжид хатахын чанадаар хатавч өлдсөн улдсанд өгөөж өл болох хатан чанараа эс алддаг увдистай юм байх даа, хөөрхий.

е. Харьяалахын тийн ялгалын нөхцөлтэй бүлэг үгийг ажиглаад, ямар утга илтгэж байгаагаар нь бүлэглэн ангилаарай.

1. тавгийн ёроол
2. хаврын хавсарга
3. ааруулын үнэр
4. айргийн тос
5. хэлний үзүүр
6. дэлхийн хишиг
7. дэлэнгийн шим
8. хүний сэтгэл
9. хуруудын дэвтмэг
10. хөрсний шим
11. малын дэлэн
12. монгол гарын ааруул

- а. эзний утга
- б. орны утга
- в. бүхэл хэсгийн утга
- г. цагийн утга
- д. зориулалтын утга
- е. үүслийн утга
- ё. чанарын утга



Эсээ гэж үзэхийн учир юу вэ? Эсээ нь хувь хүний мэдлэг, чадвар, хандлагын илэрхийлэл болно.

- **Мэдлэг:** Эсээнээс тухайн хүний мэдлэг, уншсан хүрээ, танин мэдэхүйн түвшин зэрэг нь харагддаг ба эсээний хамгийн гол шалгуур нь эсээнээс мэдлэг “ханхалж” байх ёстой гэж үздэг. Тухайлбал, Л.Түдэв гуайн бичсэн эсээнд гүнзгий мэдлэг шингэсэн байдаг.
- **Чадвар:** Бичигч сэдвийн хүрээнд шинжлэн судлах, ажиглан эргэцүүлэх, задлан тайлбарлах, нэгтгэн дүгнэх, харьцуулан дүгнэх, жиших зэрэг оюуны үйлийг хэрхэн хийж байгааг харах боломжтой.
- **Хандлага:** Эсээ бол зохиогчийн үзэл бодлын илэрхийлэл юм. Эсээ нь хүн өөрийн бодол санааг чөлөөтэй илэрхийлэх, түүндээ тулгуурлаад “би” гэдэг дотоод ертөнцөө нээх боломжтой учраас бидэнд илүү ойр дөхөм байдаг. Эсээнээс та хэн бэ, та юунд зорьдог, тэмүүлдэг, ямар үзэл бодолтой, тухайн асуудлыг аль өнцгөөс яаж харж байна, үзэл бодол, үнэлэмж хандлага, үнэт зүйл, эрхэм чанар нь юу байна вэ? гэдгийг харах боломжтой. **Эсээ бол БИ ӨӨРӨӨ юм.**



Дасгал 3

Аян замын тэмдэглэлийн хэсгээс уншиж, мэдлэгээ бататгаарай.

Хунгийн чуулга

...Олон жилийн өмнөхөн цэл залуухан, эвлэлийн ажилтан байхдаа сансрын нисэгч Ж.Гүррагчаа гуайд газарчлан Дарьгангынхаа Шилийн хөх уулсаар хөндлөн гулд дамнан дамжиж “цахилан цахилсаар” хамгийн сүүлд Ганга нуурандаа ирэхэд хадган цэнхэр нуур тэр аяараа л цагаан далай болсон байхтай анх удаа тааралдаж, гайхан биширч, үлгэрт бус үнэнд итгэсэн удаатай.

Зайрмагтсан нуур алдаг оног мөстөж, ус мөсөн мандал уран зургийнх шиг бидэртэнэ. Цав цагаан хунгийн суга час улаан болчихсон тэртээ холоос элин халин мөсөн дээр буухдаа халтирч гулсаад, ус руугаа пал хийтэл унахад нэгтээгээс өөр нэгэн хун ирээд түшээд босгочхов уу даа гэмээр аяглах. Өдөр өдрөөр тэлэн хором хормоор зузаарч буй мөсөн дээгүүр хээнцэрлэн алхах нь тун ч хянамгай. Хамгийн гол нь намар оройн Гангад өглөө, оройдoo хунгийн ганганаа уянга түрэн эгшиглэх нь газар тэнгэрийн савслага дахь найрал хөгжим мэт байдаг. *Ай. Төмөр-Очир*

Ганга нуурын эмгэнэл

...Энэ намар Ганга нууртаа эрхлэн хөвж, эрэг даган нисэлдэх хунгийн чуулганаа Монголчууд харж чадахгүй болжээ.

Ганга гэдэг нь ширгэшгүй ундран оргилдог, үүрд мөнх гэсэн утгатай үг аж. Харамсалтай нь үүрд ширгэшгүй оргилж байхын бэлгэдэл, мөнөөх мянган цагаан хун чуулан бүжиж байдаг нуур маань нүдний өмнө ширгэж, армаг тармаг хэсэг бусаг хатсан сайр болчихож. Ийм харамсмаар, халагламаар дүр зургийг үзээд, хэлэхийн аргагүй сэтгэл хөндүүрлэв. Уяхан зарим нь уйлж, ууртай нэг нь буруутныг

зүхэж, Ганга нуур, хун сүргийнхээ өмнөөс гашуудлаа. Арга ч үгүй биз. Ганга нуурт минь очсон хүн өнжмөөр, өнжсөн хүн өвөлжмөөр үнэхээр байгаль эхийн шидэт бүтээл байсан юм шүү дээ. Э.Мөнхзаяа



- а. Дээрх хоёр цогцолбор аян замын тэмдэглэлийн ямар ямар шинжийг агуулсныг тайлбарлаарай.
- б. Аян замын тэмдэглэлээс бодит байдал, мэдрэмж, сэтгэгдэл илэрхийлсэн үг, өгүүлбэрийг олж бичээрэй.

Эх	Бодит хэрэг явдал	Мэдрэмж, сэтгэгдэл
Хунгийн чуулга		
Ганга нуурын эмгэнэл		

- в. Зохиогчийн хандлагыг илэрхийлсэн үг хэллэгийг ялган бичиж, ямар үүрэгтэй байгааг тайлбарлаарай.
- г. Хоёр цогцолбор юугаараа ижил, юугаараа ялгаатай байгааг харьцуулан, дүгнэж бичээрэй.
- д. Санаагаа илэрхийлэхэд уран дүрслэл ямар үүрэгтэй байгааг тайлбарлаарай.

дамнан дамжиж “цахилан цахилсаар”
хадган цэнхэр нуур
цагаан далай болсон байх
...ус мөсөн мандал уран зургийнх шиг бидэртэх
...түшээд босгочхов уу даа гэмээр аяглах
хээнцэрлэн алхах
хунгийн ганганаа уянга түрэн эгшиглэх
газар тэнгэрийн савслага дахь найрал хөгжим мэт
эрхлэн хөвөх хун
мянган цагаан хун чуулан бүжих


сэтгэл хөндүүрлэх
байгаль эх
байгаль эхийн шидэт бүтээл
очсон хүн өнжмөөр, өнжсөн хүн өвөлжмөөр

е. Ганга нуурын урьдын болон өнөөгийн дүр зургаас төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ уран сайхнаар илэрхийлж бичээрэй.

- Цав цагаан хунгийн суга ув улаан болсон байгаа нь.....
- Нуурын ус цэнхэртэн хун шувууд мандлыг бүрхэн байгаа нь.....
- Хун шувуу нуурын мөсөн дээр хээнцэрлэн алхах нь.....
- Намрын орой хунгийн ганганаа тасрахгүй байх нь.....
- Хунгийн чуулганаа харахгүй болсон нь.....
- Нуур ширгэж, армаг тармаг хэсэг бусаг хатсан сайр болчихсон байгаа нь.....
- Сэтгэл хөндүүрлэн, гашуудаж байгаа нь.....

ё. “Хунгийн чуулга”, “Ганга нуурын эмгэнэл” гэж нэрлэсний учир юу вэ?


ж. Ганга нуурын тухай баримтаас бахархсан, харууссан өнгө аясад тохирох баримтыг сонгон авч, дэлгэрүүлж бичээрэй. Баримтаар баяжуулах нь ямар ач холбогдолтой вэ?



дуу


Хүслийн цэнхэр мэлмийд нь шувууд зэллэж хоргодсон
 Хүний сэтгэл гэгэлзсэн хайрын хээтэй мандал
 Ганга нуурын хөвөөнөөс дуу нэгийг сонсох сон
 Ганцхан удаа боловч ертөнцийг түүнээс харах сан

Д.Оюундэлгэр “Ганга нуур”



домог

Эрт цагт энэ нутгаас нэгэн лам бадарчлан явсаар Энэтхэг оронд хүрч, тэнд олон жил сууж, ном эрдэм сураад, нутаг буцахдаа Ганга мөрний рашаанаас бумбанд хийж ирж, Молцог элсний хаяанд булсан юм гэнэ. Тэр газрыг хожим нь Бумбат гэж нэрлэх болжээ. Уг бумбаны рашаан сүүлд дэлбэрэн гарснаас одоогийн Гангын цагаан нуур буй болсон гэдэг. Ийнхүү Ганга мөрний рашаанаас хөрөнгө авч үүссэн учир эл нуурыг Ганга нуур гэж нэрлэсэн түүхтэй ажээ.



судалгаа

Манай дэлхийд нүүрлээд байгаа байгаль экологийн хувьсал болох дулаарал, хуурайшил, элсний нүүдэл Дарьганга нутагт хүчтэй нөлөөлсөн, мөн хүний буруу үйл ажиллагааны улмаас нуурын ус татран багасаж, ширгэж болзошгүй аюулын харанга дэлдээд байна.



уриалга

- Гадаад дотоодын жуулчид, сайн дураараа мод тарьж, буян үйлдэх
- Хуралдсан замгийг цэвэрлэхэд туслах
- Нуурыг хамгаалах хөдөлгөөн, сайн дурын идэвхтнүүдийг бий болгох
- Нуурыг хамгаалах 10 жилийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх
- Баримтат кино хийж, ном хэвлүүлэх
- Ази дахь байгаль орчны чухал бүсийн хамгаалалтыг сайжруулах олон улсын гэрээнд нэгдэх
- Ганга нуур орчмын бургас, эмийн ургамал, ашигт ургамлуудыг мөчрөөр болон үрээр үржүүлэх
- Сан бий болгох
- “Ганга нуурын чуулган” хөтөлбөрт нэгдэхийг элэг нэгт монгол ахан дүүстээ уриалж байна.

Г.Мэнд-Ооёо



Дасгал 4

а. Нийлмэл өгүүлбэр дэх өгүүлбэрийн заагийг тогтоож, ямар хэрэглүүрээр холбогдож, ямар өгүүлбэр бүтсэнийг тайлбарлаарай.

1. Зайрмагтсан нуур алдаг оног мөстөж, ус мөсөн мандал уран зургийнх шиг бидэртэнэ.
2. Өдөр өдрөөр тэлэн хором хормоор зузаарч буй мөсөн дээгүүр хээнцэрлэн алхах нь тун ч хянамгай.
3. Ийм харамсмаар, халагламаар дүр зургийг үзээд, хэлэхийн аргагүй сэтгэл хөндүүрлэв.
4. Уяхан зарим нь уйлж, ууртай нэг нь буруутныг зүхэж, Ганга нуур, хун сүргийнхээ өмнөөс гашуудлаа.
5. Ганга нуурт минь очсон хүн өнжмөөр, өнжсөн хүн өвөлжмөөр үнэхээр байгаль эхийн шидэт бүтээл байсан юм шүү дээ.
- б. Эхэдэнгийн ба нийлмэл өгүүлбэрийн аль нь олон байна вэ? Учрыг тайлбарлаарай.
- в. Дээрх өгүүлбэрүүдээс нэгийг сонгон янз бүрээр хувиргаж, аль нь эхийн найруулгад оновчтой байхыг тайлбарлаарай. Жишээ нь:

“Ийм харамсмаар, халагламаар дүр зургийг үзээд, хэлэхийн аргагүй сэтгэл хөндүүрлэв” гэсэн өгүүлбэрийг хураах, дэлгэрүүлэх, тонгоргох, салаалах зэргээр хувиргавал:

1. Ийм дүр зургийг үзээд харамсан халаглаж, сэтгэл ихэд хөндүүрлэв.
 2. Харамсаж халагламаар дүр зураг сэтгэл өвтгөв.
 3. Сэтгэл хөндүүрлэм дүр зургийг үзээд харамсан халаглав.
 4. Ийм дүр зураг үзээд хэлэхийн аргагүй сэтгэл хөндүүрлэв.
 5. Ийм дүр зургийг үзээд харамсан халаглаж, сэтгэл хөндүүрлэснийг хэлэхийн аргагүй.
- г. Өгүүлбэрийн холбоосыг солиход утга, бүтцэд ямар өөрчлөлт гарч байна вэ?

Зайрмагтсан нуур алдаг оног мөстөж, ус мөсөн мандал уран зургийнх шиг бидэртэнэ.

Зайрмагтсан нуур алдаг оног
 Нуур зайрмагт+н, алдаг оног

мөст+өөд
 мөстөх+д
 мөстөх+өөр
 мөст+х үед
 мөст+ж

ус мөсөн мандал нь
 уран зургийнх шиг
 бидэртэнэ



ӨГҮҮЛБЭР

ӨГҮҮЛБЭРИЙГ “ГЭ-”, “ХЭМЭЭ-” ХОЛБОХ ҮГЭЭР ХОЛБОН НАЙРУУЛАХ

- "Гэ" холбох үг бүхий өгүүлбэрийг тайлбарлая
- Өгүүлбэрийг гишүүн, гишүүн өгүүлбэр, "гэ" холбох үгтэй өгүүлбэр, хэлц зэргээр дэлгэрүүлэн найруулья

ХЭЛЦ ӨГҮҮЛБЭРИЙН ГОЛ БА ҮҮДЭЛ САНАА

- Хэлц ба хэлц бус өгүүлбэрийг ялган танья
- Хэлцийн үүдэл ба гол санааг тайлбарлая
- Хэлц бус өгүүлбэрийг хэлц үгээр солин найруулья
- Ойролцоо ба эсрэг санаат хэлцийг эх, өгүүлбэрт сонгон найруулья

ӨГҮҮЛБЭРИЙГ “ГЭ-”, “ХЭМЭЭ-” ХОЛБОХ ҮГЭЭР ХОЛБОН НАЙРУУЛАХ

Өгүүлэгч бодол санаагаа илэрхийлэхдээ, юуны өмнө, өгүүлбэрийг төрөл бүрийн холбох хэрэглүүрээр холбон найруулдаг. Иймээс нийлмэл өгүүлбэр нь найруулгад чухал үүрэгтэй байдаг. Тухайлбал:

Холбож хэлэх үгтэй аж л, чи
 Хошоолж хэлэх цээжтэй аж л, чи
 Үгтэй бол өч.
 Хошоотой бол холбо.
(Чандага сэцэний үг)

хэмээсний доторх “үг” гэгч нь үнэн хэрэгтээ “**өгүүлбэр**” юм.

Өгүүлбэрүүд нь нөхцөл юмуу хэл зүйн утгатай үгээр холбогдож, янз бүрийн нөхцөлөөр төгсдөг боловч утга санаагаараа холбоотой байдаг. Жишээ нь:

а. Өсөх бага наснаас
 Өөрийн улсад зүтгэв.
 Өнчин надад эх болсон
 Өршөөлт засаг минь танина уу.

б. Хар бага наснаас
 Хайрт улсаа гэв.
 Ганц надад хань болсон
 Хайртай засаг минь харна уу.

дөрвөн төгс өгүүлбэр нь хос хосоороо (а, б) ойролцоо санаатай тул нэг төгс санааг илтгэж байна.

Өгүүлбэрүүд нь утга агуулгаараа ойролцоо ба эсрэг, төсөөт ба зүйлчилсэн санаатай байдаг бол хэлбэр бүтцээрээ энгийн ба нийлмэл гэж ялгардаг. Ийнхүү өгүүлбэрийн агуулга, хэлбэр хоёр нь түүнийг найруулах үндэс суурь болдог. Жишээлбэл:

а. Харагч үнээ тугаллана **гэтэл**
 Цагаан хурга гарна.
 Цагаан хонь хургална **гэтэл**
 Улаан тугал гарна. *(Гутал тайлах)*

Хоёр төгс өгүүлбэрийг “ГЭ-” язгуур бүхий “гэтэл” хэмээх холбох үгээр холбосон тул энэ нь оруулбар өгүүлбэртэй нийлмэл өгүүлбэр болно. Зүйлчилсэн өгүүлбэрийг ижил хэлбэрээр хашин зохиожээ.

б. Хүсэх мөрөөдөл хязгаарлашгүй
 Хүлээст гяндан завсаргүй
 Хүний эрмэлзэл хэмжээлшгүй
 Хүслэнгийн үйл нээлт үгүй *(Д.Н.)*

1 ба 3, 2 ба 4-р өгүүлбэр нь ойролцоо санаатай өгүүлбэр болно.

- в. - Ямар юм муухай вэ? гэвэл
- Үл мэдэгч муухай гэв (Д.Р.)

гэсэн асуун хариулсан өгүүлбэрийг “гэвэл” (“гэж асуувал” гэсэн үйл үгийг хурааж хэмнэсэн) гэсэн болзох утга бүхий үйл үгээр холбожээ.

- г. Бодовч бодын шийр дөрвөөс хэтрэхгүй **гэгчээр** Итгэлтээс гуйхаас өөр арга олдсонгүй.

гэхэд хэлц өгүүлбэр (Бодовч бодын шийр дөрвөөс хэтрэхгүй)-ийн санааг дараагийн өгүүлбэрийн санаатай буюу уг үйл явдалтай адилтган тодотгож, “гэгчээр” хэмээх үгээр холбосон байна.

- д. Төмөрөөс үргэсэн сүрэг зээр дээр дээр үсрэн давхиж зугтсанаа гэнэт эргэж, **алсаас ирсэн энэ хүнийг таних гэсэн юм шиг** баахан харж зогссоноо налайн идэшлэлээ. (Ч.Л.)

гэхэд ерийн өгүүлбэрийн санааг уг үйл явдалтай адилтган, “гэ-” холбох үгээр (гэсэн юм шиг) холбон найруулсан байна.

- е. Төмөр нүдээ тас анин, аажим бөгөөд **жил гаруй ширлүүлж эвхчихсэн биеэ нэг мөсөн тэнийлгэх гэсэн юм шиг** суниагаад, түрүүлгээ харан хэвтэж, суунагласан манангийн дунд нүүгэлтэж байгаа Тайширын нурууг ширтэв. (Ч.Л.)

Дүрслэг өгүүлбэрийн санааг уг үйл явдалтай адилтган “гэ-” холбох үгээр (гэсэн юм шиг) холбон найруулсан байна. Өөрөөр хэлбэл, тогтвортой хэлц өгүүлбэрийг тогтворгүй, чөлөөт, ерийн өгүүлбэртэй холбон найруулахад “гэ-”, “хэмээ-” гэсэн холбох үг чухал үүрэгтэй байна.

- ё. “**Нохой хоры!**” **хэмээн** дуудахад айлын хүмүүс цугаар унтсан тул нэлээд удсаны хойно гэрийн дотроос “**Хэн бэ?**” **хэмээн** хашхирав. (Д.Н.)

гэхэд нөгөө этгээдийн хэлсэн үг (өгүүлбэр)-ийг “хэмээ-” гэсэн үгээр шууд дамжуулж илтгэсэн байна.



Дасгал 5

“гэ-”, “хэмээ-” холбох үгээр гол өгүүлбэрт холбосон гишүүн өгүүлбэрийг ялгаж бичээд, “гэ-” холбох үг нь хэл зүйн ямар утга, үүрэгтэй байгааг дараах байдлаар тайлбарлаарай. Үүнд:

- а. Хэлц өгүүлбэрийн санааг уг үйл явдалтай адилтган холбосон;
- б. Ерийн өгүүлбэрийн санааг уг үйл явдалтай адилтган холбосон;
- в. Дүрслэг өгүүлбэрийн санааг уг үйл явдалтай адилтган холбосон;
- г. Өгүүлэгчийн хэлсэн үг буюу хөндлөнгийн үг (өгүүлбэр)-ийг шууд ба шууд бусаар дамжуулж илтгэсэн;
 - 1. “Явсан хүн яс зууна” гэгчээр Хүрэл, Дорж хоёроос Данзан бие хөлсөө авсан бөгөөд авчирсан зүйлсээ Хүрэлийн тусламжтайгаар борлуулсан ажээ. (Д.На.)
 - 2. Дээш харахад үдшийн гялаан орой дээр орчин тойрныхоо олон оддоос онцгой гэгээ гэрэлтэйгээр нүдэнд тусах нь өнөөх үзэсгэлэнт эмэгтэй түргэн уулзаж танилцах гэж яаруулаад байх шиг санагдана. (Д.На.)
 - 3. Юу ч болсон, зөөлөн ус дуслан дусалсаар хатуу чулууг нүхэлдэг гэгчийн үлгэрээр дахин давтан санал хүсэлт оруулаад байвал яадаг бол? (Б.Р.)
 - 4. Гүвээний цаад руу ороход сэтгэл хэдий тайвширсан боловч уушги зүрх нь мөн амаар гарах гэж байгаа юм шиг оволзсоор байлаа.
 - 5. “Зааныг хаяж заан болдог” гэгчээр харин их юм болох юм биш үү гэж Итгэлтийн хэлснийг Далай ойлгосонгүй бололтой “Тийм ээ, тийм ээ” гэж бөхөлзөв. (Ч.Л.)
 - 6. Нуруугаараа газар унасан Бадарч “Хи... э” гэж битүү дуугарахад нь Дулмаа наадамд очоод ирж яваа эхээ харсан хүүхэд шиг дэвхцэн, тас тас инээж, шилбүүрийн бөгсөөр газар балбаж байснаа гүйн ирж, Эрдэнийн магнайнаас гарч байгаа цусыг арчин, толгойнхоо алчуураар боов. (Ч.Л.)
 - 7. Эмээ минь “Эвий минь хүн болох гэж яваа нялх амьтан. Хүүгээ хүн болохыг нь үзээд үхэхэд гомдох юм алга” гээд намайг үнсэн, өхөөрдөн, эрхлүүлдэг байсан тэр цагт энэ явдал болсон санагдана. (Ж.М)
 - 8. Ээ дээ, говьд айлын зарц болж төрснөөс хангайд бух болж төрсөн нь дээр юм шив дээ гэж хэлж билээ. (Б.Р.)



Холбох “гэ-”, “хэмээ-” үгийн өмнө орсон төгс өгүүлбэр нь утгаараа шууд тусагдахуун гишүүн өгүүлбэр болно. Учир нь энэхүү “гэ-”, “хэмээ-” үйл үг нь тусах үйл үг болно. Жишээ нь:

- а). “Дорлиг [түүнийг хуучин бууны хугархай] гэж хэлэв” гэхэд холбох “гэ-”-ийн өмнөх оруулбар өгүүлбэр нь тусагдахуун гишүүн өгүүлбэр болно.
- б). “Тэнгэр над үрийн хутаг эс заяасан тул намайг хадан гэрт гарахад энэ муу нохой, юуны өмнө, **миний хошуу засгийн хэргэм залгамжлах гэж** гүйх юм байна шүү” (Б.Р.) гэхэд холбох “гэ-” нь өмнөх “залгамжлах” гэдэг үгтэй нийлж, зорих утга илтгэж буй тул бие даасан тусах утгаа гээсэн байна.



Дасгал 6

“гэ-”, “хэмээ-” гэсэн холбох үг нь “хэл-, өгүүл-, ярь-, бод-, сана-, мэд-” гэх мэт тусах үйл үгийн утгаар орсон, эсвэл зорилго, болзол, тодосгогч, шалтгааны зэрэг өөр ямар утгаар үгс ба өгүүлбэрийг холбож байгааг тайлбарлаж бичээрэй.

1. Эртний үг **гэлээ**, “Өргүй бол баян, өвчингүй бол жаргал” гэж үнэн биш үү.
2. Идэр насан **гэгч нь** мандарваа цэцгийн адил. (Д.Н.)
3. Зуд болбол олон дээр, дайн болбол улс дээр **гэгчээр** улс гүрнээрээ тэгж чармайж зүтгэж байхад биеэ оторлож суух шиг адгийн юм байхгүй **гэдгийг** би тэгэхэд ойлгосон. (С.Э.)
4. -Яах юу байх вэ? Эд нар чинь барьж идчих **гээд** зүгээр суулгахгүй юм. Миний мал турчихсан **гэх юм**. Чи яагаад эр хонины минь хөлийг доголгочхоо вэ **гэх юм**... гэж өвгөн өгүүлэл тавьсаар явав. (Л.Т.)
5. ... Харъя **гэвэл** нүд муу
Хазъя **гэвэл** шүдгүй
Хамар **гэвэл** харанхуй нүх. (Д.Н.)
6. Докторт очив, дотоод гадаад эрхтэн бүгдийг үзэв
Дотрын өвчин гэмгүй гэмгүй, долоо хоног дотор эрүүл болно **гэв**.
7. Би чамайг **гэнэ**, чи намайг **гэнэ**.
Бид хоёр ертөнц дээр ангир шувууны адил явнам. (Д.Н.)
8. Эрхэм ном бүхнийг сэтгэл **гэж** эс оновол
Эндүүрлийн үндэс язгуурыг таслах нь бэрх. (Д.Р.)
9. Татах **гээд** түлхэгдэх
Чичлэх **гээд** алдах
Хэрсүүлэх **гээд** гэнэдэх
Энэ хэдэн үгсийг ерд хичээ. (Д.Р.)



Дасгал 7

“гэ-”, “хэмээ-” гэдгийг үйлийн нөхцөлөөр хувилгаж, үндэсний бичгээр бичээд, найруулгад бичлэгийн, үүргийн ялгаатай байгаа эсэхийг тайлбарлаарай.

Үйлийн нөхцөлдүүлэн холбох нөхцөл:	Цагаар тодотгон холбох нөхцөл:
гэж (хэмээж), гээд (хэмээгээд), гэн (хэмээн), гэсээр (хэмээсээр), гэмэгц (хэмээмэгц), гэтэл (хэмээтэл), гэвч (хэмээвч), гэвэл (хэмээвэл), гэвээс (хэмээвээс), гэхүл (хэмээхүл), гэхлээр (хэмээхлээр), гэнгээ (хэмээнгээ), гэнгүүт (хэмээнгүүт), гэлгүй (хэмээлгүй), гэшгүй (хэмээшгүй)	гэх (хэмээх), гэхүй (хэмээхүй), гэхүйеэ (хэмээхүйеэ), гэмээр (хэмээмээр), гэхүйц (хэмээхүйц), гэдэг (хэмээдэг), гэсэн (хэмээсэн), гэгч (хэмээгч)
Биеэр төгсгөх нөхцөл:	Цагаар төгсгөх нөхцөл:
гэе (хэмээе), гэсүгэй (хэмээсүгэй), гэгтүн (хэмээгтүн), гэтүгэй (хэмээтүгэй), гээсэй (хэмээгээсэй), гээрэй (хэмээгээрэй), гэг (хэмээг), гээч, (хэмээгээч), гэвүүзэй (хэмээгүүзэй)	гэнэ (хэмээнэ), гэнэм (хэмээнэм), гэмүй (хэмээмүй), гэв (хэмээв), гэжээ [гэжүхү], (хэмээжээ) [хэмээжүхү], гэлээ (хэмээлээ)
Хэвийн дагавар:	Байдлын дагавар:
гэлц (хэмээлц), хэмээлд, гэгд (хэмээгд)	гэчих (хэмээчих), гээнэ (хэмэээнэ), гэсхий (хэмээсхий), гэцгээ (хэмээцгээ)


Дасгал 8

Хэлц нийлмэл өгүүлбэрийг кирилл үсгээр сийрүүлэн бичээд, төгс өгүүлэхүүнүүдийн холбогдсон арга хэлбэр, утгын холбоо харьцааг тайлбарлаарай.

- | | | | | | |
|--|--|--|--|--|--|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠭᠤᠨ
ᠲᠠᠮᠤᠮᠤ ᠮᠤᠮᠤᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ
ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠲᠠᠮᠤᠮᠤ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ
ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ | ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ
ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ | ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ «ᠭᠡᠭᠡ»
ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ «ᠭᠡᠭᠡ» | ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ
ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ | ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ
ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ | ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ
ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ ᠬᠡᠭᠦᠨᠢᠨ |


“гэ-”, “хэмээ-” холбох үг нь төгс өгүүлбэрийг дараагийн гол өгүүлбэрт янз бүрийн хэлбэр, утгаар холбох үүрэгтэй. Жишээ нь:

Өгнө гэхэд өрвөс хийнэ, авна гэхэд арвас хийнэ гэсэн хэлц нийлмэл өгүүлбэр нь аялгаар буюу тэг холбоосоор холбогдсоны зэрэгцээ **“өгнө”, “авна”** гэсэн өгүүлбэрийг **“өрвөс хийнэ”, “арвас хийнэ”** гэсэн өгүүлбэрт **“гэхэд”** гэсэн холбох үгээр холбосон байна. Гэхдээ энэхүү холбоос (**“гэхэд”**) нь шалтгааны утга илтгэж байна. **“гэ-”, “хэмээ-”** холбох үгээр хоёр төгс өгүүлбэрийг холбодог учраас ийм өгүүлбэрийг жинхэнэ нийлмэл өгүүлбэр гэдэг. Үүнийг нийлмэл өгүүлбэр бүтээх бусад хэрэглүүртэй харьцуулбал:



Нэг өгүүлбэрийг нөгөө өгүүлбэрт **“гэ-”, “хэмээ-”** холбох үгээр холбон оруулахдаа хувиргах, эс хувиргах хоёр янз байдаг. Үүнийг шууд ба шууд бус хөндлөнгийн үг гэдэг. Жишээ нь:

Намайг ирээрэй гэж багш хэллээ. гэхэд **“Чи ирээрэй”** гэсэн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүнийг заахын тийн ялгалын нөхцөлөөр хэлбэржүүлж хувиргасан байна. **“Чи ирээрэй” гэж багш хэлсэн** гэвэл өгүүлэгдэхүүн нь нэрлэхийн тийн ялгалын нөхцөлөөр хэлбэржиж, уг оруулбар өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн хувирсангүй.



Ер нь хөндлөнгийн
 этгээдийн хэлсэн
 оруулбар өгүүлбэрийг
 гол өгүүлбэрт багтааж
 оруулах гурван хэв маяг
 байна. Үүнд:

Соль нулимсаа арайхан тогтоож
 хэлсэн нь: “Чи мэнд сайн яваад
 ирээрэй. Би чиний хэлсэн ёсоор гэрээ
 цагаан болгож, малаа олон болгоод
 сууж байя. Бас үрээ том болгоод байя”
 (Ц.Д.) гэхэд мэдээллийг онцл он чухалчлах
 зорилгоор гол өгүүлбэрийг эхэнд өгүүлж,
 харин оруулбар өгүүлбэрийг “гэж”
 холбоосгүйгээр эцэст хэлсэн байна.

Өвөлдөө малыг
 сайн усалж
 байгаарай гэж
 малчин Товуудай
 хэлэв.
 Бат гэрийн гадаа
 ирээд, “Нохой
 хорь” гэж чанга
 дуудав. гэхэд
 хөндлөнгийн үгийг
 “гэ-”, “хэмээ-”
 холбох үгээр
 холбосон байна.

Энэ нь сонгодог бичгийн хэлнээс
 уламжлалтай найруулах ёс юм. Дээрх
 өгүүлбэрийг Соль нулимсаа арайхан
 тогтоож, “Чи мэнд сайн яваад ирээрэй. Би
 чиний хэлсэн ёсоор гэрээ цагаан болгож,
 малаа олон болгоод сууж байя. Бас үрээ
 том болгоод байя” гэж хэлэв. хэмээн
 хувиргаж болно.

Цэргүүд “Энэ балархай зураг дээр цагаан хар нь
 төдий л тодорхойгүй байна” гэж инээлдэв. (Ц.Д.);
 “Сайн малчин Хишиг гэдэг нь нутагтаа алдартай хүн
 байна шүү” гэж Батын санаанд оров. (Ц.Д.); Тэр хүү
 “Гэрт манай ээж байна” гэв. “Нэгэн дусал янагийн
 нулимс мянган лангийн үнэтэй” гэдэг хуучны үгийн
 үнэн болохыг ойлгов. (Ц.Д.) гэхэд “хэлэх, өгүүлэх,
 ярих...” зэрэг тусах үйл үгийг нь хурааж “гэ-” холбох
 үгээр холбон найруулсан байна.

Зүй нь “Цэргүүд...гэж (хэлээд) инээлдэв; ...гэ (сэн бодол) Батын санаанд оров;
 ...Тэр хүү ... гэж (хэлэв); ...гэж (сургадаг+хэлдэг) хуучны үг... гэсэн найруулга
 болно. Ингэж үйл үгийг хураасан тохиолдолд “гэ-”, “хэмээ-” холбох үг нь
 төлөөний үгийн үүрэгтэй болсон байдаг.



Хэлц холбоо үг, хэлц өгүүлбэрийг хэлэх санаа, болсон үйл явдалтай адилтган өгүүлэхдээ **“гэ-, хэмээ-, гэх шиг, мэт”** зэргээр холбодог.

Өөрөөр хэлбэл, ерийн өгүүлбэрийн санааг хэлц нэгжийн далд утгаар дэлгэрүүлж, үйл явдалтай адилтгах замаар хэлэх санааг улам лавтган тодруулахад **“гэгчээр, гэгчийн үлгэрээр, гэж”** гэсэн үгээр холбодог. Энэхүү “гэ” холбох үг нь *“хэл-, ярь-, өгүүл-, хүүрнэ-, хөөр-, бувтна-, гөрд-, гүтгэ-”* гэх мэт үйл үгсийг өөртөө багтаах тул эдгээр үгийг хэлэхүйд хураан хэмнэж, “гэв, гэсэн, гэдэг, гэжээ, гэхэд” зэргээр хэлэх нь нэн түгээмэл болно. Жишээ нь: *“Тийм тийм” гэв.* гэхэд “хэл-, өгүүл-” гэсэн холбох үгийг хурааж хэлсэн байна. Зүй нь “Тийм тийм” гэж хэлэв (гэж өгүүлэв) гэсэн найруулга болно.



Дасгал 9

Д.Нацагдоржийн “Адуу манаад” өгүүллэгийн хэсгээс холбоосгүй шууд хөндлөнгийн оруулбар өгүүлбэрийг олж, **“гэ-”, “хэмээ-”** холбох үгээр гол өгүүлбэрт холбон найруулах, мөн шууд бус хөндлөнгийн өгүүлбэр болгох зэргээр хувирган бичээрэй. Хэлбэр, утгын ямар ялгаа байгааг ярилцаарай.

...Цогт хүү уяан дээрээ очиж, мориноосоо бугаад, эцгийн ойр очмогц эцэг нь:
 -За, хүү, адуугаа сайн манав уу?

Хүү: Сайн маналаа. Та энэ өглөө юунд ийм эрт босов?

Эцэг: Авын мэдээ ирээд, би чинь чамайг хүлээн хүлээн байна. Бушуу орж цайгаа уу! гэмэгц хүүгийн нүд нь сэргэж, бахтай сэтгэл төрөн, эцгийн хамт гэртээ орвол эх нь цайгаа буцалгаад, самран сүлж байна. Эцэг зүүн хойно, хүү баруун талд тус тус сууцгаасны хойно, хүү:

-Авлах гэнэ ээ, юутай сайн бэ? Хэзээ болох вэ?

Эцэг: -Өчигдөр орой ахмадынхаас Даян гуай ирж, одоо зургаа хоноод, арван таванд авлахаар хэлэлцэж явав...



Бусдын үг яриа ном бүтээлээс авсан эшлэлийг **“гэ-, хэмээ-”** холбох үгээр холбон, шууд тусагдахуун гишүүн өгүүлбэр бүтээх нь түгээмэл бий.

Жишээ нь:

“Нойроо бэхлэх үгүй хүн манаа битгий мана. Эвээ чадахгүй бол яарч битгий ханил” гэж “Сэтгэлийг амраагч” хэмээх сургаалд өгүүлжээ гэх мэт. Ямар нэг зохиол, бусдын үг яриа, ном бүтээлээс сонгон авч, хэлэх өгүүлэх зүйлдээ гэрч баримт болгон шууд ашигласан эшлэл нь **“гэ-, хэмээ-”** холбох үгээр холбогдсон оруулбар өгүүлбэр, цогцолбор болно. **“гэ-, хэмээ-”** холбох үгээр ямар ч гишүүн өгүүлбэр холбогдоно. Эшлэл нь эрдэм шинжилгээний эргэцүүлэх найруулгад, мөн ятган итгүүлэх эсээ зэрэгт чухал үүрэгтэй байдаг.



Дасгал 10

“Монгол хэлний тухай хууль”-д заасан Монгол улсын иргэний эрх, үүргийг үндэслэн, эргэцүүлэмж эх бичихдээ үндэсний хэл соёлын талаар зохиолч, судлаачдын хэлсэн үгийг эшлэл болгон ашиглаарай. Эшлэл нь хэл зүй ба агуулгын хувьд ямар үүрэгтэй байгааг тайлбарлаарай.

20 дугаар зүйл. Монгол улсын иргэн

- 20.1. Монгол улсын иргэн дараах эрх эдэлнэ:
 - 20.1.1. Монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, монгол хэлээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар санаачилга гаргах;
 - 20.1.2. Хуульд заасан бусад эрх.
- 20.2. Монгол улсын иргэн дараах журамт үүрэг хүлээнэ:
 - 20.2.1. Монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх;
 - 20.2.2. Хуульд заасан бусад үүрэг.

Монгол хэмээх нэгэн нэр ертөнцийн
 чихнээ дуурсхалтай
 Монголын тул хэмээх сэтгэл манай
 зүрхэнд холбоотой
Д.Нацагдорж

Чихинү чимэг болсон аялгуу сайхан
 монгол хэл
 Чин зоригт өвгөд дээдсийн минь өв
 их эрдэнэ
Б.Ринчен

Монгол хэлээ хамгаалах нь Монгол
 улс хилээ хамгаалахаас ч нарийн
 арга ухаан шаардах цаг ирнэ.
Л.Түдэв

Хэл минь эвдэрч, ойлгомжгүй, хөндий,
 уйтгартай болбол, товчоор хэлэхэд, би
 эх хэлээ эвдэх юм бол миний амьдралд
 түүнээс аймшигтай юм үгүй болно.
Расул Гамзатов

Хэлээ хайрлана гэдэг бол өөрийгөө
 хайрлах, үндэстнийхээ сэтгэхүйг
 хайрлах гэсэн үг.
Б.Даш-Ёндон



Дасгал 11

Хөндлөнгийн этгээдийн хэлсэн үгийг “гэ-” холбох үгийн ямар хэлбэрээр холбож, ямар утга илтгэж байгааг тайлбарлаад, хураасан үйл үгийг сэргээн бичээрэй.

- За, Батбаяр гуай минь, энэ хэний хот байсан гэдгийг та мэдэх үү? **гэжээ.** (Б.Р.)
- Хүүхээ, өвгөн Батбаярыг Сүрэн эмгэний хамт дуудаад, нааш нь ирүүлээч **гэхэд** Дэрэн сэтгэл зовсхийж, өвгөн зангийн захиаг гүйцэтгэх **гэж** босов. (Б.Р.)
- Уулыг цас дарж, намайг нас дарж, чамайг мунхаг чинь дарж дээ **гэж** өвгөн Батбаяр Жамбыг зэмлэв. (Б.Р.)
- Эзэн хичээвэл аз хичээдэг гэдэг дээ. Би чамд айл хүний амь нэг **гэж**, нөхрийн сэтгэлээр чамд тус болох **гэж** үхрээ тариул **гэж** хэлж ядсан билээ. Чи миний үг огт авахгүй аашилж байсан шүү дээ. (Б.Р.)
- Сор залахыг үзэх **гэж** хотын олон амьтан дагаж, тэр өдөр зах зээлийн газар юм авах **гэж** хөдөөнөөс ирсэн олон хүн бас сонирхон, олон амьтан морьтой нь морилж, хөлтэй нь хөлхөж, хөллгүй нь мөлхөж, цувралдан хөдөлжээ. (Б.Р.)

- За тэгвэл, миний муу гэзгийг авч хаяад, манж шоронгийн үнэр танарыг салгаж өг **гэж** Алтанхуяг Ондорайн өмнө ирж суув. (Б.Р.)
- Манай эмгэн хүүгээ их санаж, өрөвдөлтэй болжээ...Эх хүний сэтгэл **гэж** аргагүй дээ. Би **ч гэсэн** ямар хүрэл чулуун зүрхтэй юм биш, хүүтэйгээ уулзахын хүсэл болоод, эмгэний үгийг зөвшлөө. (Б.Р.)
- Морины эмээл авъя **гэж** Батбаяр босож, гадагш гарав. (Б.Р.)
- Эмээл тохмоо аятайхан **гэгчээр** олом жирмээр даруулж, үүрэхэд эвтэйхэн болгоод, ардаа үүрч...зангийн өвөлжөөний зүг алхав. (Б.Р.)
- Амны чинь хишиг мөчдөж дээ. Харин энэ дээл, гутал хоёр чинь зүгээр юм байна **гэж** инээгээд, **гэвч**, ингэж юм амархан олддог юм байна **гэж** битгий шунаарай. Ёс бусаар олсон юм гарахдаа ч ёс бусаар гардаг **гэж** хэлэв. (Б.Р.)



Дасгал 12

а, б, в цогцолборын утга санаанд тохируулан, (...) цэгийн оронд хэлц өгүүлбэрийг сонгож бичээрэй. Эдгээр хэлц өгүүлбэрүүд найруулгад ямар үүрэгтэй байна вэ?

1. Идсэн ч чоно, идээгүй ч чоно гэгчийн үлгэрээр

а. Тэр жил би ноёны бараа болж, Хүрээ ороод, бээжин Содномдаржаагийн пүүснийхэн манай ноёныг зочлон будаалж билээ. Би архинд нь согтоод, бусдыг дагаж, зээл тавьж, эхнэртээ нэг луучин гутал, хүүхдэд хоёр жин чавга авсан чинь хожим харин гурван бүдүүн ирэг өгч салсан шүү гэж зангийн хэлэхэд Батбаяр инээмсрэн,
- Яах вэ дээ, Соном гуай (...) Та ч бас нэг сайхан хоол идэж авсан биш үү, тэгэхдээ гэжээ. *Б.Ринчен*

2. Нар дагавал даардаггүй, Ноён дагавал өлсдөггүй гэдэг шүү дээ.

б. “Тайзнаа тавих жүжиг чи өөрөө бич. Чамд сэтгэлийн их хөдөлгөөн бий. Бичиж чадна гэдэгт би найдаж байна” гэж шууд тулгах нь тэр. Огт бодож зүүдлээгүй явсан зүйлийг ингэж гэнэт үүрэг даалгавар болгоно гэдэг санахад үнэхээр бэрх байлаа (...) Их зохиолч Дашдоржийн Нацагдоржид очиж учир явдлаа хэллээ.
Д.Намдаг

3. Шаварт унасан шарын эзэн хүчтэй гэгчээр...

в. За, тэнэг тархи, чи одоо хэргээ хүлээж улайх уу? Нөхдөө зааж өгөөд, мах цуснаас нь идэлцэх үү? Чи нэг л хэрэг хүлээдэг бол хуучин сэжиг бүхий хэрэг цөмийг уудалж (...) тулгана шүү дээ. *Б.Ринчен*



Дасгал 13

Онъсогыг уншаад, “гэ-”, “хэмээ-” холбох үгээр холбогдсон үг, өгүүлбэрүүд хэл зүйн ямар үүрэг, утгатай байгааг, тухайлбал, тодотгол, тусагдахуун, зорилго, шалтгаан, болзол зэрэг утгын алин болохыг тайлбарлан бичээрэй.

- | | |
|--|---|
| <p>1. Агуу гэдэг ууланд
Гүгүү гэдэг амьтан
Сүвээ хоёрыг түнхэлзүүлж
Сүүл нэгийг саадаглаж
Агаарын жигүүртнийг
Алгасалгүй барьж иднэ.
<i>(Гүрвэл)</i></p> | <p>2. Хүнийг цатгах гэж
цүдгэр гэдэстэй төрөв.
Хүндэлж байх гэж
бөгтөр хүзүүтэй төрөв. <i>(Данх)</i></p> <p>3. Ноёны амрыг эрэх гэсэн
Морины ам дийлдсэнгүй.
<i>(Хамхуул)</i></p> |
| <p>4. Ур мод цавчив.
Уран гэж хэлсэнгүй.
Улаан залаа залаалав.
Гоё гэж хэлсэнгүй.
<i>(Тоншуул)</i></p> | <p>5. Хэцүүгийн аманд
Хэрээ өндөглөнө.
Хэн очиж авах вэ гэвэл
Хэнхээдэй л очиж авна.
<i>(Хайчаар цог авах)</i></p> |



Монгол хэлний уламжлалт найруулгад өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн болон ер аль ч гишүүнийг *гэж, гэгч, гэгч нь, гэдэг нь, гэдэг бол, гэдэг чинь, хэмээгч, гэгчээр* зэрэг үгээр ялган тодосгож онцолдог ёс буй. Тухайлбал: *Хайртай хэмээгч дотуурчилсны нэр. Хилэгнэх гэгч урины нэр. Жаргах гэгч нойрын нэр. Их хурц гэгч омгийн нэр. Харилхана гэгч атааны нэр. (Д.Р.) Дөрвөн эрдэм хэмээгч инү...* гэх мэтээр найруулсан байхаас гадна бичгийн болон ярианы найруулгад: *Эмээл тохмоо аятайхан гэгчээр олом жирмээр даруулж, үүрэхэд эвтэйхэн болгоод, ардаа үүрч...зангийн өвөлжөөний зүг алхав. (Б.Р.); Далай их үү гэвэл их. (Р.Г.); Усыг тос гэж хайрлая. Усыг амьдрал гэж шүтье. Дусал дуслаар хэмнэж, далай болгоё. (Б.П)* гэх мэтээр нийлмэл өгүүлбэрийн бүтцэд түгээмэл хэрэглэсэн жишээ арвин буй.

Дуугүй ард түмэн гэж байж ердөө болохгүй. Дуу гэгч морьтонг буулгаж, сонсуулна. Явганыг эмээлд нь ухасхийн мордуулж, шувуу мэт нисгэнэ. Өлгий хөдөлгөж, хүүхэд тэвэрч, ...хүүгээ таалсан эх хүнийг санаад үз! Сайн сайхан гэдэг тэр, үнэн гэдэг тэр, нэр төр гэдэг тэр болой. Сайн муу хүн гэж байдаг, тэр ч атугай сайн муу дуу гэж байдаг. Гэлээ ч гэсэн эх хүн, эхийн тухай дуу хоёр ямагт сайхан байдаг. (Р.Г.) гэхэд тодруулсан үгс нь гишүүнийг ялган онцолж, мэдэгдэлд чухалчлах үүрэгтэй, бас зарим нь санааг эсрэгцүүлж холбох үүрэгтэй байна.



Дасгал 14

Үүнийг бичгийн хэлний найруулгад ямар үүрэгтэй байгааг тайлбарлаарай. Үүнийг дуурайн зохиоходоо аль болох бичгийн хэлний найруулгын аястай болгохыг хичээгээрэй.

“Гэ-”, “хэмээ-” холбох үг нь нийлмэл өгүүлбэр, цогцолбор, эхийн хэсгүүдийн санаа мэдээллийг “гэвч, гэтэл, гэхдээ, гэлээ ч гэсэн, гэлээ ч” гэж эсрэгцүүлэн холбох нь элбэг. Жишээ нь:

Хэл мэдэхгүй **гэвч** хүнтэй уулзах дуртай
 Хэрэг шийдэхгүй **гэвч** улаан жинстэй (хөөрөг) гэхэд хоёр энгийн хэлхэц өгүүлбэрийг “**гэвч**” гэсэн үгээр холбож, санааг эсрэгцүүлсэн байна. Энэхүү “гэвч” холбох үгийг **мөртөө, хэрнээ, боловч, гэсэн ч, гэхдээ, ч, байтлаа, гэтэл, атал (атлаа)** зэрэг үгээр солин найруулж болохоос гадна байрыг нь сольж, “Хүнтэй уулзах дуртай **ч гэсэн** хэл мэдэхгүй; Улаан жинстэй **ч гэсэн** хэрэг шийдэхгүй” гэж болно.

Дасгал 15

Юуг юутай адилтгаж, оньсоголсныг ярилцаад, “гэ-” холбох үгийг өөр үгээр солих, үгсийн байр дарааллыг өөрчлөх зэргээр янз бүрээр хувирган найруулж бичээрэй.

- | | |
|---|--|
| <p>1. Солбисон очир хуягийг биедээ зүүж Сонирхон үзье гэхээр нүүрээ нууна.
(Зараа)</p> <p>2. Авдар дээр алим байна.
Авъя гэсэн
Айгаад байна.
Идье гэсэн
Ичээд байна.

(Тахилын идээ)</p> | <p>3. Хэлсэн үг нь цэцэн гэж аргагүй Явсан мөр нь шулуун гэж аргагүй. Малгайг нь аваад үзвэл Толгой нь шал нойтон (Бийр)</p> <p>4. Даарахгүй гэж Дахтай төрөв. Далдирахгүй гэж хуягтай төрөв. Бээрэхгүй гэж цамцтай төрөв.

(Самар)</p> |
|---|--|



“А”, “Б” хэсэгт бичсэн өгүүлбэрийн төгсгөлийг харьцуулж, адил ба ялгаатай талыг тайлбарлаарай. “Б” хэсэг дэх өгүүлбэрийн төгсгөлд буй “гэнэ, гэдэг” хэмээх үгс бүхэл өгүүлбэрийн санаатай ямар холбоотой байгааг тайлбарлан ярилцаарай. Эдгээр үгийн утга, үүргийг тодорхойлоход “Хэл зүйн тайлбар” гэсэн хэсгийг ашиглаарай.

А.

1. Атан тэмээ ангас ангас гэнэ.
Аргамжийн үзүүр хэлбэс далбис гэнэ.
(*могой*)
2. Хааны газар хангис гэнэ.
Хатны газар жингэс гэнэ.
Туух нуруу нь түгдэс гэнэ.
Тугал сүүл годос гэнэ.
(*цан, хэнгэрэг*)
3. Газар доор түс түс гэнэ.
Газар тэнгэр нир нир гэнэ.
(*айраг бүлэх*)
4. Шагайн дөрвөн этгээд нь дөрвөн зүйл нэртэй. Хонхортой этгээдийг хонь буюу цэг гэнэ. Бөмбөгөртэй этгээдийг бөг гэнэ. Дээд талыг морь гэнэ. Доод талыг тэмээ гэнэ. (*Ц.Д.*)

Б.

1. Агаар мандалд уур хэлбэрээр 12,900 шоо километр ус байдаг гэнэ.
2. Нээрэн цулгүй газар торох юу ч байхгүй атлаа хамхуул хийсэхгүй тогтоод байх юм гэнэ. (*Ж.М*)
3. Тэд зулзагануудтай зунжингаа хоолоо хувааж идээд, намар экспедиц буухад нутагт нь орхисон гэдэг. (*Ж.М*)
4. Энэ хангайд Автай сайн хааны аав нутагладаг байсан юм гэнэ лээ. Ан ав хийж аваад, нэг шөнө цагаан баавгай дайрлаа гэж зүүдэлж хоносон гэнэ. (*Ж.М*)



Бодит байдал ба өгүүлэмжийн агуулгын харьцаа өгүүлэгчийн хувьд шууд бус дам шинжтэй байвал тодорхой бус бодит баймж утга илэрнэ.

Тодорхой бус бодит баймж утга илэрхийлэх, бусдын хэл яриаг дамжуулахад ГЭ-язгуурт *гэх, гэнэ, гэдэг, гэж байна, гэж* зэргийн үйл үг ихээхэн үүрэгтэй байдаг. ГЭ-язгуурт үйл үг нь ихэвчлэн тодорхой бус баймж утга илтгэх бөгөөд энэ тодорхой бус шинжээс нь хамаарч, хэлэхүйн нөхцөл байдалд янз бүрийн нэмэлт, далд санаа илэрч болно. Тухайлбал:


- а. Дорж хаана байна вэ?; Дорж **гэдэг** оюутан хаана байна вэ? гэсэн нэг санаа бүхий өгүүлбэрийг харьцуулахад уг өгүүлэгч уул хүнийг таньдаг, таньдаггүй нь баймж утгаар ялгарч байна.
- б. **ГЭНЭ** гэсэн үгийн тусламжтайгаар өгүүлэгч тухайн мэдээллийг өөрөө шууд бус замаар хүлээн авч дамжуулсан баймж утга илэрхийлдэг. Жишээлбэл: “Ханд ван тархийг нь хага цохиж алсан **гэнэ**. Тэр нь худлаа **юм байх**. Хор идэж үхсэн **гэнэ**. Хор идсэн нь худлаа **гэнэ шүү**. Мориноос унаж үхсэн **гэнэ**” гэж хүртэл ярилцав. (*О.Ц.*)

ГЭНЭ хэмээх үгийн дараа *билээ, лээ, дэг, ээ, шүү, шүү дээ* зэрэг дутмаг үйл үг, сул үгийг хэрэглэж, тухайн өгүүлэмжийн утгыг лавшруулан, баталсан утгатай болгоно.

Ю. Мөнх-Амгалан. Орчин цагийн монгол хэлний баймжийн ай. Уб., 1998., 69-73-р тал

ХЭЛЦ ӨГҮҮЛБЭРИЙН ГОЛ БА ҮҮДЭЛ САНАА

Үгс нь юмс үзэгдлийн гол шинжийг илтгэдэг бол өгүүлбэр нь утга санааг илтгэнэ. Жишээ нь:



од


1. Дэлхий ба бусад гаргийг тойрон эргэх огторгуйн гэрэлт ба илчит одыг **нар** гэнэ.




мандах

2. Далд байсан юм ил болохыг **гар**ах гэнэ.

Нар гар- гэсэн цөм өгүүлбэр нь а. “өдөр болох” б. “баярлах” гэсэн утгыг бүтээжээ.



өдөр бол



баярла

Шууд нэрлэх нь			Шууд бус нэрлэх нь
Зуны шөнө богино тул өглөөний найман цагт нар нэгэнт дээр гарчээ . (Д.Н)			Арай гэж нэг өдөр Ерөөлт эргэж ирэхэд Болормаагийн нар гарч , уйтгарлахыг түр зуур мартана. (Л.Т)
найруулга	дээд	нар манд-, урга- гий-, дэгж-	нар нь гар- { <ul style="list-style-type: none"> баяртай явдал тохиолд- баярлаж хөөр- хүсэл нь биелж баярлах-
	дунд	нар-, гар-, цухуй-	нар нь гар-, хөл нь хөнгөр-
	доод	хэдэн хялгас	өвчүүний цаад руу юм хая-
орчлонгийн нар гар-			хүний нар гар-
Орчлонгийн нар гарч, газар дэлхий гэрэлтэн гийх явдлыг хүнд тохиолдсон баяр бахдалтай үйл явдалтай адилтган, “нар нь гар”- (баярлах, хөхих) гэж хэлц өгүүлбэр бүтээжээ.			

Бодит үйл явдлыг нэрлэсэн өгүүлбэрийг хэлц бус өгүүлбэр гэх ба бодит үйл явдлыг хийсвэрлэн шууд бус нэрлэсэн өгүүлбэрийг хэлц өгүүлбэр гэнэ.

Хэлцийн утгыг монголчуудын утга соёлын өвөрмөц онцлогоор тайлбарлаж болно. Жишээ нь:

“Хэлэхэд амархан, хийхэд хэцүү” гэсэн цогцолбор хэлц нь “Аливаа ажил нь биеийн хүч, ухааны чадвараас болдог” гэсэн гол санаатай бөгөөд “Санасан бодсоноо амаар биш, биеэр гүйцэтгэх” гэсэн нь үүдэл санаа болно. Харин энэ хэлц цогцолборын санааг “амар хэцүү” гэсэн үгсийг эсрэгцүүлэн, “ам гар”-аар үйлдэх гэсэн утга бүхий “хэлэх, хийх” гэсэн зүйлийн утгатай үгсийг харьцуулан сонгож бүтээжээ. Ямар нэг үйлсийг бүтээхэд сэргэмж болгосон санааг мөн агуулж байна. Үүнийг дүрсэлбэл:

(Ам, гар) үүдэл санаа..... гол санаа (хэлэх, хийх)

Энэ хэлц цогцолбортой ойролцоо санаа бүхий хэлцүүд нь:

1. Хазъя гэхэд алга хол
Харъя гэхэд чих хол
2. Харахад ойр
Хазахад хол
3. Хошуу нэмэхэд амархан
Хуруу нэмэхэд хол
4. Хуяг байвч дуулгагүй
Нүд байвч хөмсөггүй

“Хазъя гэхэд алга хол

Харъя гэхэд чих хол” хэлцийн үүдэл санаа нь “ам - алга, нүд - чих” гэсэн үгсээс “хаз-, хар-”, “алгаа хаз-, чихээ хар-” гэсэн хэрэг явдлаас бий болжээ. Гол санаа нь “хол” гэсэн орны утгатай тэмдгийн нэрнээ төвлөрч “хэцүү, хүнд хялбар бус” гэсэн санааг бүтээсэн нь “Аливаа ажил бүтээх нь хэцүү байдаг” гэсэн гол санаа болон хувирчээ. Энэ санааг “Хүн алгаа хазаж, чаддаггүй шиг, чихээ харж чаддаггүй” гэсэн хэрэг явдлыг ажил хийхтэй далдуур адилтган уран санааг бүтээжээ. Хамгийн хялбар мэт санагдах өчүүхэн ажил ч хүнээс ухаан хүч шаарддаг.



“Хошуу нэмэхэд амархан

Хуруу нэмэхэд хол” гэсэн хэлц цогцолбор нь дээрх хэлцээс юугаараа ялгаатай вэ? гэвэл “хошуу” нь “үг хэл”, хуруу нь “ажил хөдөлмөр”-ийг тус тус орлуулан хэлсэн. Харин “нэм” гэсэн үйл үг нь “туслах, хамжилцах” гэсэн адилтгасан салаа утгатайгаар оржээ.

“Хуяг байвч дуулгагүй

Нүд байвч хөмсөггүй” (загас) гэсэн оньсогот хэлц өгүүлбэр нь загасны гадаад дүр байдлыг “нүд, хайрс”-аар нь төлөөлүүлэн, “баатар эр” хэмээн төсөөлж, утга далдлан бүтээжээ.


Зүй нь хуягтай бол дуулгатай, нүдтэй бол хөмсөгтэй байх ёстой. Гэвч оньсогод “байвч” гэсэн үйл үгээр байх ёстойг байхгүйтэй сөргүүлэн хэлхэж, егөөдсөн санааг илэрхийлсэн бөгөөд загасны хайрсыг баатрын хөө хуягтай адилтгажээ. Үүнийг

- Хуягтай *атлаа* дуулгагүй
Нүдтэй *атлаа* хөмсөггүй
- Хуягтай *боловч* дуулгагүй
Нүдтэй *боловч* хөмсөггүй
- Хуягтай *ч* дуулгагүй

Нүдтэй *ч* хөмсөггүй гэх мэт ойролцоо бүтээврээр солин найруулж болно.

“Хуяг байвч дуулгагүй” гэсэн эхний өгүүлбэр,

“Нүд байвч хөмсөггүй” гэсэн хоёр дахь өгүүлбэр нь адилтгал, хүншүүлэл бүхий дүрслэлээр бүтжээ. Иймд энэ хэлцийг далд санаа бүхий өгүүлбэрээр хослуулан найруулжээ. Үүнийг загварчилбал:



Дасгал 17

Ойролцоо нэгжүүд ямар аргаар бүтсэнийг дээрх загвараар тайлбарлан бичихдээ гол үгийг олоорой.


1. **бур-**, хадуур-, мэдэмхийр-, чалч-
дэмий ярь-, авч давхи-, хоосон
чалч, амаа олохгүй, сул чалчаа
яриа, амны хэмжээгээр ярь-, аманд
орсноо чалч-, далан долоон юм
донгос-, эсэн бусан юм чалч-, хэлэх
хэлэхгүй үг чалч-
2. **Ухаангүй ноёнд урагшгүй албат-**
Мах багадахад бохь чөмөг ахал-
Мах ховордоход богтос түрүү
Хадаг ховордоход самбай ахал-
Нохой үгүйд гахай хуц-
Бурхангүй газар бумба галзуур-
Ламгүй газрын банди галзуур-
Бухгүй газрын бяруу галзуур-
3. **хамжилц-**, Хажуу хавиргандаа ав-
Хормой нөмөртөө байлга-, Хаяагаа
түшүүл-, Нөмөр нөөлгөндөө ав-
Нэмэр сэлбэг хий-
4. **биеэ барихгүй-**, Уур нь оволз- хилэн
нь бадар-, Уур манас хий-, омог
нь бадар-, Уур шат-, омог нь шат-,
Аазгай хөдөл-, дээлэндээ багтахгүй
бол-
5. **үхэн зүтгэ-**, Тамираа тасартал-,
Шөрмөсөө сунатал-, Хар хулгана
болтол-, Усан хулгана болтол-,
Хар хөлсөө цувтал-, Хатан ясаа
гулзайтал-, Арван хурууны араа
барж-, Таван хурууны тараа барж-

Дасгал 18

Эсрэг нэгжүүд ямар аргаар бүтсэнийг тайлбарлан бичихдээ, гол үгийг олоорой. Жишээ нь:

“Малгай тавибал манайх

Маргааш болбол хүнийх” гэвэл “Айлд ирэхдээ өөриймсөг байснаа явах болохоороо хөндий хүнийрхүү” гэсэн үүдэл санаатай ба “Хэрэгтэй бол наалддаг, хэрэггүй болмогц хийсдэг (хоёр нүүртэй)-г илэрхийлсэн нь нь гол санаа юм. “манайх-хүнийх” гэсэн эсрэг утгыг зэрэгцүүлж, зэргэд бүтээсэн ба “малгай тавих” нь “зочлох, хонох” гэсэн санаатай орлуулсан тойруулал юм. Энэ бол уран санаа юм.



- | | |
|---|---|
| <ul style="list-style-type: none"> • Зүрх алд - зүрх ор- • Нааш хар - цааш хар- • Их барьсан ч өмхий-бага барьсан ч өмхий • Цухал хүр - цухал гар - • Санаа зов - санаа амар- • Хадан гэр ойртож, ханан гэр холд- • Гар газар хөл хөсөр • Далан долоон үг дэлгэ- амаа үд- • Өглөө хазаар орой ташуур | <ul style="list-style-type: none"> • хийморь доройт - хийморь дэлгэр • хөлөө ол - хөлөө алд- • амь ор - амь гар • борви бохис хий - борви бохис хийхгүй • амь наана там цаана • надаас цаагуур нарнаас наагуур • нүд хужирла - ой гут- • хатуу сэтгэл зөөлөн сэтгэл • Улаан чулууг мах гэж залги
Цагаан чулууг өөх гэж залги - |
|---|---|

Хэлц өгүүлбэрийг шууд утгат өгүүлбэртэй харьцуулан тайлбарлая

Ойролцоо өгүүлбэрээр илрэх нь

Шууд утгат хэлц бус ойролцоо өгүүлбэр:	Шууд бус утгат ойролцоо хэлц өгүүлбэр:
Хувцас биед таар- Замд таар- Хоорондоо тохир- Ярьж тохир-	санаанд таар-, сэтгэлд нийц- гар нийл-, ганзага нийл-, гар таар- санаа нийл- яриа таар-
Амт сайтай- Дурла-, шохоорх-	арааны шүлс асгарам, хорхой хүрэм, шүлс гоожмоор, дээд уруулд хүргэмгүй, дэргэдэх хүнд өгөмгүй дур татам, хүн шохоорхом, хараа булаам, нүд хужирлам

Ацаг өргөсийг тодорхой бич-
 Сайхан бич-
 Сурцтай бич-
 Гэдэс тэнцүү бич-

дурайтал нь бич-, бичнэ гэж сийлдэг, зурсан юм шиг бич-, шугамдсан юм шиг бич-, бичнэ ч гэж бичсэн, хорхой хүрэм сайхан бич-, сүүн цацлага жигд, шугамарсан голтой угалзруулдаг, өдтэй бичиг гэгчээр янзтай сайхан бич-

Бүтэшгүй-
 Үл биел-
 Бүтэхгүй-

хар усан дээр өрөм тогтоо-, элсээр дээс том-, эр үхэр сааж элгэн тараг бүр-, үнсээр чөдөр зангид-, цасан дээр цэцэг ургуул-, хөхөөг хүйдсээр цохь-, үхэр хэдгэнийг дээсээр бугуйлд-, нар баруун талаас навтас чирээд гарч ирэх

Эсрэг өгүүлбэрээр илрэх нь

Шууд утгат хэлц бус өгүүлбэр:

- Муу муухай гэгч орчлонгоос нэгд нэггүй тонилон одож, гагцхүү сайн сайхан дэлгэрсэн мэт санагдана. (Д.Б)
- Царсны навчийг шарлаад байхад Нарсны мөчир ногоороод байдаг Цагаан хусыг хатаад байхад Цармын арц нойтон байдаг Хээрийн ногоог хуурай байхад Хэцийн зээргэнэ сөлтэй байдаг. (Ц.Д)
- Энэ завсар Дагдангийн эхнэрийн таргалсан Цэрмаагийн турсан хоёр яг тэнцэнэ. (Д.Н)
- Ядуу бол ухаантай байсан ч хаягдана Чадуу бол солиотой байсан ч шилэгдэнэ. "Таван сургамж"

Шууд бус утгат хэлц өгүүлбэр:

- Чиний найз чинь аргагүй л нэг аз нь шовойсон хүү юм даа. (Ц.Д)
"Над шиг хөл нь чангарчихсан амьтан өнгөрөө дөө. Аз нь харьсан эр алтан дээгүүр нүдээ аниад өнгөрдөг юм гэнэ лээ" гээд маг маг инээв. (Д.С)
- Тэр үгийг сонсоод Хүчүлүг хаан өгүүлрүүн: "Таян хан мөн аанай (муусайн) эм мэт зүрх алдаж, ийм үг хэлжээ" (МНТ)
На ван тэр байдлыг үзэж, зүрх ороод ихэрхэг дүрэм үзүүлж суув. (Б.Р)
- Эрдэнэ Итгэлтийн хэлснээр түрүүлж болохгүйг Батад захиж өгөөд, хээр морь аман хүзүүнд иржээ. (Ч.Л)
- Эс тэгвэл ард олон гар хөдөлж, самуун үүсгэвэл удирдахын оронд бид, харин сүүл барьж хоцроход хүрч болзошгүй. (Б.Р)

 **Дасгал 19**

Тухайн үйл, хэрэг явдлыг өгүүлсэн хэлц бус өгүүлбэрийн санааг төгс төгөлдөр болгохын үүднээс хэлц өгүүлбэрийг эш татан, нийлмэл өгүүлбэр бүтээсний учир шалтгааныг тайлбарлаарай. Жишээ нь:

Би гуйгаад, чи тусалж, монголд диваажин байгуулна гэдэг нь харганын унгас түүж, эсгий хийх шиг хэрэг байна даа гээд Эрдэнэ хөгжилтэй инээв. (Ч.Л)

Би гуйгаад, чи тусалж, монголд **харганын унгас түүж,**
 диваажин байгуулна гэдэг нь **эсгий хийх шиг хэрэг**

бүтэшгүй (адилтгал)

1. Яваан минь, би чамд л гэж үүнийг хэлж байна шүү. Манайханд “Төрийн төлөө оготно боомилж үхэв” гэдэг цэцэн үг бий шүү. (Б.Р)
2. Тэр дайнаар олон хүний “Нүд нь нээгдэж, сүв нь онгойсон” бололтой. (Б.Р)
3. Дээл гутал цөм цахар болчхож, царай чинь аавынхаа залуугийн төрхтэй яасан адилхан болов. Бас “цээж нимгэрч” эрдэм номтой болсон шинж царайд чинь байна шүү. (Б.Р)
4. Хараач, нөхөд минь, “Эрхийн чинээ биетэй мөртөө үхрийн чинээ том” шуудайтайг шүүрдэг эр байна шүү. (Б.Р)
5. Би чам юугаан “гэгээн өдөр цээжиндээ, харанхуй шөнө зүүдэндээ” дурсаж явна гэж хэлэв. (Б.Р)
6. ...хуарандаа ойртосхийж байгаад, Дамдин тэргүүний “бор зүрхийг долгилж, богино хавиргыг маталзтал” дуулаад орхино доо гэж ярьцгааж явав. (Б.Р)
7. Хуучны улс “Эвт шаазгай буга буулгадаг” гэдэг нь үнэн үг шүү гэв. (Б.Р)
8. Чингэхэд “Их чулууг бага чулуугаар хөдөлгөдөг” тул бага хошуунаас Монгол уудам их нутагт тустай юм хийж болно шүү дээ. (Б.Р)
9. Бид хоёр, өвгөдийн мэргэн үгээр “Амьд явбал алтан аягаар рашаан унд уух” цаг ирэх вий гэлээ. (Б.Р)
10. Тэгээд олон жил “алтан дэлхийн тоос хөдөлгөж” явах мөртөө бичиг үсэг сураагүй өдий хүрсэндээ ичиж явлаа. (Б.Р)
11. Сор залахыг үзэх гэж... олон амьтан “морьтой нь морилж, хөлтэй нь хөлхөж, хөлгүй нь мөлхөж” цувралдан хөдөлжээ. (Б.Р)



Дасгал 20

Өгүүлбэр дэх хэлц өгүүлбэрийн санааг алдагдуулалгүй хэлц бус үгээр сольж бичээрэй. Жишээ нь:

“...нарийн сураар хүлсэн дөрвөн мөч нь бадайран, сур маханд нь улам бүр шигдэж байхад хор нь буцалсан Түгжил хөмхийгөө зуун, үг дуугүй хэвтэж байлаа” (Ч.Л) гэсэн өгүүлбэрийн “хор буцалсан”-ыг “ихэд хорссон”, “хөмхийгөө зуун” гэхийг “занан” гэж сольж болно.

1. Бас Гүнсэндүлаамтай уулзаж, үгээ ололцохыг хэн байг гэх вэ? Ус балгасан, юм шиг дуугүй, өөрийгөө зовоож явснаас сэтгэлээ нээгээд авбал дээр дээ. (З.С)
2. Насны нар хэлбийж яваа улсад энэ мэт том хурлын индрээс магтуулах нь юу нь муу байх вэ? (Ц.Б)
3. Овоо доо. Тэр чинь голыг нь олж бичээд, хорыг нь хөдөлгөж байгаа байх (С.П)
4. Шаварт унасан шарын эзэн хүчтэй гэгчээр хонины ээлж таарсан ба энэ хэргийн учир начрыг олж л таараа. Хичээх болно оо. (Ц.Б)
5. Чамаар заалгахгүй, хүү чинь, эцэгтэй чинь эрүү өвдгөө нийлтэл явж өсгөсөн хэдийгээ нэгдэлд өгсөн юм. (Ж.Б)
6. Болох болохгүй юм амны зоргоор донгосож, хар толгойдоо булуу хурааж явах ч гэж дээ. (Б.Н)
7. Сэлэнгийн ус морины тамга алгадан, түрхэрч, нэлмэгэр их мандал дээгүүр нь

- модны өгөр мөчир, үндсэнд нь ширэлдсэн бут сөөг үе үе гүдэлзэж гөвөлзөн өнгөрнө. (С.П)
8. Ямар ч бол хэрэггүй юманд ухаан зардаг хүн биш хойно учир утгатай л үг, улаан цагаан хоёр хоорондоо тулаад, нэг хэсэг нь орж ирэх нь дээ. (С.У)
 9. ...биднийг хамба багш явуулсан гэж ирэгсдийн нэгний хэлснийг сонсмогц Содном хөл алдан, тарган мах чанав. (Ч.Л)
 10. Тэгээд тэр ав аянаас хойш Анутай хоёулаа ариун сайхан амраг сэтгэлтэйгээ мэдэлцэж, хувь заяагаа холбон, жаргал зовлонгоо хамтатгана гэж зорин бодож явсан билээ. (Б.Р)
 11. Май, Мишиг, “Урт настай удаан жаргалтай болоорой, төмөр голтой, төө сахалтай болоорой” гэж ерөөв. (Б.Р)
 12. Алтан улсын цэрэг нэгэнт цөс хэмхэрсэн тул монголын цэргийг сонсмогц, царай үзэхгүйгээр буруулахад монголын цэрэг хоосон газар явах мэт хялбар. (В.И)



Дасгал 21

Өгүүлбэрийн онцлон ялгасан үгийг утга ойролцоо хэлц, холбоо үг, өгүүлбэрээр сольж бичээрэй. Жишээ нь:

Дашнямын хөвөнтэй дээл дорхноо нэвтрэв. (С.Э)

- | | |
|---------------------------|--|
| дорхноо (цагийн байц) | - нүд ирмэхийн зуур
- агшин зуур |
| нэвтрэв (төгс өгүүлэхүүн) | - усан хулгана болов
- усан гүзээ болов
- норсон элээ шиг болов
- ус цутгуулсан зурам шиг болов гэж солин найруулж болно. |

Хэлц бус өгүүлбэр:	Хэлц үг, өгүүлбэр:
Хангайн хар Дагданд халзан хээрээс нь илүү чухаг амьтан энэ ертөнцөд байсангүй. (С.Э)	морин эрдэнэ, амин сүнс
Түрүүчийн цаснаар би нутагтаа очсон байв. (С.Э)	унасан газар, угаасан ус, төрөлх нутаг, эхээс мэндэлсэн газар шороо, хар нялхаас тоглож өссөн нутаг
Болор уст уулын горхины дэргэд гал түлж, бяцхан зэс тогоонд цай тавиад, хоёул тавлан суулаа. (С.Э)	хэвтээ хонь үргээхгүй, ус балгасан юм шиг, цээж тэнэгэр, ясаа амраа-, гэрээс гарахгүй, гэдэс алдахгүй, хорхойд хоргүй, сүх далайтал үхэр амар, сүүж автал чөмөг амар
Монголын өргөн талд шар өнгийн өвс халиуран хийснэ. (Ц.Д)	нүд алдам, нүд гүйцэж харахааргүй тал газар, нүд гүйцэмгүй тал

Хэлц холбоо үг, өгүүлбэр нь үгийн утгыг олон талаас буюу өөр өөр үйл явдлын санаагаар тайлбарладаг. Жишээ нь:

СУР

Мэдэхгүй, чадахгүй зүйлийг мэддэг чаддаг болох

- Сурсан нь далай
- Сураагүй нь балай.
- Сурсан эрдмээр сувдыг ч олно
- Ариун эрдмээр алтыг ч олно.
- Сурсны сайн нь хэрэглэх дээр
- Судалсны дүн нь бүтээл дээр.
- Сурсан занг сураар боож болохгүй.
- Судар самбайг дээсээр ороож болохгүй.
- Сураад барагдашгүй эрдмийн далай
- Судлаад баршгүй бодисын далай.
- Эдээр биеэ чимэхээр
- Эрдмээр биеэ чим.
- Эд хураахаар
- Эрдэм хураа.
- Мэргэний эрдэм дотроо
- Мунхгийн эрдэм гаднаа.
- Номтой бол насан турш жаргана
- Номтой газар нохойн чих цайна.
- Номын нүдтэй бол
- Номын хураар ундаалаад.



Дасгал 22

а. Өөр өөр аймгийн үгс хэлцэд ямар утгатай орсныг тайлбарлан бичээрэй.

Хэлц бус үг	Хэлц үг	Ойролцоо хэлц үг
чийрэг (тэмдгийн нэр)	амь бөхтэй ястай яс сайтай	бөх бие, төмөр шиг бие хад чулуу шиг бие чулуугаар цохисон ч алзахгүй барагтай хамрын ханиад хүрэхгүй хамуу жидүү тусдаггүй
ухаантан (жинхэнэ нэр)	их билигтэн цоорхой хүн сод билигтэн суу	хосгүй дээдэс ухаантан мэргэд билиг танхай
урвай (үйл үг)	урам хугар уруу царайл царай алд	дотор гонсгор, урам муутай яв- бүлх залгисан юм шиг бай- гутал нь хавчаа юу, хоёр эхнэртэй юм уу гэгч бол- гуньж гуншиж яв-
долоо (тооны нэр) Долоон булчирхай, Найман найлуурхайгаа тооч	үнэнээ хэл- тооч- бодлоо хэл- сэтгэлээ илчил-	байдгаа дэлгэ-, өвчүү дэлгэн хэл- сархинагийнхаа баасыг гөв- доторхоо юул-, дотроо онгойтол хэл- санаагаа нуухгүй, ний нуугүй, илэн далангүй

<p>наана, цаана (орон цагийн нэр)</p>	<p>тэшүүлэн бөмбөлзүүлэн тэлмүүлэн</p> <p>1.амь наана, там цаана</p> <p>жирэлзүүлэн жирийлгэн таварган харайлган гишгүүлэн</p> <p>2.амь наана там цаана</p>	<p>ум хумгүй, хурд саалгүй, юу юугүй ухаан жолоогүй дөрвөн тавхайгаа эргэ- мангас сорин, далавчилсан мэт хөл мэдэн, нисэх шахан, хөлийнхөө хурдаар, хар хурдаар шурд шурд хийж</p> <p>амьсгаа дээр яв-, байж суух аргагүй дороос нь хатгасан юм шиг цавь руу нь чичсэн юм шиг гал дээр гишгэсэн юм шиг оломны цанхтай юм шиг цанх нь хөдөлсөн юм шиг</p>
<p>хага (дүрс дуурайх үг)</p>	<p>хар нүдээ хага тат- хар нүд хуул-</p>	<p>нүд нуух анилд-, нүд анивч- нүдээ сүүмийлгэ-, нүдээ онгойлго</p>
<p>гангар гунгар (авиа дуурайх үг)</p>	<p>гангар гунгар хий- гүнгэр гангар хий-</p>	<p>дотночлон хүүрнэ- нүүдлийн шувуу дуугар-</p>

б. Төлөөний үгс ямар утгатайг тайлбарлаарай.

<p>Хэлц бус үг (төлөөний үг)</p>	<p>Хэлц үг</p>	<p>Ойролцоо хэлц үг</p>
<p>би чи (биеийн төлөөний үг)</p>	<p>би чи дээ хүр-</p>	<p>сайн муугаа дуудалц- ам муруй-, ам дордой-, ам зөрөлц-, хошуу муруй-, хэрүүлээр хоол хий-, хэрүүлээр амьсгал-</p>
<p>яах ийх (үйлийн төлөөний үг)</p>	<p>яах ийхийн зуургүй яах ийхийн завгүй</p>	<p>нүд ирмэх зуур, нүд цавчрахын зуур агшин/ эгшин зуур, хоромхон зуур цахилгаан шиг хурдан</p>
<p>юм (жинхэнэ нэрийн төлөөний үг)</p>	<p>юман чинээ бодохгүй</p>	<p>нэг нүдээр үзэхгүй (тоохгүй) юманд тоохгүй (гүжирмэг бай)</p>
<p>ямар (тэмдгийн нэрийн төлөөний үг)</p>	<p>ямар нүүрээрээ</p>	<p>ичих нүүргүй, ичих нүүрээ бар- ичих нүүрэндээ илэг наа- ичгүүр сонжуураа алд-</p>
<p>хэд (тооны нэрийн төлөөний үг)</p>	<p>хэдэн хялгас</p>	<p>таван хялгас үсний төдий (үсний оронцог)</p>
<p>хэзээ (цагийн нэрийн төлөөний үг)</p>	<p>хэзээ л бол хэзээ</p>	<p>хэзээ ч хамаагүй, хэзээ нэгэн цагт дуртай цагтаа, цаг болзохгүй хэдийд ч яахав</p>
<p>хаа (орны нэрийн төлөөний үг)</p>	<p>хаа үгүй ханхайсан толгой</p>	<p>сэтэртэй мал шиг, гэрээ умартсан Гэсэр шиг гараа хумхи-, элгээ тэвэр- хийсэн юмгүй хий дэмий суу- гар газар, хөл хөсөр суу- сул сунх-, цаг нөгчөө-, хоосон сэлгүүц- ажлаа алд-</p>

<p>яаж (дүрс дуурайх үгийн төлөөний үг)</p>	<p>борви бохис хийх завгүй</p>	<p>бие хайргүй зүтгэ- хөлсөө шавх-, хар хөлсөө цувтал, хатан ясаа уяртал зүтгэ морь нохойн хүчээр зүтгэ-, хазаарт морь, илжиг шиг зүтгэ-, морь нохойн хүчээр зүтгэ-, чөдрийн морь шиг бөхгүй тэмээ бол-</p>
<p>яаж (авиа дуурайх үгийн төлөөний үг)</p>	<p>пал хийх</p>	<p>зүрх шир хий-, үнхэлцэг хагар-, бие арзай- сүнс зайл-, сүнс халь- оройн үс өрвөс хий-, нуруу хүйт орги- дотор харанхуйл-, хоолой гарахгүй</p>



Дасгал 23

Дараах хэлц холбоо үг, хэллэгийг өгүүлбэрт оруулан, холбон найруулж бичээрэй.

Жинхэнэ нэр

ар хударгаар, элэг бүтэн айл, алаг хорвоо, чулуун зүрх

Үйл үг

яс хавталз-, шил заа-, цээжээ хавтасла-, хужирхай
тэнийтэл

Тэмдгийн нэр

хуруун чинээ, цэцэг цэврүү шиг, чанга гар, хуй салхи
шиг хурдан

Тооны нэр

таван салаа боов шагна-, нэг гараараа нөгөө гараа
барь-, зуун ямаанд жаран ухна

Орон цагийн нэр

гүвээний цаанаас тархид-, дотор онгой-, дээсэн
дөрөөн дээр, үдийн хугархай

Авиа дуурайх үг

тар тур хий-, уухайн тас, цор цор хий-, дав дээр
далан хоёр худал хэл-, шав хийсэн хархүү

Дүрс дуурайх үг

ам мөлтөс, мэл гайхаж, цэл хөхөр-, хага таш-,
зад буу-, сүр сар хийсэн амьтан



Дасгал 24

Дараах хоёр цогцолборт морь эзэн хоёрын хэрэг явдлыг зохиогч үзүүлэхдээ дүрслэг хэлц ба хэлц бус холбоо үг, өгүүлбэрийг хэрхэн хэрэглэснийг тайлбарлана уу? Жишээ нь:

“Салхины эмгэн одоо л нэг тулмаа уяж дээ. Бид ч гэсэн хөгшин ясаа амраа даа гэж Батбаяр сүүлийн удаа малаа эргэж нэг үзэв” (Б.Р) гэхэд “салхины эмгэн тулмаа уя-, ясаа амраа-, сүүлийн удаа” гэсэн хэлц холбоо үг, өгүүлбэр оржээ. Үүнд:

ЯС

Хүн амьтны бие төрхийг гаргадаг тулгуур, хатуу эд (үндсэн утга)

Яс нь махны дотуур байх тул “яс мах”

Яс махыг холбох шөрмөс болох тул “яс шөрмөс”

ясны дотор тослог чөмөг байх тул “яс чөмөг” гэсэн зэрэгцсэн хоршоо үг бүтнэ.

“яс амар” гэхэд “яс” хэмээх үг үйл үгэнд захирагдаж, бүхэл бие цогцсыг орложээ. (солин нэрлэх буюу орлол)

“яс амар-, ясаа амраах” гэсэн хэлц өгүүлбэрийг уран зохиолын найруулгад түлхүү хэрэглэж, бусад найруулгад “бие сэтгэлээ амраах” гэж хэрэглэнэ.

СҮҮЛ

Толь бичигт “Мал гөрөөс зэрэг амьтны нурууны ясны үзүүр этгээдийн яс”-ыг “сүүл” гэж тайлбарласан нь уг үгийн бодит утга бөгөөд амьтны ясны нөгөө этгээд нь толгой юм.

Ингэж “эх адаг” гэсэн утгатай “толгой сүүл” хэмээх хоршоо үг бүтнэ. Энэ бол сүүл хэмээх үгийн хийсвэр утга юм.

Амьтны сүүл нь биеийнхээ адаг буюу эцэст байдгаас “дараа хожим” гэсэн салаа утга бий болжээ. Үүнээс “сүүлд орох, сүүлийн үе” гэсэн цагийн утгат холбоо үгс бүтжээ.


Найруулгад “сүүлийн үе-сүүлний үе” гэж “-н”-тэй “-н”-гүйгээрээ ялгарах болжээ. Ийм хоёр үг бий болсон нь адилтгалын аргаар салаалсантай холбоотой.

- а. Хээр халзан нь эзнийхээ уяран баярласныг мэдсэн мэт зуузай цагаригтай хазаар юугаа дарж, омголон цог бадарсан хүнхэр нүдээ гялалзуулан, сайхан хагсарснаас өнгө зүс нь хилэн торго шиг болсон урт сайхан зоо юугаа хотолзуулан тойрч авай. Тийнхүү Галшарынхны Хангайн хар хэмээн хочилсон ядуу малчин Дагдан хээр халзандаа их наадмын хүрээнээ түмний эхийн цол дуудуулж, улсын наадмын тэргүүн бай аваад, уулын чинээ урамтай, уул нутагтаа буцлаа.
- б. Улаанбаатараас гаран гартал нь моринд хорхойтой, энгэр тостой баячууд хоргоож, хаш манан соруул, хатир жороо морь, хамба торго, халиу булга цөмийг тоочин, үнэ хаяж, нэхүүл дагуул мэт салахгүй нэг хэсэг зовоожээ. Гэвч Дагдан ам тосодсон морин эрдэнэ, амин сүнс нь болсон ганц бор хүүгийнхээ унааг авдар алтаар ч өгөхгүй гээд халхгар баячуулыг хавьтуулсангүй. (С.Э)



Дасгал 25

Хэлцийн үүдэл ба гол санаа, уран дүрслэлийг тайлбарлаарай.



- | | |
|---|--|
| <ul style="list-style-type: none"> - Нар баруун хойноос навтас нөмрөөд гарах - Саваагүй нохой саранд хуцах - Үйлээ үзэж, үсээ тоолох - Хужирхай нь тэнийх - Өрөөлтэй морь гүйцэхээ байх - Хамраараа газар хатгах - Яс хаях - Элс үмхэж, эрэг мэрэх - Ханан гэр нь холдож, хадан гэр ойртох - Ааг идсэн илжиг адуу дагаж гүйх - Салхины эмгэн тулмаа уях - Нүдний хор гаргах - Даахгүй нохой булуу хураах - Үхэр алаад, ахар сүүлэн дээр нь - Хоосон ам, шалдан гуя - Борооны түрүү шороо Боохойн түрүү хэрээ Богдын түрүү элч | <ul style="list-style-type: none"> - Маргаашийн өөхнөөс Өнөөдрийн уушги - Амташсан хэрээ арван гурав дахих - Алга урвуулахын хооронд - Арьс махтайгаа хатах - Аягатай цай руу шороо цацах - Батганы хошуу багтахгүй - Буруу ишилсэн сүх шиг - Гал усны гашуун зовлон - Гар зүсчих шахсан - Гүзээнд наалдсан дэлүү шиг - Данс дугуйлах - Дээгүүр доогуур гүйх - Загатнасан газар маажсан юм шиг - Зогдор хөдөлгөх - Зүүд зэрэглээ болох - Модон өмд өмсчихсэн юм шиг - Нар сар гэрэлтсэн |
|---|--|




НИЙТЛЭЛ

НИЙТЛЭЛ УНШИХ

- Нийтлэл дэх зохиогчийн мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодол, үнэлэмжийг уран дүрслэлийн талаас задлан шинжилж, тайлбарлая
- Нийтлэлийг уншиж, бүтэц, агуулга, утга хэлбэрийн уялдаа холбоог хам сэдвийн хүрээнд тайлбарлая
- Уран нийтлэлийг сэдвээр нь ангилъя
- Уран нийтлэлийн онцлогийг тодорхойлъё
- Уран нийтлэл эсээнээс ялгаатай болохыг тайлбарлая

НИЙТЛЭЛ БИЧИХ

- Уншигч, зорилго, нөхцөл байдалд тохируулан бүтэц, хэв маягийг сонгон бичье
- 

НИЙТЛЭЛ УНШИХ

Уран нийтлэл

- Цаг үеийн бодит хэрэг явдлаас томоохон асуудлыг дэвшүүлдэг.
- Бодит хэрэг явдал, баримтыг уран зураглалын өнгө аястай хослуулдаг.
- Уран нарийн хурц дайчин үгийн нөлөө боломжоор итгүүлэн үнэмшүүлдэг.
- Хэрэг явдлыг оюуны үнэт зүйлтэй холбон, яруу тайлбарлахдаа өөрийн үнэлэлт дүгнэлтийг олон нийтэд зориулдаг.



Дасгал 26

Эхийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Зул

Өргөн их тасалгааны үүдийг нээмэгц хоёр хуруу лааны гэрэл сүүмийн үзэгдэж, холоос ирсэн зочны урмыг эвдэх нь тун ч уйтгартай байтал удалгүй цаад тасалгааны дотроос залуу бүсгүй гарч ирэн, чийдэнгийн товчийг мушгимагц түүний зүрхний дотор нь басхүү зул ноцож, сэтгэл хөгжөөд, даруй бийрийг авч, шүлэг зохион эхлэв.

Д.Нацагдорж

а. Нийтлэлийн бүтцийг түлхүүр үгээр тоймлосныг ажиглаад, тайлбарлаарай.

зочин – лаа  чийдэн – бүсгүй

зул
шүлэг

- Хэдэн цогцолбороос бүтсэн бэ?
- Зохиогчийн уран сэтгэмж, үзэл бодол, үнэлэмж дүгнэлт хэрхэн илэрснийг ярилцаарай.
- Чөлөөт уран зураглал, бодит баримт хоёрыг хэрхэн хослуулсныг тайлбарлаарай.
- Улс орны дэвшил хөгжлийн талаар ямар мэдээлэл өгч байна вэ?
- Эхийн сэдэв, санааг тайлбарлаж, уран нийтлэлийн талаар дүгнэлтээ хэлээрэй.

Уран нийтлэл нь зохиогчийн уран сэтгэмж, үзэл бодол, үнэлэмж дүгнэлт давамгайлсан олон түмний урмыг сэргээж, ухааныг тэлсэн, чөлөөт уран зураглал, бодит баримт хоёрыг хосолсон тайлбар бүхий нийтлэл - уран сайхны богино чөлөөт эх юм.

“Зул” уран нийтлэл нь уран зураглал, бодит баримт хоёроос бүтжээ. Нэгхэн нийлмэл өгүүлбэрээр бүтсэн богино уран нийтлэлд лааны гэрлийг чийдэнгийн гэрэлтэй харьцуулсан нь монголд цахилгаан гэрэл нэвтэрч буй дэвшлийг үзүүлсэн бол залуу бүсгүйг үзмэгц зочны зүрхэнд бас зул ноцсоныг урнаар илэрхийлжээ.

Нийтлэл дэх зохиогчийн мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодол, үнэлэмжийг уран дүрслэлийн талаас шинжилж, тайлбарлая



Дасгал 27

а. Эх нь зохиогчийн үнэлэмж бүхий уран зураглал болсон гэдгийг ямар жишээ баримтаар баталсан байна вэ? Ярилцаарай.

Буянт-Ухаа

Буянт-Ухаа гэдэг нэрийг анх сонсоход, аавын минь мөр тохойд нь гарын тос арчсан хул торгон тэрлэг давын өмнө санаанд орж билээ. Ардын дуу шиг энэ нэрийг дахин дахин сонсох бүрий үүрийн сэрүүнд нялх унага тэнцэн босох намжаа толгод, олон адууны хөлөөр алтран босох шаргал тоос сэтгэлд буудаг байлаа.

Олон жилийн баяр наадмын тос буян шингэсэн энэ талбар саяхан хурдан морьдын барианы газар байсан бол эдүгээ монгол хүнд цэнгэлийн жигүүр ургуулах гарааны газар болжээ.

Буянт-Ухаа ирэх шувуудаа хүлээх хаврын нуур шиг тэнгэр ширтэж байна. Тэнгэр ширтэх билгүүн мэлмий нь алтан гадас од лугаа замбуулин хурмастын тохиох орд байна.

Тэнгэрт аялахад дэлхийн минь нэр Буянт-Ухаа

Газарт явахад гэрийн минь нэр Буянт-Ухаа. *Ж.Лхагва*

Монголчуудын цэнгэлийн манлай болсон их баяр наадмын талбар Буянт-Ухаа хурдан морьдын барианы газар байснаа нисэн ирэх, одох зочдын жигүүр ургуулах буудлын газар болсон тухай зураглан өгүүлсэн нь угтаа монголчууд дөрөө жийх хүлэг мориноосоо гадна жигүүртэн мэт зорчих хөлөг онгоцтой болсон хэмээх санааг гаргажээ. Өөрөөр хэлбэл, улс орон маань хөгжин дэвжиж, хот маань хаяа тэлэн өргөжиж байгааг энэ уран нийтлэлд харуулжээ.

Энэ уран нийтлэлийн дүрслэх ба найруулах ур маягийг дараах байдлаар тодруулж болох юм.

Дүрслэх ур маяг




1. Ардын дуу **шиг** энэ нэр, хаврын нуур **шиг** ширт-, билгийн мэлмий нь **алтан гадас од лугаа адил**
2. а. **Алтран босох шаргал тоос, цэнгэлийн жигүүр ургуулах**, билгүүн мэлмий нь **замбуулин хурмастын тохиох орд**, баяр наадмын **тос буян шингэсэн**
 б. **Буянт-Ухаа** гэдэг нэрийг анх сонсоход аавын минь мөр тохойд нь гарын тос арчсан **хул торгон тэрлэг** давын өмнө санаанд орж билээ. **Энэ нэр** (Буянт-Ухаа)-ийг сонсох бүр **намжаа толгод, шаргал тоос** сэтгэлд буудаг байлаа.
3. **Санаанд** ор - гэвэл “санаа” нь тархи толгойд үүсэх тул багтах багтаах орон зайн харьцаагаар үзвэл “санаа” нь толгойг орлон нэрлэжээ. Үүнчлэн **“сэтгэлд буу-”** гэдэг нь орлол болно. “барианы газар, гарааны газар” гэхэд “газар” нь “буудал”-ыг орлон нэрлэжээ.
4. “Адууны **хөлөөр**” гэхэд бүхлийг хэсэг (хөл)-ээр төлөөлсөн бол баяр наадмын **“тос, буян”** гэдгийн **“тос, буян”** нь “идээ цагаа” гэсэн ерөнхий нэрийг “тос” гэсэн

тодорхой нэрээр төлөөлөн нэрлэжээ. “Өвөг дээдсийн өвлүүлсэн эд хөрөнгө” гэсэн бодит утгыг хийсвэр утгатай “буян” хэмээх үгээр төлөөлүүлжээ.

“Ирэх шувуудаа хүлээх нуур” гэхэд “нуур”-ыг амьдчилан дүрсэлжээ. “Давын өмнө” гэдэг нь “дав хийхийн өмнө” гэснээс хураагдаж, “давын өмнө” болсон ба “дав” гэдэг нь авиа дуурайх үг юм. Иймд уг үйлийг “юуны түрүүнд, бүхний өмнө хийх” гэсэн хэтрүүлэг болно.

Чимэг үг: хул торгон тэрлэг, намжаа дэлхий, шаргал тоос, алтран босох тоос, Буянт-Ухаа, билгүүн мэлмий, алтан гадас

Найруулах ур маяг



- Давтах:** дахин дахин сонсох, тэнгэр ширтэж, Буянт-Ухаа
- Хорших:** ...хул торгон тэрлэг... санаанд орж билээ.
...шаргал тоос сэтгэлд буудаг байлаа
...энэ талбар саяхан хурдан морьдын барианы газар байсан бол эдүгээ монгол хүнд цэнгэлийн жигүүр ургуулах гарааны газар болжээ.
Тэнгэрт аялахад дэлхийн минь нэр Буянт-Ухаа
Газарт явахад гэрийн минь нэр Буянт-Ухаа
- Цөөлөх:** Буянт-Ухаа гэдэг нэрийг анх сонсоход аавын минь мөр тохойд нь гарын тос арчсан хул торгон тэрлэг давын өмнө санаанд орж билээ.
Олшруулах: Ардын дуу шиг энэ нэрийг дахин дахин сонсох бүрий үүрийн сэрүүнд нялх унага тэмцэн босох намжаа толгод, олон адууны хөлөөр алтран босох шаргал тоос сэтгэлд буудаг байлаа.
- Санаа онцлох:** ...мөр тохойд нь гарын тос арчсан... тэрлэг
...үүрийн сэрүүнд нялх унага тэнцэн босох...
...олон адууны хөлөөр алтран босох...

Хэрэг явдалд зохиогч хэрхэн хандаж, оролцож байгаагаа “анх сонсоход, давын өмнө, санаанд ор, сонсох бүрий, сэтгэлд буу-” зэрэг холбоо үгсээр, мөн “аавын минь, дэлхийн минь, гэрийн минь” гэхчлэн нэгдүгээр биеийн хамаатуулах нөхцөл, өгүүлэгчид мэдэгдэж буй утга бүхий саяхан төгссөн цагийн “-лаа”, одоо цагийн “-на” нөхцөлөөр илэрхийлжээ.



Үгсийн тайлбар:

ухаа - тал газар буй өндөрхөн зоо газар, ухаа гүвээ, ухаа толгод

намжаа - дөлгөөн тайван, амар амгалан

билгүүн - цэцэн ухаантай

замбуулин - манай дэлхийн өөр нэр. Мөн замбуутив, замбатив, замилан (хорвоо, дэлхий) гэж хэд хэдэн хувилбараар хэлдэг үг юм. “замбуу” нь Энэтхэгт ургадаг модны нэр, “лин” тив гэсэн үг

хурмаст - гучин гурван тэнгэрийн эрхэм нэг тэнгэрийн нэр. Хан хурмаст (эзэн тэнгэр), хурмастын үүл (тэнгэрийн үүл), мөн “хормост” гэх ба “гэрэл хийгээд сайн эхлэлийг бүтээх тэнгэр” гэсэн утгатай ажээ.

б. Хоёр бүлэг үгсийн аль нь адилтгасан, аль нь эс адилтгасан утгатай байгаагийн учрыг тайлбарлаарай.


алт-р-	алс-р-	хаяа-р-	догш-р-
мөнгө-р-	амьд-р-	ямаа-р-	онцгой-р-
сувд-р-	тоос-р-	соёо-р-	алмай-р-
туяа-р	нугал-р	нохой-р-	даахь-р-
солонго-р-	явцуу-р-	том-р-	зас-р-
сүл-р-	ноол-р-		



Дасгал 28


Уран нийтлэлийн бүтэц, утга, дүрслэх ба найруулах ур маягийн тайлбарыг нягтлан уншиж, ярилцаарай.

Цаг ирвээс



Би цэцэрлэгч бүлгээ. Цэцэглэгтээ сэтгэлийн яруу цэцгийг энхрийлэн ургуулнам билээ. Хүмүүний нүднээ үл үзэгдэх арвис илбийн тунгалаг өнгөт сэтгэлийнхээ цэцгийг төрсөн нутгийнхаа алтан наранд ээлгэж, долгилогч зүрхнийхээ халуухан цусаар тордон ургууллаа, би. Хорт муу нүднээс энхрийлэнхэн хамгаалж, цэцэглэгт орох зам үүд хаалаа, би. Гагц цаг ирвээс, миний цэцэглэгийн хаалга өөсөөн нээгдэж, журамт амраг орогсдоо босгын

өмнө бахданхан угтаж, хүжсийн үнэр анхилсан сэцэглэгтээ удирданхан оруулмуу, би. Тэгээд сэцэглэг минь түмний баярын сэцэглэг болжуу.



Би санг хадгалагч бүлгээ. Сэтгэлийнхээ яруу эрдэнэсийг сандаа энхрийлэн хадгалнам билээ. Хүмүүний нүднээ үл үзэгдэх арвис илбийн хурц өнгөөр эрдэнэс минь гилбэлэнхэн, алаг зүрхний минь гал улаан цус гялалзан байгаа нь тэр буюу. Муу нүднээс энхрийлэн хамгаалж, эрдэнэсийн санд орох зам үүд хаалаа, би. Гагц цаг ирвээс миний эрдэнэсийн сангийн хаалга өөсөөн нээгдэж, журамт амраг орогсдоо босгын өмнө бахданхан угтаж, гялалзанхан гилбэгнэсэн эрдэнэсийнхээ санд удирданхан оруулмуу, би. Тэгээд эрдэнэсийн сан минь түмний түгээлийн сан болжуу. *Б.Ринчен*




Үгсийн тайлбар:

- өөсөөн* - өөрсдөө, өөрснөө, тухайн зүйлд хамааралтай хүмүүс орогсод- орогч хүмүүс
- арвис* - 1. оюун ухаан, эрдэм мэдлэг
2. шившлэг тарни.
- арвис ухаан* - буддын шашны нууц тарнийн ухаан гагц- гагцхүү, зөвхөн, ялангуяа, нэн ялангуяа
- болжуу* - юу - одоо ирээдүй цагийн хүндэтгэх утгатай нөхцөл ардаа эгшигтэй учраас шууд залган бичнэ.
- цэцэглэг, сэцэглэг* - хамжин шүргэх "ц" гийгүүлэгчийг шүргэх "с"-ээр сэлгэж, хүндэтгэлийн аястай болгосон.

Энэ уран нийтлэл нь

1. Хоёр цогцолбороос бүтэж, цогцолбор бүр нь хоёр дэд цогцолбороос бүтжээ. Үүнд:



“би” хэмээн цэцэрлэгчийг зохиолчтой, цэцэг цэцэглэгийг зохиол бүтээлтэй тус тус адилтган дүрсэлжээ.

2. “Цэцэрлэгч цэцэглэгтээ сэтгэлийн яруу цэцгийг муу нүднээс хамгаалан ургуулж, цэцэглэгийн санг бүтээж, цаг ирвээс цэцэглэгтээ журамт сайн нөхдөө удирдан оруулж, түмний баяр, түмний түгээлийн сан болно” гэсэн хэрэг явдал нь угтаа зохиолч уран бүтээлээ туурвин, түмэн олны магнай тэнийлгэх болно гэсэн санаатай ажээ.

Энэ нь зохиолч Д.Батбаярын хэлснээр цэцэг “бүтээхүй” бол бүтээн туурвихуй. Бүтээн туурвихуйн үйлийг өнө эртнээс чимхлүүр ажил ихтэй, нарийн нямбай хөдөлмөр гэж үзсээр иржээ. Зарим хүн үүнийг шүүдрийн дусал түүж, цай чанахын дайны ч гэж үздэг.

Энэхүү уран нийтлэл нь нэн ерөнхий өргөн хүрээтэй хэрэг явдлыг үзүүлжээ.

3. “Би” гэдэг зохиогч ч байж болно, эсвэл уншигч ч байж болно.

би - **цэцэрлэгч**,

зохиол бүтээлийн хөмрөг - **цэцэглэг**

үг хэллэг - **сэтгэлийн яруу цэцэг**

мэдрэмж - **зүрхний халуун цус**

атаач матаач - **хорт муу нүд**

сэргийлэн хамгаалах - **зам үүдийг хаах**”-тай тус тус адилтган өгүүлснээс гадна

“яруу цэцэг

халуухан цус

цэнгэл баярын цэцэглэгч

алаг зүрх

түмний түгээлийн сан

энхрийлэн хамгаал-

гэх мэт чимэг үгсийг олонтоо хэрэглэжээ.

тунгалаг өнгөт сэтгэл

хорт муу нүд

сэтгэлийн яруу эрдэнэс

улаан цус

энхрийлэн ургуул-

бахданхан угт-

долгилогч зүрх

журамт амраг орогсод

арвис илбийн хурц өнгө

эрдэнэсийн сангийн хаалга

тордон ургуул-

гялалзан гилбэгнэсэн эрдэнэс”

Мөн “арвис илбийн (арвис илбэс мэт), алтан нар, гал улаан цус зэрэг адилтгал ч тохиолдож байна.

Сэтгэлийн яруу цэцгийг энхрийлэн ургуулнам, би

“Сэтгэлийнхээ яруу эрдэнэсийн сандаа энхрийлэн хадгалнам билээ” гэхэд “сэтгэл, яруу, энхрийл-” хэмээх үгийг давтахын зэрэгцээ, “цэцэг”-ийг “эрдэнэсийн сан”-аар, “ургуулна” гэдгийг “хадгална” гэж сольсон байна.

Эхний цогцолборт “тунгалаг” хэмээхийг дараагийн цогцолборт “хурц” хэмээгч үгээр сольсон шиг “долгилогч зүрхнийхээ халуун цус” гэснийг “алаг зүрхний минь гал улаан цус”, “миний цэцэглэгийн хаалга өөсөөн нээгд-” гэснийг “миний эрдэнэсийн сангийн хаалга өөсөөн нээгд” гэх мэтээр үгсийг давтахын хамт нэг гишүүнийг өөр гишүүнээр сольсон байдаг нь энэ нийтлэлийн урлах онцлог мөн.

4. “би” буюу зохиогч, эсвэл уншигч уг нийтлэл дэх хэрэг явдлыг удирдан гүйцэлдүүлж байгаагаас гадна “би”-д өртөж буй юмсыг нэрийн эзэнд хамаатуулах “-аа”, нэгдүгээр биеийн хамаатуулах “-минь” нөхцөлийг хэрэглэн өөртөө хамаатуулжээ.

цэцэглэгт-ээ	цэцэглэг минь
сэтгэлийн(х)-ээ	эрдэнэс минь
санд-аа	зүрхний минь
нутгийн(х)-аа	сан минь
зүрхний(х)-ээ	
өөс-өөн	

Мөн “би” хэмээх нэгдүгээр биеийн төлөөний үгийг долоон удаа давтсан ба үүний харьяалахын тийн ялгалын хувилбар (миний)-ыг хоёр удаа давтжээ. Энэ мэтээр давтсан үг нь эхийн холбоц болжээ. Түүнээс гадна “-нам, муу, юу” хэмээх сонгодог бичгийн хэлнээ арвин хэрэглэгддэг төгсгөх нөхцөлийг давтан хэрэглэж, найруулгад эрхэмсэг хүндэтгэлийн өнгө аяс нэмжээ.

Нийтлэлийг уншиж, бүтэц, агуулга, утга хэлбэрийн уялдаа холбоог
хам сэдвийн хүрээнд тайлбарлая



Дасгал 29

Уран нийтлэлийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Салхич шувууны дуун

Тэнгис далайн буурал мандал дээгүүр салхин, үүлсийг хуралдуулан, үүл далайн завсраар салхич шувуун, харанхуй цахилгаан мэт халин элэн дэгдэнэ.

Тэр шувуун, жигүүрээр долгионыг гэнэт дайран, нэгэнт үүл харвасан сум мэт дэгдэн дэгдэж, дуугаран явахад, үүлс түүний эрэлхэг дуунд, баярын чимээг сонсон байв. Тэр дуун их салхийг хүсжээ. Тэр дуун хилэнгийн агуу хүчир, хүслэнгийн цог, ялахын үнэмшлийг дуурсган бийг үүлс сонссон байв.

Цахлай шувуун, их салхийг зөгнөн гасална. Ахууна шувуун мөн эмээн гасалж, амьдрахын байлдаан, тэмцлийн хав цэнгэлийг мэдэхгүй, тулалдагчийн аянга мэт дуунаас хэлмэгдэн цочно. Тэнэг пингвин тарган биеэ гадна нуун далдлаад, ганц эрэмгий омогт салхич шувуун буурал хөөс бургих тэнгис далайн дээгүүр элэн халин ниснэ.

Үүлсийн чуулган улам харанхуй болон тэнгис далайн зүг нэн ойртон буухад долгио аянгын зүг тэмүүлэн сөрнө.

Тэнгэр дуугаран, долгио догшрон, хөөс сахран, салхитай тэмцэн цуугилдана. Салхин хоосон уурсаж, индранил эрдэнийн өнгөт долгиныг хаднаа товрог болтол балбалан цохилно.

Харанхуй цахилгаан мэт салхич шувуун хашхиран хальж, үүлсийг сум мэт нэвтрэн жигүүрээр долгины хөөс хярган дэвж, их салхины омогт шулам мэт элэн халин, инээн уйлан, үүлсийг элэглэн инээж, бахдан баясан хүрхрэн уйлна. Аянга хүрхрэн хилэгнэхийн дотор цочин алжаасныг хэдийнээ сонор шулам мэт мэдээд, үүлс удтал нарыг халхлан далдалж үл чадахыг таньсан байна.

Салхи урхиран... аянга хүрхрэн... тэнгис далайн гүн усан дээгүүр үүлсийн сүрэг, хөх толон татан, далай аянгын сумыг шүүрэн барьж усны гүнээ сөнөөхөд толон туяа нь гал могой мэт яралзан мушгилзаж мөхнө.

Их салхи, их салхин хөдөлнө гэж дуудагч, энэ бол эрэлхэг салхич шувуу, хилэгнэн урхирагч тэнгис далайн дээгүүр цахилгааны завсраар элэн халин нисэх бөгөөд энэ бол ялахыг зөгнөн мэдэгч “Их салхин хөдөлбөл нижигнэнхэн хөдөлтүгэй” гэж хашхиран дуудна. *М.Горький*

- а. Нийтлэлийг уншиж, сэдэв ба гол санааг тодорхойлоорой.
- б. Эхлэл, гол, төгсгөл хэсгийг зааглаарай.
- в. Дүрслэх ба найруулах ур маягийг тайлбарлаарай.
- г. Зохиогчийн санаа, эхийн өнгө аясыг тодорхойлоорой.
- д. Найруулгын хэв шинжийг тайлбарлаарай.



Үгсийн тайлбар:

салхич шувуу - Салхи сөрж нисэхдээ сайн. Мөн далайн хараацай гэнэ. Өд нь харавтар хүрэн, савар нь хар бөгөөд сарьстай, үргэлж далай дээгүүр халин нисэж, жижиг загас, сам хорхойгоор хооллодог, хараацайтай төстэй шувуу
ахууна - Хөвсгөл, Хэнтий, Хангайн их уулсын тайга, таг, царамд нутагладаг, өвөл цагаан, зун бор цоохор болж, зүс нь хувирдаг агнуурын шувуу.

пингвин - Оцон шувуу, өмнөд хүйтэн далай, Антарктид, Өмнөд Америк, Африк, Австрали тивийн эргээр нутагладаг, бараан саарал зүстэй, цагаан хэвлийтэй, зөөлөн өтгөн өд ноолууртай нисдэггүй шувуу.

индранил - “эрхэт” гэсэн утгатай. “индра”, “нила” гэсэн үгээс бүтсэн, хөх өнгөтэй хатуу эрдэс, эрдэнийн чулуу

толон - Өглөө үдшийн нар сарны гэрлээс ойсон үл мэдэг цайвар гэгээ, монгол хэлнээ “с, т” гийгүүлэгч сэлгэх тул “солонго” хэмээх үгтэй гарал нэг болно.

Уран нийтлэлийг сэдвээр нь ангилъя



Дасгал 30

Уран нийтлэлийг дараах байдлаар ангилсан байдаг. Ингэж ангилахын гол шалгуурыг тайлбарлан ярилцаарай.

Ухаарал
бодролын
тухай

Д.Батбаяр “Үг” (Амрагийн тэнгэр, Уб., 2000)

Шинжлэх
ухаан
техникийн
тухай

*Ч.Эрдэнэ “Түүхэн товч”, “Дорно ба өрнийн ялгаа зөрөө”,
(Их гурвалжин, Уб., 2002),
Л.Түдэв “Мэлмий”, “Тархи”, (Дал №29)*

Нийгэм
улс төрийн
тухай

*С.Эрдэнэ “Алтай”, “Миний эх орон-Миний тоонот”, (Уб., 1978)
“Мөнгөн хазаарын дууль”, (Шилмэл өгүүллэгүүд, Уб., 1988)
Л.Түдэв “Босоо ухаан” (Дал №230)*


Урлаг
соёлын
тухай

*О.Дашбалбар “Мөнхийн бүтээлүүд мөхлийн ирмэг дээр”,
“Миний нээсэн эх орон”
Д.Батбаяр “Намдагийн хүчирхэг хүмүүс”,
(Сайхныг бүтээхүйн нууц, Уб., 2016)
“Тулгуур болгон ашигласан зарим нэг ном зохиолын тухай
ойллого”, (Бүтээхүйн зүй тогтол, Уб., 2007)
Д.Нацагдорж “Пионерийн гэгээрэл боловсролын тухай”
(Бүрэн түүвэр Уб., 1996)*



Дасгал 31

Уран нийтлэл нь найруулгын хэв шинжээрээ ялгаатай болохыг хураангуйлж үзүүлэв. Найруулгын хэв шинж тус бүрийн гол онцлогийг тайлбарлаарай.



1

Үүлэн завсраар нар шагайлгалгүй өдөржин шөнөжин бороо оров. Өмнө, умар, зүүн баруун уулс өөхөн цагаан манангаар устаж, өлмий өсгийнөөс борооны ус жаргалтайгаар жиндүүлээ. Сайхан, сайхан хөх бороо хонон өнжин зүсрэхүйеэ данхнаа борцтой цай зөөгшиж нэг, ууршиж нэг халах байдал сэтгэлд төсөөлөгдөх нь нүүдэлчний явдал л. Ертөнцийн тоос ертөнцийнхөө бороонд урсаж одоод, моддын зулзаган навчис дээр харин усны тоос зөрөн ирээд төвхнөчихжээ. Бороон дусал хэн дээр, юун дээр ямар өнгөөр, ямар авиагаар өлмийдөн унана вэ? Ямар үзэгдэл, ямар үзэгдлийг, юуны мөн чанар, юугаар солигдсоноо үгүйлүүлнэм бэ? Ажлынхаа газрын цонхоор харж ээ зогсохноо, цахилгааны утас хуйвын гэдэс шиг унжина. Байшингийн адраас дүүжлээстэй энэ унжуургаас усны дусал унжин санжин шал шол хийн унана. Уяатай морины цулбууртай ч адилхан юм уу. Уяан дээр бөмбөгнөж, туурай нь дэвтсэн морины цулбуур тайлж шивхэрвэл ч үү.

Б.Золбаяр. "Борооны тоос", 2006

Байгалийн улирлыг нүдэнд үзэгдэж, сэтгэлд харагдтал дүрсэлсэн уран нийтлэлийн хэсэгт "Ертөнцийн тоос, ертөнцийнхөө бороонд шингэдэг ч эргээд дахин өөр тоос болдог шиг юмс үзэгдэл нэг нь нөгөөдөө уусан шингэдэг." гэсэн гүн ухааны аясыг илэрхийлсэн бөгөөд "Бороо" нь энэ цогцолборын сэдэв юм. Б.Золбаярын энэ бодролыг Б. Явуухулан "Бороо" шүлэгт үйлийн тодотгол, нэрийн тодотгол гишүүн өгүүлбэрүүдийг тэгшлэн зэрэгцүүлж, байгалийн уран яруу зураглал бүтээсэнтэй харьцуулж болох юм. Шүлэгт "Цөхөртөл хүлээсэн бороо орж Шарлатал төөнөсөн ган тайлав Нэвсийтэл уйтгарласан ой тайга сэргэж Нэвтэртлээ ундалсан газар ногооров. Чилтэл хүлээсэн хүүтэйгээ уулзсан Буурал эхийн баярын нулимс шиг Чилгэршсэн навчнаас ус бөнжигнөн Бөөн бөөн дусал газарт унав" гэсэн байдаг. Ухаарал бодролын өнгө аяс бүхий "Борооны тоос" эхэд хөх бороо, усан бороо, бороон дусал, борооны шинж чанарыг байн байн дурдах тул, дүрслэн тоочих хэв маягт хамаарах ба "Ертөнцийн юмс үзэгдлийн далд мөн чанарыг" өгүүлжээ.

2

Мэлмий маань хүн хүнд ижил мэт боловч өнгөөрөө таван янзаар ялгарч, хар нүдэн, цэнхэр нүдэн, ногоон нүдэн, хонин бор нүдэн, зэгэл саарал нүдэн хэмээн яригддагаас гадна таван давхар бүрхэвчтэй, мянга гаруй хүлээн авагчтай, маш нарийн бүтэц бүхий нандин эрхтэн гэдгийг эмч нараас өөр хүн төдийлөн сайн мэддэг гэхэд эргэлзээтэй ажээ. Мэддэг байсан сан бол, хүн амын ялангуяа хотын иргэдийн гурав дахь хүн бүр нь хараа муутай, мэлмийн гажигтай болчихгүй сэн билээ. Монголчууд энэ зууны эхэн үед хурц нүдтэйгээрээ гайхагдаж байсан юм.

Л.Түдэв "Мэлмий" Дал сонин №30

Шинжлэх ухаан техникийн тухай энэ цогцолборт "Нүдний өнгө таван янз байдаг" гэсэн ерийн ойлголтыг "Нүд нь таван давхар бүрхэвчтэй, мянга гаруй хүлээн авагчтай" гэсэн шинжлэх ухааны ойлголттой харьцуулан, "Хотын хүн амын гурав дахь хүн бүр нь хараа муутай, мэлмий гажигтай болчихгүй сэн билээ" гэж дүгнэсэн тул эргэцүүлэх найруулга болно. Энэ цогцолборыг "Эвклид, Птомлей зэрэг эрдэмтэд "Нүдний хараа бол нүднээс гарсан цацраг биет дээр ойж, тэгснээр бид хардаг" хэмээн үзэж байсан бол Араб- Персийн тоо зүйч Альказен сүүдэр болон ойлтыг ажиглаж "Гэрэл эхлээд биетээс ойж, шулуун шугамаар бидний нүд рүү ордог" гэсэнтэй харьцуулж болох юм.

3

Ер бусын гайхамшигт сайхан хийгээд ёс бусын муу муухайн цогцлол бол урлаг уран зохиолд байдаг. И.В.Гёте “Би тэр муу хүмүүс гэдгийг чинь сайн сайхныг юүлэх сав гэж үзсэн юм. Ингэснээрээ би яруу сайхныг дүр дүрслэлт бүрэн бүтнийг буй болгож чадсан юм. Хэрвээ би сайн сайхан хүмүүсийг сайн сайхан хүмүүсийн дунд гаргасан бол тийм юмыг хэн тоож унших билээ дээ” гэж хариулсан байдаг. Муу хүн байдаггүй сэн бол сайн хүн яаж байх билээ. Орчлон ертөнцийн зохилдолгоо нь ийм юм.

Д.Батбаяр “Бүтээхүйн зүй тогтол буюу сайхныг бүтээх нууц”

Урлаг соёлын тухай сэдэвт энэ цогцолбор нь “Муу хүн байдаггүй сэн бол сайн хүн яаж байх билээ. Орчлон ертөнцийн зохилдлого нь ийм юм” гэсэн санааг И.В.Гётегийн хэлсэн үгээр баталсан учраас тайлбарлах найруулга болно. Д.Нацагдорж “Сонин ба зохиолч” нийтлэлдээ “Эдүгээ үед таван тив нь сонин сэтгүүлээр бүрхэгдэж, сонин сэтгүүл нь бүх дэлхийг бужигнуулан буй бөгөөд энэхүү шинэ цагийн сонин сэтгүүлгүйгээр шинэ ертөнц тогтнож хэрхэвч чадахгүй болой. Нэг хэдэн үгээр түүний учрыг товчлон тайлбарлаваас, “Сонин бичиг болбоос нийтийн сонирхож буй зүйлийг сонсгох ба хүсэж буй зүйлийг бүртгэх, эрж буй зүйлийг олгох бөгөөд олон ардыг нийтийн байдал лугаа танилцуулан холбоно” гэх мэтээр уг хэрэг явдлын учрыг тайлбарласан нь нийтлэлийн үндсэн шинж юм.

4

Боловсролтой хүн амьдралыг утга учиртай, зорилготой болгодог.

Боловсролын хүчээр хүн өөрийгөө төдийгүй нийгмээ, түүхээ, хүний болон амьд ертөнцийг, орчлон хорвоог мэдрэн, өөрийн байгаа цэгээ тодорхойлж чадна. Орчлон ба цагийн агуу ихийг мэдэрснээр энэ зайн дотор юу хийж, юу бүтээх ёстой нь ойлгогдож... орон зайд биш, цагт шүтэх бишрэл бий болно.

Амьдралын арван хувь нь хувь төөргөөс, ерэн хувь нь чиний түүнд хандах реакц*аас хамаарна.

Баабар “Дори идэр дүүдээ”

* реакц - үйлдлийн хариу

Энэ цогцолбор нь “Хүмүүсийн дунд амьдрахад боловсрол чиний зүг чигийг зааж өгнө” гэсэн гол санаатай бөгөөд хүн нийгмийн тухай бичихэд хэрэг явдлыг хүүрнэн өгүүлэх нь илүү дөт ажээ. Үүнийг Л.Түдэв гуайн “Цагаан ямаа” нийтлэлээс үзэж болно.

- Уул нь цагаан ямаа тэсвэр муутай ч гэсэн сүү сайтай, үржихдээ түргэн амьтан л даа гэж тэр өвгөн хэлэв.
- Үржихдээ түргэн гэж үү?
- Тийм ээ, тийм. Үрэгдэж хорогдохдоо амархан амьтан, үржихдээ бас түргэн байдаг юм. Заяа нь тэгж зохилддог юм байлгүй дээ. Айхавтар хурдан өснө, айхавтар хурдан ч хорогдоно. Хорогдохыг ч багасгаж болно л доо.
- Яаж багасгах вэ?
- Яах вэ дээ. Ердөө л хонин дотор өвөлжүүлдэг юм. Цагаан ямаа хонины бөөрөнд наалдаж, хүйтнийг өнгөрөөдөг юм билээ. Ноос ихтэй хонины хажууд хоргодож өвөлжөөд, зун түүнээ мартчихдаг юм... гэж өвгөн яриу.



Миний нээсэн эх орон

Миний багын төсөөллөөр эх орон бол тэнгэр, толгод хоёр байжээ. Эдүгээ он жил улирч, сайхан юм бүхэнд эх орон шингэсэн гэж би итгэдэг боллоо. Зөрж буй сайхан бүсгүйд эх орны нуугдмал дүр бий бөгөөд түүний хэвлийд хөдөлж эхэлсэн хүүхэд одот ертөнцтэй холбоотой, салхи шуургыг мэдэрч буй гэдэгт үл эргэлзэнэ. Сансрын хураангуйлсан биет бүсгүй хүний хэвлийд торниж буй нялх үр оддын тохиолоор бүтэн бүрэлдэхийн ид хавыг эдэлж, эхийн нь алхаанд цаг мөч агшин хэмжигдэхүй, хожмын өдөр хоёр хөл дээрээ бат зогсож, хязгааргүй орон зайн нээлттэй уудамд од мичид анивчихыг ширтэх хөвгүүнийг нь би миний болоод хүн төрөлхтний үр гэж мэдмүү!

Хэвлийдээ нялх үр тээсэн эх алхаж явна. Түүнд эх орон оршиж буй гэмүү. Миний өмнө зулзаган улиас навчсаа сэрчигнүүлэн найгалзана. Энэ модонд ч эх орон оршиж буй агаад навчис бүхэн нь намайг эх орны нүдээр харж байна. Бүх хүнд оршиж буй тэнгэрлэг хүчийг эх орон гэмүү. Хүн төрөлхтний мөрөөдөл дүрслэлийн хамгийн гэрэлт дүр нь эх орон байлаа. Түүнд л хамаг сайн сайхнаа шингээн бодож, хүслээрээ энэрэнгүй их үнэнийг буй болгон, түүндээ тэмүүлж, тэмүүлэл нь хүнийг бурханлаг болгодог байв.

Алтан-Овоо бол үнэхээр амилсан уул юм. Энэ уулыг хүн ард хэдэн зуун жил дараалан хайрлан биширч, тэрхүү олон зуун мянган хүний бодол санаа нэгэн цэг – энэ уул дээр төвлөрөн, хүн бүхний итгэл, хүсэл түүнд шингэж, ийнхүү энгийн нэг уулнаас эх орноо хайрлах хайр болтлоо бэлтгэгджээ. Өвөг дээдэс минь дэмий ч нэг энэ уулыг тахиж шүтээгүй ээ! Тэд нэг л юманд хайраа шингээх ёстой байсан юм! Бидэнд ирэх ёстой тэр мөнх хайрын бэлгэдэл нь Дарьгангын Алтан-Овоо буюу.

Тэгээд би үеийн үед хүний итгэл, нууц хүслэн шингэсэн уулыг харах бүр гурван зуун жилийн өмнө өвгийн өвөг минь энэ уулыг яг л над шиг ширтэн зогссон доо гэж бодном. Үүнээс үүдэн би энэ уулыг хайрлан биширсэн юм. Өвөг дээдэс минь энэ уулаар дамжин надтай уулзах гэсэн байжээ. Гурван зуун жилийн адагт энэ ууланд ирэх үр сад минь бас л миний адил Алтан-Овоог ширтэхүй дор, би орчлонд амьдарч яваагаа түүгээр дамжин мэдэрнэм. Ийнхүү Алтан-Овоо бол бодлын шидээр бүтсэн уул тул үнэн мөн гэмүү. Юуг шүтэж эхэлнэ, тэнд хайр оршино. Хаана хайр оршино, тэнд сайхан санаа, сайн үйл зэрэгцэнэ.

Эмэг эхийн яриаг өгүүлмүү.

- Эрт цагт нэгэн банди Баруун зууд эрдэм сурахаар одохуй дор, төрүүлж өсгөсөн эх нь Цагаан Дара эх бурхан бүтээлгэж ирэхийг захижээ. Хүү чанад нутагт ном гүйцээгээд, эргэх цагтаа эхийн захиасыг умартан, гагцхүү гэрийн гадаа ирсэн дор гэв гэнэт санав. Буцъя гэвч хожимджээ. Эхийн хүслийг эс гүйцэтгэсэн тул нүүр учрах хэцүү, ийн олбиргон бодолд автан газар ширттэл бөөрөнхий цагаан чулуу үзэгдэв. Хүүгийн дотор нэгэн бодол гялс хийх зуур нөгөөх чулуугаа яаран шүүрч, хив хадагт сайтар ороогоод өвөртлөв. Ингээд уулзсаны эцэст эхийн захиасыг биелүүлэв хэмээн хуурч, нөгөөх хадагт боолттой чулууг өгчээ. “Ээж минь үүнийг хэзээ ч задалж үл болно” хэмээн хатуу захив. Эх нь нутгийн чулууг насан эцэс болтол бурхан гэж итгэн тахисаар нэгэн өдөр ертөнцийн жам ёс тулж ирэв. Эх өгүүллрүүн:

- Хүү минь, би бурхандаа үнэн сэтгэлээсээ дөчин жил сүсэглэн мөргөв өө! Ямагт буяны мөр хөөж, хүсэл бүхнээ бурхандаа даатгалаа. Өнөө амьдын хорвоогоос одох цаг ирэв. Бурхнаа л нэг үзвэл сэтгэл гүйцмүй! гэжээ. Хүү яах аргаа эс олж, удтал дуугүй зогсож, эцэст нь үнэнээ хэлэхээр шийдэв ээ!

- За яах вэ, чулуу ч болсон үзье дээ, нэгэнт дөчин жил бурхан гэж итгэж, өдөр бодолдоо, шөнө зүүдэндээ үзэн тахисан учир харахгүй хагацаж үл чадна гэв. Хүү гүнээ гэмшин хадгаар ороосноо задалбаас тэнд чулуу бус шижир алтаар бүтээсэн Цагаан Дара эх бурхан өнгө үзэсгэлэн төгс гялалзаж байв. Үүний учрыг тайлах нь:

Бодолдоо үнэнхүү итгэж, бүхий л оюун санааны хүчээ нэгэн цэгт төвлөрүүлэн сэтгэж чадсанд оршмуу. Тэгж чадваас эс бүтэх юм нэгээхэн ч үгүй билээ.

Би нүүж яваа үүлсийн сүүдэр доор ганцаардан ахуйдаа эх орноо дуудмуу. Тэр залбиран хүлээх эх орон минь итгэл билээ. Тэрхүү итгэлийн хүчээр би бие, сэтгэл, оюун бодлоо ариусгаж цэвэрших болно. Эх орныхоо гоо сайхны оргилд хүрэх зам маань байгаль ээж буюу.

Байгальд хүрэх зам маань дотоод сэтгэлийн дээд зэргийн ариутгал буюу. Оюун санааны дээд үнэнд хүрэх замыг зөв үйл, зөв сэтгэлээр засмуу.

Агуу их Сүхбаатар, Занабазар, Нацагдоржийг төрүүлэх бэлтгэл мянга мянган жилийн турш үргэлжилсэн ажгуу. Хэрвээ хүнд авьяас билиг буй аваас түүгээр бардах юун. Тэр нь түүнийх бус бөгөөд түүгээр дамжуулан эх орон минь бусдад үйлчлэх шат буюу. *О.Дашбалбар*

а. Эхийн дараах бүтэц зохимжтой эсэхийг шалгаад, тус тусад нь товч нэр өгөөрэй.

- I. 1. Сайхан юм бүхэнд эх орон шингэсэн гэж би итгэдэг боллоо.
2. Алтан-Овоо бол үнэхээр амилсан уул.
- II. 1. Эмэг эхийн яриаг өгүүлмүү.
2. Бодолдоо үнэнхүү итгэж, бүхий л оюун санааны хүчээ нэгэн цэгт төвлөрүүлэн сэтгэж чадсанд оршино.

б. Найруулгын ямар ямар хэв шинж холилдон орсныг тайлбарлана уу.

в. Эхийг товчлон бичиж, нөхдөдөө уншуулж, саналаа солилцоорой.

г. Дараах жишээ нь ямар ямар дүрслэх ур маягаар бүтсэн байна вэ?

- Эх орон бол тэнгэр толгод хоёр байжээ.
- Сайхан юм бүхэнд эх орон шингэсэн.
- Сайхан бүсгүйд эх орны нуугдмал дүр бий.
- Сансрын хураангуйлсан биет бүсгүй
- Эхийн нь алхаанд цаг мөч агшин хэмжигдэх
- Хэвлийдээ нялх үр тээсэн бүсгүй алхаж явна. Түүнд эх орон оршиж буй.
- Энэ модонд ч эх орон оршиж буй.
- Навчис бүхэн нь намайг эх орны нүдээр харж байна.
- Бүх хүнд оршиж буй тэнгэрлэг хүчийг эх орон гэнэ.
- Хүн төрөлхтний мөрөөдөл дүрслэлийн хамгийн гэрэлт дүр нь эх орон байлаа.
- Түүнд л хамаг сайн сайхнаа шингээн бодож, хүслээрээ энэрэнгүй их үнэнийг бий болгон, түүндээ тэмүүлж, тэмүүлэл нь хүнийг бурханлаг болгодог байв.

- Алтан-Овоо бол амилсан уул юм.
 - Олон зуун мянган хүний бодол санаа нэгэн цэг- энэ уулан дээр төвлөрнө.
 - Мөнх хайрын бэлгэдэл нь Дарьгангын Алтан-Овоо буюу.
 - Өвөг дээдэс минь энэ уулаар дамжин, надтай уулзах гэсэн байжээ. Алтан-Овоо бол бодлын шидээр бүтсэн уул тул биширч болох амуй.
 - Хүү чанад нутагт ном гүйцээгээд...
 - Эхийн хүслийг эс гүйцэтгэсэн тул нүүр учрах хэцүү.
 - Ийн олбиргон бодолд автан...
 - Ямагт буяны мөр хөөж, хүсэл бүхнээ бурхандаа даатгалаа.
 - Өнөө амьдын хорвоогоос одох цаг ирэв. Бурхнаа л нэг үзвэл сэтгэл гүйцмүй гэв.
 - Өдөр бодолдоо, шөнө зүүдэндээ үзэн...
 - Би, нүүж яваа үүлсийн сүүдэр доор ганцаардан ахуйдаа эх орноо дуудмуй.
 - Тэр залбиран хүлээх эх орон минь итгэл билээ.
 - Эх орныхоо гоо сайхны оргилд хүрэх зам маань байгаль ээж буюу.
 - Байгальд хүрэх зам маань дотоод сэтгэлийн дээд зэргийн ариутгал буюу.
 - Оюун санааны дээд үнэнд хүрэх замыг зөв үйл, зөв сэтгэлээр засмуу.
- д. Дараах жишээ үг, өгүүлбэр уул эхэд ямар үүрэгтэй болохыг өмнөх хойдох үг өгүүлбэртэй холбон, утга санааг нь тайлбарлаарай.
- Миний багын төсөөллөөр... - Миний өмнөх...
 - гэж итгэдэг боллоо. - Навчис бүхэн нь намайг харж байна.
 - гэдэгт үл эргэлзэнэ. - үүнээс үүдэн би...
 - би... гэж мэдмүү. - надтай уулзах гэсэн байжээ.
 - буй гэмүү - бас л миний адил
 - Миний өмнө... - би амьдарч яваагаа...
 - Эх орон гэмүү - Би ганцаардан ахуйдаа...
 - -Тэгээд би... гэж бодном. - Би бас сэтгэл, оюун бодлоо ариусгаж...

Уран нийтлэлийн онцлогийг тодорхойлъя



Дасгал 33

Уран нийтлэлийн онцлог болон холбогдох жишээ баримтыг нягтлан уншиж, 58-р талд буй дүгнэлттэй холбон тайлбарлаарай.

Уран нийтлэлийн онцлог	Жишээ
<p>Чухал хэрэг явдлыг өргөн хүрээтэй нийтлэг орон зайд цаг үеийн урт хугацаанд дэвшүүлдэг.</p>	<p>Юм мэдэхгүй явсан он жилүүд минь ус мэдэхгүй явсан он жилүүдтэй тэнцдэг болохыг ухаартлаа би мөн ч олон оймс элээж дээ. Энэ тэнцэтгэл тооны ухааны тэнцэтгэлийн нэг адил аль нэг өгөгдөхүүн нь ихсэхэд нөгөө нь хар аяндаа ихсэн, тэнцүү байх зарчмаа хадгалсаар явдаг аж. Өөрөөр хэлбэл, ус мэдэхгүй байх тусам юм мэдэхгүй байна гэсэн хэрэг л дээ.</p> <p style="text-align: right;"><i>Д.Батбаяр “Ус” Аз жаргал хүсье Уб., 2008</i></p>

Хүний бүтээсэн оюуны үнэт зүйл буюу шинжлэх ухааны нарийн ширийн зүйлсийг нийт хүн ухаарч ойлгогдохуйц энгийн хэлээр тайлбарладаг.

“Тархи гэдэг маань цагаан саарал уураг бөгөөд 14 тэрбум мэдрэлийн эсээс бүрдсэн гурван давхар бүтэцтэй, цагт 288 километрийн хурдтайгаар дохио мэдээлэл дамжуулах чадалтай төв юм” гэсэн эрдэм шинжилгээний хийсвэр нэр томъёо бүхий өгүүлбэрийг “Хоёр мөрөн дээрээ буюу хүзүү гэдэг богинохон баганан дээр бид зүйрлэшгүй их баялгийнхаа алтан авдрыг тээж яваа” гэж бодох ёстой ажээ. Тэр нь мөнгөний шүүгээ шиг дөрвөлжин биш, ган төмрөөр хийсэн хэдэн тоннын хүнд авдар биш мөртлөө доторх баялгаа бусдад байтугай, тээж яваа эзэндээ ч хэр барагтайд нээж өгдөггүй бат нууцтай, басхүү хоёр гарын нь алганд бараг багтчихаар жижигхэн бөөрөнхий бөмбөлөг буюу гавал юм” гэж тайлбарлахад хэн ч ойлгох биз ээ.

Л.Түдэв “Тархи” Дал №29

Тухайн хэрэг явдлыг олон ургалч үзлийн үүднээс үнэлж дүгнэхдээ үгийн урлагийн хүч нөлөөг бүрэн дүүрэн ашиглаж, уран зураглал, онцгой сэтгэмж, гүнзгий сэтгэгдлийг хослуулдаг.

Хэдхэн өдөр нүдний булангаар харж, давхин өнгөрсөн уул ус тархины хальсанд тэгтлээ тод сайхан зураг болон бууж, амьдрал болоод байгалийн хамгийн санаандгүй юмстай үе үе холбогдон гарч ирээд, аль эрт нойрссон төсөөлөл, зүйрлэлийг гэнэт цочоон сэргээж, бас өнийн дуртгал болсон гуниг баяр, хорсол гомдлыг хүртэл эгүүлэн авчирч, энэ ертөнцөд төрсөн биеэ авч яваагийн учир холбогдол хийгээд хожмын зам чухам ямар “ууланд” хүргэхийг тааварлан ядах санаашралд унагаж болдгийг би тэгэхэд дахин ойлгосон юм.

С.Эрдэнэ “Алтай”

Бүх нийтийн сэтгэл санааг ил тод илэрхийлж, нийгмийн ухамсар сэтгэхүйд нөлөөлж, улс орны хувь заяатай холбоо бүхий асуудлын талаар өөрийн үзэл бодол, санал хүсэлтээ чөлөөтэй бичдэг.

Нар бол хэнээс ч мөнгө нэхэхгүй, ахин сэргээгдэх эрчим хүчний бэлэн эх булаг, тэр тусмаа “Нарлаг монгол” гэж алдаршсан манай оронд аж ахуйч, ажилсаг хүнд бол зүгээр олддог, байнга бэлэн байдаг. (Шөнө яах вэ? гэлтгүй, өдөр нараар зайгаа цэнэглээд нөөцөлчихдөг) Ийм уурхайг ухах хүрз, жоотуу хэрэггүй. Ухаанаа л ухах хэрэгтэй. Ухаанд чинь юм байхгүй бол бусдын ухааныг ухаж, наран дэнлүүг цаламдаач ээ, залуус аа!

Л.Түдэв “Нарыг цаламдаж, салхийг залгицгаая, залуус аа!”



Цогцолбор бүрийг нягтлан уншиж, нийтлэлийн ямар ямар шинж байгааг тодорхойлж бичээрэй.

1

- Монгол гэх хайр юунаас эхэлснийг бүү мэд! Нэг л мэдэхэд өр зүрхэнд минь шувууны өндөг шиг орогнож, өөр юмны сүүдэр хүртэл тусах вий гэхээс айдаг болсон. Наран сумын хэдэн цагаан байшин, сумын төвийн айлууд, зуны орой үнээ сааж буй хүүхнүүд, эл хуль хээр талаас эхэлсэн юм уу? Өвлийн үдэш пийшингийн дэргэд эмгэн ээжийн минь ярьсан үлгэр туульс, бага сургуулийн сурах бичигт байраа эзэлсэн бүрх малгайтай, махир гаанстай найрагчийн зураг, “Миний хэнз хурга” шүлгээс эхэлсэн юм уу? Бүү мэд, нэг л мэдэхэд эх орон гэх бодол зүрхтэй минь цуг цохилох болсон.

О.Дашбалбар “Хаврын сүлжээ буюу уянгын халил хэмээх зураглал”, “Гол ус намуухан урсана”, Уб., 1989

2

- Монголчууд эхээс төрж, манцуйтай хэвтэж байхдаа л тэнгэрийг тооноороо харж өсдөг бөгөөд мал маллах үйлстээ ямагт “тэнгэрийн царай” харж уншихдаа дээд зэргийн “эрдэмтэн” байлаа. Гэхдээ бас “зурхайн ухаан” хөгжүүлж, одон орны солбицол, дохиоллыг уншиж, мэдээлэл авдаг хүмүүс ч цөөнгүй байсаар ирсэн. Харамсалтай нь, зүрхийг мэдлэг талаасаа шүтлэг тал руу хэлтийлгэгчид олширч, нэр хүнд, итгэхийн хэлийг сулруулж, сүүл сүүлдээ судалгаа ч хийх нь идэвхгүй болсоор байх юм. Яаж амьдрахыг тэнгэр, газар нутаг нь зааж өгдөг байсан цагаас уйдаж, хотжиж “шавар байшинд шавааралдан суух” болсны балгаар “залуу үе маань” тэнгэр, газрын хүчийг мэдрэх, дагах, хүндлэх, хэрэгжүүлэх авьяас, мэдлэг, чадвар, мэдрэмжээр уламжлалаасаа тасарсаар байна. “Мөнх тэнгэрийн хүчин” Төв Азийн зулай дээр голлодог цэг нь таарч байдгийг умартаж, Европ, Америкт хүртэл тархан сууж, сүүлийн үед Солонгос, Тайланд, Японд дурлах болжээ.

Л.Түдэв “Тэнгэрийн эрхшээл”, “Сүүдэр сүүдэр цаашаа” XXXVI. Уб., 2005

3

- ...Одоо зулзаган заг эгнэн ярайж байна. Ер нь заг бол үр төл сайтай ургамал юм санж. Намрын энэ үед бор нүдтэй, цагаан шаргал цэцэг багсайтал ургачихсан байна. Намар орой тэр нь үр болон гөвөгддэг ажээ. Ер нь говийн хөрсийг бэхжүүлэх, элсний давшилтыг зогсоох ажлыг шинжлэх ухааны үндэстэй, далайцтайхан явуулах цаг болжээ. Ялангуяа, улам их газар хагалан тариалж байгаа одоо үед агротехникийн үүднээс, маш нарийн бодох хэрэгтэй юм. Хагалах газрын хэмжээг бодлогогүй ихэсгээд байвал хөрс салхиар зулгаран хийсдэг говь хээр газар үржил шимгүй цөл болон хувирахад хүрнэ.

Л.Түдэв. “Говь гэмээнэ говь билээ”

4

- Сайхан гэдэг ойлголт ухагдахуун биш. Сайхан бол цэнгэлтэй, таатай мэдрэмж. Урлаг уран зохиол бол орчлон ертөнцийн сайхныг мэдрэсэн мэдрэмжээ хөг аялгуу, өнгө төрх, үг хэл, дүр дүрслэлээр илэрхийлж байгаа илэрхийлэл. Мэдрэмжийг бүтээж, бүтээсэн мэдрэмжээрээ сонсогч үзэгч, уншигчийн мэдрэмжид хүрч, мэдрэмжийг нь сэрээхүй юм. Чухамхүү ийм зорилготой учраас Ванчинбалын Инжаннаши “Хүний сэтгэлийг хөдөлгөж эс чадваас хөнгөн бийрийг хөшиж юу хийнэ” хэмээжээ. Эндээс юу харагдана вэ?

Урлаг уран зохиолын бүтээл туурвилын зам харагдана. Сайхныг мэдрэсэн мэдрэмж, түүнээ илэрхийлсэн илэрхийлэл, тэр нь уншигч, сонсогч, үзэгчийн сэтгэлд хүрч, мэдрэмжийг нь сэрээсэн цагт сая уран бүтээл болдог байна. Энэ учраас уран бүтээлч хүн ер бусын маш нарийн, арвин их мэдрэмжтэй байх учиртай.

Д.Батбаяр “Сайхныг мэдрэх мэдрэмж”, “Сайхныг бүтээхүйн нууц”, УБ., 2016

5

- Дуу хорвоо ертөнцөөр дүүрэн байв чиг манай уртын дуу шиг буддалаг гэгээн, шүншиг бүхий тарнилаг, ид шидийн шүтээнлэг, зүүдэн юм шиг зөн бэлгэдэлт, тайлахын эрхгүй оньсоголог, хүршгүй ариун дагшин, сүлд оршоох хийморилор, ая дагнах торгомсог, алт мөнгөөр аялгууг сийлбэрдэн эмхүүрдэх шиг тийм аялгуу эгшгийн хаан хаа байх билээ. Би элдвийн “хаан” тодотголтой зүйлд дургүй хэрнээ уртынхаа дууг ёстой хаан суудалт эгшиглэн, хаан сэнтийн дуу гэж ташаагаа тулж байгаад бардам хэлж чадна.

До.Цэнджав “Дэлхийд ижилгүй уртын дуу минь”, “Essay”, УБ., 2010

6

Хөвсгөл нуур цэвэр усны хэмжээгээр зөвхөн Байгалийн дараа л орох юм. Уулс бий болоход үүссэн гүн хонхор дагаж тогтсон учир усны багтаамж ихтэй, ёроолын нь талбайн бараг 70 хувь нь зуугаас илүү, зарим газраа 268 метр хүртэл гүнзгий. Монгол орны нийт гол мөрний арван жилийн ургацтай тэнцэх хэмжээний цэвэр цэнгэг усыг Хөвсгөл ай савдаа агуулдаг байна.

Амьд бүхний эх ус билээ. Гэтэл ертөнцийн хүмүүсийн тэн хагас уух усаар гачигдаж, усны нийт нөөц бохирдох төдийгүй, бүр хордох аюулд оржээ. Иймээс усны төлөөх тэмцэл бол амьдралын төлөөх тэмцэл юм. Энэ утгаар нь авч үзвэл, Хөвсгөл нуурыг хамгаалах асуудал нэн онцгой юм. Гэтэл бид улс орондоо байтугай дэлхийд ховорхон цэнгэг усны эрдэнийн бумба болсон цор ганцхан Хөвсгөл нуураа, ард түмэндээ хайрлагдсан “Далай ээж”-ээ хөнөөхөөр цаазын тавцан бэлтгэж байдаг нь юу болж байгаа хэрэг вэ? Хөвсгөлийг дотор гаднаас нь бид өөрсдөө хайр найргүй бохирдуулж байна.

Ц. Балдорж “Далай ээж минь цаазын тавцанд” Үнэн сонин 1987 №233

Уран нийтлэлийн онцлогийг дүгнэвэл:

- Цаг үеийн урт хугацаатай хэрэг явдлыг өргөн дэлгэр дүрслэн зураглаж, хүүрнэсэн тодорхой хэрэг явдлаас ангид байх
- Хэрэг явдал баримтыг өөр зүйлтэй жиших, хялбаршуулах, гол баатаргүй байх
- Алив юмсын учир утгыг оюуны үнэт зүйлтэй холбож, уран яруу тайлбарлах, ургуулан бодох, ухааруулах
- Өгүүлэгч өөрийн үзэл бодлын үүднээс үнэлж дүгнэх, уншигчдын урам зоригийг бадраах, хариу бодол төрүүлэх
- Тухайн хэрэг явдлын талаар асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, санал гаргах
- Олон нийтэд зориулж, тэдний санаа бодлыг илэрхийлсэн, олон ургалч үзлийн үүднээс тэдний ухамсар сэтгэхүйд хандах зэрэг онцлогтой.



Дасгал 35

Цогцолборуудын санаанаас уг эхийн бүтцийг хэрхэн загварчилж, онцлогийг тодруулсныг ажиглаарай.

а. Орчин үеийн мэдээллийн технологи нь мэдлэгт тулгуурласан эдийн засгийн гол ноён нуруу болж хувирав.


Мэдээллийн технологийн гол ололтуудын нэг болох өчигдрийн вэб, өнөөдрийн грид (grid) нь эгэл бөөмсийн физикээс гаралтай ба физикчдийн судалгааны соёлын үр дүн болно. Ихэнх шинжлэх ухаанд тоо томшгүй их хэмжээний мэдээллийг боловсруулах шаардлага гардаг. Хүн төрөлхтний түүхэнд урьд өмнө боловсруулагдаж байгаагүй асар их мэдээлэл, тухайлбал, Европын цөмийн судалгааны лабораторийн 27 км урт дугуй хонгилон хурдасгуураар гэрлийн хурдтай гүйх эгэл бөөмсийн сигналын процессыг бүртгэхэд жилд нэгийн 15 тэгтэй тооны мэдээлэл боловсруулах шаардлагатай. Энэ нь бидний удамшлын генэн доторх мэдээллийн тооноос сая дахин их гэсэн үг.

Ингэж дор хаяхад мянган тэрбум мэдээллийг боловсруулах аргачлалыг физикчид анх санаачлан, амьдралд нэвтрүүлж байна.

Х.Намсрай “Хатуу шинжлэх ухаан ба мэдлэгт тулгуурласан эдийн засаг”

Мэдээллийн технологи нь эдийн засгийн ноён нуруу

- а. Мэдээллийн технологи нь эгэл бөөмсийн физикээс гаралтай.
б. Мэдээллийн технологи нь физикчдийн судалгааны соёлын үр дүн.
- а. Шинжлэх ухаанд тоо томшгүй мэдээлэл боловсруулах шаардлагатай.
б. Асар их мэдээлэл, жилд 1.000.000.000.000.000 мэдээлэл боловсруулах шаардлагатай.
- в. Энэ нь хүний удамшил дахь мэдээллээс сая дахин их юм.
- а. Физикчид мянган тэрбум мэдээллийг боловсруулах аргачлалыг санаачлан, амьдралд нэвтрүүлж байна.



1а, б - эхлэл

26 - гол хэсэг

4а - төгсгөл


2а, 3в - гол хэсэгт туслах санаа

б. Намрын шөнө түмэн түмэн одон жирэв жарав гялтганасан огторгуйг ширтэн бодлогоширном. Тал нутгийг минь ивээн бүрхсэн агуу тэнгэрийн дор хүний үр юуг эс үзнэм билээ. Бодлын харгуйг үзүүргүй сунгасан энэхүү одот орчлонд монголынхоо зориг сэтгэлийн гэрэлт замыг гарган, сансрын хөлгөөр дүүлэн яваа тал нутгийн хөвгүүний дүрийг сэтгэлдээ зурагланам. Одтой ижилссэн од билээ, тэр. Монгол хүн сансарт нисэн, олны зүрхнээ мөнх тэмдэглэгдэх цагт, манайхан хүүхэд хөгшидгүй цөмөөрөө нэгэн зэрэг гэрээс гарч, тэнгэрийг ширтэн, монголынхоо одыг олж үзээд, ямархан баяр хөөр болох вэ.

С.Эрдэнэ “Мөнгөн хазаарын дууль”

Намрын шөнө огторгуйг ширтэн бодлогоширном.

- 1 а. Агуу тэнгэрийн дор хүний үр юуг эс үзнэм билээ.
- 2 а. Сансрын хөлгөөр дүүлэн яваа тал нутгийн хөвгүүний дүрийг сэтгэлдээ зурагланам.
- б. Одтой ижилссэн од билээ, тэр
- в. Монгол хүн сансарт нисэн, олны зүрхнээ мөнх тэмдэглэгдэнэ.
- 3 а. Манайхан цөмөөрөө тэнгэрийг ширтэн, монголынхоо одыг үзээд баярлана.



Дасгал 36

Доорх уран нийтлэлийг уншаад,

- а. “Эх- анхилмал үнэр, цэцгийн анхилмал үг- багш нар, ордын үзэсгэлэн гоотөрсөн нутаг, ард түмэн, нандин бодлын гантиг, арвисын үзэсгэлэн- ачтан хөвгүүд” гэсэн хос үгсийн утга учрыг тайлбарлаж бичээрэй.
- б. Дөрвөн цогцолборын санаанаас уг эхийн бүтцийн онцлогийг загварчлаарай.

Дөрвөн цогцолборын хуучин санаа нь шинэ болж, улмаар шинэ санаа нь хуучрах зэргээр эхийн зохиомжийн үр хөврөл буй болдгийг

“Дөч хүрээд бие сая тогтноу, (хуучин) мэдээлэл

Уулын оргилоос цагаан болюу, (шинэ, хуучин) мэдээлэл

Сэтгэл минь гүн нуураас амгалан болюу (шинэ, хуучин) мэдээлэл

Санаа сэтгэл минь одооныхоос сайхан болюу (шинэ, хуучин) мэдээлэл гэх мэтээр ойлгож болно.

- I. Тэгээд, үгсийн цэцэрлэгч болж ч магад буюу. Тэгвэл...цусаар, үнэрээр ачий нь магтан хариулюу
- II. Тэгээд, мөнх билгийн налина лянхуа цэцэг сэтгэл зүрхэнд минь дэлгэрэнхэн цэцэглэж магад буюу. Тэгвэл...үгээр... ачий нь магтан хариулюу
- III. Тэгээд, үгсийн уран бүтээлч болж ч магад буюу. Тэгвэл ... үгээр үзэсгэлэн гоогоор... ачий нь магтан хариулюу
- IV. “Тэгээд, үгсийн уран барималч болж ч магад буюу. Тэгвэл...гантигаар, үзэсгэлэнгээр ачий нь магтан хариулюу” гэх мэт давтсан нь энэ эхийн зохиомжийн онцлог болж байгааг ажаарай.

Юуны магад

Дөч хүрээд би сая тогтноюу. Тэгээд үгсийн цэцэрлэгч болж ч юуны магад буюу. Тэгвэл, сэтгэлийн гайхамшигт сайхан цэцэг зүрхнийхээ улаан цусаар ургууланхан, намайг хүн болгосон эх орондоо анхилмал үнэрээр нь ачий нь магтан хариулюу.

Цаст уулын оргилоос цагаан болюу, толгой минь. Тэгээд мөнх билгийн налина лянхуа цэцэг, сэтгэл зүрхэнд минь дэлгэрэнхэн цэцэглэж магад буюу. Тэгвэл, гайхамшигт сайхан цэцгийн анхилмал үгээр намайг сурган хүмүүжүүлсэн Багш нарынхаа ачий нь магтан хариулюу.

Сэтгэл минь, гүн нуураас амгалан болюу. Тэгээд үгсийн уран бүтээлч болж ч магад буюу. Тэгвэл, сэтгэлийнхээ чин үгээр хүсэн сэтгэхүйн гайхамшигт сайхан орд босгон, гялалзсан үзэсгэлэн гоогоор нь төрсөн нутаг, ард түмэндээ ачий нь магтан хариулюу.

Санаа сэтгэл минь одооныхоос сайхан болюу. Тэгээд, үгсийн уран барималч болж ч магад буюу. Тэгвэл, сэтгэл зүрхнийхээ нандин бодлын гантигаар хүсэн сэтгэхүйн гайхамшиг хөрөг бүтээн босгож, дур булаам арвисын үзэсгэлэнгээр нь ард түмнийхээ ачтан хөвгүүдийн ачий нь магтан хариулюу. *Б.Ринчен*



Үгсийн тайлбар:

Лянхуа - усанд ургадаг, шулуун иштэй, анхилуун үнэртэй, том сайхан цэцэгтэй, дүгрэг навчтай, олон наст өвс. Ариун тансаг үнэрээрээ өртөнцийг тэтгэхийн бэлгэдэл болдог учраас бурхны өлмийд залдаг ажээ. Мөн “Оюуны лянхуа нээх” гэсэн хэлц нь “гэгээрэх”, “ухаарах” гэсэн утгатай.

Налина - бадамлянхуа

болюу - сонгодог бичгийн хэлэнд хүндэтгэлийн утгаар хэрэглэдэг "юу" нөхцөлийг эгшиг болоод гийгүүлэгчээр төгссөн үгэнд шууд залгана.

- в. “Сая би тогтноюу, үгсийн цэцэрлэгч, сэтгэлийн гайхамшиг цэцэг, зүрхнийхээ улаан цусаар ургуул-, эх орондоо анхилмал үнэрээр нь ачий нь хариул-” холбоо үгсийн дүрслэх ур маягийг тайлбарлаарай.
- г. Эзэнд хамаатуулах болон биеийн хамаатуулах нөхцөл нь энэ уран нийтлэлийн өгүүлэгч баатартай ямар нэг холбогдол байна уу.

би, намай-г

минь

толгой минь
сэтгэл зүрхэнд минь
сэтгэл минь
сэтгэл минь

Үгсийн
цэцэрлэгч

- аа⁴

зүрхний(х)-ээ
эх оронд-оо
багш нарын(х)-аа
төрсөн нутаг ард түмэнд-ээ
санаа сэтгэл зүрхний(х)-ээ
ард түмний(х)-ээ

д. Уран нийтлэлийг дараах шинжээр тайлбарлаарай.

1. Цаг үеийн урт хугацааны болон өргөн хүрээтэй орон зайд зураглах
2. Шинжлэх ухаан буюу үнэт зүйлийг нийт хүнд ойлгогдохуйцаар хялбаршуулах
3. Үгийн урлагийн хүч нөлөөг ашиглан, онцгой сэтгэмж гүнзгий сэтгэгдлийг хослуулах
4. Өгүүлэгч “би” хэмээгчийн үзэл бодол, үнэлэмж нь тод илэрч байх



Дасгал 37

а. Эхийг уншиж, сэдэв ба гол санааг тодорхойлон бичээрэй.

- Эрийн гурван наадмын нэг болох бөх барилдах нь монголчуудын өнө эртний бахархалт тэмцээн юм.
- Хүч мэх бүрэн төгс бүрэлдсэн бөхөө дээдэлдэг нь монголчуудын оюун санааны нэг үнэт зүйл мөн.
- Алдарт бөх Их Монгол Шаравжамцын барилдааныг үзсэн нь Их Монгол бидний бахархал мөн.


б. Эхийн утгын бүтцийг дараах байдлаар ангилсныг харьцуулна уу.

1а, 1б - гол цогцолбор

2а, 2б - дэлгэрүүлэгч цогцолбор

3а, 3б - үнэлэмж, баймж бүхий цогцолбор

4а, 4б - орон цагийн утгат ба өгүүлэгч “би” хэмээх цогцолбор



- в. “бага ч гэж дээ, ер нь, ай, үнэхээр, мөн, маягтай, юм, гэлтэй, лав, андашгүй, гэмээр, гэнэ, вий, мөн ч, билээ” гэх мэт үгс ямар үүрэгтэй болохыг тайлбарлана уу.
- г. Тэмдгийн нэрийг түүж, ямар утга үүрэгтэй байгааг тайлбарлана уу.
Жишээ нь:

“Тэр өдөр их л халуун байсан” гэхэд “халуун” гэсэн шинж чанар заасан тэмдгийн нэр нь үйл үгийн байрнаа орсон тул үйлшжээ. Уул нь “халуун өдөр” гэх байв. Тодотгол болох нь тэмдэг нэрийн үндсэн үүрэг юм. “Их” нь тэмдэг нэрийн харьцуулсан давуу зэргийг илтгэж байна. Иймд “их” гэдэг нь “маш” “нэн” гэсэн бүтээврийн үүргээр оржээ.

Их Монгол

4а. Дөчин таван оны зун билээ. Дайн дуусаж, тэр жилийн наадамд олон аймгийн наадамчид ирцгээж байв. Буянт-Ухаад гангийн улаан тоос дэгдэж, олон цагаан гэр, эрээн майхан ярайж, эртний монгол их цэргийн буудалласан газар мэт морь мал, хүн амьтан хөөрцөгнөн байв.

4б. Би бага байжээ. Бага ч гэж дээ, арван зургаатай, цэргийн сургуулийн сурагч. Биднийг наадмын байранд баруун жигүүрийн дээгүүр суулгадаг байв. Ер нь цэргийн хатуу журмын хажуугаар их өхөөрдөж эрхлүүлдэг байсан юм. Тэр

өдөр их л халуун байсан. Бид цөмөөрөө бөхийн хорхойтнууд. Халууныг тэсвэрлэн ёслолын гоё хувцсаа улаан алаглуулан сууцгаав.

1а. Зүүн жигүүрийн бөхийн майхнаас нэгэн гоц өндөр чилгэр биетэй, цал буурал толгойтой хүн алгуурхнаа дэвсээр гарч ирэхүй дор наадамчин олон зэрэг “Ай” гэсэн бөглүү дуу гаргаж, нэг нэгнийхээ толгой дээгүүр өлөлзөн бужигнацгаав. Амьтны анхаарлыг тийн зэрэг татсан хүн бол домогт даян аварга Их Монгол байжээ.

2а. Түүний дэвэн дэвсээр гарч ирэх нь үнэхээр Их Монгол мөн. Засуулаа тойрон алсын уулын толгойг ээлжлэн харах маягтай буурал толгойгоо нэг өргөж, нэг гудайлган, тэнгэрийн хаяа алдлах мэт урт гараа элэн халин нисэгч бүргэдийн жигүүр гэлтэй ихэмсэг тайвнаар дэвэн байхуйд улаан торгон зодог нь галын дөл дүрэлзэх мэт харагдана. Бие нь цул судас шөрмөснөөс бүтсэн мэт гүрдийж, агуу уужим хавиргууд нь нумлан харагдах тэр “буурал толгойд” аварга хүчин бий гэдэг нь андашгүй.

3а. “Их Монгол гуай дал хүрч яваа гэнэ шүү” гэж наадамчин олон гайхан шогшролдоно.

2б. Засуулч нь лав шавил эр биш гэдэг нь тодорхой боловч Их Монголын дэргэд хүүхэд мэт тонгойн харагдаж байсан сан. Тийнхүү газар доргио болов уу гэмээр дэвслэх хөлийн доороос элс шороо пур пур хийн, Их Монгол гуай юу юугүй тэнгэрт хөөрч, үлгэрийн шидэт хангарди адил нисэн одох вий гэмээр харагдана. Гэвч тэр тэнгэрийн бус газрын Их Монгол хойно нисэн одсонгүй. Алдар цолоо дуудуулж, дэвэн дэвсээр амлаж авсан бөхтэйгөө үзэлцэхээр наадмын хүрээн дунд гарч ирэв. Олон явган шувуу нисэхийг завдан, улаан цэнхэр далавчнуудаа дэвэн буйн дунд Их Монгол гэгч нэг аварга том улаан хангарди ялгарах мэт байв.

1б. Тэрбээр, хэдэнтээ сайхан сэлгэж, өөрөөс хавьгүй дүү бөхийг хав дөрвөлжин барин авч, далаар нь тавиад, татан босгож, хоёр хацар дээр нь үнсэхэд наадамчин олны цээжнээс “Ай” гэх дуун нэгэн зэрэг гарав.

3б. Тийнхүү би домогт Их Монголыг анх үзэж билээ. Миний багадаа үлгэрт сонссон буюу номд уншсан домогт баатар амилан боссон мэт мөн ч бахдалтай харагдаж билээ. *С.Эрдэнэ*



Үгсийн тайлбар:

Их Монгол - Их Монгол хэмээх Шараежамц нь 1900 оны даншиг наадамд тав, 1904 оны мөн наадамд тав, 1906 оны даншигт найм давж, мөн оны тусгай даншигт найм давсан ба 1908 оны арван засгийн наадамд зургаа давж, 1911 оны даншигт 11 давж түрүүлсэн ажээ.

даншиг - (бат оршил) нь ихэс дээдэс, хувилгаан гэгээнтний мэндэлсэн болон тодорсон ирсэн ойг дурсан тэмдэглэх шашны нэг зүйлийн ёслол болно. XVII зууны эхэн үед Халхын долоон хошуу нийлж, долоон хошууны бат орших ерөөл тавин, наадах болсон байна. Үүнээс долоон хошуу даншиг наадам гэх болжээ. 1940 онд Түшээт Сайн хан Гомбодоржийн хүү өндөр гэгээн Занабазарыг монголын шашны тэргүүн, анхдугаар богд гэж ширээнээ залсанд зориулан Булган аймгийн Гурванбулаг сумын нутаг Хөгнө Тарнын голын эхний их бага Монгол уулын өвөр Өлзийт цагаан нуур хэмээх газар халх долоон хошууны наадам хийж, даншиг буюу бат оршил өргөсөн байна. Халхын долоон хошуу гэгч нь Чингисийн удам 19 дүгээр үеийн ач Гэрсэнз жалайр хун тайжийн долоон хөвгүүд халхыг хувааж захирснаас гарсан нэр ажээ.

д. Эхэд “мэт, маягтай, гэлтэй, гэмээр, адил” гэх зэрэг үгс ямар утга үүрэгтэй буйг тайлбарлаарай.

е. “Тэр жилийн наадам, биднийг, тэр өдөр, бид цөмөөрөө, тийн зэрэг татсан, түүний дэвэн дэвсээр, тийнхүү газар доргио болов уу гэмээр, гэвч тэр тэнгэрийн бус, тэр бээр, хэдэнтээ сайхан сэлгэж, тийнхүү, миний багадаа үлгэрт сонссон” гэх мэт холбоо үгс эхэд ямар үүрэгтэй байгааг өмнөх хойдох жишээтэй нь холбон тайлбарлаарай.

 **Дасгал 38**

а. Д.Батбаярын “Үг” хэмээх эсээ нийтлэлийн а, б хэсгийн санааг харьцуулан, аль нь эхийн бүтэцтэй, аль нь зохиомжтой холбоотой болохыг тайлбарлаарай.

Эхийн бүтэц нь агуулгын доторх санааны харьцааг илтгэдэг бол, эхийн зохиомж нь хэрэг явдлын элдэв зохицлыг илтгэдэг.

- | | |
|--|---|
| <p>а.</p> <ul style="list-style-type: none"> • Үг гэдэг ухааны тэнгисийн эрэгт чулуудагдсан эзгүй дун. • Орчлон ертөнц гэдэг нэр үг. Оршихуй гэдэг үйл үг. • Үг бол үндэстэн ястны оюуны баялаг. • Иргэншил гэдэг ойлголт ухагдахууны адилшилт | <p>б.</p> <ul style="list-style-type: none"> - Үгэнд оюун санааны зөвхөн мөр л байдаг. - Монгол хэлний үгсийн дийлэнхийг үйл үг эзэлдэг. - Тогтсон хэллэг, үг өгүүлбэр, үгийн хоршил зохицлын хэвшлийг эвдэх хэрэгтэй. |
|--|---|

- б. Эхийн сэдэв ба санааг тайлбарлаж бичээрэй.
- в. Эсрэгцсэн санааг илтгэх үгсийг “нүүдэл-суурьшил” гэх мэтээр ялган бичиж, зохих санааны дагуу өөрсдөө жишээ татан, дэлгэрүүлэн тайлбарлаарай.
- г. Энэхүү эсээ нийтлэл нь ухаарал бодролын тухай нийтлэл болохыг “Юуны магад”, “Цаг ирвээс” зэрэг нийтлэлтэй харьцуулаарай.
- д. Уран нийтлэлийн шинжийг доорх эхээс ярилцаарай.

Үг

I. Үг гэдэг ухааны тэнгисийн эрэгт чулуудагдсан эзгүй дун. Дунг чихэндээ барин чагнахад далайн шуугианы сураг анир төдий сонсогддог. Оюун санааг үгээр бүрэн дүүрэн илэрхийлж чаддаггүй. Бидний ярьж бичиж байгаа үгэнд оюун санааны зөвхөн мөр л байдаг.


II а. Орчлон ертөнц гэдэг нэр үг. Оршихуй гэдэг үйл үг. Оюун санаа нэр үг ч биш, үйл үг ч биш. Биш бусын язгуур. Нэр үг үйл үгтэй нөхөрлөж буян ба нүглийг үйлдэнэ. Амьдрал бол үйл үг. Үхэл бол нэр үгийн хувьсал. Хөөрхий хүмүүн гэгч амьтан нэр үгийг хүчтэй хэмээн бодно. Нэр үгэнд шунана. Үйл үгийн тэнхээгээр нэр үгийг өөрт хураахыг эрмэлзэнэ. Суурьшил бол нэр үгийн хуримтлал. Нүүдэл бол үйл үгийн хуримтлал. Алив үндэстэн ястны оюуны тэнхээ нь нэр үгийн хуримтлалаар бус, үйл үгийн хуримтлалаар хэмжигддэг. Бидний монгол хэлний үгсийн сангийн дийлэнхийг үйл үг эзэлдэг. Үйл үгийн арвин их сантай үндэстний хэлэнд харь үйл үг орж чаддаггүй. Зөвхөн цөөн тооны нэр үг орж ирж, эрлийзжин нутагшдаг.

б. Үг бол үндэстэн ястны оюун ухааны баялаг. Энэ баялаг соёлд

харьяалагдахаас иргэншилд харьяалагддаггүй. Иргэншил гэдэг ойлголт ухагдахууны адилшилт. Өнөөдөр олон улс орны үгийн сан жил ирэх тутам адилшиж байна. Ойлголт ухагдахууны адилшилт бол хүн төрөлхтний ухааны мунхрал. Олонх улс орон хэдхэн үгээр төрөө жолоодож, хэдхэн үгээр эд баялгаа буй болгож, хэдхэн үгээр оюуныхаа баялгийг бүтээж байна. Хэрэглэж байгаа үг хэдий чинээ цөөн байх тусам сэтгэлгээ төдий чинээ ядуурч байдаг. Тухайн үеийн сэтгэлгээний эл дол болсон хуучин загварыг эвдэхийн тулд тогтсон хэллэг, үг өгүүлбэр, үгийн хоршил зохицлын хэвшлийг эвдэх хэрэгтэй. Шинэ сэтгэлгээг гагцхүү шинэ үг л илэрхийлнэ.

III. Энэ шинэ үг хаана байна вэ? Ямар шинэ үг вэ? *Д.Батбаяр*

- | | |
|--------------------------------|---|
| I. Үг гэдэг ... эзгүй дун. | Үгэнд оюун санааны зөвхөн мөр л байдаг. |
| II. Үхэл бол нэр үгийн хувьсал | Амьдрал бол үйл үг. |



III. Үгийн хоршил зохицлын хэвшлийг эвдэх



Дасгал 39

Нийтлэлийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Түүхэн товч “Их гурвалжин” номоос

Африкийн Олдувайг малтсан доктор Л.Б. Лики хүний хувьслыг 2 сая жилээр хэлэлцэх болгов. Монголын чулуун зэвсгийн нас 500-700 мянган жилд хүрэв. Ухаант хүмүүн Хомо Сапиенс төрөлтөн 40-50 мянган жилийн өмнө бий болжээ. Үүнд: Хомо ба хүмүүн нь нэг гарвал язгууртайг эрхбиш анзааръя. Зүгээр яльгүй тоглож хэлэхэд гуманизм нь хүмүүний зам. Тоглохгүй хэлэхэд, гуманизм хэмээх анх дахин сэргэлтийн Италид гарсан ойлголтыг бид хүмүүнлэг, энэрэнгүй үзэл гэж багагүй өрөөсгөл ойлгодог. Гэтэл гуманизм нь хүнийг тэр чигээр нь сайнтай муутай нь хүлээн зөвшөөрч, хүлцэн тэвчих тухай сургаал юм.

Дээр цагт хийсвэр оюун дүгнэлтийн анхдагч хэлбэрүүд үүсэж, хүмүүс саланги үг юм уу, энгийн хялбархан өгүүлбэрээр хэлэлцэж байв гэнэ. 7000 жилийн тэртээ эртний их соёл иргэшлүүдийн суурь тавигдаж, чухам энэ зааг дээр логик дүгнэлтийн төгс хэлбэрүүд боловсорч, хэлэнд нарийн нийлмэл өгүүлбэр зүй нэвтэрч, олон хэл ялгаран, салах үйл явц эхэлжээ.

Хүн өөрийгөө сэтгэж байна хэмээн ухамсарлаж, энэ тухайд эргэцүүлэн бодох болсон нь 5000 жилийн өмнө тохиосон гэж үзнэ. Чухам тавин зууны өмнө эртний Египетийн нэгэн бээр бичиж үлдээсэн нь: “Нүд харна, чих сонсоно, хамар агаар үнэрлэнэ. Тэд зүрхэнд аваачна. Зүрх бодсоныг хэл даган давтана. Тэгж аливаа ажил, аливаа чадвар, гарын бүтээл, хөлийн гишгэлт, бүх эрхтний хөдөлгөөн нь зүрх сэтгэж, хэл өгүүлсэн тушаалаар болно” гэжээ. Эртний хүн сэтгэх үйлийг зүрхэнд хамаатуулж байсан нь нийтлэг үзэгдэл бөгөөд энэ нь тийм ч тэнэг дүгнэлт биш болохыг хожмын хийгээд бүр өнөөгийн шинжлэх ухааны ололтоос харж болно. Сэтгэх нь сэтгэлийн чин зорилгоос хамаардаг.

Тэгсээр 2500 жилийн өмнөөс сэтгэх үйлийн асуудлыг эртний Энэтхэг, Герег, Хятадад нягтлан судлах болсон аж. Бүрэн хэлбэржсэн учир шалтгааны ухаан Аристотель, Дигнага, Дхармакирти нарын бүтээлд цогцолсноос хойш математикийн үндэслэлийн тухай математик салбарыг эс тооцвол нэмэлт засвар шаардлагагүй байсаар экстремаль логик зарчмыг томьёолоход хүржүхүй.

Маш эртний армаг тармаг сэтгэмж дүгнэлтүүд нэг үе зөвхөн өнгөрсөн баларсны бүдүүлэг дуртгал мэт харагдаж байсан бол шинжлэх ухаан орчин үед нарийн төвөгтэй асуудлыг шийдэх хэрээр анхдагч сэтгэмжүүд санаанд багтамгүй мэргэн ончтой байсан нь улам бүр илэрч байна. Анхны санаа алт гэдэг нь тэр байх. Ер байгальтай цул нэгдмэл байсан эртний хүний зөн нэн хүчтэй байсан гэх. Үүний улбаа нь бөө мөргөлийн зүйл.

Нэмэлт. Хүн бид биологийн хувьслын эрхэм дээд бүтээгдэхүүн бөгөөд хүний хэлбэр дүрс анатоми яагаад чухам ийм байдаг, өөр байж болоогүй юм бэ гэдэг сониноосоо илүү суурь асуудал бий. Хамгийн гайхалтай нь хүний дүрс, тэр байтугай, анатоми, физиологийн гол онцлогууд үнэмлэхүй геометрийн суурь байгууламж дүрсээр яв цав тодорхойлогддог юм байна. Ертөнцөд ганц л геометр байх учраас энэ ойлгомжтой хэрэг. Тэр суурь дүрс ер бүх амьтны хэлбэр дүрсийг тодорхойлж байна. Тэгвэл могой огт хамаатахгүй биш үү гэж асууна. Хамаатна. Гэхдээ амьтдын хэлбэр галбир нь мөнөөх үндсэн геометр дүрсийн аль нэг параметрийг хэт хөгжүүлсэн байх юм. Хувьсал хөгжлийн спираль хуулиар чухам хүний анатоми анхдагч геометр дүрсээ гойд бүрэн төгс давтсан байна. *Ч.Эрдэнэ*

а. Дараах гурвалжаас “Түүхэн товч”-ийн сэдэв, гол санааг тодорхойлж бич.




б. Энэ шинжлэх ухааны нийтлэлд эшлэлийг хэдэн янзаар хэрэглэснийг тайлбарла.

в. “Зүгээр биш үү, яльгүй тоглож эхлэхэд, Хомо Сапиенс эрхбиш, бүр, гэхдээ, тэр байх, тэр байтугай, багагүй өрөөсгөл ойлгодог, ер тоглохгүй хэлэхэд, үүнд, гэтэл, тэр бие сэтгэл чигээрээ, гэж үзнэ, гэжээ, зөвхөн, улам бүр, гэнэ, чухам, эс тооцвол, томьёолоход хүржүхүй, санаанд багтамгүй, ер гэх, сониноосоо илүү, хамгийн гайхалтай нь, энэ

ойлгомжтой хэрэг, нэн, тийм ч тэнэг дүгнэлт биш болохыг, яв цав, юм байна” гэх мэт үг, өгүүлбэр эхэд ямар утга санааг илтгэж, ямар үүрэгтэй болохыг тодорхойлоорой.

- г. “Чулуун зэвсэг, учир шалтгааны ухаан, шинжлэх ухаан, оюун дүгнэлт, өгүүлбэр зүй, анхдагч сэтгэмжүүд, бөө мөргөл” гэх мэт нэр томьёог ялгаж, тус бүрийг толь бичиг ашиглан тодорхойлоорой.
- д. “Санаанд багтамгүй, улам бүр, тийм ч тэнэг дүгнэлт биш, нэн хүчтэй байсан гэх, хүнийг тэр чигээр нь” гэх зэрэг ярианы хэлний үг, холбоо үгсийг түүн бичиж, найруулгын өвөрмөц онцлогийг тайлбарлана уу.
- е. Эхийг уншаад, төрсөн сэтгэгдлээ бичээрэй.
- ё. “Түүхэн товч” хэмээх эхийн агуулгыг дараах байдлаар бүлэглэсэнтэй санал нэг байна уу, ярилцаарай.



Үгсийн тайлбар:

Аристотель - (НТӨ 384-322) эртний Грекийн гүн ухаантан. Платоны (НТӨ 427-347)-ы шавь бөгөөд Афинд бие даасан сургууль байгуулж, “Физик”, “Метафизик”, “Оюун санааны тухай” зэрэг бүтээл туурвижээ.

“Аналитик”, “Категори”, “Улс төр” зэрэг алдарт зохиолуудыг бичжээ.

Дигнага - (НТ-ын 480-540) буддын логикийг үндэслэгч, гэгээрлийн онолч, Энэтхэгийн гүн ухаантан.

Дхармакирти (НТ-ын VII- VIII зуун) буддын логикийг хөгжүүлэгч, гэгээрлийн онолч, Энэтхэгийн гүн ухаантан.

Олдавай - Л.Лики 1959 онд Хойд Танзаны Олдавайн агуйгаас 2 сая жилээс дээш насны хоёр хөлт, эртний хүний яс олжээ. Энэ нь Австралийн хүн дүрст амьтантай төстэй аж.

Луйс Лики - (1903-1972) Английн хүн судлаач, хуучны судлалын эрдэмтэн, Тэрээр Зүүн Африкаас эртний хүнийг нээн олжээ.

Экстремаль логик - (extremum)-захын, дээд гэсэн утгатай латин үг. Нарийн төвөгтэй хүнд, дээд логик. Үүнд Эйлорын ялгаварлах тэгшитгэлийг жишээ болгожээ. “Л.Эйлор (1707-1783)-ийн дугуй” гэдгийг тоо ба физикийн багшаасаа лавлаарай.

“Метаматематик- тооны бус тоо буюу тоо зүйн дараах тоо зүй” гэсэн утгатай параметр- юмын гол шинжийг заасан хэмжээ.

Хомо Сапиенс - анхны оюун ухаант хүн.

Гуманизм - хүмүүнлэг энэрэнгүй ёс.



Уран нийтлэл

1. Цаг үеийн чухал сэдвийг өргөн цараатай дүрслэн үзүүлдэг
2. Сэдэвт холбогдох жишээ баримтыг зэрэгцүүлэн жишихийг чухалчилдаг.
3. Уран зураглалыг онцгой сэтгэмж, гүн сэтгэгдэлтэй чадмаг хослуулдаг.
4. Нийт олны санал хүслийг илэрхийлэхдээ өөрийн үзэл бодол, үнэлгээг дэвшүүлсэн байдаг.

Эсээ

Элдэв жишээ баримтыг олон шалтгаанаар тал бүрээс нь тайлбарлана.

Чөлөөт сэтгэлгээгээр задгай тайлбарлахыг оролддог.

Хэлц ба хэлц бус, дүрслэх ба найруулах ур маягийг бүтээлчээр хэрэглэж, сэтгэхүйн өвөрмөц сонголтыг эрхэмлэнэ.

Сэдвийн тухай асуудлыг эргэцүүлэн бясалгаж, бодлоо чөлөөтэй илэрхийлэхдээ өөрийгөө танихыг ямагт эрмэлзэж байдаг.

Чулууд

Үрэл хөх чулууд шаргисан намхан давааны оройд саатаж, өвөг дээдсээс ирүүлсэн бэлгэ мэт намрын номин хөндийг ширтнэм. Морин хөх зэрэглээнд хэдэн цагаан гэр нисэн нисэн алдан, сэрүү татсан хөндий нулимс асгарам уянгалаг.

Наранбулаг минь... тэнд хэдэн хүүхэд морьт усалж, бага шиг нь зэрэглээн дунд тоодог адил гүйж харагдана. Мориноос буугаад би хөх хөх чулуудыг илбэн санаа алдав. Зарим чулуу нь цэнхэр, зарим нь шувуу шиг цагаан, мэдээж хун цэн л бодогдоно.

Хүүгийнхээ толгойг илбэх шиг би чулуудыг илбэсээр л явлаа. Насны багад энэ чулуудын дээр сур элдэж, мөн ч их зовоодог байж дээ. Чулуу өвддөг бол хөөрхий сөн. Өдөржин нойтон сураар ороолговч чулуу эс дуугарна. Харин би л ядарна. Тэгээд би чулуун дээр сууж амардаг сан.

"Монди чинь, чулуун дээр яг л шувуу шиг суучихсан, тараараа* хашхирч байх юм" гэж эмээ үглэнэ.

Эдүгээ санахад, энэ хэдэн чулуу намайг хатуужуулж, хол явах хүч өгсөн юм. Эмээ минь алга. Чулууд л үлджээ. Намрын хөх зэрэглээнд аргал түүж явсан эмээ минь уянгалаг, мөнхийн номин хөндийдөө намайг орхиод, хорвоогийн зэрэглээнд ууссан бололтой.

Удган ээрүүл (Хас ба хос)

...Европ зүгт зөвхөн эр бэлгэ, Дорно дахинд эр эм бэлгэ хоёул буй бөгөөд соёл, ахуй судлалын үүднээс энэ нь гүнзгий агуулгатай, зарчмын үзэгдэл болохыг дараах бүлгүүдээс үзмүү.

"Ёсгүй ёс гэж байхгүй" гэсэн хуучны үг нар зөв эргэх монгол заншлын тухайд туйлын сонин учир холбогдолтой. Юу гэвэл, нар зөв, буруу эргэх нь ертөнцийн орон зай, цаг хугацааны доторх физик үзэгдлийнхээ хувьд тэс өөр зүйл болохыг профессор Н. Козырев нарийн туршилтаар харуулж чадсан юм. Нар зөв эргэх физик хөдөлгөөн нь дэлхий дээрх цаг хугацааны чиглэлтэй зохирч, улмаар энерги хуримтлуулах арга болдог байхад нар буруу эргэхэд энерги алддаг нь гироскоп (удган ээрүүл)-оор хийсэн туршилтын хэмжилтээс тод илэрсэн байна. Тэгэхээр баруун зүүн зүг ч адил бус физик утгатай байж болно. Монгол ёсонд баруун талыг эрхэмлэх бөгөөд С.Чагдуров үзэхдээ "баруун" нь хожмын Энэтхэг Варуна (баруун зүгийн тэнгэр) болсон гэжээ. Эртний монгол домог зүйд зүг чигийн ялгааг гойд анхаарч, үндэслэлийг яст мэлхий суурьт хорвоогийн домгоор гаргасан байдаг.

Ертөнцийн таван махбодын асуудал угтаа үүнээс гарчээ.

* тар - хүн амьтны ир чадал, танаг

Би мориндоо мордож, дэргүүлсээр булгийн эхэнд очив. Яг энэ хэдэн чулууны дунд аавын гэрийн буурь байна. Энд би газар дэлхий, мөн хүмүүстэй учирсан юм. Алаг дэлхийд унасан эхний өдөр надаас холдон холдсоор авч, хожмын нэгэн өдөр би хорвоогоос алдууран, эхний өдөртөө очиж, нийлэх бөлгөө. Ертөнцийн тооцоонд орж ирсэн өдөр минь өвөл цагийн улбар нар ээсэн, хялмааны ширхгүүд нүд гялбам солонгорсон агшнуудаас бүрджээ. Өдөр түлхэн ессөөр хожим нь оддын цэнхэр, шар, улаан, ногоон чулуу гарт шаргидаг бага насандаа үлгэр үнэн хоёрын гүүр- тэнгэрийн заадас ширтэн, оддыг өнгө өнгийн чулуу шиг боддог байж... Хамгийн гоё, хамгийн хөөрхөн чулууг хамт тоглодог Хонгорзулдаа эрж, бэдчин явдаг байж! Тэр энхрийхэн нялх амьтан надад оддын дундаас олз олох шиг бас л чулуу түүж ирдэг сэн.

Гэрэлт дуртгалын манан дундуур би бэдчиж, санааны минь хамгийн гүн мухарт хадгалаастай явдаг үл хиртэх цагаан чулуу шиг бодлоо. Өнгөт кино шиг үзэж сууна. Оддын хөвгүүн, оддын охин хоёр шиг наадаж явсан жаахан Хонгорзултайгаа эдүгээ учирвал хэн хэнээ эс таних биз. Таньсан ч харь гаргийн гийчин мэт өөр санагдах биз.

Оддын шүлэгч болох сон.

Оддын чулуу түүх сэн.

Оддын охинд дурлах сан.

Инээдэмтэй атлаа бяцхан гунигтай энэ бодол намайг сэргээж, “Шүлэгчийн бардам сэтгэлээр би Шөнийн тэнгэрт од атгалаа” гэж арван хэдэн настайдаа бичиж явсныг минь сануулав. Одтой явсан тэр алтанхан үедээ би амьдралынхаа гарчгийг тавьжээ. Эдүгээ би шүлгүүдээ нялх багын тунгалаг ариун сэтгэл шингэсэн юунд ч үл хиртэх оддын чулуу байгаасай гэж хүснэм...

О.Дашбалбар

Өнөөгийн физикийн ухааны яв цав ойлголтоор орчлонг үүтгэж, шүтэн барилдуулсан тэр арга хоосон чанар нь тэгш хэмийн зарчим юм. Гэхдээ хамаг учир нь хатуу хэрэгжих тэгш хэмд бус, харин тэгш хэм яльгүй, гэвч гүнзгий үр дагавартай зөрчигдөх, алдагдахад оршино. Хаана ямар тэгшхэн үйлчилж, яаж тэгш хэм алдагдаж байгаа нь онолын физикийн судалдаг үндсэндээ ганц сэдэв билээ.

Физик ертөнцийн зүг чигийг ав адилхан (изотроп) гэж үздэг ч чухам эргэх хөдөлгөөнд зүг чиг хамаатай болох нь Козыревээс өмнө ч харагдсан байхад ерөнхий дүгнэлт хараахан гараагүй л байна. Монголд гироскопыг удган зэрүүл гэх бөгөөд удган нь бөө мөргөлийн гол нэр томьёо, үг байдаг нь дээрх удгантай холбогдоод ирэхээрээ гайхалтай юм. Хэрэв Дорнын анагаах ухаан олон мянган жилийн үнэмлэхүй нарийн гярхай ажиглалт, зөн бэлгэч сэтгэлгээний хам үр дүн байдаг бол зүг чигийн санамсаргүй мэт зааг ялгааг ч эртний хүмүүс туршилтаар тогтоосон байхыг үгүйсгэх аргагүй.

Ер нь гироскопын онолоор Эйнштейн ч оролдож байсан хүнд салбар бөгөөд өнөө хэр бүрэн дүүрэн онол байхгүй гэж физикчид хэлдэг юм. Энд молхи бичээчийн хэлэх гэсэн санаа гэвэл, аливаа домог нь дам үг боловч утга ба үндэслэл төгс байж болох юм шүү гэдэгт оршино. Нар зөв эргэх ардын заншил гэхэд гүн агуулгатай байна. Үнэмлэхүй геометрийн нэмэлт. Материйн гүн түвшинд баруун ба зүүн зүг яльгүй ялгаатайг физикт Ян Женьнин томьёолж, хатагтай Ву туршилтаар баталсан юм. Харин энэ ялгаа буюу (Chirality) зөв, солгой гарын гэдэг үзэгдлийн язгуур шалтгааныг мэдэхгүй байлаа. Гэтэл чухам үнэмлэхүй геометрт зүг чигийн тэгш хэмийн алдагдлын учир шалтгаан бүрэн илэрч байна. *Ч.Эрдэнэ*

Удган - эм бөө,

удган зэрүүл - хүүхэд эргүүлэн наадах тоглоом,

удган эрвээхэй - толботой шавж,

удган хатираа - морь гурван хөлөө зэрэг

гишгэж, нэг зэрэг газраас хөндийлөн явах

Гироскоп - гиро - дугуйрах, эргэх

Миний эх орон – Миний тоонот

Хэдэн жилийн өмнө намар цаг Алтайд явахдаа Ховд голын Баян нуурын тавилан дээр түр саатаж билээ. Ховд голын ус хүүхдийн сэтгэл шиг тунгалагхан мэлмэрээд, намрын алтан улиас ганц хоёр навчаа харуусах мэт уснаа орхин, аян замд баахан алжаасан бид дуу шуу цөөнтэй бодол болон Алтайгаа халиаж суусан сан.

Тэртээ умард тэнгэрийн мандалд Хархираа Түргэний бадамласан цагаан оргилууд бага насны гэгээн зөгнөлд ургадаг асан үлгэрийн орныг санагдуулан, өмнөхөн талд Цамбагарав гэж бардам нэртэй их уул цаст оргилынхоо сэрүүн цагаан салхийг бидний зүг илгээн байлаа. “Чи бас азтай хүн шүү!” гэж ямар нэг далдын юм чихнээ шивнэхүйд “Би бас азтай хүн шүү” гэж дотроо давтан хэлж билээ. Тэгтэл “Энэ сайхан эх орон чинь хаанаас эхэлсэн билээ” гэж өөрөөсөө асуун, Онон голын хойд бие Галт хан гэдэг хадат хөх уулын өвөрт, орхигдсон өвөлжөөний арын дэнжид байдаг тоонотоо харах шиг болсон. Эхээс төрөхөд хүйсийг минь булж дарсан тоонот хэмээх тэр нэг элгэн хүрэн чулуу юутай бүлээхэн санагддаг билээ. Тоонот гэрээ барих хүн төрлөө гэж тоонот гэсэн тохмын чинээхэн газраас эх орон минь эхэлсэн гэлтэй. Тэндээс амьдралын минь өлзийт зам эхэлж, би эх орноо таньсан.

Үзүүр шугуйн модонд
 Үрээн бугын гүйдэлтэй
 Үзээд хойшоо харахад

Ийм л хол Алтай даа гэсэн дуутай алсын хүдэр баян Алтайдаа би иржээ. Казахын хар нүдэн бүсгүй домбор хөгжмийн эгшгэнд уяхан биелгээ хийж, шар шувууны өд хатгасан малгайтай эрэмгий эрчүүд жороо морь уралдуулахыг үзээд, халирхаж хачирхсангүй, харин ч сэтгэл уяран Онон голын шугуйд хур шиг шаагих адуунд явдаг асан ангир шарга морио, айл аймаг, ах дүүгээ гэнэтхэн их санаж билээ. Алтайдаа миний тоонот байлаа.

“Хоёр хангайн нутаг хүрэлтэж найгана,

Хошууны олон та нар минь санагдах л янзтай”. Аль тавин долоон оны зун Архангайн урд Тамирын хөвөөнөө сонссон энэ дуу сэтгэлд уяатай явдаг юм. Жаран долоон онд Энэтхэг Жумна мөрний хөвөөнд зогсон байтал тэр дууны үг, аялгуу сэтгэлд орж ирэхэд “Би чинь нутгаа саначихжээ. Түргэхэн л харья” гэж бодсон сон. “Хоёр хангайн нутаг хүрэлтэж найгана” гэхээр сэтгэлд нэг юм бууна шүү дээ, та минь. Өвөрхангайн Найман нуурыг үзээгүй бол нутгийнхаа сайхныг мэдсэн гэж бүү бод гэж хэн хэллээ дээ. Тийнхүү Найман нуурыг үзье гэж бодон бодсоор бас л нэг намар, шувууны зудаар хүрээд очлоо. Ширээтийн даваан дээр гараад ирэхэд хүрэлтэн найгах хөвч уулсын дунд холбоо Найман нуур мэлтэс хийн харагдаж билээ. Тэртээ чанадад Орхон мөрний эхний уулс униартан цэнхэрлэж сэтгэл уужруулан “Энэ сайхан орондоо урт удаан насалж, их юм бүтээх сэн” гэсэн сэтгэл аяндаа төрж билээ. Бага диваажин хэмээх Найман нуурыг үзээд, үнэхээр нас нэмэх шиг болсон. Энэ дэлхий дээр хэчнээхэн амьд явахыгаа мэдэхгүй боловч нутаг усныхаа үзэсгэлэн гоог бишрээд, нас нэмлээ гэж бодох ч жаргал шүү дээ. Хангайдаа миний тоонот байлаа.

Би говьд сэтгэлтэй болсон хүн. Шаргын говиос Галавын говь хүртэл явж, хүн байгаль хоёрын мөнхийн тулалдааны шастир болсон тэрхүү гайхамшигтай бөгөөд сэтгэл булаах далдын их увдистай сүр хүчин яруу уянга хосолсон газар нутгийнхаа бүлээн дулааныг мэдрэхүйд “Ямар их хувь заяагаар бид эзэн нь болж төрөв” гэсэн шүлэгчийн үг санагдаж билээ. Говьд олон ч удаа очлоо.

Очих бүрийд заавал нэг сонин сайхан талаасаа үзэгдэн, бодлын түмэн сэжүүр гаргаж өгнө. Говийн байгальд яруу уянга, сүр хүчин хосолсон нь хүндээ бас шингэжээ. Би говийн хүний ааш араншинг таниад, амьдралд илүү их итгэсэн. Тийрэлтэт онгоцны утаан сүүл мэт хулангийн цагаан тоос, уулсыг газраас тасалсан усан бага насны яруу найраг сэрэн алдаад ер сэтгэл алжаалж, онгод унтрахын цагт эх орны газар шороо, уул уснаас урам зориг төдийгүй ухаан бодол ч ургаж болохыг мэдэрнэм билээ. Зуны цэнгэлэгхэн орой Гурван Сайханы хяр дээрээс говийн манант алсыг ширтэж, чухам ямархан үгээр зурж болохыг олж ядан суутал “Үлэмжийн чанар”-ыг бүрэн шингээсэн ялдамхан бор бүсгүй цагаан тэмээ унаад ирж явна гэж зүүдлэх мэт болсон тэр цагаас хойш түүнийг говийн бэлгэ тэмдэг гэж бодох болсон билээ. Говьдоо миний тоонот байлаа.

Дорнодын тал минь. Монгол хүний суу залиг бадруулсан баян тансаг, хотол төгөлдөр тал минь. Гадаад их далайн давлагаа мэт үелзэнхэн тогтсон ухаа гүвээнүүдийг давж, Хэрлэн мөрний холч урсгалыг дагаж, хэчнээн ч явав даа. Талдаа очиход сэтгэл найман сарын нарлаг өдөр шиг дэлгэр тэнүүн боллоо. Ганган нуурын ганган улаан бургас ганхаж байхыг үзсэн цаг амьдралын их олз мэт санагдан, Тоорой бандийн домогт Шилийн богд, талын дунд асарлан цэнхэрлэхүйд монгол хүн оршин амьдарсан цагаас энэ гэрэлт дуулим тал минь хэчнээн юм үзээ бол оо гэх зэрэг олон юм бодогдсон сон. Өнгөрсөн дайны талбар монгол хөвгүүдийн цус шингэсэн Халхын голын дэнж талд алимны мод цэцэглэн, хэдэн сая дүнчүүр цагаан эрвээхэй газарт буусан юм шиг эх орон, эх нутгаа харийн дайснаас өмөөрөн тэмцэж амь алдагсдын гэгээн дурсгалыг тийнхүү таван сарын цагаан эрвээхэй цэцгээр мялаасан юм шиг байхыг би үзсэн. Хэрлэнгийн усаар ундаалсан халхын удамт хурдан хүлгүүдийн тоосон дундаас түмний эх цойлон гарч, унасан хүүхдүүдийн цовоолог дуун хангинахад, учиргүй уяхандаа биш сэтгэл жигтэй догдолсондоо нулимсаа сэмхэн арчиж явснаа хүртэл тэр болгон тохиолдоогүй явдал шиг санах юм. Талдаа миний тоонот байлаа.

Алтай, хангай, говь, тал. Миний эх орон - Миний тоонот билээ. *С.Эрдэнэ*

1. Эхийн сэдэв, санааг тодорхойлоорой.
2. Нийтлэлийн эхлэл төгсгөл хоёрыг олоорой.
3. Уг нийтлэлийг 4 хуваасан өгүүлбэрийг олж, учрыг тайлбарлаарай.
4. а. “Ховд голын ус хүүхдийн сэтгэл шиг тунгалагхан мэлмэрээд”...
 б. “Намрын алтан улиас” гэсэн шиг ил ба далд адилтгалыг түүж, юуг юутай адилтгасныг тайлбарлан бичээрэй.
5. “Тоонот гэрээ барих хүн, тэр нэгэн элгэн хүрэн чулуу юутай бүлээхэн санагддаг билээ, тэндээс амьдралын минь өлзийт зам эхэлж, тохмын чинээхэн газраас эх орон минь эхэлсэн, Найман нуурыг үзээд, нас нэмэх шиг болсон, монгол хөвгүүдийн цус шингэсэн Халхын голын дэнж

талд алимын мод цэцэглэн” зэрэг өгүүлбэр яагаад тойруулал болсныг тайлбарлаарай. Жишээ нь:

“Энэ дэлхий дээр хэчнээн амьд явахыгаа мэдэхгүй боловч нутаг усныхаа үзэсгэлэн гоог бишрээд, нас нэмлээ гэж бодох ч жаргал шүү дээ” гэсэн өгүүлбэр доторх “энэ дэлхий дээр хэчнээн амьд явах” гэдэг нь “хэд наслах”, “нас нэмлээ” гэдэг нь “ухаан суулаа, ухаарлаа” гэснийг тойруулж хэлсэн байна.

6. “-хан⁴” бүтээврийг ямар үгсийн аймгийн үгнээ залгасныг тогтоож, уг үг өгүүлбэрт ямар утга илэрхийлж буйг тайлбарлан бичээрэй.
7. Сэтгэл мэдрэмжийн утга бүхий “хүүхдийн сэтгэл шиг, гүлмэрхэн бага насны яруу найраг сэрэн сэрэн алдаад, унасан хүүхдийн цовоолог дуун хангинахад, сэтгэл жигтэй догдолсондоо нулимсаа сэмхэн арчиж явснаа хүртэл...” гэх мэт өгүүлбэрийн учир холбогдлыг уг уран нийтлэлийн юутай холбогдож байгааг тайлбарлаарай.
8. Уул усны оноосон нэрийг Алтай уул, Ховд гол гэж ялган бичиж “Монголын газар зүйн дээж бичиг” (Уб., 1976), Ш.Шагдарын “Монголын газар зүйн нэрийн товч толь” (Уб., 1978), О.Намнандоржийн “Монгол орны газарзүйн гайхам сонин” (Уб., 1967) зэрэг номыг ашиглан, товч тайлбар бичээрэй. Жишээ нь: Ховдын их тохойгоос урагш Хонгор - Олонгийн голоос хойш цасан хүрмээ байнга өмссөн, мөсөн гол тал бүр лүүгээ унжуулсан алдарт сайхан үзэсгэлэнт 4213 м, өндөр цаст богд буюу Цамбагарав уул хөх мөнх тэнгэрийн хөвөн цагаан үүлсийг тулж, наран сөрөг харахад шижир алтан туургатай, сийрс мөнгөн дээвэртэй сэрүүн сайхан орд харш лугаа адил гялалзана. *О.Намнандорж*
9. Унасан хүүхдүүдийн цовоолог дуун хангинахад ...гэхэд “-н” дагавар ямар утгатайг тайлбарлаж дараах жишээгээр өгүүлбэр зохиогтун. намираан, адуун, ахан, цасан, зүрхэн, цусан



Үгсийн тайлбар:

дүнчүүр - 9 оронтой тоо, зуун сая

хур - өнгө харавтар, бие хавтгай, сүүл охор, агнуурын шувуу, хар гургуул

тавилан - ачаа, тэрэг ба зорчигчдыг тээвэрлэх, ус гаталгагч хөвөгч байгууламж

цэнгэлэгхэн - буриад аялгууны сэнгэлиг хүжюун (хөхин баясах) гэсэн үг

шувууны зуд - намар шувууд олноороо цуглах шувууны чуулган

асан - байсан

халиах - харах

тоонот нутаг - төрсөн нутаг

шастир - үеийн үед уламжилж ирсэн түүхийн бичиг

диваажин - тоост ертөнцөөс бусад бурхад сахиулсан орших ариун амгалангийн орон

сахиулсан - түмэн бодисыг харж хамгаалах бүтээж чадах шид бүхий эзэн

үрээн буга, үрээ - 3-5 насны эр адуу

НИЙТЛЭЛ БИЧИХ

Уншигч, зорилго, нөхцөл байдалд тохируулан бүтэц,
хэв маягийг сонгон бичье



Дасгал 41

а. Бичил эхийг уншаад, өөрийн үзэл бодлоо тусгасан, уран нийтлэл болгон найруулж бичээрэй.

Бичихдээ:

М.Горькийн “Салхич шувууны дуун”

“Посейдон болон далай тэнгисийн тэнгэрүүд”

(Эртний Грек, Ромын домог туульс Уб., 2015 25-28-рт)

Галидас “Үүлэн зардас” Уб., 1963

“Одиссей салхины тэнгэрийнд ирсэн нь”

(Хомерын туульс Уб., 1974, 85-87-рт) зэрэг зохиолоос үлгэр аваарай.

Зардас

Хүрхрэн давлагаалах далай шиг аюумшигт сүртэй юм хорвоо дээр үгүй мэт. Хязгаар хярхаггүй асар том амьтан сэрвээ юүгээ босгон түг түмэн сарвуугаараа газар дэлхийн элэг тэмтчин хүрхрэх нь тэнгэрийн зарлигийг сонсгон буй зардас гэлтэй. Тэнгэр эцэг зарлиг юугаа энэхүү зардсаар дамжуулан, хүн амьтанд илгээдэг ч юм билүү. Гагцхүү амьтан хүний заяа доройтсоны урхгаар тэнгэрийн хэлийг мартаж, зарлиг юуг нь сонсохоо больсон байж болзошгүй. *Д.Батбаяр*

б. Цогцолборыг уншаад, нийтлэлийн шинжийг ярилцаж, уран дүрслэлийг ойролцоо утгатай үг хэллэгээр солин найруулж бичээрэй.

Өндөр албыг хаах.....

Уушгиа хийлэх.....

Тулалдаанд бэлэн жагссан хороо цэрэг шиг.....

Сэргийлж байх.....

Барьж хориглох.....

Хамар бол халаагч.....

Хамар бол хөлдөөгч.....

*Нийтлэл бол юмсын
утга учрыг оюуны
үнэт зүйлтэй
холбож, уран яруу
тайлбарладаг.*

Хамар зөвхөн үнэрлэхээр барахгүй, амьсгалах эрхтний өндөр албыг хаана. Хамраараа агаар сорж, уушгиа хийлдгийн ачаар хүн амьд явдаг. Хамрын нүхэн дотор тулалдаанд бэлэн жагссан хороо цэрэг шиг олон тооны үс сэрвийн сэргийлж байх бөгөөд гаднаас сорогдон орж ирсэн агаартай хамт тоос шороо нэвтрэхээс сэрэмжлэн, өчүүхэн жижиг тоосонцрыг ч дотогш оруулахгүй барьж хориглоно. Хамар агаар цэвэрлэн шүүж байх зуураа хүйтэн халууныг нь тааруулж, нэг секундын дотор нэмэх 36-37 хэмд хүргэдэг ер бусын хүчин чадалтай халаагч юм. Халаагч төдийгүй бас хөргөгч ажээ. Халуун агаарыг 36-37 хэм хүртэл хөргөөд, уушгинд дамжуулдаг тул маш гайхамшигтай эрхтэн мөн.

Л.Түдэв “Хамар”

в. Уран нийтлэлийн шинжийг тайлбарлаад, цогцолборыг хурааж бичээрэй.

Хөх монгол, их эзэн богд Чингис хаан хоёрыг дагаж төрсөн Та минь хэн сэн, юу сан, ямар сан, яасан сан билээ? Нас сүүдэр тань долоон зуун тавин он зооглосны өлзий буяныг дэлгэрүүлэх энэ өдөр айлтгал эрж, ерөөлд нэхэн сануулах, өөртөө нөхөн шивнэх, тандаа сүслэн айлдварлах олон бус цөөн ч бага бус, их бодол надад байна. Чингис төрөхдөө “нууц товчоон” Таныг Хасараас том дүү, Өүлэнээс их эжий, Жамухаас их анд, Шихихутугаас илүү мэргэн, Мухуйлайгаас давуу баатар болгон дагуулжээ.

Та азын есөн тэнгэрийн гайхамшигт учралын тохироо. Та арван хоёр жаран хагасын өмнөх оюуны тэнгэрийн хүрд. Та цагийн сүнсэнд амилсан ном, номын биед оршсон цагийн сүнс. Таныг бурхан хүмүүс, хүмүүн бурхад бүтээжээ. Чингээд, та хүмүүний гэтэл бурхны, бурхны гэтэл хүмүүний бүрэлбаа, номон тэнгэрт шилжсэн нирваан дүр, мөнхөд үүрсэн хатирах түүхийн цагаан хүлэг явсаар өдгөөг хүрчээ. Таныг төрөхөд тэнгэр дүүрэн одод адуу шиг түрхрэн гэрэлтэж, Таныг хулгана жилийн сар туяагаараа угааж, Хэрлэний хөдөө арал Дэлүүн Болдог хормойдоо Таныг тосож, нутаг сэлгэн бууж асан хааны орд ширэн баринтагт Таныг сандчин өлгийджээ. Өлгийн бүс нь оонын хүзүүн хуйв, залсан газар нь их хааны тамга орших хоймор болжээ. Хүн төрөлхтөнтэй тэгш насалж, мөнх амьдрахын тань эрхэм учир дээр өгүүлсэн бүхэнд оршмуй. *Д.Маам “Монголын нууц товчоон мину зэ”*

г. Цогцолборт уран нийтлэлийн ямар шинж байгааг ярилцаад, утга, бүтцийг дуурайн, “Галаар тоглох аюултай” гэсэн эх зохиогоорой.

...Хүүхэд усаар тоглох их дуртай байдаг. Гэвч тоглоом нь шоглоом болж, хувцсаа норгохоос эхлээд усанд үйх хүртэл аюулд усан тоглоом хүргэж байсан удаа цөөнгүй. “Усаар тоглох нь галаар тоглохтой адил” гэсэн яриа байдаг...

Сүүлийн үед хүүхэд биш үүхэд нь “усаар тоглох” сонирхолтой болж, тэр нь өрнө зүгээс дорнодод шилжсээр байна. Монголчууд энэ тоглоомд оролцохоор ухалзах болов...

Усаар их тоглодог Орос орныг дуурайж, үлгэр авахдаа сайнд нь нүд гялбан “сохолздог” зуршлаа түр огоорч, сургамж болох саарыг нь хараагаа хурцлан ажиглах нь “усаар тоглох” аюултай тоглоомд орохын өмнөх хичээл байгууштай.

Дэлхий дээр усаар хамгийн их тоглож, олон тооны “хиймэл” далай байгуулснаараа Орос орон алдаршжээ. Гэвч тэр хиймэл далайгаар аялагчид ихэвчлэн “шаварт” суужээ.

“Рыбинское море” гэж алдаршсан нэгэн хиймэл усан сангийн ёроолд Молого гэдэг хот бүхэлдээ, бас 720 гацаа тосгон, хашаа байшин, тариа ногооны газартайгаа, мөн эцэг өвгөдийнхөө шарил, оршуулгын газартайгаа хамрагдан живсэн юм байна...

Ус гэдэг өөрийн хүндийн жинтэй учраас хаана их ус хуримтлагдана вэ, тэнд газрын хөрсөн дээрээс дарах ачаалал өр бусаар нэмэгдэж, эх газрын атар унаган нуруу хотойход хүрдэг нь гарцаагүйгээр барахгүй олон тооны хиймэл усан сангийн нийлбэр хүндийн жин нь эцсийн дүнд дэлхийн тэнхлэгт ч нөлөөлж, тэр нь улмаар экологийн гамшигт хүргэж болох аюултайг эргэцүүлэн бодсон хүмүүсийн ачаар Сибирийн их гол мөрдийг Дундад Ази руу эргүүлэн “юүлэх” их зөгнөлийн галыг түр унтраасан болой.

Л.Түдэв “Усан тоглоом”



Дасгал 42

Уран нийтлэл бичихэд юу анхаарах ёстойг ярилцаарай.

Зорилго:

- Юуны тухай бичих вэ?
- Яагаад бичиж байна ?
- Ямар чухал мэдээллийг тайлбарлах вэ?

Уншигч, сонсогч:

- Хэнд зориулж бичих вэ?
- Уншигч сонсогч энэ асуудлаар хэр мэдлэгтэй байгаа вэ?
- Уншигч, сонсогчдод ямар сэтгэгдэл төрүүлэхийг хүсэж байна?

Агуулга:

- Ямар гарчиг өгөх вэ?
- Ямар асуудал дэвшүүлэх вэ?
- Ямар санаа, мэдээллээр үзэл бодлоо дэмжих вэ?
- Ямар баримт ашиглах вэ?
- Ямар арга хэлбэрээр бичих вэ?

Бүтэц:

- Яаж эхлэх вэ?
- Гол үзлээ хэрхэн танилцуулах вэ?
- Хэсгүүдийг хэрхэн уялдуулах вэ?
- Гол хэсэгтээ баримт мэдээллийг хэрхэн уялдуулах вэ?
- Яаж төгсгөх вэ?
- Дүгнэлт ямар байх вэ?

Өнгө аяс:

- Мэдрэмж үнэлэмжээ хэрхэн илэрхийлэх вэ?
- Ямар өнгө аястай бичих вэ?
- Өнгө аясыг сэдэв агуулгатай хэрхэн тохируулах вэ?

Арга, хэлбэр

- Нийтлэлийн олон хэлбэрээс алийг нь сонгох вэ?
- Хүүрнэх, тоочих, тайлбарлах, эргэцүүлэх найруулбарын алиныг сонгох вэ?



Дасгал 43


а. Цаг үе, нөхцөл байдлаа ярилцаад, тулгамдсан чухал асуудлын жагсаалт гаргаарай.

*Ухаарал бодролын тухай юу?
Урлаг соёлын тухай юу?
Шинжлэх ухаан, техникийн талаар уу?
Нийгэм, улс төрийн талаар уу?*

- Монгол бичгээ эрхэмлэн дээдлэхийн учир
- Бид монгол ёс заншлаа умартлаа гэж үү?
- Хэлц бол хэлний дархлаа
- Их дээд сургуульд заавал сурах ёстой юу?
- Бэлэнчлэх сэтгэлгээ
- Гадаад хэлийг улс оронд нь очиж сурах нь чухал уу?
- Байгаль дэлхийгээ хайрлахын учир юу вэ?
- Байгалийн нөхөн сэргээлт юунд хэрэгтэй вэ? гэх мэт

.....
.....

б. Жагсаалтаасаа нэг сэдвийг сонгоорой. Аль болох тодорхой сэдэв сонгоорой. Тухайлбал:



Хэл соёл - Монгол хэл соёл - Үндэсний бичиг

- в. Яагаад сонгосон шалтгаанаа тайлбарлаарай.
- Энэ сэдэв яагаад чухал байв?
 - Энэ сэдвийн талаар хэр мэдэж байна?
 - Энэ сэдвээр ямар асуудал дэвшүүлж болох вэ?
 - Ямар зорилгоор бичих вэ?
 - Хэнд хандаж бичих вэ?
 - Уншигчид юуг ойлгоосой гэж хүсэж байна вэ?



Дасгал 44

Сонгосон сэдвийнхээ хүрээнд баримт цуглуулъя.

- Сонин хэвлэл, ном зохиол, телевиз радиогийн нэвтрүүлэг, интернет, судалгаа шинжилгээний бүтээл ашиглаарай.

Сэдэв

Үндэсний бичиг үсгээ хайрлан дээдэлье.

Ямар зорилгоор бичих вэ?

Монголчуудын оюуны соёлын өв, үндэсний бахархал болсон монгол бичгээ дээдлэх үзэл санааг дэлгэрүүлэх

Ямар асуудал дэвшүүлэх вэ?

Монголчууд үндэснийхээ бичгийг мартаж өсгүй.

Хэнд хандаж бичих вэ?


Нийт уншигч болон үндэснийхээ бичиг соёл, түүхийг мэдэхгүй хүмүүс, гадаадын хэл соёлыг хэт туйлшран шүтэгчдэд

Уншигчид юуг ойлгоосой гэж хүсэж байна вэ?

Мянган жилийн түүхтэй монгол бичгээ дээдлэн хүндэлж, хүн бүр сурахыг чармайн, үр хүүхдэдээ өвлүүлэн үлдээхийг эрмэлзэх, үндэсний хэл, соёлоороо бахархах

- Гол гол бус, хэрэгтэй хэрэггүй гэж ангилахыг бүү яараарай.
- Систем дэс дараатай тэмдэглэх гэж хичээх хэрэггүй, олсон бүхнээ л бич.

- Ямар эх сурвалжаас авснаа заавал тэмдэглээрэй.
- Сонгосон баримтаа хэрхэн цэгцлэх вэ? Дэвшүүлсэн асуудалд тохирох баримтыг сонгоорой.



Баримт хэрэглэгдэхүүн үнэн зөв, албан ёсны шинжтэй байна. Баримтаас эш татан авч ашигладаг. Бичиж буй зүйлдээ бусдын зохиол бүтээлээс баримт баталгаа болгон оруулсан өгүүлбэр, цогцолборыг эшлэл гэнэ. Эшлэлийг голдуу – гэ, - хэмээ холбох үгээр холбон найруулдаг. Жишээ нь: Нэн эртний судлалын тэргүүлэх мэргэжилтэн академич А.П Окладниковоос Монголын дурсгалын түүхэн онцгой ач холбогдлыг үнэлж дүгнэхдээ “Урлагийн эхлэл гараа, суурь үндэс, анхдагч эх булаг зөвхөн өрнөдөд бус, басхүү Төв ба Умард азийн гүнд буйг хойд Цэнхэрийн агуйд хийсэн ажиглалтууд гэрчилж байна” гэсэн юм.

- Дараах баримт хэрэглэгдэхүүнийг зөв харгалзуулж, ямар сэдвээр, ямар асуудал дэвшүүлбэл аль нь илүү тохирохыг дүгнэж ярилцаарай.

1. Хувь хүний шинжтэй.	<p>а. Монгол хэлний хуульд 2025 оноос төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ хос бичгээр хөтлөн явуулахаар заасан бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд монгол бичгийн дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр боловсруулж, монгол бичгийн үндэсний стандарттай болохоор зорьж байгаа юм байна.</p> <p style="text-align: right;"><i>www.nationallibrary.mn</i></p>
2. Албан ёсны мэдээллийн шинжтэй.	<p>б. Монгол бичгийн анхны дурсгал нь 13 дугаар зуунд урласан “Чингисийн чулууны бичиг” юм.</p> <p style="text-align: right;"><i>Монголын уран зохиолын тойм 1 дүгээр дэвтэр</i></p>
3. Эрдэм шинжилгээ судалгааны шинжтэй.	<p>в. Өвөг дээдсийн минь түүхийг бичсэн Өндөр төрийн хойморт заларсан Дэлхийд ганцхан босоо заяатай Дээд тэнгэрийн бичиг минь</p> <p style="text-align: right;"><i>Ш.Чоймаа</i></p>

- Нийтлэлийн үндсэн шинжүүдээс баримт хэрэглэгдэхүүнд холбогдох ойлголтыг ялган тодруулна уу.

Нийтлэлийн үндсэн шинж

- Судалгаа шинжилгээний тунгаан бодсон аястай, нийгмийн чухал асуудлыг хөндсөн, задлан шинжилж, нэгтгэн дүгнэсэн, шийдэх арга замыг заасан, үйл явдлын нягт уялдаатай, шинжлэх ухааны нэр томъёог өргөн ашигладаг.
- Албан ёсны шинж чанартай.
- Уншигч, сонсогчийн сэтгэлийг эзэмдэх, итгэл үнэмшил төрүүлэхийн тулд адилтгал, зүйрлэл, чимэг үг зэрэг уран дүрслэлийн арга, ярианы найруулгын үг хэллэг, өвөрмөц, хэвшмэл хэллэгийг өргөн хэрэглэдэг.

- Өөрийн сонирхож байгаа сонин болон интернэт вэбсайтын нийтлэл 5 – аас доошгүйг сонгон уншаад, тус бүрээс баримтуудыг ялган түүвэрлэж найдвартай сайн баримт мөн эсэх талаар дүгнэлт бичнэ үү. Дараах хүснэгтийн дагуу бичээрэй.

Сонин болон вэбсайтын нэр	Нийтлэлийн зохиогч, гарчиг	Нийтлэлийн дэвшүүлсэн асуудал, гол санаа	Ашигласан баримтууд
.....
Уншсан нийтлэлийн баримтад хийсэн дүгнэлт:			

- “Үндэсний бичиг үсгээ дээдэлье” сэдвээр хувь хүний туршлага, яриа сонсох, ном зохиол, судалгаа шинжилгээний материал унших зэргээр төрөл бүрийн эх сурвалжаас баримт мэдээлэл цуглуулж өөрийн үзэл бодолтой нэгтгэн бичил дүгнэлт бичнэ үү. Дүгнэлт бичихдээ доорх үг хэллэгүүдээс ашиглаарай.

Үлгэрлэвэл: *Түүхээс үзвэл, монголчуудын эртний өвөг Хүннүчүүд гэдэг лавтай билээ... Түүхийг мөшгөж үзвэл, Чингис хааны өвөг дээдсийнхний сүлд цагаан шонхор шувуу байв... Домогт өгүүлснээр, Монгол – нирунчууд нь Алунгоо хатны нөхрийн өнгөрснөөс хойш төрсөн отгон хүү Бодончараас салбарласан аймгууд юм бол хожмын монгол – нирун улсын сүлд цагаан шонхор шувуу болж таарч байна.* (Ч.Арьяасүрэн)

Эрдэм шинжилгээний найруулгад, Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, нэрт эрдэмтэн, профессор Лхамсүрэнгийн Хүрэлбаатар агсны “Огторгуйн цагаан гарди” (Уб., 1996) номд буй өдий төдий жишээ баримтаас “зэрэгцээ үг”-ийг гойд тансаг, зелдүүлэн хэрэглэсэн олон тохиолдлоос нэгээхэн хэсгийг татаж харахад бидний сонирхож буй нөгөө “хорших ёс”-ыг даанч сайхан баримтлан, найруулсан нь бэлхнээ тодорч байна. (Б.Пүрэв - Очир) гэх мэт

1. эрдэмтэн ий (...ы) судалснаар ... (олж тогтоосноор, хэлснээр, айлдсанаар ...
2. бидний өвөг дээдсийн туршлага, ажиглалтаас үзвэл
3. судлаачдын тооцоолсноор
4. албан (албан бус) мэдээгээр
5. ... - ийг (- ыг, - г) үндэслэвэл (эргэцүүлж бодвол)
6. бүтээлд дурдсан (тэмдэглэсэн, иш татсан) – ыг үзвэл
7. түүхээс үзвэл
8. д өгүүлснээр
9. ий (... ы) бүтээлд гэж (хэмээн) өгүүлсэн байдгаас үзэхэд... гэх мэт




Амьдралдаа тохиолдсон элдэв сонин үзэгдэл, учрал, үйл явдал, сонсож дуулсан зүйлээ тэмдэглэхийн зэрэгцээ тухайн үед төрсөн сэтгэгдэл, үзэл бодол, таамаглалаа тэмдэглэх нь хожим, бичих зүйлдээ ашиглах бодит хэрэглэгдэхүүн болдог. Аливаа зүйлийг харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх зэрэг мэдэрч танин мэдэх замаар олж авсан мэдээллийг баримт болгон ашиглаж болно.



Дасгал 45

Цуглуулсан баримтаа шинжилж, ангилан цэгцлээрэй.

- а. Ямар ямар төрлийн баримт байна вэ?
 Гол санааг дэмжихэд хэр ач холбогдолтой вэ?
 Бодит мэдээлэл, хувийн ажиглалт туршлагын аль нь вэ?
 Ижил санаатай баримтуудаас аль нь оновчтой вэ?
 Ямар ямар баримтыг сонгож авах вэ?
- б. Одоо баримтаа багцлан ангилаарай. Гол асуудал, гол санаа, баримтыг дугаарлан цэгцэлж, дэд гарчиг өгч, учир зүйн дараалалд оруулаарай.



Дасгал 46

Төлөвлөгөөгөө боловсруулаарай.

- а. Бүтцийг төлөвлөхдөө агуулгаа хэрхэн баяжуулах вэ, гэдгээ чухалчлаарай. Гол утга санааг уншигчдад хэрхэн хүргэх вэ? Эхлэл, гол, төгсгөл хэсгээ хэрхэн төлөвлөх вэ? Жишээ нь:

Гол санааг уншигчдад хэрхэн хүргэх вэ?	Гол санаа болон дэмжигч мэдээллүүдийг хэрхэн эвлүүлэн бичих вэ?
“Монгол бичиг бол өвөг дээдсийн минь ертөнцийг үзэх үзэл, тэнгэр газрыг шүтэх ёсон, бэлгэдлээс улбаатай байж мэднэ” гэсэн санааг дэвшүүлж баримтаар нотлох.	<p><i>Эхлэл хэсэгт:</i> Товч танилцуулга Үндэсний бичиг үсгээ эрхэмлэн дээдлэхийн учир <i>Үндсэн хэсгээ 3 цогцолбортой бичнэ.</i> Нэгдүгээр цогцолборт монгол бичгийг анх зохиосон сэдэв санаа Хоёрдугаар цогцолборт оюуны үнэт зүйл маань бидэнд монгол бичгээр л дамжиж өвлөгдсөн тухай санаа Гуравдугаар цогцолборт төрийн бодлого, шийдвэр <i>Төгсгөл хэсэгт:</i> Монгол бичгээ дээдлэн хүндэлж, хүн бүр сурахыг чармайх, хэл соёлоороо бахархдаг болох нь монгол хүн бүрийн үүрэг болох тухай</p>

- б. Төлөвлөгөөнийхөө дагуу эхний нооргоо хийгээрэй.
- в. Ямар гарчиг өгөх вэ? Доорх гарчгуудыг уншихад та нарт ямар төсөөлөл бууж байна вэ? Ийм гарчигтай эхэд юуны тухай бичсэн байж болохыг таамаглан ярилцаад, нийтлэл эхийн гарчиг ямар байх талаар дүгнэлт гаргаарай.
- Харийн галт тэрэг монголд саатахын учир *Л.Болормаа*
 - Ямар азаар, бид хоцрогдов оо *С.Оюун*
 - Машиндаа ч гологдсон бензин *Д.Жаргалсайхан*
 - Монголын үрс зэсийн үнэ хэмээн хэлд орно *Л.Болормаа*
 - Сайхан жил- муухай жил *Б.Цэнддоо*
 - Их хааныг хилэгнүүлсэн байх аа *Л.Эрдэнэбулган*
 - Америк бууз *Л.Болормаа*
 - Хөх зүрхний зураас *Б.Баабар*
 - Чулуу эмд ордог эрдэнэ *Ж.Оюун*
 - Америкт “хулгай” хийж явна *Л.Болормаа*
 - Биднийг хэн тэжээдэг вэ? *Б.Баабар*
 - Инфляци галзуурах цагаар *Л.Болормаа*
 - Хакердуулсан малгай *Б.Цэнддоо*
 - Алчууртай аялал *Л.Болормаа*
 - Туулаа бодоод уйлмаар аа *Б.Ганчимэг*



Дасгал 47

а. Яаж эхлэх вэ? Эхлэх аргуудаас алиныг сонгомоор байна вэ? Жишээ нь:

Эшлэлээр
эхлэх

“Чихинү чимэг болсон аялгуу сайхан монгол хэл Чин зоригт өвгөд дээдсийн минь өв их эрдэнэ” гэсэн шүлгийг найман настай балчраас эхлэн наян настай хөгшид минь ч андахгүй.

Асуултаар
эхлэх

Ухааны минь шандаст хүлэг монгол бичиг минь ээ. Нарт орчлонд та хэдийд мэндэлж, нас сүүдэр хэд хэчнээнийг хүртэж явна вэ? *Д.Батбаяр*

Дүгнэлт буюу
баталгаа
нотолгоогоор
эхлэх

Хүн төрөлхтний бичгийн соёлыг гадаад далайд цутгадаг их мөрөн хэмээвээс түүний ширгэшгүй ундарга, тасаршгүй цутгалын нэг нь болох монгол бичгийг монголчуудын оюуны соёлын гайхамшигт өв гэдгийг дараах хэдэн үндэслэлээр нотолж болно. Аливаа соёлт үндэстэн үсэг бичгийн шинэ тутам тогтолцоог боловсруулан буй болгохдоо тухайн цаг үеийнхээ ярианы хэлэнд шүтэн дулдуйдаж, түүгээр тулгуур үндэс хийдэг жамтай. Үүний нэгэн адил, монгол бичиг анх үүссэн цаг үеийнхээ амьд хэл аялгууг шууд тусган тэмдэглэсэн нь тодорхой юм...

Таамаглалаар
эхлэх

Хүн, хэл, хил гурав бол улс үндэсний тусгаар тогтнолын тулгын гурван чулуу билээ. Өөрийн гэсэн хилгүй хүн ардыг тусгаар улсад үл тооцно. Өөрийн гэсэн хэлгүй хүн ардыг сэтгэлгээний тусгаар улсад үл тооцно. Хэл бол улс үндэстний соёлын салшгүй хэсэг хүн ардын оюун санааны дархлаа, тэдний мөн чанар, оршихуй юм. Монголчууд бид гайхалтай сайхан хэл соёлтой онгон дагшин оюуны дархлаатай хүмүүс. Үүний баталгаа нь сүүлийн 400 жил 7100 хэл мөхөж устсан байхад эх хэл маань тэсэж үлдэж чадсан явдал юм. Энэ нь монгол хэлний торгон хил халдашгүй, монгол хүний сэтгэлгээ дархлаа сайтайн тод илрэл биз ээ.

Баримтаар
эхлэх

“Шерокичууд мөхөж буй эх хэлээ аврах арга чарга эрэлхийлж байна” гэсэн өгүүлэл нийтлэгдсэнийг олж үзээд, аялгуу сайхан монгол хэлээ хайрлан хамгаалах сэтгэлийн үүднээс нэгийг бодож, нөгөөг сэтгэх болов уу гэх сэтгэлээр энэ нийтлэлээ толилуулж байна.

Хэрэг явдал,
товч түүх
ашиглаж
эхлэх

Сажа Бандида Монгол улсад аль үсгээр туслах болох хэмээн шөнө тугдам барьж, эрт манагар бэлгэлэхүйд нэгэн эхнэр хүмүүн мөрөн дээрээ хэдрэг модыг барьж ирээд, мөргөвөөс, тэрхүү бэлгээр Монгол улсын үсгийг хэдрэгний дүрсээр нь эр, эм, эрс гурваар, чанга хийгээд хөндий ба саармаг гурваар зохиосон болой.

*Данзандагва “Огторгуйн маани хэмээх судар оршвой”
Судрын 4а тал*

Дурсамж
яриагаар эхлэх

“Монгол бичиг бол хүн төрөлхтний соёлын санд монголын ард түмний оруулсан үнэт хувь нэмэр төдийгүй дэлхийн утга соёлын нандин өв” гэж Чой. Лувсанжав багш минь хэлж байсныг санаж байна.


Эсрэг санаа
буюу нөхцөлийг
сонгон авах

Монголчууд 10 гаруй авианы тогтолцоот бичиг үсэг зохион хэрэглэж байсан оюунлаг ард түмэн. Олон монгол үсэг бичгийн дундуур сүвлэн сүлбээлж, ганцаар амь бөхтэй оршиж ирсэн бичгээ үл ойшоон, харийн хэл рүү хошуурцгаах болсонд сэтгэл эмзэглэж байна. Даяаршлын давлагаагаар гадаад үг хэллэгээс зугтаж үл чадах ч монгол хүн монголоороо л ярья.



Дасгал 48

Сонгосон сэдвээ дараах алхмын дагуу агуулгыг өрнүүлж, гол санааг илэрхийлж бичээрэй?



Дасгал 49

Уншигчдад гоо зүйн таашаал төрүүлэхийн тулд, санаагаа урнаар хэрхэн илэрхийлэх вэ? Хоёр эгнээний шууд ба шууд бус утгат үг хэллэгийг харгалзуулан ялгаж тэмдэглээд, дүгнэн ярилцаарай.


Зохиогчийн санаа	Урнаар илэрхийлсэн нь
<i>Монгол бичиг бол дээрээс доошоо бичдэг дэлхийн ганц бичиг.</i>	<p>Дээд тэнгэрээс газар дэлхий рүү хур буухын өгөөж буяныг бэлгэдэж дээрээс доош нь бичье гэж бодсон байх. <i>Д.Батбаяр (бэлгэдэл)</i></p> <p>Дэлхийд ганцхан босоо заяатай Дээд тэнгэрийн бичиг минь... <i>Ш.Чоймаа (хүншүүлэл)</i></p>
<i>Монголчууд согд гаралтай бичгийг өөрийн хэлэнд тохируулан боловсруулж хэрэглэсэн нь арван зуунаас наашгүй. Тийм ч учраас бид монгол бичгээ мянган жилийн түүхтэй хэмээн үздэг.</i>	<p>Эцэг тэнгэрээс газарт буух босоо тэнхлэгт бодлого бол монгол хүний гүн ухааны үзэл, ахуй, зан заншлын бэлгэдэл, сэтгэлгээний хэв шинж мөн. Тэгээд ч бид өвдөг шорооддоггүй босоо бөх гэж хүндэлдэг, ухаан билгийн бичиг юүгээ босоо бичиг гэж бахархдаг, бас өөрсдийгөө босоо монгол гэж омогшдог. <i>Д.Баттогтох (адилтгал)</i></p> <p>Үг хэллэг хэдийгээр цагийн аясаар өөрчлөгддөг боловч анхныхаа төрөлхийн мэнгийг хэзээд хадгалсаар ирдэг онцлогтой. Тэр мэнгээр нь таньж, ураг төрлийг нь тогтоодог билээ. <i>Л.Түдэв, Үгсийн нууц уурхай УБ., 1996 (хүншүүлэл)</i></p> <p>Алтан ургийн элэнцээс нааших ахуй төрийн түүхийг танаар бичсэн байх юм. <i>Д.Батбаяр (хүншүүлэл)</i></p> <p>Тэнгэрийн хураар тэжээгдсэн түмэн жилийн түүхт монгол бичиг <i>Д.Батбаяр (хүншүүлэл)</i></p>


<p><i>Хэл идэвхтэй хэрэглээнд орохгүй удахынхаа хэрээр алхам алхмаар орхигдож улмаар гээгдэх буюу мартагдана.</i></p>	<p>Хэрэглэгдэхээ байж яваа балт сүх, хадуур мэтийн багаж зэвсэг яваандаа зэвэрдэг бичигдээгүй хуулиар олон үндэстний төрөлх хэл хэрэглээнээс гарч, мартагдах хувь тавилантай тулгарч байна. <i>Л.Түдэв (адилтгал, хүншүүлэл)</i></p>
<p><i>Монгол бичиг сурах нь хэцүү биш. Оролдвол амархан сурна.</i></p>	<p>Монгол бичиг сурах нь тийм ч өндөр даваа, өгсүүр зам биш гэдгийг санаж, оролдоод үз, оролдсон зүйлээ орхилгүй оройд нь хүртэл сураад үз. Чингэвэл үл мэдэхийн балраас амархан ангижирна. <i>Д.Баттогтох (адилтгал)</i></p>
<p><i>Монгол бичгийн талаарх эндүү ташаа ойлголт амнаас ам дамжин тархаж нийгэм, хүнд их хор хохирол үчруулж байна.</i></p>	<p>Эндүү сэтгэцээс эндүү бодол төрнө. Эндүү бодлоос мунхаг ухаан үүснэ. Мунхаг ухаанаас буруу үзэл төрдөг тул монгол бичгийн талаарх андуу ташаа бодлууд “зүүнээс хурц үзүүр”-ээр чичин хатгаж, нийгмийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж байна. <i>Д.Баттогтох (ахиулал, адилтгал, хүншүүлэл)</i></p> <p><i>Монгол бичгийн талаарх олны яриаг дам сонсон, сурахад хүнд гэж “Уул үзээгүй хормой шуух” нь эндүү ташаа бодол мөн.</i> <i>Д.Баттогтох (адилтгал)</i></p>
<p><i>Бидний өвөг дээдэс эх хэлээ цэвэр ариун байлгахыг эрхэмлэж ирсэн.</i></p>	<p><i>Үгсийн сандаа харь хэлний шарилж өвс ургуулахыг ихэд цээрлэж байсны нэг тод жишээ бол тэр хэлнээс орж ирсэн ормол үгийг монгол бичгээрээ бичиж хэвшүүлэхдээ эх хэлнийхээ хууль зүйг зориуд зөрчин, дүрэм зүйд үл нийцүүлэн тухайн хэлний үгийн бичлэгийг “үсэгчлэн буулгах” зарчмаар бичиж хэвшүүлсэн нь харангуут харь үг гэдэг нь танигдаж байдаг.</i> <i>Д.Баттогтох (адилтгал)</i></p>


Нийтлэл бичихийн тулд: Ямар бүтэц хэлбэрийг сонгох вэ?

 1. Аливаа зүйлийн гадаад, дотоод шинжийг бичих хэлбэр. Санал сэтгэгдэл, өдрийн тэмдэглэлийг ийм маягаар бичиж болно. **Тоочимж бичих гол загвар юм.**

 2. Хэрэг явдлыг цаг хугацааны дарааллаар бичиж, эцэст нь дүгнэнэ. Дурсамж, аяллын тэмдэглэл зэргийг бичихэд тохиромжтой. **Хүүрнэмж эхийн загвар.**

 3. Эхлээд, хэлэх гэсэн гол зүйлээ бичээд, дараа нь түүнийхээ үндэслэл, агуулгыг задалж тайлбарлаж бичих хэлбэр. **Тайлбарламж эхийн гол загвар.**

 4. Эхлээд, гол санаа, үндсэн агуулгыг бичээд, дараа нь нэгтгэн дүгнэж бичих хэлбэр. 3-ын эсрэг загвар. **Эргэцүүлэмж бичих үндсэн загвар.**

 5. 3 ба 4-ийн холимог хэлбэр. Эхлээд, хэлэх гэсэн зүйлээ бичээд, дараа нь түүнийхээ үндэслэл, учир холбогдлыг тайлбарлаад, эцэст нь дүгнэлтээ бичнэ.



Эхийг төлөвлөх: Юуны өмнө уг сонгосон сэдвийг найруулгын ямар хэв маягаар, өөрөөр хэлбэл тоочимж, хүүрнэмж, тайлбарламж, эргэцүүлэмжийн алинаар бичихийг сайтар бодно. Урьд болсон хэрэг явдлыг цагийн дарааллаар бичих үү, эсвэл хамгийн чухал санааг эхэлж гаргаад цааш нь дэлгэрүүлж бичих үү гэдгээ шийднэ. Тухайлбал:

- * Хэрэг явдлыг цагийн дарааллаар бичихдээ заавал хүүрнэмж маягаар бичих албагүй, өдрийн тэмдэглэл маягаар товчоолж болно.
- * Урьд болсон хэрэг явдлыг өгүүлж буй мэтээр бичиж болно. Ингэхдээ тухайн үед хүмүүс уг хэрэг явдалд хэрхэн хандаж байсныг дурсах байдлаар, эргэцүүлэн бодох байдлаар бичиж болно.
- * Тайлбарламж бичихдээ эхлээд хамгийн чухал зүйлийг өгүүлдэг. Цаашид уг санаагаа нотлох зорилгоор янз бүрийн баримт дурдаж, тоочиж тодорхойлон бичих замаар баталж нотолно.
- * Бичлэгийн хэлбэр нь эсээ, сэтгүүлийн өгүүлэл, аяллын танилцуулга, өдрийн тэмдэглэл, захидал зэргээр олон янз байж болно.
- * Зохион бичих хэлбэрээ сонгосны дараа агуулгын гол хэсгүүдийг товч төлөвлөнө. Эхлэл хэсэгт юу бичих, үндсэн хэсэгт юу өгүүлэх, төгсгөл хэсэгт юу гэж бичихийгээ тогтооно гэсэн үг.

Ноороглох ба засварлах: Төлөвлөгөөгөө баримталж бичнэ. Өөр зүйл рүү анхаарлаа сарниулахгүй. Цаасны хоёр талаар нэлээд зай үлдээж бичнэ. Дараа нь янз бүрийн засвар хийхэд тохиромжтой байдаг. Гаргацтай эмх цэгцтэй бичнэ. Ингээд эхний нооргийг бичээд төлөвлөгөөтэй харьцуулж, дахин уншина. Тэгээд засварла. Компьютерт бичсэн бол хэвлээд уншаарай.


Ноороглож дуусаад: Боломжтой бол өөр хүнээр уншуулж, санал солилцож зөвлөгөөг сонс. Эсвэл бичсэн нооргоо анхааралтай уншиж сайтар тунгаан бод. Зорилгоо хэрэгжүүлсэн эсэхээ өөрөөсөө асуу. Нэмэх хасах зүйлээ ноорог дээрээ тэмдэглээрэй. Эргэлзэж байгаа үгийн доогуур зурж тэмдэглэн, толь бичгээс харж шалгана. Цэг цэглэл зөв эсэхийг хянана. Оновчгүй үг хэллэг, өгүүлбэрийг хасаж оронд нь шинэ засвараа оруулна. Компьютерээр бичиж байгаа бол шинэ засварыг шууд хийгээрэй.

Хяналт ба эцсийн хувилбар: Дахин хяна. Яарч болохгүй. Догол мөр, найруулгын алдааг шалга. Засварыг хаана, хэрхэн оруулснаа өмнөх ноорогтойгоо тулгаж, дахин нэг хяна. Анхны нооргийг хуулж бичихдээ, үг үсэг гэсэн байж болзошгүй тул нягт нямбай ажиллаарай. Ер нь анхнаасаа л гаргацтай, эмх цэгцтэй бичиж сурах нь чухал.



Дасгал 50

а. Нийтлэлийн найруулгын олон төрлөөс алиныг нь сонгож, ямар арга хэлбэрээр бичих вэ? гэдгээ шийдээрэй.



- Сэтгэлийн таашаал өгөхөөр дүрслэн тоочиж бичих үү?
- Итгэл үнэмшил төрүүлэхүйц эргэцүүлж бичих үү?
- Учир шалтгааныг тайлбарлаж бичих үү?
- Хэрэг явдлыг цагийн дарааллаар хүүрнэх үү?

Нийтлэл бичихэд гурван үндсэн арга хэрэглэдэг.

1. Уншигчдад цаг үеийн мэдээллийг богино хугацаанд хүргэх зорилгоор хэзээ, хаана, юу болсныг мэдээлэх
2. Хэрэг явдлын мөн чанарт нэвтэрч, янз бүрийн нөхцөл байдлын учир холбогдлыг тайлбарлах, аливаа үзэл бодол, санал зөвлөмж, санаачилгын үндэслэлийг тайлбарлах зорилгоор далд харилцаа холбоог илрүүлж, харьцангуй өргөн хүрээний асуултуудад хариулт өгөх
3. Бодит байдлыг уншигчдын сэтгэлд хүрэхээр уран дүрслэх

Уран нийтлэл бичихэд доорх шинжүүдийг анхаарч бичдэг.

- Тодорхой чухал асуудлыг дэвшүүлэх
- Тодорхой хэрэг явдлаас ангид байж, баатруудын биечилсэн хэрэг явдалгүй байх
- Өнөө маргаашийн асуудал биш, нэлээд урт хугацааны асуудлыг дэвшүүлэх
- Хялбар ойлгогдохоор харьцуулан жишсэн байх
- Урнаар зурагласан байх
- Олон нийтийн санаа бодлыг илэрхийлэх
- Өгүүлэмжид өгүүлэгч би оролцон, уг асуудлын талаар үзэл бодол, үнэлэлт дүгнэлт өгөх



Дасгал 51

Мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо илэрхийлээрэй.
Жишээ нь:

Баримт мэдээлэл	Мэдрэмж, сэтгэгдэл, үнэлэмж	Үзэл бодол
Дэлхийд ганцхан босоо бичиг.	Тэнгэрээс хур буух мэт өгөөж буяны бэлгэдэл	Монгол хүн монгол ахуй язгуурын соёлоосоо үүтгэн монгол ухаан, сэтгэхүйгээр бодож сэтгээд, тэнгэр эцэгт, газар эхт шүтлэгтэйн тул дээрээс доош бичих босоо бичгийг бүтээжээ. <i>Д.Баттогтох</i>
Гадаад хэлний үг их хэрэглэх болжээ.	Эх хэлнийхээ рашааны ундаргыг булгийн эх шиг ариухан байлгах	Хойч үеийнхнийгээ хосгүй сайхан монгол хэлтэй болгоход дэлхийн аль ч улсаас тус дэм ирэхийг хүлээн суулгүй гагцхүү дөрвөн уулын дунд урагшаа харсан үүд хоймор үүсгэсэн, утаагүй улаан галаа бадраан, угсаа язгуураа дээдэлж яваа монгол улс, монголын эзэн болсон одоогийн бид нар л эрвийх дэрвийхээрээ хичээх ёстой буй за. <i>Чой. Лувсанжав, Үнэн, 1992.№1</i>

<p>Монгол бичиг он жилийн уртыг туулан боловсорч ирэхдээ эрт цагийн үгийн бүтцийг өчүүхэн ч алдагдуулалгүйгээр бидэнд авч ирсэн.</p>	<p>Монгол хэлний хөгжил хувьсал бүхнийг ташаагүй үнэн тэмдэглэсэн түүхэн сурвалж бичиг мэт ажээ.</p>	<p>Орчин цагийн монгол хэлний дуудлагаас өөрөөр бичиж байгаа үг бүрийн цаана эх хэлний маань түүхэн хувьсал, үгийн гарлын учир шалтгаан, үндэсний хэл сэтгэхүйн маань бүхэл бүтэн түүх байгаа гэдгийг онцлон дурдах нь зүйтэй болов уу.</p>
<p>Өвөгчүүд монгол бичгийг дээсэн бичгээс үүссэн гэж үздэг.</p>	<p>Дээсэн бичгийг газар сунгаад тавьчихаар монгол бичгэрхүү юм харагдана.</p>	<p>Ортой ч байж мэднэ. Дээр үеийн улс бэрх шүү дээ. Дэмий юм сэднэ гэж байх биш. Дээсийг элдвээр зангидаж үзүүр гогцоо гарган үг хэл болгодог байж л дээ. Дээсэн бичгийн ачаар овог аймгаа хүртэл сөнөх аюулаас аварч байсан юм гэнэ лээ.</p>
<p>Сажа Бандида, нэгэн эхнэр хүмүүн мөрөн дээрээ хэдрэг модыг барьж ирээд мөргөвөөс, тэрхүү бэлгээр Монгол улсын үсгийг хэдрэгний дүрсээр тэмдэглэжээ.</p>	<p>Ацаг шүд нь хөрөөний шүдтэй адилхан байдаг.</p>	<p>Хээр талын нүүдэлчид хэдэргээ дуурайлгаж зохиосон гэдгийг үгүйсгэх аргагүй. Ямартаа ч ахуй амьдралаас нь үүдэлтэйг нотлох нэг баримт юм.</p>



Дасгал 52

Нийтлэлийн дүгнэлт, төгсгөл хэсгийг бичихдээ дараах хэлбэрээс сонгоорой:

Бодол дүгнэлтээр төгсгөх

“Эх хэлээ хайрлацгаа... энэ маань өвөг дээдсээс бидэнд үлдсэн цул эрдэнэ, баялаг юм. Энэ хүчит зэвсгийг хүндэтгэн хэрэглэ. Чадвартай эзэмшвэл гайхамшгийг бүтээнэ шүү” гэсэн И.С. Тургеневийн үгээр төгсгөө.

Асуудал дэвшүүлж төгсгөх

“Чихинү чимэг болсон аялгуу сайхан монгол хэл”-ээ хайрлан хамгаалах талаар дорвитой арга хэмжээ авах цаг болжээ.

Уриалгаар төгсгөх

Босоо монгол бичиг бол их эзэн Чингис хааны үеэс уламжлан ирсэн Монголын эзэнт их гүрний төрийн албан ёсны бичиг, монголын үндэсний соёлын алтан ганжир тул монгол хүн бүр дээдлэн биширч, сүслэн сурч эзэмших ёстой үнэт өв юм. Босоо монгол бичгээ сурч эзэмшихийг эрхэм Та бүхэнд уриалж байна!

Уншигчдад төгсгөлийг үлдээж төгсгөх

Хойч үе минь монгол бичгээ төгс сурч, оюунлаг ард түмнийхээ шавхагдашгүй өв санд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэдэг. Ийм цаг үе хэзээ ирэх бол...

Санал дэвшүүлж төгсгөх

Монгол хүн монгол бичгээ уламжлалт аргаар илүү сайн сурдаг тул дунд сургуулиудад энэ аргаар зааж сургах аргыг нэвтрүүлэх нь зүйтэй.



Дасгал 53

Бичсэн нийтлэлээ дараах шалгуураар хянаж, эцэслэн найруулж бичээрэй.

Агуулгыг хянах

- Зорилгодоо нийцсэн үү?
- Танилцуулах хэсэг нь уншигчдад нөлөөлж, сонирхлыг татаж байна уу?
- Гол санаагаа илэрхийлж чадсан уу?
- Баримт мэдээллийг гол санаандаа уялдуулж чадсан уу?
- Сонин содон баримт мэдээлэл хангалттай ашигласан уу?
- Дүгнэлт оновчтой байна уу?
- Мэдрэмж, үнэлэмж, үзэл бодлоо оновчтой илэрхийлсэн үү?

Бүтцийг хянах

- Санаа болон мэдээллүүдийн учир зүйн дараалал зөв байна уу?
- Цогцолбороо зөв заагласан уу?
- Дэвшүүлсэн санаагаа оновчтой дүгнэж чадсан уу?

Хэл зүйн ба найруулгын алдааг хянах

- Гадаад дотоод холбоосыг зөв хэрэглэсэн үү?
- Үг, өгүүлбэрийг оновчтой сонгосон уу?
- Уран дүрслэл оновчтой хэрэглэж чадсан уу?
- Эшлэл зүүлтийг зөв хэрэглэсэн үү?
- Зөв бичих дүрмийн алдаа байна уу?
- Цэг тэмдгийг зөв хэрэглэсэн үү?



ЯТГАСАН ЭСЭЭ

ЯТГАСАН ЭСЭЭ УНШИХ

- Эхийг уншиж, ярилцъя
- Итгүүлэн үнэмшүүлэх аргатай танилцъя
- Эхийн бүтэц, агуулгыг задлан тайлбарлая
- Үзэл бодлоо илэрхийлье

ЯТГАСАН ЭСЭЭ БИЧИХ

- Асуудал дэвшүүлэн, итгүүлэн үнэмшүүлж бичье
- Дүрслэл ашиглан, итгүүлэн үнэмшүүлж бичье
- Баримт нотолгоо, эшлэл зүүлт ашиглан, итгүүлэн үнэмшүүлж бичье

ЯТГАСАН ЭСЭЭ УНШИХ

Эхийг уншиж, ярилцъя

БҮХ БОРЛУУЛАЛТ АДИЛХАН. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, ер бүх зүйлийг зарахад нэг л зарчим үйлчилдэг. Эхлэх цэгээс төгсгөлийн цэг хүртэл нэг л шулуун шугам байгаа. Тэр шугаман дээр ямар нэг арга замаар ятгах л хэрэгтэй, үр дүнд нь гэрээ хийж, тухайн зүйл зарагдах ёстой”. Энэ бол Белфорт*ын алтан зарчим.

Тэгвэл ятган итгүүлэх урлаг гэж юу вэ?

-Өөрийн мөрөөдөл, эрмэлзлийг бусдад хэлээд, энэ нь тухайн хүмүүст үүний нэг хэсэг болох юм сан гэж бодох хүртэл нь ярихыг ятгах урлаг гэдэг. Мөрөөдөлдөө хүрэхэд ятгалга маш чухал. Итгэл үнэмшилгүйгээр мөрөөдөлдөө хүрэх ямар ч боломжгүй. Боломжтой ганц арга зам нь лото хожих байж магад. Үгүй бол ятгах хэрэгтэй.

Хүмүүст үргэлж хэлэхийг хүсдэг нэг зүйл маань одоо байгаа энэ дэлхийг байгаагаар нь, бодитоор эсвэл байгаа хэмжээнээс нь хэзээ ч доогуур битгий хар. Илүү ихийг төсөөл. Алсын хараатай бай. Түүндээ хүрэхэд чинь харин ятгах урлаг чухал хөшүүрэг болдог.

Та бүхэн “Шууд HD”, “Shop mongolia”, “Trade TV HD” болон телевизийн бусад сувгийн зар сурталчилгааг ажиглаарай. Эдгээр нэвтрүүлгийн үгэн ба дүрстэй сурталчилгааны

- Зорилго нь юу байдаг вэ?
- Хэнд зориулсан байдаг бэ?

“Шар докторыг өдөр бүр заавал уу!” гэсэн чацарганы ундааны сурталчилгаанд:

- Ямар асуулт тавьж болох вэ?
- Сурталчилгаанд “заавал” гэсэн үг ямар үүрэгтэй байна вэ?

Ажилд орж буй хүмүүст олон шаардлага тавьдгийн нэг нь “Ятган итгүүлэх буюу хүнтэй харилцах чадвар” ажээ.



Эх уншиж, задлахад дараах алхмыг анхаараарай.

- а. Бичлэгийн ямар төрөл вэ? Болсон явдал, дурсамж, зөвлөмж эсэх
- б. Үндэслэл нь юу вэ? Баримт нотолгоо, судалгаа, хөндлөнгийн дүгнэлт бодитой байна уу?
- в. Дуу хоолой нь хэнийх вэ? Бодит үнэнийг өөрийн биеэр үзэж мэдэрсэн жирийн уншигчаас гадна олны хүндэтгэл хүлээсэн эрдэмтэн, алдартай, нэр хүндтэй, туршлагатай, өөртөө итгэлтэй хүн байна уу? Тэдний асуудалд хандах ёс зүй, мэдрэмж, хандлага ямар байна вэ?
- г. Сонсогч нь хэн бэ? Хэн ч байсан тэдний үнэлэмж, хандлага, итгэл үнэмшил, сэтгэгдэл нь ямар байна вэ? Үр дүнг хэрхэн харж, үнэлж байна вэ?
- д. Найруулга нь ямар байна вэ? Өгүүлж буй зүйлээ бусдад итгэн үнэмшүүлэе гэвэл үг хэллэг, баймж үгсийг зөв сонгоно. Тэгснээр сэтгэлийг нь хөдөлгөж, хандлагыг нь өөрчлөн, зөв үйлд хөтөлж чадсан уу? Үүнээс өгүүлэгчийн ёс зүй, хандлага, үзэл бодол ямар байгааг харж болно,
- е. Зорилго нь юу вэ? Тодорхой зорилго агуулсан эсэх, ойлгомжтой байна уу, мэдээлэх, ойлгуулах, тайлбарлах, нотлох, итгүүлэх, уриалахын алин болох,

* Ж.Р.Белфорт - АНУ-ын бизнесийн зөвлөх, илтгэгч, “The Wolf of Wall Street” номын зохиогч.

Өгүүлэгчийн хэлэхүйн зорилго

Дүрслэн бичих	Хүүрнэн бичих	Тайлбарлан бичих	Эргэцүүлэн бичих	Итгүүлэн үнэмшүүлж бичих
---------------	---------------	------------------	------------------	--------------------------



Дасгал 54

Ятгах хэрэглүүр ашигласан нэгэн жишээг ажиглая.

“Ваго ч янзтай даа! Шинэ ногоо амтагдаад л...” гэсэн сурталчилгааг задлан шинжилбэл:

1. Ярианы хэлний “янзтай” гэдэг үг чухал үүрэгтэй байна.
2. “шинэ ногоо” гэсэн хэлц холбоо үг онцгой сэтгэгдэл төрүүлж байна.
3. Өгүүлэгчийн (Соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч Ш.Гүрбазар) дуу хоолойны өнгө, нүүрний хувирал, хөдөлгөөн, сэтгэл хөдлөл, сэтгэл хангалуун байдал, олон түмэнд танил болсон хүн.
4. Ерөнхий дүгнэлтийг шинэ санаагаар лавшруулж батлах байдлаар бүтээгдэхүүнээ сурталчилсан.



Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д “ятгах” гэдэг үгийг:

1. Бусдад юмны учир начир, хор холбогдлыг ухуулан өгөх
2. Хүнийг буруу мууд удирдан дагуулахыг хэлнэ хэмээн тайлбарлажээ.

хүрэх гэсэн үйл юм.

Өнөө үед мэдээ мэдээллийн өргөн боломж бий болсноор хүмүүс санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж байна. Энэ нь юу хийхээ бус харин яагаад хийхээ асууна гэсэн үг. Энэ яагаад гэдэг асуултад хариу өгч чадаж байвал итгэл үнэмшил төрүүлж чадаж байна гэсэн үг юм.

Ятгах нь боломжтой мөртөө нэгдэж чадахгүй байгаа олон янзын санааг нэгтгэнэ гэсэн үг. Сэнхрүүлэн ярих нь 3 үе шаттай байж болно.

1. Санаа сэдвээ олох, нээх
2. Ятгах бэлтгэл хийх
3. Харилцан ярилцах

Юуны түрүүнд ятгах гэж буй хүн өөрийг нь сонсох хүмүүс болон итгүүлэх зүйлийнхээ талаар нэлээд сайн судалж, төлөвлөсөн байх хэрэгтэй.

Бүтэц найруулга нь товч бөгөөд тодорхой байгаа нь ятган итгүүлэх санаа зорилготой холбоотой.

Гэвч энэ үгийн утга учрыг өнөө үед илүү өргөн дэлгэр сайн сайхнаар тайлбарлах, хэрэглэх боллоо.

Ятгаж сэнхрүүлэх нь өөрийн санаа бодлыг бусдад тулган зөвшөөрүүлэх биш, харин өөр бусадтай зөвшилцөх, нэгдэх, нэгдмэл шийдвэрт



ХЭНД, ЮУГ, ЯАЖ итгүүлэх вэ?




Уриалга

...Зөв бичих зүйн асуудлаа зохицуулдаг дэлхийн улс орнуудын нийтлэг жишигт нийцүүлэн хэвлэж буй энэхүү журамласан толийг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага, тус улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бусад хуулийн этгээд бүхэн дагаж мөрдөх үүргийг хуулиар хүлээж байгааг сануулахын сацуу хэлбэрэлтгүй дагаж мөрдөн, үсэг бичгийн асуудлаа цэгцлэн журамлахыг уриалж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга



Монгол мөн л юм бол, монгол зүрхтэй хүн мөн л юм бол, монгол хэлтэй хүн мөн л юм бол энэ киног үзэх ёстой. Яагаад гэвэл, монгол хүний тусгаар тогтнолыг харуулсан, бас цаад санаа нь энэ юм. *Өлзий телевиз, Соёлын гавьяат зүтгэлтэн Г.Цоггэрэл*



- Ямар ном унших вэ гэж үү? Монтенийг л унш. Хүн төрөлхтний хамгийн агуу сод ухаантан мэргэдийн санаа бодлоор сэлбэгдсэн тийм баялаг оюуны ертөнцийг дотроо бий болгож амьдрах хэрэгтэй. Үүний тулд давын өмнө Монтенийг унш.

Г.Флобер

- Үнэнийг эрхэмлэдэг хүмүүс үгүй болоогүй цагт энэ номыг уншсаар л байх болно. *Д.Дидро*



... Би одоо 75 настай. Бүхий л амьдралынхаа турш би ийм номыг л хайж явсан юм. *Эвелин Сагден*

... Энэ дасгал миний амьдралдаа олсон хамгийн гайхалтай, сайн эм байлаа. *Эрнест Кортец*

Бие физиологи, сэтгэл зүй болон оюуны чадварт үзүүлж буй нөлөө нь үнэхээр гайхалтай. *Стивен Хант*

- Дээрх эшлэлүүдээс чи ямар хариуг авч байна вэ?
- Өгүүлэгчийн сэтгэл хөдлөл ямар үг хэллэгээр илэрч байна вэ?
- Эрчимжүүлсэн тэмдэг нэр, чимэг үгс нь ямар мэдрэмж төрүүлж байна вэ?
- Итгэл үнэмшил төрүүлэх нийтлэг үг хэллэг, санааг ялгаж бүлэглээрэй.
- Түвд, Төвд, Төвөд гэсэн оноосон нэрийн аль нь зөв бэ? 2018 оны “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-оос лавлаарай.



Итгүүлэн үнэмшүүлэх аргатай танилцъя



Дасгал 56

Цогцолбороос ятгасан үг, хэллэгийг ялган тэмдэглээрэй.

Хүний сэтгэлийг хөдөлгөж, урнаар дүрслэн ярих

... За Жуужаа, энэ жил одоо хамт нүүх юм байгаа биз дээ. Ачлага уналга аваад ирсэн шүү дээ. Ээ, манайхны очиж буух Майханы эх гэдэг ч ёстой л нэг торго шиг эрээлж байна гэнэ дээ. За тэгээд ч, Оросын Сибирийн их салхи гэж замдаа таарсныг буулгаж шидсэн айхавтар их салхи айсуу яваа юм байх аа. Өнөө өглөө цаг агаар тэгж хэллээ. ...

С.Пүрэв “Насны чагтага”

Ятгасан үг хэллэг нь:

Үндэслэл, баримт нотолгоотой тайлбарлан бичих:

1974-1988 онд ... хийсэн хайгуулаар Хөвсгөлийн фосфоритын ай сав газруудад 20 орчим орд нээж, 1,6 тэрбум тоннын нөөц илрүүлсэн нь ... хэмжээгээрээ Төв Азид томд тооцогдож байна. Гол нөөц нь 300 км урт, 70-120 км өргөн газар нутгийг эзлэх бөгөөд... ашиглахад бэлэн болсон нь Бүрэнхааны орд юм. Энэ ордыг түшиглэн, зургаан сая тонн хүдэр олборлох хүчин чадалтай ил уурхай байгуулж ашиглавал, жилд 18,4 тонн фосфор, 8,7 тонн фтор, бусад хорт элементүүд агаарт дэгдэнэ гэсэн судалгааны дүнг төрийн бус байгууллагынхан урьдчилан гаргажээ...

Фосфоритыг ихэвчлэн ил аргаар олборлодог. Ингэснээр ...“селен” нэртэй маш хортой, нунтаг бодис ялгарч, байгаль орчныг бохирдуулдаг. ...Бүрэнхааны фосфоритын орд Хөвсгөл аймгийг хөгжүүлж болох ч, Хөвсгөл далай ээжийн амийг таслах ёсгүй.

Д.Оюун-Эрдэнэ “Далай ээж маань дахиад цаазын тавцанд” цуврал нийтлэлээс

Ятгасан үг хэллэг нь:

Үйл явдлын зөв дараалалтай хүүрнэн бичих

...Зөгнөн бодох авьяас хүн бүрд ижил заяадаг нь мэдээж боловч түүнийгээ тэтгэн хөгжүүлж, амьдрал, үйлдвэрлэлд тус хүргэх тухайд хүн болгон ижилгүйгээр барахгүй зөнч сэтгэлгээтэй хүмүүс өдрийн од шиг ховор үзэгддэг. Түүний учир нь... илэрхий юм. Нялх багад нь хүүхдүүдийг зөгнөн ярих, дүрслэн төсөөлөх авьяас цухалзахын цагт ширүүн гартай эцэг эх, хатуу үгтэй багш нар элдвээр хэлж мохоодгоос “зөгнөлийн зул нь” бага нялх цагт нь унтарчихдагаас л гол гай ургадаг болой. Зөнч болох хүүхдийн сонин яриаг томчууд үл тоомсорлох, аягүй бол “далан худалч” болох нь хэмээн болгоомжилж, доог тохуу хийх буюу шууд хориг цээр тогтоох тохиолдол тун элбэг байдгийн гайгаар бид хэчнээн ч олон Жюль Верн, Артур Кларк, Урсула Ле Гуннаа алдаж байна вэ дээ.... *Л.Түдэв “Зөгнөл”*

Ятгасан үг хэллэг нь:

Үндэслэлтэй дүгнэлт гаргаж, эргэцүүлэн бичих

“Монголын үзэсгэлэнт сарангуа намайг төрүүлсэн ижий” гэдэг мөрийн цаана арван сарын явдал суудал, “Яруу сайхан эгшгээрээ бөн бөн бүүвэйлсэн ижий” гэдэгт ямартаа ч гурван жилийн ачлал энэрэл, санаашрал багтана. “Зөөлөн цагаан гараараа хөдөлгөн өсгөсөн ижий” гэсэн мөрт бас л гурваас дөрвөн жилийн хайр энхрийлэл байдаг. “Зүйтэй уран үгсээрээ сурган хүмүүжүүлсэн ижий” хэмээх мөрт наанадаж гучин жилийн, цаанадаж дөчин жилийн ажил хөдөлмөр хамаатай юм л даа.

Яагаад? Яагаад гэвэл, монгол хүн дөч шүргэж байж дөнгөж сая л нэг юм хүмүүншиж, тогтнож ирдэг аж.

Б.Пүрэв-Очир “Дашдоржийн Нацагдорж болон түүний...”

Ятгасан үг хэллэг нь:



Эхийг уншиж, хэсэг тус бүрийн агуулгын ялгааг ажиглаж, тайлбарлаарай.

Аргалын утаа

<p>Алхам 1:</p> <p>Энэ цогцолборт</p> <ul style="list-style-type: none"> • Суурь мэдээлэл • Үндэслэл • Дэвшүүлсэн асуудал байна уу? 	<p>“Аргалын утаа бургилсан Малчны гэрт төрсөн би” гэж бахархан хэлэхэд өрнөдийнхөнд ч, дорнодынхонд ч үл ойлгогдоно. Голдуу л сөрөг талаар нь ойлгож, түүнд сонирхмоор юу байх вэ дээ гэж бодоцгооно. Учир нь тэд “Нүүрсний утаа бургилсан Нүсэр хотын хүмүүс”. Утаа гэдэг үг хоёр янзаар ойлгогдохгүй нэг зүйлийн нэр боловч урд нь “аргалын”, “нүүрсний” гэсэн тодотгол өгөөд яривал хоёр өөр утаа гэдэг нь мэдэгдэнэ. <i>Чулуун нүүрсний утаанд аргалын утаанд байдаг ач тустай юм бас байхгүй.</i></p>
<p>Алхам 2:</p> <p>Статистик тоо баримт, шинжээчийн дүгнэлт нь “Чулуун нүүрсний утаанд аргалын утаанд байдаг ач тустай юм бас байхгүй” гэсэн өгүүлбэрийн шалтгаан болж чадах уу?</p>	<p>Аргалын утаа бургилсан малчны гэрт төрж, өссөн хүмүүс сүүлийн үед нийслэл Улаанбаатар луу хошуурцгааж нүүрсний утаа баагьсан хотын хүмүүс болцгоосоор байна. Дурлаж ирсэн тэр хотод нь жилдээ таван сая гаруй тонн нүүрс түлдэг дулааны гурав, дөрвөн станц, 400 гаруй тонн нүүрс түлдэг 250 гаруй жижиг уурын зуух, 625 мянган тонн нүүрс түлдэг 240-өөд мянган гэр өрх жилийн сэрүүн улирал ялангуяа өвлийн саруудад Алтан тэвшийн хөндийг утаан тэвшийн хөндий болгож орхидог. Нүүрсний тэрхүү утаа нь 200 гаруй төрлийн хорт бодисыг дээш нь цацдаг ч хүмүүсийн хамраар дотогшоо орно. Тэр утаанаас нь хордсон хүмүүс нийслэлд гэхэд л жилд 1600 хүрч “нүд аныцгаадаг” болсоор удлаа. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) агаарын чанарын стандартаас Улаанбаатарын утаа 35 дахин илүү байгааг тогтоожээ.</p> <p>“Утаагүй Улаанбаатар” болохын төлөө эрх баригчид, эрүүл мэндийн албаныхан хориод жил ярьж, олон тэрбум төгрөгийн төслийг “утаа болголоо”. Нийслэлийн хүн ам, айл өрх жил ирэх тусам олширсоор байгаа болохоор нүүрсний утаа нэмэгдсээр байх нь мэдээж. Нүүрсний утаанаас нүүрстөрөгчийн давхар исэл, хүхэрлэг хий, азотын давхар исэл, хар тугалга гэхчлэн гай хөөний юм гарч, иргэдийг их багагүй, хүүхэд хөгшидгүй утсаар байна.</p>
<p>Алхам 3:</p> <p>Өгүүлэгч байр сууриа нотлон, уншигчийн итгэл үнэмшил төрүүлэх үг хэллэг байна уу? Ялган бүлэглэж, тайлбарлаарай.</p>	<p>Аргагүйн эрхэнд ийм хувь тавиланд оосорлуулж байгаа ч гэсэн арга барагдсан юм биш, арга олон байна. Хийн түлш, био түлш, салхин болон наран эрчим хүч гэж үнэгүй шахам эх булагтай, хор багатай түлш захаас аван байж л байна. Багахан хөдөлмөр зүтгэл л дутсаар байна. Арга барагдахад аргалын утаандаа утуулж суувал аминд өлзийтэй юм санж. Бараг тавиад сая малтай болж буй өнөө үед өвөг дээдсийн мянга мянган жил гал голомтоо бадрааж ирсэн аргал, хоргол, хөрзөн хааяагүй л хэвтэж байна. ... Аргал бол зөвхөн түлш болоод зогсдоггүй эм болдгоороо хор цацдаг нүүрснээс хавьгүй ариун эд гэдгийг монголчуудын нүүдлийн малчны соёл иргэншил эрт дивангарт нотолчихсон зүйл.</p>

<p>Алхам 4.</p> <p>Итгүүлэх арга хэрэглүүр</p> <p>Өгүүлж буй зүйлийн учир шалтгааныг тунгаан бодож, тодорхой үзэл бодлыг баримтлах болсон үндэслэл, шалтгаан, түүний нотолгоо</p> <p>Сэтгэл хөдлөл, сэтгэлийн өнгө аяс, мэдрэмж, оновчтой хэлц уран дүрслэл</p> <p>Өгүүлэгчийн итгэл үнэмшил, ёс зүй</p>	<p>Нэгд. Аргалын утаанд утагдаж, насаа элээдэг учраас монгол малчид хэр баргийн өвчинд нэрвэгддэггүй, төрийн байтугай өрхийн эмнэлэг ч шаарддаггүй байсан урт түүхэн замнал бий. Аргалын утаа, эрүүл агаар хоёроор амьсгалдаг тул хөдөөнийхөн одооны “амьсгалын замын гэгдэх” өвчинд нэрвэгддэггүй байсан гэж болно. Итгэмээргүй мэт боловч итгэлтэй хэрэг.</p> <p>Хоёр. Монголчуудын аргалын утааны нууцыг Энэтхэгийн нэгэн эмч, эрдэмтэн доктор Шарма олж мэдээд монголоос аргал аваачаад, уушгины тахал туссан хүмүүсийг аргалын утаагаар утсан чинь их амжилт олж, утааны эдгээх чадалд гайхсан байна. (Энэ мэдээг дахин дахин хэлүүштэй) “Аромотерапия” буюу “Үнэрээр анагаахуй” нийтлэлд ч дурдсан.</p> <p>Гурав. Японы эрдэмтэн аргалын утааг судалж үзээд, түүнд элдэв өвчний нян устгагч байгааг тогтоосон нь ... аргалын утааны тухай яриад буйн том баталгаа болж өгөх мэдээлэл юм. Тэгэхдээ монгол малчдын шээзгийг түүж цуглуулдаг “монгол аргал” л тийм чанартай болохоос өөр орны, өөр малын баас тийм биш нь мэдээж. Сарлаг гэхэд л 200-аад төрлийн эмийн ургамал иддэг мал шүү дээ.</p> <p>Дөрөв. Монголчууд судар номыг баринтаглаад, хоймынхоо авдар дээр нандигнан тавьдаг уламжлалтай билээ. Авдар дээр тавиастайгаар олон жилийг өнгөрөөсөн судар аргалын утаанд шарлатлаа нэвчсэн байдаг. Тийм судрууд манай үндэсний Төв номын санд хэдэн зуугаараа, бүүр 1920-оод онд “Судар бичгийн хүрээлэн” байгуулагдахаас эхлээд бараг зуу шахам жил хадгалагдаж байгаа. Гэтэл тэдгээр судруудад орчин үеийн цаасан номын өвчин болох мөөгтөх, хорхойтох, чийгтэх тоосжих аюул огтхон ч халдаагүй байсаар байгаа билээ.</p> <p>Орчин үеийн ном бүхий номын сангууд “микологийн сэргийлэлт” бүрдүүлж дээр дурдсан “өвчнөөс” хамгаалах журамтай байдаг. Тэр хяналт байхгүй бол ном мөөгтөж, хорхойд идүүлж эхэлдэг. Гэтэл аргалын утаанд нэвт утуулсан монгол судрууд тэрхүү хяналт, сэргийлэлт байхгүйгээр олон жилийн турш “эрүүл” байсаар ирсэн юм.</p> <p>Энэ бол бас аргалын утааны нэг гайхамшгийн нотолгоо юм.</p>
<p>Алхам 5: Дүгнэлт</p>	<p>Аргалын утаа бургилсан малчны гэр ариун болой.</p> <p style="text-align: right;">Л.Түдэв, 2014 он</p>



Хүн юунд итгэдэг вэ, хэмээвээс,

- Аливаа юм ба хэрэг явдлын үндэс, учир шалтгаанд итгэнэ.
- Баримт нотолгоо, үнэнд итгэнэ.
- Сэтгэл татагдсан зүйлд итгэнэ.



Нэгэн эмнэлэг дээр залуухан эмчтэй ярьж суутал

- Та 70 хүртлээ ерөөсөө эмнэлэгт хэвтэж байгаагүй юм уу гэж гайхан асуусан юм.
- Тийм ээ гэж хариулсан чинь үнэмшихгүй гайхаж,
- Нэг ч удаа хэвтээгүй гэж үү? гэв....
- Дал хүртлээ юу гэж ахин лавласнаа,
- Таны насныхан эмнэлгээс салахгүй л юм. Та яаж ийм эрүүл байна? гэж асуув.

Өгүүлэгч нь хэн хэн байна вэ? Онцлох санаа нь юу вэ?

Яахав дээ. Би хөдөөний хүүхэд болохоор хоёр мээм хөхөж өссөн юм. Тэгээд л тэр биз... Ээжийнхээ мээмийг хөхөж сүүнд нь цадахаар нэхий манцуйтай нь орон дээр тавьж унтуулна. Тэгэхдээ аманд минь хонины сүүл үмхүүлээд орхичихдог байсан юм билээ. ...Тэгдэг байснаа би яаж мэдэх вэ?. Харин дүү нар минь яг над шиг сүүл хөхөж унтдагийг сүүлд өөрөө үзсэн юм. Сайхан унтаж байснаа л сэрэхээрээ нөгөө сүүлийг хөхөөд, бувалзаж байгаад ахиад унтаад өгдөг. Өхөөрдмөөр хөөрхөн харагддаг байж билээ....

Таамагласан, баталсан санааг ялгаж, дээрх цогцолборын аль хэсгийг юугаар нотолсныг хэлнэ үү.

Нээлт! Нээлтийг минь баталгаажуулахад хэрэгтэй гэж дуу алдав. Би гайхаж,

- Ямар нээлт? гэвэл
- Хонины сүүл дархлаа сайжруулдаг гэж би нотлоод байгаа юм.

Тэгэхлээр та, манцуйтай үедээ хонины сүүл их хөхөж, дархлаагаа сайжруулсан байна шүү дээ гэж баясав.

I, II цогцолборын шалтгааныг хэрхэн тайлбарлаж байна вэ?

...Хонины сүүлэнд Д, С, А, К гэхчлэн амин дэмүүд агуулагдаж байдаг юм байна. Эдгээр нь харшил, хордлого, сульдааны эсрэг сайн нөлөөтэй, бас өвчин эсэргүүцэх чадвар, ухаан санаа, бие бялдарт их өгөөжтэйг судалгааны дүн харуулж, гадаадын эрдэмтэд ч дэмжиж сонирхдог болсон гэж залуу эмч ярихад....

Хонины сүүл, өвчүүний талаар ярих болсон шалтгаан, хэрэгцээ нь юу вэ?

Монгол хонь чинь эрс тэс уур амьсгалтай дөрвөн улиралтай энэ орондоо байгалийн шалгарлаар үлдсэн сонгодог мал болсон юм биш үү?

...Монгол хонины сүүл бол түүний “банк” гэж болно. Хамаг шим тэжээлтэй бүхнээ зун намрын цагт хуримтлуулж сүүлэндээ шингээн хадгалж түүнийхээ ачаар өвөл хаврын тарчиг хэцүүг давдаг амьтан билээ. Тэмээ хоёр бөхөндөө тэр шим тэжээлээ хадгалдаг бол хонь сүүлэндээ хуримтлуулдаг биз дээ...

Уншигчийн сэтгэлийг хөдөлгөх, өгүүлэгчийн хандлагыг илэрхийлсэн үг хэллэгийг ялган, тайлбарлаарай.

...Хонь наяс доошгүй ургамлаар хооллодгийн дотор 30 гаруй зүйл нь гагцхүү эмийн ургамал байдаг юм байна. Тэгэхлээр хонины сүүл нь “банк” бас “аптек” юм. Тиймээс хүнс тэжээлээр барахгүй эм тан болдог зүйл гэмээр байна....

Өгүүлэгчийн итгэл үнэмшлээс уншигчдад нөлөөлөх үг хэллэгийг ялгана уу?

Хонины өөх ходоодонд ороод 50 хэмд, үхрийнх 47 хэмд, гахайнх 37 хэмд, адууных 28 хэмд хайлдаг юм гэдэг. Тиймээс хонины өөх нь их хүнд хоол гэж ходоод муутай хүмүүс үздэг.

Хүнсний зохисгүй хэрэглээнээс татгалзах хэрэгтэйг итгүүлэх үндэслэл ба нотолгоо байна уу. Ялган тайлбар хийгээрэй.

Тэгээд л гахайн маханд дурладаг. Гэтэл хонины өөхөнд холестрин хамгийн бага байдаг. Ердөө л 29 мг. Тэгвэл гахайн маханд холестрин 125 мг байдаг. Хачин байгаа биз? Холестрин ихтэй маханд нь дурлаад л түүний архаг тусаад байдаг. Гэтэл хонины мах иддэг монголчууд тэр өвчнийг тун бага тусдаг.

Урьдын цагт хонины сүүл зөвхөн хүүхдэд төдийгүй хөгшдөд бас хүсэмжит хоол нь байсан юм. Нэгд, тэжээлтэй, хоёрт, зөөлхөн болохоор шүд муутай хөгшид аргагүй л сонирхдог байсан биз..... Сүүлийг сүү мэт шимцгээе!

Зохиогч зорилгоо хэрхэн илэрхийлж, дүгнэсэн байна вэ?

Ярилцъя.

- ▶ Чи хэн нэгнийг ямар нэгэн зүйлд уриалан ятгаж байсан уу? Яаж?
- ▶ Чи хэн нэгний ятгалгад автаж, ямар нэгэн зүйл хийж байсан уу? Яагаад?
- ▶ Чи ямар нэгэн зүйлд итгэж, үнэмшихдээ юуг гол шалгуур болгодог вэ? (үг, үйлдэл, зар сурталчилгаа, дотны найз учраас, сонссон учраас, үзэж харсан учраас, уншсан учраас, мэдэрсэн учраас, өөрийн биеэр оролцсон учраасгм)



Дасгал 59

а. Итгүүлэн үнэмшүүлсэн эсээний хэсэг тус бүрд харгалзах даалгаврыг гүйцэтгээрэй.

Талхигдлаас үүсэж буй цөлжилтөөс гагцхүү үлийн цагаан оготны хэт олшролт л аварна

Тийм ээ, малын хөлийн талхигдал буюу бэлчээрийн даац хэтэрснээс үүсэж буй цөлжилтөөс гагцхүү үлийн цагаан оготны хэт олшролт авардаг аа гэдгийг малчид маань, тэр тусмаа монгол ухаанаа гээж, төрөл арилжаагүй малчид маань сайн мэдэж буй нь лавтай.

Эхний өгүүлбэр нь зохиогчийн үзэл бодлын илэрхийлэл мөн үү?

Энэ баримтыг дурдсаны учир юу вэ?

2013 оны 9-р сард БОНХЯ-ы сайд дарга нар цөлжилтийн шинэ атлас гарсныг танилцуулж, Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 72% нь тодорхой зэрэглэлээр цөлжилтийн аюулд өртлөө гэдгийг телевизээр дамжуулж, мэдэгдэж байсан юм. Иймээс ... цөлжилтийг зогсоох, бууруулах, арилгах талаар яаралтай арга хэмжээ авч ажиллах нь хэнд ч ойлгомжтой асуудал болов уу. Тиймээс ч өнөөдөр оготноо устгах тухай их ярьж байна.

Монгол орны говь, тал, хээрийн бүс нутгуудад цөлжилт нүүрлэх урьдчилсан нөхцөл шалтгаан чухам юунаас үүсдэг, тэр нь эргээд байгаль эхийн өөрийнх нь дотоод зохицуулалтаар хэрхэн гайхамшигтайгаар нөхөн сэргээгдэж, унаган төрхөө хэвийн хадгалан авч үлддэг байсан байж болох талаар товчхон хөндье. Монгол тал хээрийн бүсийн өнгөн хэсэг гэгддэг үржил шимт давхарга нь харьцангуй нимгэн байдгаас түүнийг хүүхдийн зулай мэт эмзэгхэн хөрс гэж үздэг. Иймээс хөрсний эвдрэлд амархан орж, цөлжилт нүүрлэн цааш хурдацтай тархаж болох аюултай бүс юм.

Хөрсний энэхүү эвдрэл доройтол чухам юунаас голлон шалтгаалж үүсдэг вэ гэвэл бэлчээрийн даац хэтэрснээс гэж шуудхан хэлж болно.

Талхигдлаас үүссэн хөрсний энэхүү нягтрал хатуурлыг цааш даамжрахаас сэргийлж эс чадвал тухайн газар нутаг бэлчээрийн гүн доройтолд орж, улаан сайр болон хувирах аюул нүүрлэдэг юм. Тэгвэл энэхүү бэлчээрийн гүн доройтолд орж, чулуужин хатуурч буй үхмэл хөрсийг сийрэгжүүлэн зөөлрүүлж, мөн элдэв төрлийн ялзмаг, ялгадсаар баяжуулан бордож, нар салхи, ус чийг нэвтрүүлэн, улмаар ургамлын үндсийг уртасгах нөхцөлийг бүрдүүлж, өтгөн шигүү өвс ургамалтай, соргог сайхан бэлчээр нутаг болгон хувиргах тэр гайхамшигт технологичийн үүргийг хэн гэгч ачтан буянтан гүйцэтгэж чадах вэ гэдэг асуудал одоо эндээс гарах нь лавтай болов уу.

Тийм ээ, энэхүү туйлын хүнд хэцүү нүсэр их ажлыг гагцхүү ҮЛИЙН ЦАГААН ОГОТНО хэмээгч хорголжин бор нүдэт, хурдан шалмаг, нөр их хөдөлмөрч бяцхан амьтад л нуруундаа үүрч, зүтгэхээс өөр хэн ч үүнийг гүйцэтгэж эс чадах тийм нарийн технологи шаардсан үйл ажиллагаа гэж хэлж болно. Үүний үнэн худлыг нотлохын тулд нөхөн төлжих чадвар нь муудсан тэрхүү үхмэл хөрсийг оготно хэмээх бяцхан амьтад ямар гайхамшигт арга технологиор, хэрхэн яаж дахин сэргээж амьдруулдаг болохыг үзье. Энэ тухай А.А.Таракановский, Г.Амарсанаа, Ц.Одбаяр нарын эрдэмтэн

судлаачдын 1980-аад оны бүтээлээс эш татъя. "... өвс ургамал сайтай бэлчээр нутаг жил дараалан малын хөлд талхигдсанаас хөрс дагтаршиж, ургамал сийрэгжин, улмаар оготно олшрох таатай нөхцөлийг бүрдүүлдэг.

Судлаач эрдэмтдийн бүтээлээс эш татахын учир юу вэ?

Ийнхүү 10-14 жилийн зайтайгаар оготно хэт олширч, тухайн нутгийн ургамлыг идэж хоосолсноор хүн мал, амьтад бүгд дайжин нүүж, тэр орчин талхигдах эдэлгээнээс түр ч болов амсхийдэг байна.

Оготно олшрох үедээ нэг га-д 1000 гаруй толгой оногдож, өдөрт дунджаар 4-5 кг, жилдээ 2 тн орчим ялгадас гаргаж, хөрсийг борддог. Мөн хөрсийг хавж сэндийчин, хааш хаашаа 1 метр газарт 4, нэг га-д 40000 нүх малтаж, талхигдан дагтаршсан хөрсийг агааржуулан сийрэгжүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг. Нөгөө талаар нүх ухах явцад газрын гүнээс өнгөн хэсэг рүү эрдэс бодис эргэдэг онцлогтой. Оготны хэт олшролт нь цаашдаа өөрсдийгөө дарамтад оруулж, үржил нь зогсонги болж, мөхөлд хүргэдэг юм. Ийнхүү оготны нөлөөгөөр иж бүрэн сайжирсан хөрсөнд 2-3 жилд янз бүрийн ургамал ургаж, ургац хэд дахин нэмэгддэгийг олон жилийн судалгаа харуулдаг. Энэ бүхэн бол хөрсийг бэлчээрийн доройтолд оруулахгүй амрааж байх өөрийн дотоод зохицуулалтыг байгаль эх заяаж буйн гайхамшиг. Үлийн цагаан оготно бидний дайсан биш ээ ..." хэмээн онцолжээ.

Энэ баримтууд юуг нотлох вэ?

- "Өнөөдөр манай улсын малын тоо нь бэлчээрийн даацаас 30%-аар хэтэрчээ"
- Монгол улсад хонин толгойд шилжүүлснээр 110 сая мал өвөлжинө" гэсэн хоёр мэдээ энэ хэсгийн ямар санааг баталж байна вэ?

Энэ бол үлийн цагаан оготно хэмээгч ач буянтан хэт олширсныхоо хүчээр хийж буй гайхамшигт нөхөн сэргээлт бөгөөд бүх ургамлыг хөрсөн доор нь оруулж, бүрэн гүйцэд бордлоо гэсэн үг.

Үнэндээ, монголын говь тал хээрийн бүсэд бэлчээрийн даац хэтэрснээс үүсэж буй цөлжилтөөс гагцхүү үлийн цагаан оготно хэмээгч гайхамшигт технологич аварна уу гэхээс өөр хэн ч аварч чадахгүй гэдгийг энэхүү баримт харуулах болов уу. Иймээс бид чоныг байгаль эхийн цэвэрлэгч "санитар" хэмээн нэрлэдэг шигээ үлийн цагаан оготныг бол байгаль эхийн маань цагаан нөмрөгт гоо сайханчид гэвэл харин ч дэгсдэхгүй бололтой.

Байгаль эх энэхүү гайхамшигт нууцыг ашиглаж, өвс ихтэй, хөрс зөөлөн ойт хээрийн бүсийг бус, харин малын хөлөөр амархан дагтаршиж хатуурдаг, маш эмзэгхэн тал хээрийн бүсэд их хурдацтай үржин тархаж олширдог үлийн цагаан оготно гэгч энэ хурдан шалмаг, нөр хөдөлмөрч бяцхан амьтныг бүтээж буй болгосон нь ойлгомжтой.

Уншигчийг юунд итгүүлж, юу хийлгэхийг хүсэж буйг ярилцана уу.

Тиймээс оготно олшроод ирэнгүүт л бидний суудал ихдэж, газар дэлхийдээ даац хэтрүүлэн дарамт үүсгэснээс тэнгэр эцгийн ивээлээр оготно олширлоо хэмээн ухаарч, 2-3 жил алслан нүүдэллэж оддог байжээ.

Тэгвэл өнөөгийн малчид юуны чинь нүүх суух манатай, өмчилж авсан хашаа бууц, худаг усаа сахин, жилийн дөрвөн улиралд нэг довон дээрээ эргэлдсэн дошны амьтан болон хувирч байна шүү дээ. ... Тэгэхлээр цөлжилтөөс аврагдъя

гэж бодож л байгаа бол байгаль эхийн энэ дотоод зохицуулалтыг хүлээн зөвшөөрч, оготно олшроод ирэхийн цагт нутаг сэлгэн алсалж, хөрсөө амрааж байхаас өөр арга зам байхгүй гэдгийг харуулж байна.

Эхийн төгсгөл хэсэгт юуг, хэрхэн дүгнэсэн байна вэ? Зохиогчийн хандлагыг тодорхойлно уу.

Эцэст нь хэлэхэд, эх байгальд минь устгуулж байх ёстой тийм илүүдэл хэрэгцээгүй амьтад гэж хаана ч, хэзээ ч байдаггүй бөгөөд, харин өнөөдөр устгаж хорогдуулахаас өөр аргагүйд хүрч мэдэхээр нэг аймшигт амьтан гарч ирсэн нь эх байгалиа сүйтгэж байгаагаараа хүн өөрөө болчхож тун


болзошгүй байна шүү гэдгийг л онцлон хэлмээр байна. Ж.Арилдээмбэ

б. Аливаа асуудлын талаар уншигчдад зөв, буруугийн мэдрэмж, сэтгэгдэл төрүүлэх, ухуулан сэнхрүүлэх, нотлон итгүүлэх, үзэл бодол, хандлагыг нь өөрчлөх зорилгоор уран дүрслэлт тодотгол, шилжсэн утгатай үг хэллэг, янз бүрийн баймж үг ашиглаж болно. Үүнээс өгүүлэгчийн үзэл бодлыг мэдэж болно.	Асуулт: Дараах сонгосон жишээ үгсийн утга үүргийг тодорхойлно уу.	
	- хорголжин бор нүдэт - бяцхан амьтад - гайхамшигт технологич - ачтан буянтан - нөр их хөдөлмөрч - цагаан нөмрөгт гоо сайханчид	?
	Асуулт: Дараах үг хэллэгт итгүүлэх ямар арга байна вэ? зөв хариуг олж, батална уу.	
	- монгол ухаанаа гэж - төрөл арилжаагүй малчид - хүүхдийн зулай мэт эмзэгхэн хөрс - улаан сайр болон хувирах - соргог сайхан бэлчээр нутаг болгон хувиргах - тэнгэр эцгийн ивээлээр - юуны чинь нүүх суух манатай - дошны амьтан болон хувирах - аймшигт амьтан гарч ирсэн нь байгаль эхээ сүйтгэж байгаагаараа хүн өөрөө болчхож	а. баримт нотолгоо б. ёс зүй в. сэтгэл хөдлөл


в. Хүснэгтийг гүйцээн бичнэ үү.

Зохиогчийн үзэл бодол	Баримт тайлбар	Чиний үзэл бодол
Энэ бүхэн бол хөрсийг амрааж байх өөрийн дотоод зохицуулалтыг байгаль эх заяаж буйн гайхамшиг юм.		
Улийн цагаан оготно бидний дайсан биш ээ.		
“Эцэст нь хэлэхэд, эх байгальд минь ... илүүдэл хэрэгцээгүй амьтад гэж хаана ч, хэзээ ч байдаггүй”		

г. Эхийг уншаад, шалтгаан үрийн холбоог харуулсан дараах 2 загварт тохирох жишээг олж, (сумын дагуу) нөхөж гүйцээгээрэй.
нэг.



хоёр.



д. Эхийг дахин уншаад, үзэл бодол, дүгнэлтээ бичнэ үү.



Дасгал 60

Дараах номын нүүр хавтсыг ажиглаарай.



- Уншигчдын анхаарал татах үг хэллэгийг жагсаан бичээрэй.
- Дараа нь хамгийн чухал гэсэн нэг үгийг сонгоод, шалтгааныг тайлбарлаарай.
- Чи өөрийн унших дуртай нэг номоо бусдад сурталчилъя гэвэл юу хийх вэ?



Баримт нотолгоог ажиглаад, гол санааг нэгтгэж, үзэл бодлоо илэрхийлсэн эх бичээрэй.

Тамхи юуг өгүүлж байна вэ? “Тамхинаас татгалзъя” гэсэн эх бичнэ үү.

Тамхи татахад хорын 25 хувь нь шатаж, 50 хувь нь агаарт дэгдэж, 5 хувь нь ишинд хаягдаж, 20 хувь нь хүний биед шингэнэ.

ТАМХИ

МОНГОЛ УЛСАД

- Эрэгтэйчүүдийн 67% Эмэгтэйчүүдийн 20% тамхи татдаг
- Дэлхийн хэмжээнд 1 тэрбум орчим хүн тамхи хэрэглэдэг ба 80% нь буурай хөгжилтэй орны иргэд байдаг.
- 7000 гаруй химийн хорт бодис
- 70 гаруй төрлийн хавдар үүсгэх бодис
- 600,000 тамхи хэрэглэдэггүй хүн

6.5 ТРИЛЛИОН тамхи жилд зарагддаг.

Тамхины улмаас 5 секунд тутам 1 хүн нас бардаг байна.

Насанд хүрэгсдийн 42% Хүүхдүүдийн 54% гэртээ дам тамхидалтад өртдөг.

дам тамхидалтаас болж нас бардаг.

#DOCTORPROMN



.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....



Эсээ бичвэрийг уншиж, асуултад хариулаарай.

Хялганат талын цагаан зээр хар цээр биш ээ

Хөөрхий амьтан. Намар оройн хатсан хамхуул, өгөр гандуу зээр хоёрыг хорвоо ямар даахгүй гэх биш дээ. Зэрэглээ хүртэл дээрэлхэж дээш доош нь шидэлдэг зээрийн амьдрал нэн өрөвдөлтэй, ядуугийн туйл билээ. Амьтан л болсон хойно, зайлуул, өөртөө таарсан мөрөөдөл, далд ухамсраа тээж явдаг л байх.

“Араатнаас айлгүй ганц удаа бүтэн нойртой хонож үзэх юм сан. Элчилгүй зэрэм талд минь балгахан ус байдаг ч болоосой. Өдөржин шөнөжин шилбүүрдэн хөөх хөх салхины дор хором бохис хийгээд авах малгайн чинээ нөмөр олдсоосой билээ”. Бодол гэж байдаг бол энэ хүрээд л зогсох төдий өчүүхэн.

Хорвоо, зөвхөн чинийх шүү гээд өмчилж өгсөн хялганат талдаа хулгайч шиг түгшиж амьдрах юутай шударга бус. Үүрээр дагжин чичирч босон харайна. Өмнөх өдрөөс улам хол харайж үйлийн үртэй амь биеэ амьд авч үлдэхийн төлөө зүтгэнэ. Мянга мянгаараа нийллээ ч өмөг түшиг болчих сүргийн эзэн сүрхий ооно гэж үгүй. Эр эмгүй цөмөөрөө уяхан туяхан, уйлсан уруудсан бөөн хамхуулууд. Жаднаас хурц хоёр шорон эвэр бурхнаас заяасан ч юунд хэрэглэхийг нь хэлж өгөөгүй. Юун чонын өөдөөс дайрах манатай.

Цагаан зээрийн өдий хүртэл амьд оршсоор ирсний учир юун гэвэл, хэнд ч гай болохгүй дэндүү мөрөөрөө явсных нь их буян бөлгөө. Хоёр өвс тааралдвал нэгийг нь, нэг өвс таарвал хагасыг нь үлдээж, тал нутгаа там болгодоггүй элэг зөв амьтан шүү дээ.

Энэ амьтны “Эрлэг номун хаан” нь дээхнэ үеийн цэргийн ангийн машин унасан согтуу галзуу цэрэг ахлагч нар байлаа. Тэд зээрийн сүрэг рүү байлдааны хүчирхэг буугаар гал нээж, цусанд нь будаж, зугаагаа гаргадаг байсан юм. Дорнод талд үе үе болдог энэ аллагын дараа эхийгээ босоод ирнэ хэмээн тормойтол хүлээх янзага, гэдсээ хөвүүлсэн, хөлөө санжуулсан эрэмдэг амьтдаар тал дүүрч, салхи ёолж, элэг эмтрэм эмгэнэл үлддэг сэн.... Амьтны амийг таслахад худлаа ч гэсэн шалтаг гардаг бол зээрт хэлэх үг олдохгүй. Бэлчээр талхалсан, булаалдсан гэлтэй биш. Махыг нь хүнсэнд гэх боловч арвигүй энэ тураг махаар өвлийн идшээ базаадаг хүн гэж үгүй. Элдүүр даахгүй арьс нь гутлын ул үрэхэд ч нэмэргүй. ...Цагаан зээрийг улаан зээр болтол хядах нь арай л элэг барьсан явдал юм.

Нэг зээр чонын хоол болтлоо юутай их зовлон туулдаг гэж санана. Хавар орой төрсөн янзагаар тал тэр чигээрээ хооллоно. Үнэг, хярс, элээ шаазгай хүртэл “нялх ногоо” идэж тэнхрэхээр янзаганы анд оролцдог...

Бид сувай шаргачин гээд нэг сайхан амьтан байдаг шиг ярьж дуулдаг ч билүү. Сувай шаргачин нь аборт хийлгээд гунхаж яваа залуу хүүхнээс тэс өмнөө, алаг нүдэндээ дүүрэн нулимстай, эцэнхий бөгтөр гөрөөс юм. Шаргачингууд нэг дор цугларч бөөнөөрөө төрдөг. “Жирэмсэн” гөрөөсийг эртнээс даган шиншилж яваа араатнаас үр төлөө нуухын тулд хэвтээд босохын зуур түргэн “амаржаад” бутны уг руу янзагаа шургуулаад, зугтан оддог. Хорвоод сая мэндэлсэн янзага... тэнгэрт дуугаа хадааж орилохын оронд амьсгалаа түгжин, хэдэн цагаар хөдөлгөөнгүй бүгэх зохилдлогоотой... Эх нь зугтлаа гээд тийм ч хол явчихгүй. Тэрүүхэн тэндээ цомцгоноод нүд салгахгүй.

Харин хөгшин муур зээрийн нүдийг дагуулж хараад “Аа энд л нуусан аж” гэсэн шиг янзагыг дор нь суйлаад, зуугаад явчихна. Хөөрхий зээр хөлөө газар дэвсэн, хамраа тачигнуулан, арай л үсээ зулгааж чадахгүй юм даа. Түүнийг ийн гашуудаж байхад янзага барьсан араатан нүдэн дээр нь үрийг нь амьдаар нь тамлан, өөрийнхөө зулзаганд зээр агнах хичээл заацгаадаг... Юутай ч намар гэхэд олны олон гэсэндээ тал бүрхсэн зээрийн сүрэг өсөж өндийх боловч зовлон дуусахгүй...

Хамгийн гаслантай нь малаас бус зээрээс шүлхий өвчин тарлаа гэсэн цуу тарав. Шүлхий тараасан гээд зээрийг зуу зуугаар нь буудан хөнөөж эхлэв. Санаа муут яван хатна гэгчээр тэнд одоо зээр ч үгүй, мал ч үгүй болох нь шиг байна. Цагаан зээр нь хонь ямаанаас өөр төрөл, адуу үхрээс бүр ондоо амьтан болохоор тэр болгон ойртон дотносож, шүлстэй хошуу амаа нийлүүлээд “янаглаад” байх нь юу л бол... Галзуу чоно шиг хүн мал хоёр дээр давхиад ирдэг зээр гэж үгүй. ... Талд бэлчиж яваа бүх зээрийг устгаад, оронд нь малаа тавьж бэлчээх.

Энэ бол амархан... Гагцхүү дараа нь ... Уул усны лус савдгийг хэрхэн тахиж, ямар маани уншиж аргаддаг юм бүү мэд. ... Хөөрхий дөө. *Ж.Гангаа*

- Бичлэгийн ямар төрөл вэ?
- Үндэслэл нь эхийн аль хэсэгт байна вэ?
Үндэслэлээ нотолсон баримтыг бүлэглээрэй.
- Эхээс дараах жишээ баримтыг олж тайлбарлана уу.
 - Уншигчийн сэтгэлийг хөдөлгөсөн хэсэг
 - Зохиогчийн ёс зүйг илэрхийлсэн хэсэг
- Та нарт ямар сэтгэгдэл төрж байна вэ?
- Найруулга нь ямар байна вэ? Уншигчийн сэтгэлд нөлөөлөх ятгах үг хэллэг бүхий тэмдэг нэр, үйл үг, хэвшмэл хэллэг, өвөрмөц хэллэг, төлөөний үг (бид гэдэг нь уншигчийг хэлж байгаагаас гадна дотночлох утга илтгэнэ), хар яриа, цэг тэмдэг зэргийг ялган, утга үүргийг тайлбарлаарай.



Дасгал 63

Эхийг уншаад, даалгавраас аль нэгийг сонгож, жишээгээр батална уу.

Би бичдэг боллоо. Захиа, өдрийн тэмдэглэл бас шүлэг. Бичих нь намайг хөнгөлж, хамаг бодлоо, бүх гомдлоо түүн рүү, түүний зүрх рүү юүлчхэж байгаа юм шиг тайвшруулдаг боллоо.

Саяхан би анхны хайрын эзэн найз хөвгүүнтэйгээ уулзлаа. Бүр 15 жилийн дараа шүү дээ. Тэгээд би түүнд “Тулга аа, чи намайг сэтгүүлч болгосон шүү. Чи л намайг боддог, бичдэг, тэвчдэг хүн болгож өгсөн” гэж хэллээ. Би энэ хорвоод анх удаа ухаанаа самууртал дурлаж, тэмүүлж, хүлээж, үгүйлж явсан хүндээ олон жилийн дараа ... хамгийн сайхан үгийг хэлсэн гэж бодож байна.

Яагаад гэвэл, би сэтгүүлч болох гэж...

Сэтгүүлч Б.Ганчимэг “Урьдынхаараа би өвлийг угтана” номоос, УБ; 2002

- Үндэслэл, нотолгоо байна уу?
- Дэвшүүлсэн асуудал байна уу?
- Үзэл бодлоо илэрхийлсэн эх мөн үү?
- Өгүүлэгч сэтгэгдлээ л бичсэн байна уу?
- Итгүүлэн ятгах санаа байна уу?



Дасгал 64

Зураг уншиж, тайлбарлаарай.

Сүүлийн үед олон улсын байгууллага, төрийн бус байгууллагууд хүн төрөлхтөнд тулгамдаж буй асуудлыг олон түмэнд ойлгуулахын тулд янз бүрийн сурталчилгаа хийж байна.

- Эдгээр зураг итгэл үнэмшил төрүүлэх хэрэгсэл болж чадах уу.
- Зураг тус бүрийн санааг өвөрмөц уран өгүүлбэрээр илэрхийлээрэй.



Багаар ажиллая:

Хүн төрөлхтний өмнө тулгамдсан чухал асуудлыг хөндсөн сэдэв сонгож, сурталчилгааны зураг бүтээгээрэй.



...Энэ ном бол өөр. Зохиолч хийгээд зохиол бүтээлийг судлахын үүднээс бус зохиол бүтээлийг хэрхэн бүтээдэг вэ? гэдгийг ойлгуулахын тулд бичсэн юм. Судалдаг, танддаг хүнд бус бүтээдэг хүнд зориулагдсан юм. Бүтээл туурвилын нууцад бус бүтээн туурвихын нууцад нэвтрэхийг оролдсон юм. *Д.Батбаяр*

Зохиогч “Бүтээхүйн зүй тогтол буюу сайхныг бүтээх нууц” зохиолынхоо тухай өгүүлжээ. Эхэд онцолсон үгийн итгүүлэх зорилго нь юу вэ?

“Би анх Америкт ирээд, огт дуулж сонсоогүй шинэ үг хэллэгтэй тулгараад, миний олон жилийн турш сурч судалсан англи хэл маань ямар ч хэрэггүй болохыг ухаарсан билээ. Бүгд инээж байхад чи ганцаараа ангайж зогсох нь ямар ичгэвтэр байсан гээч. Олон оюутан яг над шиг юун тухай ярьж буйг асуухаасаа ичдэг байсан юм. “Easy Talk” бол гадаад оюутан бүр уншвал зохих хамгийн сайн, орлуулшгүй сурах бичиг билээ. Өвөрмөц хэллэгүүдийг нь харилцан ярианд маш оновчтой суулгаж өгсөн нь миний сэтгэлд юунаас ч илүү нийцсэн юм. Тэдгээрийг ямар үед, хэрхэн хэрэглэхийг хэзээ ч мартахгүй. Энэ сурах бичиг таны цаг хугацааг хэмнэж, энэ бүх хэллэгүүдийг өөрөө суртлаа хүнд бэрх замыг туулж, “туршилтын туулай” болохоос сэргийлж болно. Энэ ном намайг анх Америкт ирж байхад гарч байхгүй яав даа гэж харамсдаг юм”.

Чиэко Гото

Энд “Орчин үеийн Америк хар яриа “Easy Talk” номын тухай японы нэгэн оюутан өгүүлжээ.

- Онцолсон үгс өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийг хэрхэн илэрхийлж байна вэ?
- Тэмдэг нэрийн үүргийг тодорхойлоорой.

“Далай ээж”-ийн ариун хэвлийд хөвж явдаг нефть тээврийн “Ургац” чиргүүл юуны урьд “хор агуулсан” хар хорхой болж байна. Энд ямар нэг байшин барилга, ердийн машин техник бус 300 тонн нефть агуулдаг чиргүүл онгоцны тухай ярьж байгаа хэрэг”... *Ц.Балдорж*

“Далай ээж цаазын тавцанд” нийтлэлийн энэ цогцолборт уран дүрслэлийн ур маягийг баримттай хослуулжээ. Найруулгын үүргийг нь тайлбарлана уу.

Эхийг унших явцдаа гарчиг, сэдэв, үндэслэл, агуулга, гол санаа, бүтэц, эшлэл, нотолгоо, тайлбар, дүгнэлт зэргийн уялдаа холбоог анхаараарай.

Дээшээ доошоо хоёр

1

Хүн эхээс төрөхдөө доошоо унаад, дараа нь дээшээ босдог. Түүн шигээ үйлдлийг насан туршдаа хийдэг. Ноён юм **уу** дарга болохыг хүсдэг. Хаан болох санаатай ч бас байдаг. Ноён ч бай, дарга ч бай, хаан ч бай дээшээ өргөгдсөн өндөрлөгт гарсан хэрэг. **Гэвч** тэр дээшлэлт мөнх биш. Ноёныг ч юм **уу**, даргыг ч юм **уу**, хааныг ч юм **уу** түлхэн унагаах, огцруулах, тэр ч **байтугай** цаазлах ч удаа байдаг.

Тэр бүхнийг үзэлгүй босоогоороо байж байвал хөгшрөлт **гэдэг** байгалийн хуулиар доошоо унадаг. Ер нь ч тэгээд өгсөхөөс уруудах нь хэцүү байдаг. Өгсөж буй хүн баяртай, уруудаж буй хүн гунигтай байдаг болой.

“Оргилсон гал өөдөө ноцдог

Урссан ус уруугаа явдаг” гэдэг нь ертөнцийн жам юм. Түүний эсрэг

“Дэлхийн шороог дээш нь

цацвал доошоо унана

Дэнгийн гэрлийг доош нь

харуулавч дээшээ босно”

Тэгэхлээр хүн өөд нь чулуу хаяхыг болгоомжлохгүй бол өөрийн нь толгой дээр унадаг. Зарим нь үүнийг ухаардаггүй. Өөд нь чулуу шиднэ **гэдэг** давхар утгатай үг. Жинхэнэ чулуу шидэх нэг утга нь, Үгэн чулуу шидэх **бол бас** нэг утга нь **юм**. Өндөрт гарсны дараа тэр, хүн өөд чулуу ч шиднэ, үг ч шиднэ.

2

Өндөр хүн доог тохууны суманд оногдохдоо амархан. **Харин** одой намхан хүнийг **бол** оноход бэрх гэдэг билээ. **Бас** "өндөр уулан дээр гарахад толгой эргэдэг" **шиг** өндөр албан тушаалд гарвал **бас** толгой эргэж мэднэ. Өндөр болох **тусам** сүүдэр нь уртасдаг. **Гэтэл** наран өөд хараад **л** яваад байвал сүүдрээ хэзээ ч үзэхгүйд хүрнэ.

Тэгэхлээр алдар нэр чинь сүүдэр **шиг чинь** өмнө хойно гарч, заримдаа өөрөөс чинь өндөр болж, заримдаа өөрөөс чинь намхан болж байдгийг санаж явах учиртай. Өндөрт авирч явахдаа бусдад тус болж байхгүй бол буцаж буухад замд чинь тэд ахиад дайралдана гэдгийг санаж байх хэрэгтэй.

Хүн болгон бусдаас ялгаатай, **бас** өдөр ирэх **тусам** өөрөөсөө ялгаатай болдог. Тэгдэг нэг гай бол өндөр хэргэм, **бас** хөрөнгө мөнгө нь эзэмшдэг эзнээ эвддэг, түүнд атаархагч ядуу, доодсыг ч **бас** адилхан эвддэг удаа цөөнгүй. Энэ бүхнийг тунгаан бодож явахгүй **бол** "Гэрийн хий дээшээ, гэдэсний хий доошоо" гардаг түгээмэл явдал бий **шүү**.

Монгол мэргэдийн амнаас ч, өрнөдийн цэцдийн бичлэгээс ч ийм санааг мэдлэгийн аргал түүхээр араг үүрч, үзгэн савар барьж явахдаа би олж мэдсэнээ исгэж, тараг бүрэхээр үүнийг бичвэй.

Л.Түдэв “Хөгнөөтэй эсээнүүд”

1. Ийм сэдвээр бичих үндэслэл байна уу? Жишээ гаргана уу.
2. Бид юм уншихаасаа өмнө зохиогчийг хардаг. Зохиолч Л.Түдэв гуайн алдар цолыг дурдвал:

Монгол улсын хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч, Төрийн соёрхолт, Соёлын гавьяат зүтгэлтэн, XX зууны манлай сэтгүүлч, Төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн.

Түүний бичсэн эх нь уншигчид нөлөөлөх үү? Яагаад?

- а нөлөөлнө б нөлөөлөхгүй в аль нь ч биш

3. Гол санааг өөрийн үгээр тайлбарлаарай.
4. Найруулгыг задлан шинжилье.
 - Үйл үгийн
 - тодотгон холбох -даг⁴
 - цагаар төгсгөх -на⁴ бүтээврийг олон удаа хэрэглэсний учир юу вэ?
 - Тэмдэг нэрийг түүвэрлэж, үүрэг хэрэглээг тайлбарлаарай.
 - Эхэд онцолсон үг, бүтээврүүдийг утгаар ялган бүлэглээрэй.
 - төлөөлсөн
 - тайлбарласан
 - эсрэгцүүлсэн
 - онцлон ялгасан
 - лавшруулсан
 - зэрэгцүүлсэн
 - адилтгасан
 - баталсан
 - Эхэд онцолсон үг, бүтээврүүдийг үүргээр нь ялган бүлэглээрэй.
 - үгийг үгтэй
 - үгийг өгүүлбэртэй
 - өгүүлбэрийг өгүүлбэртэй,
 - цогцолборыг цогцолбортой
 - Эхээс гадаад, дотоод холбоосыг ялгаж бичнэ үү.
 - Дараах хэлц үгийн утгыг тайлбарлаарай.

үгэн чулуу шидэх, үг шидэх, доог тохуун сум, мэдлэгийн аргал түүхээр араг үүрч, үзгэн савар барьж явахдаа, толгой эргэж мэднэ, мэдсэнээ исгэж, тараг бүрэх
 - Эхэд эсрэг утгатай үг, өгүүлбэр, эшлэл хэрэглэсэн шалтгаан нь юу вэ?
 - Уншигчийн сэтгэлд нөлөөлөх, итгүүлэх утгатай үг хэллэгийг ялган тэмдэглээрэй.

5. Зорилго нь аль вэ? Хариуг сонгоод, тайлбар бичээрэй.

- а тайлбарлан таниулах б тоочин тайлбарлах в тайлбарлан итгүүлэх
г дүрслэн хүүрнэх д уриалан дуудах е сурталчилгаа

ЯТГАСАН ЭСЭЭ БИЧИХ

Асуудал дэвшүүлэн, итгүүлэн үнэмшүүлж бичье

Бичихийн өмнө эсээний бүтцийг ажиглан, ярилцаарай.

Бүтэц нь:

Удирдамж, тайлбар:

ЭХЛЭЛ

- Уншигчийн анхаарлыг татаж эхэлнэ.
- Асуудал дэвшүүлсэн хөтөч санаагаа гаргана.
- Үзэл бодлоо илэрхийлнэ.

Анхаарал татах. Сонирхолтой баримт, статистик, утга төгс эшлэл, амьдралын сорилт, туршлагаас үүдэлтэй товч хүүрнэл гэх мэтээр анхаарлыг татаж эхэлнэ.

Хөтөч санаа. Үндэслэлээ ойлгуулахад чиглэсэн ямар нэг суурь мэдээлэл өгнө.

Үзэл бодлоо илэрхийлэх. Асуудлын талаар үзэл бодлоо тодорхой илэрхийлнэ. Баримталж буй үзэл бодол тодорхой бус бол уншигчдын итгэл алдрахад хүрнэ.



ҮНДСЭН ХЭСЭГ

- Үзэл бодлоо дэмжинэ.
- Эсрэг үндэслэлийг хүндэтгэж буйгаа илэрхийлэх, няцаах.

Итгүүлэх нөхцөл бүрдүүлэх. Учир зүй, сэтгэл хөдлөл, ёс зүйн арга хэрэглүүрийг оновчтой хослуулж, үзэл бодлоо дэмжиж, нотолно. Тэгэхдээ өгүүлэгчийн үзэл бодолд гурваас доошгүй шалтгаан байна, шалтгаан бүрд хоёроос доошгүй нотолгоо байж болно.

Хоёр талаас авч үзэх. Үзэл бодлыг тань зөвшөөрөхгүй байгаа хүний байранд өөрийгөө тавиад үз. Тэр хүн ямар үндэслэл нотолгоо гаргаж ирэх бол гэж эргэцүүл. Түүнийг нь аль нэг талаар хүлээн зөвшөөрөх юм уу, эрс няцаана.




ШИЙДЭЛ

- Үзэл бодлоо дахин илэрхийлнэ.
- Зохистой гэж үзвэл уншигчдыг үйлдэлд уриална.

Амжилттай төгсгөх. Үзэл бодлоо дахин илэрхийлж батална.


Уншигчдад нөлөөлөх. Тухайн асуудлын талаар уншигч хийх зүйл байгаа бол гүйцэтгэхийг зөвлөнө. Таны бичиж байгаа зүйл тэдний үйлдэлд нөлөөлөхөөр байна.

Ятгасан эсээ нь үндсэндээ зохиогчийн үзэл бодол, түүний шалтгаан үндэслэл, энэхүү шалтгааны нотолгоо гэсэн гурван хэсгээс бүрдэнэ. Нотолгоо нь дараах гурван гол арга хэрэглүүрээр хэрэгжинэ.



Бидэнд дараах гурван асуудлын хариултыг олох нь чухал

1. Эсээнийхээ эхэнд асуудлаа хэрхэн дэвшүүлэх вэ?
2. Дэвшүүлсэн асуудал зөв үү?
3. Асуудлынхаа гаргалгааг хэрхэн гаргах вэ? Хэрхэн нотлох вэ? Уншигчид итгэл үнэмшилтэй бичиж чадаж байна уу? Яаж итгэл үнэмшилтэй бичих вэ?



Эсээний удиртгалыг бичих

Сэдэв сонгож, асуудлаа дэвшүүлэх:

Тоо ба үсэг хэзээ үүссэн бэ? гэвэл төдийлөн сонин биш ерийн асуулт болно. Харин эрдэмтэн зохиолч Л.Түдэв нэгэн эсээндээ "...эхлээд ер нь үсэг бичиг гарсан юм уу?, тоо бодлого үүссэн юм уу? гэх ерийн мөртөө яггүй асуудал гарч ирнэ" хэмээн асуудлаа дэвшүүлээд, түүнийгээ "Бичгийн ээж нь тоо гэвэл, үсгийн эцэг нь зангилаа" хэмээн урнаар дүгнэн хэлжээ. Энэ дүгнэлтээ хэрхэн баталсан бэ?

Л.Түдэв эсээндээ "...эхлээд үсэг бичиг биш тоо бодлого гарчээ гээд хэлчих хэмээн түүхийн баримтууд шивэгнэх ажээ" хэмээн үзэл бодлоо илэрхийлж, асуудлаа дэвшүүлээд, түүнийгээ олон талаас нотолжээ.

Энэ гурван жишээг ажиглаад, чи өөрөө УУЛЫГ, ХАРАНХҮЙГ, УХААН ДУТУУГ юу гэж боддог байснаа эргэцүүлэн бодоорой. Чи зохиогчийн оронд байсан бол юу гэж бичих байсан бэ? Жишээлбэл: *“Уул өндөр учраас ууланд би хайртай. Харанхуйд юу ч үзэгдэхгүй учраас аймшигтай. Мунхаг хүний ухаан дутуу”* гэвэл хөтөч өгүүлбэр биш болно. Яагаад гэвэл, энд ямар нэг сонирхолтой асуудал, сонин санаа алга. Бүх хүн ингэж л боддог. Тэгвэл одоо өвөрмөц санаа бүхий хөтөч өгүүлбэр бичиж сурахын тулд дараах дасгалуудыг ажиллая.



Дасгал 67

Дараах хоёр АСУУДЛЫГ харьцуулаад, ялгааг тайлбарлаарай.

Үндэслэл сайтай

Уул уурхайн салбар сүүлийн жилүүдэд манайд эрчимтэй хөгжиж, эдийн засгийн гол хөдөлгүүр болоод байгаа. Гэвч газар доорх алт эрдэнэс хэмжээтэй хойно нэг л өдөр дуусахад, эл хөдөлгүүр зогсох нь тодорхой. Харин тэр үед яах вэ?

Үндэслэл муутай

Хувь хүний хөгжлийг үг яриа, харилцаагаар нь тодорхойлж болдог. Хүн бүр төгс биш гэхдээ төгс төгөлдөр болохын төлөө тэмүүлж, хүчин чармайлт гаргах нь маш чухал. Өнөөгийн нийгэмд хувь хүний эзэмшсэн боловсролыг оюун ухааны буюу шинжлэх ухааны боловсрол болон материаллаг буюу эд баялгийн боловсролоор нь дүгнэдэг. Гэтэл оюун санааны боловсрол буюу ёс суртахууны боловсролын талаарх ойлголт өнөөгийн нийгэмд хэр гүн гүнзгий оршиж байна вэ? гэдгийг эргэцүүлье.



Дасгал 68

а. Дараах үгсэд тохирох бүтээврийг олж, эвлүүлэн өвөрмөц санаа бүхий өгүүлбэр бүтээгээрэй.

- хутга, үг, муу, мохоо
- сая, нэг, бензин, ус, литр, бохирдуулна, литр
- хөг, хэв, сэтгэл, бичиг, бол, мөн
- цаас, хуудас, чанаргүй, ердөө л, диплом
- хаалгач, багийнхаа, хана, мэт, хэрэм, тэнцдэг, хагас, тэн

б. Холбоо үгсийг ажигла. Юутай зүйрлэж болох тухай ургуулан бод. Дүрсэлж тодорхойлох аргаар өвөрмөц уран санаа олж бичээрэй. Үлгэрлэвэл: Миний үзэж байгаагаар хүнд суртал бол..... Миний үзэж байгаагаар хүнд суртал бол цаасаар хооллож зөөлөн уур амьсгалд амьдардаг. г.м.

1. Миний бодлоор ангийн самбар бол ...
2. Миний үзэж байгаагаар хичээл бол ...
3. Миний ойлгосноор соёл боловсрол гэдэг нь ...
4. Миний санахад ёс заншлаа дээдэлнэ гэдэг бол ...
5. Миний бодлоор дөрвөн улирлын өнгө нь
6. Миний үзэж байгаагаар байгалиа хамгаална гэдэг ...
7. Миний санахад эх түүхээ судалж мэдэх нь ...

8. Миний үзэж байгаагаар цагаан сар бол ...
9. Миний бодлоор аав, ээж, хүүхэд гурав бол ...
10. Миний үзэж байгаагаар төрсөн өдөр бол ...



Дасгал 69

Дараах хоёр өгүүлбэрийн аль нэгийг сонгоод, баталсан эсвэл үгүйсгэсэн өгүүлбэрээр дэлгэрүүлж, эсээнд дэвшүүлсэн асуудал болгож бичнэ үү. Эсээг эхлэх 6 аргаас сонгоорой.

Амьдрал бол тэр чигээрээ уучлалт юм.

Хана хэрэм мэт хаалгач багийнхаа тэн хагастай тэнцдэг.

Дүрслэл ашиглан, итгүүлэн үнэмшүүлж бичье



Дасгал 70

- а. Дараах хэсэгт өгүүлэгч “Аль нь ч биш. Арай дээр боллоо” гэж үнэлсний учрыг тайлбарлана уу.
 “Афган салхины орон юм. Кабулд элсээр шуурч байлаа...” Аль нь ч биш. Нэг л саарал өгүүлбэрүүд, ийм сурвалжилгыг хэн тэвчиж дуустал нь унших вэ дээ. “Уулсын орны салхи гээг үсээр тоглон, элсэн энгэсэг хэдийнээ тавьж...” Арай дээр боллоо” *Л.Болормаа*
- б. Дараах хоёр эхийг харьцуулан уншаад, аль нь уншихад сонирхолтой, уран яруу байгааг тодорхойлоод, учрыг тайлбарлана уу.

Ухаан билиг, хичээл оролдлогоо гал мэт бадруулж, газар мэт өргөжүүлж, салхи мэт хөгжөөж, ус мэт ундрааж, муушаахад нь мохохгүй, сайшаахад нь сайрхахгүй, голоход нь гонсойхгүй, сонгоход нь согсойхгүйгээр олон нийтээ соёлжуулах их үйлсэд зүтгэцгээе.

Ц.Дамдинсүрэн

Ухаан билиг, хичээл оролдлогоо бадруулж, өргөжүүлж, хөгжөөж, ундрааж, мохохгүй, сайрхахгүй, гонсойхгүй, согсойхгүйгээр олон нийтээ соёлжуулах их үйлсэд зүтгэцгээе.



Чимэг үг: Аливаа зүйлийн утга, шинжийг маш тодорхой, чихнээ чимэгтэй болгох зорилгоор хэрэглэдэг онцгой маягийн уран тодотголыг чимэг үг гэдэг. Чимэг үг нь өгүүлбэр зүйд тодотгол мөн боловч аливаа тодотгол бүхэн чимэг үг болохгүй. Учир нь тодотгол бол өгүүлбэр зүйн ухагдахуун, харин чимэг үг нь дүрслэх, үнэлэлт өгөх яруу хэрэглүүрийн үүргээр тодорхойлогдох ухагдахуун. Жишээ нь: “Урин дулаан хавар” гэвэл ерийн тодотгол, “Энх улирал” гэвэл зүйрлэлт чимэг тодотгол болно. Төстэй юм үзэгдлээр нь уг зүйлийн шинж болгон утга шилжүүлэн хэрэглэснийг зүйрлэлт чимэг үг гэдэг. Тухайлбал: Ган зориг, номин огторгуй, мөнгөн сар, алтан нар гэх мэт. Үүнээс гадна тухайн юм, үзэгдлийн ерийн шинж бус гол өвөрмөц шинжийг илэрхийлэх тодотгол нь чимэг үг болдог. Жишээ нь: Алд бие, эмээлт морь, тоонот гэр, ургах нар г.м.



Дасгал 71

Дараах өгүүлбэр, цогцолборын найруулгын алдааг засаж, учрыг тайлбарлана уу.

Үлгэрлэвэл: *“Бүсгүй уртаар амьсгал аван, тэнгэр өөд харан хэсэг зогссоноо сэтгэл хангалуун инээмсэглээд, өрөө рүүгээ явж оров. Тэрээр яг л хоолондоо цадсан эм арслан мэт аажуухан тайван алхсаар өрөөндөө орлоо.”* гэхэд а. “Сэтгэл хангалуун инээмсэглэ” гэдгийг “хоолондоо цад” гэдэгтэй холбон бодвол “сайн эр явснаа, муу эр идсэнээ” гэдэг санаа төрүүлэх тул бүсгүй байгалийн сайханд баяссангүй. Иймд зөв оновчтой бус буруу найруулсан ажээ. Мөн өрөө байшинд байх тул “байшинд ор” гэх нь оновчтой. б. Монгол хүний санаанд эмэгтэй хүнийг “хоолондоо цадсан эрслэнтэй” зүйрлэсэн нь гажуу дүрслэл болжээ. **Сийрүүлбэл:** *Тэнгэрийн сайханд сэтгэл тэнийсэн бүсгүй, гүн амьсгал авч, хэсэг түдсэнээ, өрөө рүүгээ оров.*

1. 6 – 8 настай хүүхэд уншуулж, бичүүлж сургана.
2. Уг хэрэг аймгийн цагдаагийн хэлтэст эрүү үүсгэн шалгаж байна.
3. Си – Топ шинэ уусмал. Шивэр хулмасыг бүрэн анагааж, сэтгэл өөдрөг амьдрал бэлэглэнэ.
4. Ерөнхий санаа үйл явдал нь зэрэг нэмэхийн өмнөхтэй давтагдаад байх тал ажиглагдана. Жишээ нь: “Зэрэг нэмэхийн өмнө” киноны гурав ердийн хөсгөөр Да хүрээг зорьдог бол “Гэнэн гурав” машинаар Улаанбаатарыг зорьж байна.
5. Энэ төхөөрөмж нь гаднах нэвтрэн орох хаалганы дэргэдэх автомат дамжуулах товч дарахын хамт тэр хүнийг давхар шалгах, спиртийн зүйл уусан эсэх, мөн биедээ металл бүхий тэсэрч дэлбэрэх зэвсэг илрүүлэх шинэ төхөөрөмжөөр тоноглов.
6. УИХ – ын гишүүн Ц.Баярсайхан өөрөө Улаанбаатар хотод төржээ. Харин Баярсайхан арав хоногтойгоосоо эмэг эхийнхээ гар дээр сүүл ууж, сүүл хөхөж өссөн.
7. Тоглолтын бүр эхнээс л пан азийн аварга Д.Лхагваа санаачилгыг гартаа авсан бөгөөд тоглолтын гуравдугаар үед түүний урд гарын хүчтэй цохилтоос Филиппиний боксчин бултаж чадсангүй.
8. Бариа зөрөөн дээр хурдтай уран гоё барилдаж, сумо бөхийн ертөнцөд барилдааны нэгэн шинэ амьсгал оруулсан Б.Батбаяр барилдааны ур чадвараа үндэсний бөхөөр барилдаж байсантай холбоотой гэж тайлбарладаг.
9. Дамчаагийн гадаа уяан дээр олон морьд харагдана. Агтчин адуучид, айлчид, гийчид л бололтой.
10. Цаасан дээр мөртэй, цасан дээр нэртэй хүн шүү би.



Дасгал 72

Уран яруу үг хэллэгийг ашиглан, дүрслэн бичье. Дараах эхийн чимэг тодотгол үгсийг олж тэмдэглээрэй. “Монгол наадам бол...” гэдгийг үргэлжлүүлэн, чимэг тодотголыг оновчтой ашиглан, дуурайлган бичээрэй.

Цагаан сар

Цагаан сар бол монгол эрхэмсэг намба, хүмүүний ээнэгшилт ёс, ах зах, өтгөс нялхсын нандин дэг, төр сүлд, уул устайгаа харьцахын их соёл, дорнын буурал дадал заншлын хэмжээлшгүй их өв, харыг тэвчиж, цагааныг үйлдэхийн сургамжит бэлгэ дэмбэрэл - цугаарыг товчоолж багтаасан шинэ оны магнай тэргүүн өдрийн агуу их баяр.

Битүүлэг нь хуучин оныг хаах төдийгүй, шинэ оныг ханзлахын дом юм. Өнгөрч байгаа жилд учирсан өшөө хорсол, өнчрөл гаслан бүгдийг хааж, шинэ ондоо дүүрэн бэлгэтэй золгож, түвшин жаргалтай аж төрөхийн амыг нэгэн зэрэг ханзалж байгаад битүүлгийн баярын нандин учир оршино. “Шанаагаа элэгдтэл хуучилж, шанагаа эмтэртэл сүү зөөлцсөн” нэг хотныхон ч амар мэндээ мэдэлцэж, дааганы далан, бярууны булчингийн тухай яриа бололцдог нь эрхмийн дээд эрхэм ёсон мөн бүлгээ. *Д.Маам*

Хөтөч санааг дэлгэрүүлэн, цогцолбор бүтээе

Цогцолборын бүтцийг ажиглаж, ялган тодруулсан гадаад, дотоод холбоосын үүргийг тайлбарлан ярилцаарай.



САНААГАА ЭМХЛЭХ АРГА:

Дараах эхийн хэсэг, дөрвөн өгүүлбэрийн дарааллыг ажиглая.

Адууны хөх хомоолоор сүү хөөрүүлдэг. Гал нь зөөлөн болоод шаргал. Асах нь аргадал билгийн үг мэт. Зэрэглээд түлэхэд нурж унахгүй, нуранги үнс ч нэг их гарахгүй... *Дан. Нямаа*

Хөх хомоол¹ - хөх хомоолын гал² - хөх хомоолын асах³ - хөх хомоолын чанар⁴

Өгүүлбэрүүдийг учир зүйн ийм нарийн дарааллыг баримталж, яруу сайхантай хослуулан бичиж гэмээнэ утга агуулга үнэмшил сайтай болдог байна.

Ийнхүү найруулан бичихэд эхийн гадаад, дотоод холбоос чухал үүрэгтэй байдаг. Тэдгээрийг хэрэгтэй газар нь зөв сонгож байрлуулбал ярианы ба бичгийн эхийн найруулгыг утга төгс болгодог. Ялангуяа монгол хэл гадаад холбох хэрэглүүрээр нэн баялаг. Жишээлбэл: “Энэ, тэр, ингээд, гэвч, үүнчлэн, ингэнгүүт” гэх мэт энгийн (дан)

бүтэцтэй, “нөгөө зарим нь ийм учраас, ингэж байтал, ингэнэ гэдэг нь, тиймийн тул, энэ тухай” гэх мэт нийлмэл (задлаг) бүтэцтэй байдаг. Тухайлбал: Сурах бичгийн 60 дугаар талд буй Б.Ринчений “Юуны магад” эхийг дахин уншаад үзээрэй. Энэхүү эхэд “тэ-” язгуураас үүсэж, холбох үг болж хэвшсэн “тэгээд, тэгвэл” гэсэн үгсийг хоёр цогцолборын хоорондох шалтгаан, үр дагаварт харьцааг гаргахад чухал хэрэгтэй зөв байранд хэрэглэсэн байна. Насан өндөр болж оюун билгийн чанад хүрэхийн цагт ариун эрдмийн шимийг хүртээсэн ачит багш нартаа урмын үг илгээхийг анхилуун үнэрт лянхуа цэцэгтэй адилтган дүрсэлсэн төгс төгөлдөр эх болжээ. Мөнхүү санааг гаргахад “тэгээд, тэгвэл” гэсэн гадаад холбох үг чухал үүрэгтэй байна.

Эхийн холбоосыг зохистой сонгон найруулснаар төрөл бүрийн харьцааны утга оновчтой илэрч гардаг учиртай.



Дасгал 73

Дараах сэдвүүдээс аль нэгийг сонгоод, Дан. Нямаагийн бичсэн эхийг дуурайж, учир зүйн дараалал, яруу сайхны хослол бүхий эх зохиож бичээрэй.

- Сургуулийн хаалга ...
- Ангийн самбар ...
- Сурагчийн цүнх ...
- Сурагчийн үзэг ...

Ятгасан эсээний үндсэн хэсгийг бичих

- **Итгүүлэх нөхцөл бүрдүүлэх.** Уран дүрслэл, баримт нотолгоо, судалгаа шинжилгээ гэх мэт арга хэрэглүүрийг оновчтой хослуулж, байр сууриа дэмжиж, нотолно. Өгүүлэгчийн үзэл бодолд гурваас доошгүй шалтгаан, шалтгаан бүрд хоёроос доошгүй нотолгоо байж болно.
- **Хоёр талаас авч үзэх.** Үзэл бодлыг тань зөвшөөрөхгүй байгаа хүний байранд өөрийгөө тавиад үз. Тэр хүн ямар үндэслэл нотолгоо гаргаж ирэх бол гэж эргэцүүл. Түүнийг нь аль нэг талаар хүлээн зөвшөөрөх юм уу, эрс няцаах байдлаар бичиж болно.

Баримт нотолгоо, эшлэл зүүлт ашиглан, итгүүлэн үнэмшүүлж бичье

Чи ямар бичвэрт итгэх вэ? Хүн нотолгоогүй зүйлд итгэж болох уу? Баримт нотолгоог хэрхэн ангилах вэ?

Эсээнд ашиглаж болох баримтууд:

Баримт нотолгооны гурван үндсэн хэлбэр нь:

Жишээ баримт, статистик, тоон мэдээллээр нотлох: Найдвартай эх сурвалжаас авсан байх, хувь хүний туршлага болон сорил туршилтаар батлагдсан байх.

Жишээ нь: Хээрийн түймрийн дараа тухайн газрын хагдан бүрхэвч устаж, халцгай газар хоёр дахин нэмэгддэг.
Ногоон ургамлын бүрхэвчийн эргэн ургах чадвар 10 дахин буурдгийг судалгааны дүн харуулж байна.

Шинжээчийн дүгнэлт нь: Уг асуудлыг нарийн судалсан мэргэжлийн хүмүүс, шинжээч, эрдэмтэн, судлаачдын судалгаа, тайлан, мэдүүлгээс эш татах.

Жишээ нь: Технологийн эринд өсөж буй хүүхдүүдийн мэдээлэл хүлээн авах чадвар нь сайжирч, нүдний хурд нэмэгдсэн ч шийдвэр гаргах, өөрийгөө удирдах чадамж буурсан гэж шинжээчид үзжээ.

Бодит явдлын тухай өгүүлэмж, хувь хүний туршлагаас үүдэлтэй товч түүх:

Жишээ нь: Хоёр сумын дунд асаж буй түймэр 150 орчим км үргэлжлэх нарсан ойг шатааж дуусгаад, нүд үл гүйцэх шаргалтсан цэлгэр талыг хормын зуур үнсэн товрог болгон хувиргав. Салхины хүчинд дүрэлзэх гал 4-5 метр хүртэл ноцож, хоёр сумын нутгийг хар утаа нөмөрчээ.



Баримтын тухай мэдлэгээ сэргээн санаж, “Монгол хэл IX” Уб., 2017 оны сурах бичгийн 125 дугаар талаас “Баримтыг шинжлэх хүснэгт”-ийг эргэн үзээрэй.



Дасгал 74

Дараах үзэл бодол ба нотлох баримтуудыг зөв харгалзуулна уу. Ямар, ямар баримт байна вэ? Баримтуудыг агуулгаар ангилан ялгаарай.

Үзэл бодол	Баримт нотолгоо
<p>1. Шунахайрах. Тэнэглэлийн үндэс. Эд хөрөнгө, эрх дарх, алдар цолын хойноос улайран тэмцэх, олох, олсноо арвижуулахыг эрмэлзэн зүтгэх нь шуналын илрэн гарч ирж буй хэлбэрүүд... Үхэхийн цагт хураасан хадгалснаа аван одохыг хүсэмжлэх нь тэрхүү бодгалийн тэнэглэл...</p> <p style="text-align: right;"><i>Д.Батбаяр</i></p>	<p>а. Массачусетсийн анагаахын их сургуулийн профессор Жон Кабат Зин бие махбодыг мэргэн ухаан ба сэрэл мэдрэмж, ухамсраараа анагаах тухай онолоороо ихээхэн шуугиан тарьсан нэгэн. Түүнийхээр бүх зүйлийг, сэрэл мэдрэмж, бие ухааныхаа дохио бүрийг сэргэгээр хүлээн авч, мэдэрч байх нь бидэнд сэтгэл санааны амгалан байдал, эрүүл мэнд мэргэн ухаан, нигүүлсэл, өөрийгөө хайрлахуйн шинэ хэмжээсийг нээж өгөөд зогсохгүй элдэв өвчнөө анагаах боломжийг ч олгодог гэнэ.</p>
<p>2. Ертөнцийн нууц яруу найрагчийн сэтгэлд хадгалагдаж, цагаа болохоор ганцхан агшинд л илэрч цааснаа буунам. Сайн оюут тэдгээрийг ойлгож, нууцын түлхүүрийг тэмтрэх ба доод оюут үл ойшоон “байдаг л юм” гэсэн янзтай ярвайна.</p> <p style="text-align: right;"><i>О.Дашбалбар</i></p>	<p>б. “Шинэ зохиол бичихэд хамгийн эхний мөрийг гаргах бэрх. Зохиолынхоо эхний хэдэн мөрийг бичих гэж би олон сар зовдог.” гэж Габриэль Гарсио Маркес хэлсэн.... 1895 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Л.Н.Толстой салхинд явж байгаад “Төрөл арилжихуй” (Воскресение) романыгаа урагшаа явж өгөхгүй байгаагийн учрыг оллоо. Буруу эхэлчхэж” гэж өдрийн тэмдэглэлдээ бичсэн байдаг. Антон Павлович Чехов дүүдээ бичсэн захиандаа “Шууд хоёрдугаар хуудаснаас эхэл” гэж зөвлөсөн ч байдаг.</p>
<p>3. Хурдны эрин зуунд улам бүр завгүй, улам бүр яруу амьдрах хэмнэлийг биднээс шаардаж байна. Энэ нь эргээд бидний амьдралын хэмнэлийг алдагдуулж, бухимдал стрессийн үүдийг нээдэг. Хурдан машин, түргэн хоол, яруу харилцан яриа, богино амралт, цухалдуу гэр бүл гээд тойрон хүрээлж буй хурдан амьдрал дунд бид амьдралыг ч амталж амжихаа байжээ. <i>А.Амармэнд</i></p>	<p>в. 1990 оны 5 дугаар сарын 15-нд “Кристиз” хэмээх дуудлагын худалдааны Нью-Йорк дахь байранд болсон дуудлагын худалдаанаас зураач Ван Гогийн зурсан “Поль Фердинанд Гаше” эмчийн хөргийг Японы тэрбумтан Риоэй Санто гэгч хүн 82,6 доллараар, Огюст Ренауарын нэгэн зургийг 77,1 сая доллараар худалдан авчээ... Санто эл зургуудаа хожим хойно өөртэйгөө хамт чандарлахыг хүссэн гэрээслэл бичсэн байна.</p>

<p>4. Хүний байгальд үзүүлж байгаа эерэг нөлөөллөөс сөрөг нь илүү байдаг. Үүнээс болж байгалийн унаган төрх алдагдаж цаг агаар, ургамал амьтны амьдрал өөрчлөгдөнө.</p>	<p>г. 2011 оны хувьд 448128 тонн буюу 1993 оноос хойш анх удаа 400 мянган тонноос давсан үр тариа хураан авсны зэрэгцээ түүхэндээ хамгийн их төмс, хүнсний ногоо хураасан жил байв.</p>
<p>5. Хүмүүс бид өөрсдийгөө энэ хорвоог танин мэдэх, орчлонгийн бүх үзэгдлийн нууцыг тайлах, газар дэлхийг эзэмших эрхтэй гэж үздэг. Энэ маань харин алдаатай үзэгдэл шиг санагдана. <i>Г.Аюурзана</i></p>	<p>д. Еленагийн хүү Константин Константинополийн эзэнт гүрнийг үндэслэн байгуулсан бөгөөд өчнөөн зуун жилийн дараа мөн л Елена хэмээх эхээс төрсөн Константин гэгч эр мөнөөх гүрнийг мөхөөсөн билээ.</p>
<p>6. Бусдын гарз хохиролтой холбогддоггүй тийм ашиг гэж ерөөсөө байдаггүй шүү дээ. <i>М. Монтень, орч Г.Аюурзана</i></p>	<p>е. Нэг модыг унагахад хэдхэн минут зарцуулагдана. Нэг модыг тарьж ургуулаад, хэрэглэх хэмжээнд хүргэхэд 30 жил болно.</p>
<p>7. Заримдаа хувь заяа гэдэг маш урнаар бодож олсон зохиомол заль шиг санагддаггүй гэж үү? <i>М. Монтень, орч Г.Аюурзана</i></p>	<p>ё. Гучаад оны үед “японы тагнуул” гэсэн гүжир үгэнд эхлээд нэг хоёр, нэг хэсэг хүн унаж, эцсийн дүнд тэр үед манай улсын төр засгийн жолоог барьж байсан бүх хүн тийм тагнуулын хэрэгт холбогдон сүйрч, улмаар тусгаар тогтнолоо алдах дөхсөн.</p>
<p>8. Хүн хүнээ үгээр егүүтгэх, сэтгэлээр үхүүлэх маш эртний мөртлөө үгүй болдоггүй бузар хэрэглүүр бол гүтгэлэг юм. Гүтгэлэг нь бие, хэл, сэтгэл гурвын нүгэл нэгэн дор хурсан хамгийн бузар булай юмны үндэс. <i>Л.Түдэв</i></p>	<p>ж. Цэнхэр бар, одой заан, Лох нуурын савдаг гэх мэт учир нь олдохгүй хачин амьтдын тухай, Африк болон Латин Америкт ургадаг махчин моддын тухай, сүү уудаг шүтээнүүд, уг нь байгальд тийм шувуу байхгүй гэх боловч нэгэнтээ яах аргагүй бяцхан жаалыг шүүрэн одсон хангардийн тухай гээд амьд байгалийн оньсогыг тоочоод баршгүй.</p>
<p>9. Хүнсний ногоо бол эрүүл хооллолтын хамгийн чухал хэсэг бөгөөд олон төрлийн эрдэс бодис, витаминь эх үүсвэр болдог. Иймээс хүнсний ногоог өдөр тутмынхаа хоол хүнсний нэг хэсэг болгож заншсанаар өвчнөөс урьдчилан сэргийлэх боломжтой.</p>	<p>з. “Толь шил нь гялалзах том том хотын гудамжинд ч толгодынхоо салхиар дутаж, толгой нь өвддөг” Нямсүрэнг хөдөө рүү нь дууддаг “нэг юм байдаг” бололтой. “Өчигдөр оройжин бие тавгүй, уйлагнасан бороотой намрын сар үүлэн чанад орсон юм”. Тэр ингэж хэлнэ.</p>
<p>10. Эхлэх хэцүү. Уулын орой дээрээс уруу нь чулуу өнхрүүлэхтэй адил бэрх. Нэг өнхрүүлчих юм бол хар эрчээрээ өнхөрсөөр цаашлах тусмаа хүчээ авч улам хурдан эрчлэн өнхөрсөөр бэл хүрчихнэ. Үүний тулд хар эрчээрээ өнхөрч чадахаар чулуу өнхрүүлэх ёстой. Жижиг чулуу хол явахгүй. Замдаа дайралдсан томхон чулуунд тээглээд тогчихно. Тийм учраас бэл хүртэл өнхөрчөөр чулууг өнхрүүлэх хэрэгтэй. <i>Д.Батбаяр</i></p>	<p>и. Худалдаачин хүн залуучуудын үрэлгэн байдлаас, тариачин хүн талхны өндөр үнийн ачаар, барилгачид байшин барилга хуучирч нурсны үр дагавраар, шүүхийнхэн хүмүүсийн хооронд гарсан хэрүүл маргаанаас, санваартнууд (бүр тэд хүртэл шүү) өөрсдийг нь хүрээлж байдаг бишрэл хүндэтгэлээс гадна бидний үхэл, гачигдлаар бас амь зуудаг...</p>



Алхам 1. Дараах хэсгийг өгүүлэгчийн үзэл бодол, дүгнэлт гэж үзэх үү? Баримт нотолгоо гэж үзэх үү? Аль нь байхгүй байна вэ?

Юм бүхэн хувьсан өөрчлөгдөх цаг төрийн араншинд хүмүүн олноор уруудах авч жинхэнэ яруу найраг нийтийн ташаалын аясыг эс дагана. Харин жинхэнэ яруу найраг өөрийн цаг хугацааг хазаарлан хүлэглэж басхүү өөрийн амьдраагүй он цагийг эзлэн дагуулж болно. Зүрх сэтгэлийн гүн уянгат утга хийгээд хүмүүн байгалийн давтагдашгүй гоо сайхныг яруу найргийн гэрэлт бадагт тогтоон барьж хэлхсэн агшин зуурын энэхүү үзэгдэлд мөнхийн хүч чадал нь оршиж байдаг ажгуу.

Г.Мэнд-Ооёо

Алхам 2. Дээрх хэсгийг алдартай яруу найрагчийн амьдрал, зан төрх, уран бүтээлд тулгуурлан дэлгэрүүлж бичихийн өмнө, Д.Нямсүрэнгийн бүтээлд яруу найрагч О.Дашбалбарын бичсэн дараах үнэлгээг уншиж, гол ба үүдэл санааг тодорхойлно уу.

... Түүнийг шувууны яруу найрагч гэж болмоор... Шувуу бол түүнд эрх чөлөө, дураар аялахын бэлгэдэл мэт! “Өмнийн цэнхэр энэ ууланд очихдоо өөрийнхөө шувуудтай ингэж эгшиглэв ээ.” гэж нэгэн шүлэгт нь буй. “Өөрийнхөө шувуудтай” гээд байгаа шүү. Түүнд өөрийн шувууд бий. Тэр шувууд бол түүний сэтгэлийн тэнгэрт ниссэн шүлгүүд юм. “Шувуу солонгорон донгоджээ”, “Хаа газрын шувуу шиг л тэр хаврын хөх зэрэглээн дунд яваа”, “Өвгөн шувуу шиг гундан суусныг бодвол”, “Дөрвөн цагийн шувуу болжмор минь зүүдлэгдэх ахуй”, “хаврын шувуудын жиргээн дунд хайртай гэж дахин хэлнэ”...

Алхам 3. Уран зохиолын хичээлээр судалсан ямар яруу найрагчийг хамгийн сайн мэдэж байна вэ? Түүний ямар шүлэг “Алхам 1”-д Г.Мэнд-Ооёогийн бичсэнтэй тохирно гэж бодож байна. “Алхам 2”-ыг дуурайлган нотолж, дүгнээрэй.

ДҮГНЭЛТ: Эсээнд дэвшүүлсэн асуудал, гол санааг нэгтгэн дүгнэх хэлбэр. Эсээний дэвшүүлсэн асуудал өгүүлэгчийн хувьд яагаад чухал болохыг дахин сануулж, үзэл бодлоо дахин нотлох хэсэг нь дүгнэлт юм. Тиймээс дүгнэлт бол эсээний эхлэл, төгсгөлийг холбох боломж гэж үздэг.



Дасгал 76

Дараах эхлэл ба дүгнэлт өгүүлбэрийг тохирох баримтаар нотолж дэлгэрүүлэн, найруулж бичнэ үү. Гурваас доошгүй төрлийн баримт нотолгоо олохыг хичээгээрэй.

Эхлэл өгүүлбэр:

Чацаргана нь хүнсний болоод эмчилгээний асар их ашиг тустай жимс.

Дүгнэлт өгүүлбэр:

Иймээс чацаргана тариалах нь ямаа өсгөхөөс илүү ашигтай.



Дасгал 77

Дараах ятгасан эсээг уншаад, даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Захидал бичдэг өдрүүдийг эргэн санахуй

Орчин үеийн холбооны технологи бидний амьдралыг өөрчлөв, утас гар утас, facebook, youtube, e-mail гээд... Дэлхий үнэхээр нэгэн аймаг мэт болчихсон тул харилцан холбоо барих нь хүндрэлтэй асуудал биш болов. Та удаан хугацаанд уулзаагүй боловч байнга холбоо барьж байсан найз нөхөдтэйгөө дахиад уулзахад, тэд хажуугийн ерөөнөөс хүрээд ирсэн юм шиг санагдаж, танил дасал бодогдохоос биш цочиж баярлах явдал гарахгүй байж мэднэ.

Захидал гэдэг “Эрт”-ний холбооны хэрэгслийг одоо ашигладаг хүн байгаа болов уу? Гэр орноосоо холдож, гадагш гарч эрдэм сурч байгаа хүүхэд. Тэд аав ээжтэйгээ утсаар холбогдоод л гүйцээ. Олон жилээр уулзаагүй нэг ангийн хүүхэд үү? Facebook-ээр нэг инээд алдсан зургаа явуулахад л болно. Хайр сэтгэлээ илчилж байгаа хосууд уу? “Янагийн захидал” гэж аль галавын үеийн төвөгтэй зүйлээс мессежээр харилцах нь шуурхай, хурдан, ойр дотно. Дүрс дүрсээ харалцан холбоо барьчих хойно хагацаад удахын ч зовлон алга. Нийгмийн асар түргэн хөгжил нь хүмүүсийн хоорондын хайр сэтгэлийн холбоо харилцааг түргэсгэж, захидлаар харилцах орон зай дахиад олдоход бэрх болжээ. Бид захидлын тухай бодохлоор нэгэн галав алгассан мэт хол санагдах болов. Бид хэдийгээр e-mail-ээр өдөр болгон хэд ч хамаагүй захиа авдаг ч тэдгээр “Захиа” гэдэг зүйл нь захидлын утгаа аль хэдийн алдсан юм биш биз ээ.

Үнэхээр шинжлэх ухаан, технологи нисэх мэт түргэн хөгжиж байгаа өнөөдөр уужуу тайван сууж захидал бичдэг урлаг улам харагдахаа больж, хэн нэгэн ч тухлан сууж санаж мөрөөдсөн сэтгэлээ хайр бялхсан үг өгүүлбэрт шингээн бичихгүй болов. Хүмүүс сүлжээнээс үнэнч сэтгэл хайж, компьютерын гараас баяр цэнгэл мэдэрч, e-mail-ээр захидлын цаасыг орлуулахаас биш, үзэг барьж найз нөхөд, амраг гэргий, гэр бүлийнхэндээ захидал бичихгүй болов. Өнөөдөр захидал хүлээн авсан сэтгэгдлээ санаж байгаа хүн одоо чухам хэд байгаа бол? Арзгар дугтуйг нь хөндийхөн илж, дараа нь будгийн үнэр анхилсан хуудас бүрээс хайр бялхсан үг өгүүлбэрийг уншиж байсан маань маш эртний явдал шиг санагдах болжээ. Тэр үед захидал зөвхөн холбоо барих ганцхан үүрэгтэй биш, захидлаас бид бас зарим гоё сайхан нарийн зүйлсийг мэдэрдэг байсан. Захидал амьтай, тэрээр ярьж чаддаг, захидал хүний баярлах, уурлах, гуних, тайвшрахыг илтгэж чаддаг. Захидал хүлээн авах бүр захидлын дугтуй дээрх үсэг бичгийг халтихан харахад л хэний захидал болох нь мэдрэгддэг. Тэр үед түүний дуу шуу,

инээмсэглэсэн дүр төрх нүднээ тодордог. Захидлын дугтуйг хичээнгүйлэн задалж, эвдэж урахаас болгоомжлон, найз нөхдийнхөө бичиж ирүүлсэн хайрын сэтгэлийг сэвтээхээс болгоомжилдог. Захидал уншиж суухад найз нөхөдтэйгөө ярилцаж суугаа юм шиг, ирсэн захидлаа байн байн гаргаж, давтан уншмаар санагддаг. Хамгийн сайхан, дээд зэрэглэлийн цаасан дээр гоё сайхан бичсэн, бас сайтар сонгож наасан шуудангийн марктай захидлаас тэр хүний соёл боловсролын түвшин харагддаг гэж зарим хүний хэлсэн нь оргүй явдал биш биз.

Хувийн захидал түүхийн хөгжлийн хамгийн сайн хураангуй болох нь маргаангүй зүйл. Алдартай хүмүүсийн хувийн захидлыг уншин сонирхоход, тэдгээрт агуулагдсан хайр халамж, хүсэл мөрөөдөл, хайр сэтгэл мэтийг догдлон уншиж, бишрэх сэтгэл төрдөг. Алдарт зохиолч Иван Бунины нас барахаасаа өмнө нэгэн найздаа Л.Толстойн “Дайн ба Энх” романыг 50 дахь удаагаа уншиж гайхан шагшсан тухайгаа бичсэнээс зохиол бүтээлийн үнэлэмж цэгнэмжийг ухаарч, А.Линкольны дүүдээ бичсэн захидлаас хөдөлмөрлөхийн үнэ цэнийг мэдэрч, О.Дашбалбарын хайртай бүсгүйдээ бичсэн захидлаас түүний эелдэг зөөлөн зан араншин мэдрэгдэж, Вень Идүөгийн АНУ-д сурч байхдаа гэртээ бичсэн захидлаас хоцронгуй орны иргэн харь улсад амссан гадуурхал доромжлол ил мэдрэгддэг. Ч.Лодойдамба гуайн гэргий Долгорсүрэндээ бичсэн хувийн захидлаас хувь тавилан хэрхэн хүндэтгэл бишрэл болон хайр сэтгэлийг холбодгийг ойлгож, он жилийн салхи бороо, хүний ертөнцийн мандал буурлыг туулсан ч хайр сэтгэлтэй хүмүүсийн хэзээд хувиршгүй янаг хайрыг мэдэрдэг. Фү Лэйгийн хувийн захидлууд түүнд бахархал авчирсан хүү өсгөж өндийлгөж өгсөн байдаг. Алдартай хүмүүсийн хувийн захидлуудыг уншиж суухад тэндээс хязгааргүй хүчин чадал олох шиг болдог. Цаасан захидал нь жинхэнэ утгаар хүмүүсийн хайр сэтгэлийн илэрхийлэл байдаг. Сүүлийн үед хэвлэгдсэн “Хайрт Андрей” гэдэг номд Тайваний алдарт зохиолч Лүн Интай хатагтай түүний арван наймтай хүү Андрейдаа бичсэн гучин хэдэн захидал нь хоёр үеийн хүмүүсийн хоорондын ан цавыг анагаахыг хичээсэн байдаг. Захидалдаа тэд үе тэнгийн юм шиг харилцаж, өргөн асуудлыг хөндөн хэлэлцсэн байдаг. Уг номын аядуу хүлээцтэй, ухаалаг тэвчээртэй, эрх тэгш, энэрэнгүй хайртай, аргадсан зөвлөгөө нь эх хүний сэтгэл зүрхний гол хөг болж, түүний бичсэн үг өгүүлбэрт багтсан гүн агуулга нь үрээ хайрласан энгийн хүүрнэлээс хол давуу болохыг ухаардаг. Уг захидлын түүврийг даяаршлын үеийн чин сэтгэлийн харилцаа гэж зарим хүн үнэлж байна.

Ажилдаа дарагдсан хүмүүс захидал бичих, илгээх, хүлээх, унших харилцаагаар дотно хүмүүстэйгээ сэтгэлээ хуваалцаж, ойр дотно харилцаж, хүний амьдралын хүсэл мөрөөдөл болон салж ядах байдлаа мэдрэлцэж, холбоо харилцаагаа гүнзгийрүүлдэг байжээ. Харин одоо цагт, утас элбэгшиж, сүлжээ хавтгайраад, орчин үеийн электрон холбоогоор монголчуудын хэдэн зуун жилийн гэр бүл, хайр сэтгэлийн солилцооны уламжлалт сонгодог хэлбэр нэгэнт өөрчлөгдөв. Шуудан холбооны захидлын хайрцаг улам хоосрон хэвтэх болж, хүмүүс сүлжээний захидлын хайрцагаас гэрлийн хурдаар холбоо барьж, шууд хэлэлцдэг facebook, yahoo мэт нь “алс хол” зайг татан ойртуулж, дүрсээ харалцаж, дуугаа сонсолцон, ярилцах болов. Орчин үеийн холбооны технологи үнэхээр хурдан түргэн холбоо барихад амар хялбар болж, хүний хэрэгцээг бүрэн хангах болсон хэдий ч хайрын сэтгэлийг мэдрэх байдал өөрчлөгдөж, орчин үеийн хүмүүсийн хэт бүдүүлэгшиж байгаа хайр сэтгэлийг улам задгай, илэн далангүй болгож байж мэдэх юм. Захидал бичих сэтгэл, захидал



хүлээх тэвчээр, захидал авах баяр хөөр, захидал унших догдлол, энэ бүхнийг түргэн дөхөм ч орчин үеийн холбооны хэрэгслүүд хэзээ ч орлож чадашгүй.


Зөвхөн дэвшилтэт технологиор захидлын утсаныг тайлбарлан харамсаад ч нэмэргүй. Сошиал ертөнцөд хүмүүсийн захидал бичих, хүлээн авах давтамж үнэндээ маш их болсон. Тэгэвч тэдгээрийн олонх нь ажил хэргийн харилцаа, товч тодорхой, шууд шулуун, хатуу хөтүү, захидал бичигчийн сэтгэлийн өнгө ерөөс харагдахгүй, амьдралын байдал ажиглагдахгүй, ижил нэгэн хэвийн дармал үсгийн тигээс өчүүхэн төдий зүрх сэтгэлийн өнгө аяс үзэгдэхгүй. Гэвч үсэг бичиг оршиж байсан цагт олонх хүмүүсийн амьдралд захидлаар илтгэх, хүүрнэх, солилцох, чагнахыг хүсэн хүлээж байгаа зүйлс хэзээд л байна гэдэгт бид итгэж байна. Бороо хур орсон өглөө эртлэн босож, сайхан шаргал цайгаа аягалан суугаад, цэвэрхэн захидлын хуудсыг дэлгэж, тодхон гардаг үзгээ бариад, санан дурссан сэтгэл, хайр мөрөөдлөө илэрхийлэн бичих юутай сайхан. Сар, өдөр, цаг, минутаар өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа орчин үеийн технологи хүний сэтгэл зүрх, урмас зоригийг бүү халхлаасай. *Г.Лхам*

- а. Өгүүлэгчийн үзэл бодол, дэвшүүлсэн асуудлыг эсээний эхлэл хэсэгт олж тэмдэглээрэй. Өгүүлэгч шууд санаагаа илэрхийлсэн үү? Аль эсвэл өөр аргаар уу?
- в. Тодруулсан хэсгийн найруулгын алдааг залруулж бичээрэй.
- б. Үзэл бодлоо итгэл үнэмшилтэй болгохын тулд ямар ямар үг, хэллэг, өгүүлбэр ашигласан байна вэ? Ялган тэмдэглэнэ үү. Зохиогч уншигчийг юунд ятгаад байна вэ?
- в. Цаасан захидлын үнэ цэнийг өөрийнхөөрөө товч тодорхойлж бичнэ үү. Ингэхдээ эсээнээс хамгийн оновчтой гэж үзсэн гурван нотолгоог эш татаж ашиглаарай.

Бүтээлч даалгавар

Итгүүлэн үнэмшүүлж, ятгасан эсээ бичихдээ дараах алхам дарааллаар ажиллаарай.

Алхам 1. Дараах асуудлаар мэтгэлцэнэ үү. Ус бол байгалийн баялаг. Ард нийтийн өмч байсаар ирсэн, байх ч ёстой энэ үнэт баялгийг хэн нэгэн өмчилж, эрүүл ахуйн шаардлагад тохирсон эсэх нь үл мэдэгдэх, гял цал саванд хийж, өндөр үнээр худалдаж болох уу? Үүнээс үндэслээд, ер нь усыг савлаж хэрэглэх ёстой юу? гэж асуувал та нар юу гэж хариулах вэ? Асуултад ул үндэстэй хариулахын тулд гарцаагүй шалтгаан, үндэслэл хэрэгтэй болно. Шалтгааны эрэлд мордож, үзэл бодлоо хамгаалцаая.



Алхам 2. Гэвч чи аль талд байна вэ? Аль байр суурийг дэмжиж байна вэ? Өөрийн үзэл бодлыг тодорхойлоорой. Тус бүрд гурван үндсэн шалтгаан байна. Илүү бодитой шалтгаан нэмж олоод асуудлаа дэвшүүлж, хөтөч өгүүлбэрээ бичээрэй.

Алхам 3. Эсээгээ яаж эхлэх вэ? Хэрхэн үргэлжлүүлэх вэ? Ямар дүгнэлт гаргах вэ? Эргэцүүлэн бодоод, эхлэх аргуудаас оновчтойг сонгоорой.

Анхаарах зүйл. “Хуванцар сав нь хүний эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг нөлөөтэй учраас савласан усны хэрэглээг хязгаарлах ёстой” гэсэн байр суурь, хөтөч санааг дэмжиж, бусдад итгүүлье гэвэл дээр дурдсан гурван шалтгааныг учир зүй, ёс суртахуун, сэтгэл хөдлөлийн арга, хэрэглүүрээр нотолж, үзэл бодлоо тууштай хамгаалж чадвал уншигч, сонсогч уг асуудлын талаар тодорхой ойлголттой, итгэл үнэмшилтэй болж, таны үзэл бодлыг дэмжих болно.

Өгүүлэгч үзэл бодлоо хамгаалж, уншигчдад итгэл үнэмшил төрүүлэхийн тулд уг асуудалд учир шалтгаан, ёс суртахуун, сэтгэл хөдлөлийн үүднээс хандаж, хангалттай баримт, материал цуглуулсны үндсэн дээр хөтөч өгүүлбэрээ учир шалтгааны зөв дарааллаар дэмжиж, өрнүүлэхэд үндэслэлтэй (ятгасан) эсээний гол мөн чанар оршино.

Алхам 4. Бодож байгаа зүйлээ мартахаасаа өмнө шууд дэвтэр дээрээ бичиж ноороглож эхэл. Зөв, буруу байж болно. Бичсэнийхээ дараа дахин уншаад хэрэггүй, утга нь алдаатай, давхардсан зүйлүүдийг доогуур нь зурж тэмдэглэ. Оновчтой санаануудаа (✓)-ээр тэмдэглэ.

Дараах жишээнээс сонгож ашиглаарай. “Хуванцар савтай усны хэрэглээг хязгаарлах нь зүйтэй” гэсэн үзэл бодлыг хамгаалж, уншигчдад итгэл үнэмшил төрүүлж, болохуйц зарим жишээг үзүүлье. (Г.Лхагва. Литр цэвэр ус үйлдвэрлэхэд гурван литр ус зарцуулдаг. Өнөөдөр сонин. 2015. № 065.) Эдгээр нь ёс суртахуун, сэтгэл хөдлөл, учир шалтгааны арга, нотолгоо болж байгаагийн учрыг ярилцаарай.

Усны мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар үйлдвэрлэгчид нийтийн усны ундаргаас ус авч содон нэртэй, цэвэрхэн гадаргатай хуванцар саванд хийгээд, цоргоны уснаас 2900 дахин өндөр үнээр худалддаг нь дэндүү шударга бус явдал юм.

Дэлхий даяар жилд дунджаар 2,4 тонн хуванцар сав хаядгийн 75 хувь нь цэвэр усных байдаг. Хуванцар савны хөрсөнд шингэх дундаж хугацаа 700 жил. АНУ-д жилд дунджаар 50 тэрбум савласан ус борлуулдгийн талаас илүү хувийнх нь сав дахин ашиглагдахгүй хаягддаг байна.

Усаар гачигдсан юмуу, усны найдвартай ундаргагүй бүс нутагт савласан уснаас өөр сонголт байхгүй нь мэдээж. Үүнд байгаль эхийн өмнөөс өршөөл үзүүлж болно.

Савласан усны үйлдвэрүүд гүний усыг дундалж, ундны усны нөөцөд сөргөөр нөлөөлдөг. Нэг литр савласан ус үйлдвэрлэх гэж гурван литр ус зарцуулдгийг тогтоосон олон улсын мэргэжилтнүүдийн судалгаа ч бий. Олон түмний өмч байсаар ирсэн, байх ёстой үнэт эрдэнэ болсон усыг өмчилдөг нь савласан усны бизнесийн өөр нэг сөрөг тал. Цоргоны усыг шүүж, буцалгаж уух нь байгаль орчныг болоод өөрийгөө ч хайрласан үйлдэл болохыг санагтун, хичээгтүн!

Алхам 5. Одоо бичсэн зүйлээсээ хэрэгтэйг аваад, дахин сийрүүлж бич. Тэгээд дахин хяна.

Эрдэмтэн, зохиолч **Л.Түдэвийн “Бичгийн ээж нь тоо гэвэл, үсгийн эцэг нь зангилаа” эсээг** уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгэнэ үү. (Догол мөр тус бүр дээрх дугааруудыг ажиглаарай.)

Бага байхад ямар нэгэн юмыг мартчих гээд бас ч мартаж орхидог нь нялх оюуны шинж байж дээ. Мартуулахгүйн тулд ээж маань хуруунд юм уу, бугуйнд ямар нэгэн утас зангидаж өгдөг байлаа. Тэр утсыг хармагц, өнөөх мартагнах гээд байгаа юмаа санах учиртай авай. Багын ийм явдал хүн болгонд тохиохоор барахгүй хүн төрөлхтөнд ч балчир ахуйд нь тойрох аргагүй, дайрч өнгөрсөн хэрэг байжээ.¹

Үүнийг эргэцүүлэн бодохуйд эхлээд ер нь үсэг бичиг гарсан юм уу, тоо бодлого үүссэн юм уу? гэх ерийн мөртөө яггүй асуудал гарч ирнэ. Ихэнх хүмүүс, анхдагч нь үсэг бичиг байлгүй яах вэ?, тоо бол тэгтэйгээ нийлээд аравхан дүрс хоёрдугаар зэргийн юм шүү дээ гэнэ. Нээрээ ч тийм юм шиг өнгөц бодогдох вий. Гэвч “эхлээд үсэг бичиг биш, тоо бодлого гарчээ.” гээд хэлчих хэмээн түүхийн баримтууд шивэгнэх ажээ.²

... Өмч хөрөнгөтэй болоод ирэхийн цагт юуны түрүүнд тоо бодох, тооцоо хөтлөх хэрэг гардаг байна. Түүнийгээ хэрхэн гүйцэтгэхийг санаашран бодож эхэлдэг нь гарцаагүй. Тэр хэрэгцээнээс үүдэж, тоо зохиохоос өөр аргагүй болсон ажээ.³

Хамгийн эртний бичиг соёлтой гэгдэж буй эртний Шумерын шаантаг бичгээр шавар хавтанцууд дээр дармаллаж үлдээсэн, асар баялаг шавар номын сангийн нэлээдээр барахгүй, дийлэнх хэсэг нь “нягтлан бодохын” ном байдаг нь аргагүй л тооцоогоор бүх юм үүссэний гэрч болж үлджээ. Төчнөөн суулга, тариа байсан. Төчнөөнийг нь тэр авсан, төчнөөн нь эзнийх гэдэг ч юм уу, хэд хэчнээн эд хогшил байгааг нарийн бүртгэн бичсэн, тэдгээр шавар номын тооцоогоор Шумер улсын эдийн засгийн байдлыг өнөө үед шинжин мэдэж болохоор баттай баримт үлджээ. Яг түүн шиг монголчууд бүр эрт балар цагаас Хүннүгээс ч өмнөх үед мөн л тооцоо хөтөлж байжээ. Тэгэхлээр бичиг үсгээс өмнө тоо бодлого үүссэн гэхэд дэгсдэхээргүй ажээ. Бас бичгийн соёл ч эцсийн дүнд тооцоогоор дуусна. Тоочлогдоогүй (математикчлагдаагүй) нөхцөлд аливаа шинжилгээ, шинжлэх ухаан болж чадахгүй гэсэн бичигдээгүй хууль улам бүр төгөлдөржиж, орчин үеийн цахим тооцоолуурын ололт, өнөөгийн соёл иргэншлийн амин сүнс нь болж байгаа нь дээрхийг гэрчилнэ.⁴

“Хүн төрөлхтний анхны бичиг үсэг нь тоо, сүүлчийнх нь мөн л тоо байх болно.” гэдгийг түүх өөрөө нотлон өгсөөр ажээ.⁵

... Монголчуудын зохиосон анхны тоон бичиг ямархуу юм байсан бол? Үүнд ардын ой ухаанд үлдэж, өнөөг хүртэл тээгдэж ирсэн мэдээлэл тусгай хариу өгнө. Бас эртний шавар, чулуун ном судар ч гэрчлэх билээ. Юм мартуулахгүйн тулд утас зангидан өгдөг заншил саяхан болтол хөдөөний малчдын ой ухаанд хадгалагдаж үлдсэн байна. Одоо тэр нь цахим тооцоолуурын санах байгууламжид шахагдан арчигдаж бүрмөсөн үгүй болно.⁶

...“Вэй шү” гэдэг эртний нанхиадын судар бичигт: “Жужаны цэргийн дарга нь хонины хорголоор цэргийн тоог бүдүүвчлэн тоолдог, хожим тэд мод сийлж, (кэму)

тэмдэглэл хийхийг сайн мэддэг болсон.” гэж бичиж үлдээснийг эрдэмтэн Г.Сүхбаатар “Монголчуудын эртний өвөг” гэдэг бүтээлдээ (1980 он, 124 дүгээр тал) эш татан дурдсанаас өлгөн авбал, юм юмны сэжүүр гарч ирнэ. Дээрх өгүүлбэрийн эхний хэсэг жужаны (нируны) цэргийн дарга нь хонины хорголоор цэргийнхээ тоог бүдүүвчлэн гаргадаг байсан гэдэг мэдээг бясалган бодъё. Үүнээс арай боловсронгуй аргаар саяхан хорьдугаар зууны эхээр Итгэлт баян малынхаа тооцоог гаргадаг байсныг “Тунгалаг тамир”-т их л итгэж үнэмшихээр өгүүлсэн нь дэлгэцэд хүртэл гарсан гээд л бодчих. Тэгвэл тооцоо хийдэг иймэрхүү энгийн арга монголчуудыг олон үеийн турш дагалдсан нь ойлгогдоно. Хорголоор тооцоо хийж байснаа хожим нь мод сийлж (кэмү) тэмдэглэл хийх болсон гэх хоёр дахь мэдээ нь монголчууд эхлээд тоо бодож сурсан, дараа нь бичиг үсэгтэй болсон гэдгийг тов тодорхой нотлоод өгч байна. Хонины хоргол гэхээр одоогийн хүмүүст их л бүдүүлэг мэт санагдах буй. Гэтэл өнөөг хүртэл хэрэглэсээр байгаа хятад сампингийн эрх нь хонины хорголыг санагдуулахаар барахгүй түүнээс ч гаралтай юм билүү хэн мэдэх вэ?⁷

Харин тэр үеийн цэргийн даргад хонины хорголоос өөр тооцоо хийчихмээр юм дайн тулааны гал утаан дунд олдоогүй байж ч болох буй за гэж бас нэгэн хувилбараар бодохыг хэн байг гэх билээ. Монголчууд хонины хорголоос боловсронгуй бөгөөд найдвартай тооцоог түүнээс өмнө хөтөлж байсныг бас л өвгөн түүх өөрөө гэрчлэн хоцорчээ. Манай тооллоос өмнөх 5 - 4 дүгээр зууны үед бичигдсэн нанхиадын эртний “Дао дэ үзин”-д (Зам мөр, заяа буяны номлолд) өвөг бичгийн нэг болох “Зангилаа бичгийн” тухай мэдээ занги үлджээ. “Зангилаа бичиг” гэхтэй зэрэг бага балчир цагт хөөрхий ээж маань юм мартуулахгүйн тулд утас зангиж өгдөг байсан нь өөрийн эрхгүй санаанд орох нь гайхалтай. “Зангилаа бичиг” гэдэг бол утсаар зангидаж мэдээлэл хадгалдаг маш эртний тооцооны арга юм. Тэрхүү өвөг бичиг (протописьменность) дорно дахинд бүр нарийвчилбал, Хүннүгийн өвөг дээдсийн үед үүсэн бий болсон бөгөөд голчлон тооцоо тооллогын мэдээлэл хадгалах өвөрмөц бичиг үсэг байсан ажээ. Нанхиад соёлын хүрээнд хэрэглэгдэж байгаад орхигдсон тэр “бичиг”-ээс монголчуудын өвөг дээдэс ч хоцорсонгүй. Харин “зангилаа бичиг”-т тэр цагт тун ховор зүйлийн нэг болох маалинган утас, дээс мэтийн чухал хэрэгцээтэй юм хэрэглэгддэгээс өргөн дэлгэрч чадаагүй ч хонины хоргол илүү хямд төсөр, бас ч эдийн засгийн хувьд ашигтай байсан биз. Нөгөөтээгүүр монголчууд модон дээр хэрчлээс гаргаж, түүгээрээ тооцоо явуулдаг болсныг дээр эш татсан эртний судар “хожим тэд мод сийлж (кэмү) тэмдэглэл хийхийг сайн мэддэг болсон.” хэмээн гэрчилж байна. Бут бургас, хулс зэгс, яргай чаргай мэтийн модны мөчир тайрдсан дээр хэрчлээс гарган, тооцоо хөтлөх нь олон талаар ашигтай бөгөөд найдвартай байсан болно. Тэрхүү (кэмү гэдэг) хэрчлээсэн “бичиг” нь боловсронгуй болон сайжирсаар хожим руни Орхон бичиг болон хувирсан гэхэд үнэмшихээс үгүйсгэх боломж байхгүй. Орхоны хөндийн эртний дурсгалуудад үлдсэн зураасан бичиг нь модонд хэрчлээс гаргах аргаар тоо бодож явсан өвөг дээдсийн “технологи” бараг хэвээрээ өвлөгдсөн шинжтэй бичиг билээ. “Кэмү” гэдэг үг ч гэсэн монгол хэлэнд маш эртний утгаа гуйвалтгүй баттай хадгалж ирсэн, түүний өвөг мөн гэхээр шинж тэмдгийг биедээ агуулсан ажээ.⁸

“Хэм” гэж монгол үг бий. Тэр нь ямар нэгэн юмны хэм хэмжээг заасаар өдгөөг

хүрчээ. Түүнээс хэмжээ, хэмжээс, хэмжээт, хэмнэл, хэмнэх, хэмжих, хэмжүүр, хэмх, хэмхрэх гэсэн үгс уламжлагдан буй болж үржиж олширсон ажээ. Тэр нь улам арвижиж “тэгш хэм, хэм тэгш, хэр хэмжээ” гэхчлэн салбарласан боловч цөмөөрөө ямар нэгэн юмын хэм хэмжээг заасан утгаа алдаагүй ажээ. “Хэмхрэх” гэсэн үг ч ямар нэгэн юмын хэм хэмжээ алдагдахыг заасаар байна. Хэмхрээгүй бол хэмэндээ байгаа, хэмхэрсэн бол хэмээ алдаж хэрэггүй болжээ гэдгийг зааж байна.⁹

“Хэм” гэдэг үг тийнхүү модон дээр хэм, хэмжээ зааж гаргадаг байсан зурааснаас үүссэнээ нууж чадахааргүй олон үндэс, мөчир салаатай болжээ. Тэр ч байтугай “хэмээх”, “хэмээн”, “хэмээв” гэж хуучин бичгийн үлдэц үг хүртэл хэм хэмжээг хадгалсан өнгө аясаа гээгээгүй л явна.¹⁰

“Кэмү” бичигтийн дээр үед “зангилаа бичгийг” халсан боловч түүний үр үндсийг таслалгүй өнөөг хүртэл авч яваа нэгэн үндэстэн дэлхий дээр бий гэдгийг дурдахад сонин. Тэр бол наад зах нь хорин мянган жилийн тэртээ эх нутгаасаа гарч алдарт Берингийн хоолойгоор дамжин, Аляск хүрч Атлантын далайн тэртээх Америк тивийг эзэгнэн суусан Инга нэрт улаан арьстнууд юм. Тэдний ард үлдсэн Хүннү нар ч өөрсдийгөө улаан арьстан гэж үздэг байсан ажгуу.¹¹

Инга буюу олон нийтийн ярьж бичиж заншсанаар индейчүүд нь эх нутгаасаа гарч явсан соёл иргэншлийнхээ ололтыг мөн авч одоодоо “зангилаа бичгээ” тээж, алс холын замыг туулжээ. Тийнхүү “кэмү” буюу зангилаа хэмт бичгийг мартагдан мөхөх аюулаас аварчээ. Харин тэд “кэмү” биш “кипү” гэсэн нэрээр түүнийг мөнхжүүлсэн юм. Инга нарын “кипү” гэдэг зангилаа бичиг нь гол төлөв тооцооны хэрэглүүр байсан тэр л янзаараа өнөөг хүрчээ. “Кэмү”, “кипү” хоёрыг үгийн хувьд нэг гаралтай гэмээр адилхан байгааг анзаарахгүй орхих аргагүй. Бас монгол хэлэнд “хэв” гэж хэм хэмжээг цаагуураа илэрхийлсэн өөр нэг үг бий. Хэв авч түүнээсээ хэмжээ алдахгүй хоёр дахь хувилбарыг бүтээдэг болохоор энэ үг нь хэм хэмжээний утгатай юм. Хэв ямар байна, түүнд цутгаж авсан зүйл мөн л тийм байдаг ёстой. Түүн шиг “кипү” гэдэг зангилаа бичиг нь нэг л тогтоосон хэвээр зангилагддаг тул андуурах буруудах явдалгүй ажээ...¹²

“Зангилаа бичиг” гэдэг нь монгол ойлголтоор бол хөвөрхий биш уяаг хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, “занги уяа” гэдэг ойлголт юм. Хөвөрхий байвал тайлагдахад амар, тэгээд ч тооцоонд будилаан орох заль мэхэнд автахаар байх тул, хөвөрдөггүй “занги уяа” гэж монголчуудын ойлголт буй болсон. Занги, харуул занги гэдэг болжээ. Мөн сумын занги, харуул занги гэхчлэн албан тушаалтнууд гарчээ. Сүүлийн үеийн гангачуул хүзүүндээ зангиа зүүх болов. Аливаа юмыг мартуулахгүйн тулд Орос хүмүүс хамар дээгүүрээ зур! (заруби на носу) гэдэг бол монголчууд “Утас зангидчих” гэж хэлдэг нь ч гэсэн зохиогч тодруулахад нэг юм хэлээд байна. “Зангилаа бичиг” хэдийгээр тооцооны шаардлагаас гарсан хязгаарлагдмал хэрэглүүр боловч нэлээн өргөн тархсан бөгөөд ухаж ойлгоход хялбархан мэдээллийн арга юм. Тэр нь сампин, цахим тооцоолуурт байраа нэгэнт тавьж өгсөн хуучны зүйл боловч хожим хожмын төгөлдөржсөн тооцоолуур буй болгох гол түлхүүр, хүний сэтгэлгээний сонин ололт байснаараа өвөрмөц билээ.¹³

Чухамдаа хэл бичиг анхдагч уу, тоо бодлого анхдагч уу гэдэг асуултад хариу өгөхөд “зангилаа бичиг” тус хүргэх бөгөөд монголчуудын өвөг дээдэс тооцооны

ухааны энэхүү анхдагчийг зохиолцсон хэмээхэд үгүйсгэх нотолгоо үнэндээ одоогоор алга байна.¹⁴ Л.Түдэв

1. 2 ба 3 дугаар догол мөрт зохиогч асуудлаа дэвшүүлсэн байна.
 “Хүн төрөлхтний анхны бичиг үсэг нь тоо, сүүлчийнх нь мөн л тоо байх болно” гэдгийг түүх өөрөө нотлон өгсөөр ажээ.⁵ гэсэн хөтөч өгүүлбэрээ учир шалтгааны үндэслэл бүхий ямар ямар баримтаар нотолсон бэ? Нотолгоо тус бүрийг олж тайлбарлана уу.
2. Дараах гурван мэдээлэл тус бүрийн нотолгоо бүхий үг, өгүүлбэрийг эхээс олж бичнэ үү.

Зохиогчийн үзэл бодол	Баримт нотолгоо бүхий үг, өгүүлбэрүүд
Хорголоор тооцоо хийж байсан. Монголчууд хожим мод сийлж (кэмү) тэмдэглэл хийх болсон. “Зангилаа бичиг” гэдэг бол утсаар зангидаж мэдээлэл хадгалдаг маш эртний тооцооны арга юм.

3. 9, 10, 11, 12 дугаар догол мөрийг зохиогч ямар зорилгоор бичсэн бэ? Өөрийн үгээр тайлбарлан бичнэ үү.
4. 2, 3, 5, 14 дүгээр догол мөр утга санааны ямар уялдаа холбоотой вэ? Эсээний бүтцэд ямар үүрэгтэй байна вэ?
5. Дараах өгүүлбэрийн цэгийн оронд эсээг уншиж ойлгосноосоо үүдэж, өөрийн үгээр дэлгэрүүлэн нөхөж бичнэ үү.
 “Эхлээд үсэг бичиг биш, тоо бодлого гарчээ” гэдэг санаагаа эрдэмтэн зохиолч Л.Түдэв гэсэн баримт нотолгоонуудаар баталж үнэмшилтэй бичжээ.
6. Зохиолч Л.Түдэвийн дээрх эсээг бүрэн эхээр нь Л.Түдэв “Бүтээлийн чуулган” цувралаас уншаарай.
7. Дээрх эхэд байгаа “нягтлан бодохын ном”, “санах байгууламжид шахагдан арчигдаж”, “өлгөн авбал юм юмны сэжүүр гарч ирнэ”, “дайн тулааны гал утаан дунд”, “өвгөн түүх” гэсэн үг хэллэгийг зохиогч ямар зорилгоор хэрэглэсэн бэ? Ятган итгүүлэх үүргийн талаас тайлбарлаарай.
8. Д.Батбаярын “Монгол бичиг” эргэцүүлсэн эсээг олж уншаад, Л.Түдэвийн “Бичгийн ээж нь тоо гэвэл, үсгийн эцэг нь зангилаа” эсээнээс бичлэгийн аргын хувьд ямар ялгаатай байгааг тайлбарлан, дүгнэлт гаргаарай.
9. Уншигчийг ятган итгүүлэх ямар ямар арга байж болох вэ? Доорх загварыг дэлгэрүүлэн ярилцаарай.

Ятган итгүүлэх арга
Эхлээд үсэг бичиг биш тоо гарчээ

Зохиогчийн үзэл бодол

Өмч хөрөнгөтэй болоод ирэхийн цагт юуны түрүүнд тоо бодох, тооцоо хөтлөх хэрэг гардаг байна. Түүнийгээ хэрхэн гүйцэтгэхийг санаашран бодож эхэлдэг нь гарцаагүй. Тэр хэрэгцээнээс үүдэж, тоо зохиохоос өөр аргагүй болсон ажээ.

Эшлэл зүүлт:

“Вэй шү” гэдэг эртний нанхиадын судар бичигт: “Жужаны цэргийн дарга нь хонины хорголоор цэргийн тоог бүдүүвчлэн тоолдог, хожим тэд мод сийлж, (кэмү) тэмдэглэл хийхийг сайн мэддэг болсон” гэж бичиж үлдээснийг эрдэмтэн Г.Сүхбаатар “Монголчуудын эртний өвөг” гэдэг бүтээлдээ (1980 он, 124 дүгээр тал) эш татан дурдсанаас өлгөн авбал юм юмны сэжүүр гарч ирнэ.

Баримт нотолгоо:

Хамгийн эртний бичиг соёлтой гэгдэж буй эртний Шумерийн* шаантаг бичгээр шавар хавтанцууд дармаллаж үлдээсэн, асар баялаг шавар номын сангийн нэлээдээр барахгүй дийлэнх хэсэг нь “нягтлан бодохын” ном байдаг нь аргагүй л тооцоогоор бүх юм үүссэний гэрч болж үлджээ.

Уншигчид нөлөөлөх уран дүрслэл, үг хэллэгийн сонголт

- Бичгийн ээж нь тоо гэвэл, үсгийн эцэг нь зангилаа
- Анхны бичиг үсэг нь тоо, сүүлчийнх нь мөн л тоо байх болно.
 - Тойрох аргагүй дайрч өнгөрсөн
 - Ерийн мөртөө яггүй асуудал
 - Нэлээдээр барахгүй дийлэнх хэсэг нь
 - Түүхийн баримтууд шивэгнэх ажээ.
 - “нягтлан бодохын ном”
 - Санаашран бодож эхэлдэг.

* Шумер - Одоогийн Иракийн өмнөд хэсэг буюу ойрх дорнодын бүс нутгаар оршин тогтнож байсан эртний соёл иргэншилт улс, үндэстний нэр.

ИЛТГЭЛ

Хүний хамгийн хэцүү нь ярих
Хүний хамгийн агуу нь ярих
Хүний хамгийн амар нь ярих

ЯРИХ, СОНСОХ

Илтгэлийн бүтэцтэй танилцъя

Дараах асуултын дагуу ярилцлага өрнүүлээрэй.

- Ярих чадварыг яагаад эзэмших ёстой вэ?
- Харилцан яриа, ганцаар ярианы ялгаа онцлог нь юу вэ?
- Германы философич Мартин Хайдеггэрийн “Ярих хэлэх гэдэг тэс ондоо зүйл. Эцэс төгсгөлгүй ярьдаг ч ганц ч зүйл хэлдэггүй хүн байдаг. Гэтэл чимээгүй суудаг мөртөө ихийг хэлдэг хүн байдаг” хэмээн хэлсэн эшлэлийг тайлбарлаарай.



Дасгал 78

Эхийг уншиж, даалгаврыг гүйцэтгэнэ үү.



Түрэгийн Культегэний гэрэлт хөшөөний бичигт:

*“Толгойтныг бөхийлгэж,
Тойгтныг сөхрүүлнэ.*

Шөнө үл унтаж, өдөр үл сууж, улсыг их болгоно. Тэнгэр ивээж, элзий хутаг соёрхсонд би, мөхөхөд хүргэсэн улсаа өргөн тэнхрүүлж, нөмгөн улсыг хувцастай, ядуу улсыг баян, өнчин улсыг өнөр болгож, энэ улсын эв үйлсийг засаж, хаан алдрыг бататгалаа” хэмээжээ

ТОДРУУЛГА

732 онд босгосон, 3,3 метр өндөр, 1,3 метр өргөн “Культегэний гэрэлт хөшөөний бичээс”. Уг хөшөөнд 68 мөрөнд 10 мянга орчим үсэг сийлэн, Культегэн жанжны намтар, тухайн үеийн дайн байлдааны тухай өгүүлжээ. Культегэн жанжин 685-731 оны хооронд амьдарч байжээ.

- Өгүүлэгчийн үзэл бодлыг тодорхойлно уу.
- Эхэд ямар ямар санаа агуулагдаж байна вэ?
- Өгүүлэгчийн сэтгэл хөдлөлийн өнгө аясыг тодруулна уу.

Илтгэх гэдэг бол ятгах урлаг юм

Ганцаар ярианы боловсронгуй дээд хэлбэр нь илтгэл юм.

Илтгэх урлаг гэдэг нь грек хэлний “реторик” хэмээх үгээс үүдэлтэй. Илтгэх урлагийг эзэмшинэ гэдэг нь хувь хүн үгээр урлах чадвар эзэмшинэ гэсэн үг.

- Ярих гэдэг мэдээлэх
- Ярих гэдэг бол сонсох
- Ярих гэдэг бол харилцах
- Ярих гэдэг хамтарч амьдрах
- Ярих гэдэг бол хэлний бус хэрэглүүрийг ашиглах
- Ярих гэдэг бол урлаг
- Ярих гэдэг бол хариуцлага
- Ярих гэдэг бол соёл

Утга санааг урдаар бод, тэгээд бич!
 Угаас хэлэх гэсэн юм чинь тодорхой бус бол
 Учир утгатай үг эрээд нэмэргүй ээ.
 Ухаан бодолд утга санаа ундраад ирвэл
 Уран яруу үг урсаад ирнэ ээ, танд.
Н.Бауло

Ц.Сүхбаатар “Монгол хэлний найруулга зүй” УБ, 2011 он



Дасгал 79

Ардын уран зохиолч Ш.Сүрэнжав “Соёлоо мэддэг хүн сэтгэлд буух цэцтэй өгүүлдэг” лекцийн задлал тайлбарыг анхааралтай уншаарай. Илтгэлийн бүтэц, агуулгын уялдаа холбоог ярилцана уу. Зохиогчоос дэвшүүлсэн чухал санааг тэмдэглээрэй.

1. Сэдэв сонголт:



Сэдэв гэдэг юу ярих тухай ойлголт мөн боловч маш нарийн зүйл. Хэн ч, хэзээ ч, ямар ч сэдвээр ярьж болох боловч дараах зүйлийг нарийн бодож тунгаах хэрэгтэй.

Тухайлбал:

- Нийтийн сонирхолд нийцсэн үндэслэлтэй байх
- Цаг үетэйгээ уялдах
- Шинэ ба шинэлэг санааг агуулах
- Ээдрээтэй, сонирхолтой асуудал дэвшүүлсэн байх зэрэг нь сэдэв сонгоход чухал юм.

“Монгол хүн, монгол гэр, монгол мал гурав байгалиасаа ургасан юм. Тэгэхлээр эх орон минь байгалиасаа ургажээ” гэж аварга малчин Шарав гэдэг хүн хэлсэн байдаг. Хөдөө, малын шар бууцан дээр төрсөн энэ хувь заяандаа би үнэхээр баярладаг. Харахад хотын хүн болчихсон ч гэлээ дотоод сэтгэл зүрхэнд минь Монгол байдаг.

Энэ бол илтгэлийн эхлэл хэсэг. Энэ цогцолборын тулгуур үгээс нь үндэслэн эхийн сэдвийг “Монгол” болохыг мэдэж болно. Цогцолборт буй “Монгол хүн, монгол гэр, монгол мал гурав байгалиасаа ургасан юм” гэсэн хэллэгийн санаа (... байгалиасаа ургасан) содон, урам сэргээн (сэтгэл зүрхэнд минь Монгол байдаг), итгэл төрүүлж байгаа зэрэг нь цааш юуны тухай, ямар шинэ сайхан юм сонсох бол гэсэн сэтгэгдэл төрүүлж байна.

2. Зорилгоо тодорхойлох:

Ямар ч сэдэв байсан үндсэн зорилго нь сонсогчдын сэтгэлийг сэргээх, шинэ зүйлийг мэдээлэх, урмыг сэргээх, итгүүлэн сэнхрүүлэх, уриалан дуудах, агуулга утга төгөлдөр байх ёстой. Мөн чанартаа ярианы үндсэн зорилго бол сонсогчдын хүлээн авах, асууж сонирхох, өөрөө хариулах тэмүүллийг бий болгодог.

...Монгол гэрт их онцлог бий. Сургалт хүмүүжил гээд хамаг бүхэн тэр орон зайд багтдаг. Ертөнцийн энэ тойрог азийнхан, тэр дундаа нүүдэлчин соёл иргэншилтэй Монголчуудад л байдаг. Нар, сар хоёр дугуй. Дэлхийн бөмбөрцөг өөрөө дугуй. Бөмбөрцөг дээр тогоо шиг хөмрөглөөд цэнхэртдэг тэнгэр дугуй. Үүнийгээ дуурайгаад бидний нүүр дугуй, нүд дугуй, хонго булчин бүх юм маань дугуй. ... Монгол гэрийн бууриар нутгаа тамгалаад явж байна. Энэ нь монгол ахуйн үндсэн тэмдэг гэмээр... Монгол гэрт амьдрах амьдрал бол тойрог.... Тойрог дугуй юм зөрчилгүй... Дугуй дотроо хүмүүжнэ, эх хэлээ сурна....

Монголын тухай яриа хэзээ ч үл хуучирна. Бид өөрийгөө хэр мэдэх билээ? Мэдэх нь бидний зорилго. Ф.М.Достоевский “Өөрийгөө өөртөө эрж бай! Өөрөө өөртөө захирагд! Өөрөө өөрийгөө эзэмш!” гэж бичсэн байдаг.

3. Сонсогчоо тодорхойлох:


Өөрийнхөө өмнө дэлхий дээрх хамгийн чухал хүмүүс сууж, яриаг минь сонсож байна гэж бодох хэрэгтэй.

Бид тэнгэр соёлтой, тэнгэр газрын нарийн шүтэлцээтэй ард түмэн. Онгодын цагт би тэнгэрийн харьяат, омогдуу бодлоор орчлонг тулж, оргилуун хүслээрээ одонд хүрч, увдист сэрлийн үзүүрийг атган, ухааныхаа үзүүрт зогсож байдаг... Ерийн малчин хүн яруу найрагч шиг тэнгэрийг шинжих ухаантан байдаг. Бидний багад эрт бос, үүрийн шар гэгээ харвал нас уртасдаг юм, тэнгэрийн хаяа хар, ямар өдөр болох нь вэ гэдэг сэн. Хөөрхий, дөнгөж ургаж байгаа юм, битгий тасал гэж алтан харганыг хүртэл хайрладаг сургаалаа манай өвгөд дандаа шүлгээр хэлсэн байдаг....

Монгол хүний хүмүүжил төлөвшил ямар байсан, ямар байхыг сануулан сургамжилсан, ухаарал шингээсэн энэхүү цогцолборын агуулга, хэлэх гэсэн санаанаас хэнд зориулсан байж болохыг мэдэж болно.

4. Байр сууриа илэрхийлэхдээ эшлэл, баримт цуглуулж, ашиглах

Сонсогчдын сониуч занг хөдөлгөх, амьдралд тохиолдсон бодит явдлаас эшилсэн, итгэл үнэмшил төрүүлэх жишээ баримтыг тохируулан сонгох




Урсгал

Манай ардын урлаг, сургаал бүхэн хүний сэтгэлийг ариусгах увдистай. Элдэв шуналаас чөлөөлөгдсөн цагт хүн ариусдаг. “Шуналаас биеэ чөлөөлсөн цагт амар амгаланг олно. Сэтгэл ханамжийн мэдрэмж бол аз жаргалын түлхүүр атгасантай адил” гэж XIV Далай лам хэлсэн. Энэтхэгийн Арьяандэв хэмээх холыг харсан хосгүй эрдэмтэн “Хүний биед 3-5 давхар бүрхүүл бий бөгөөд эндээс гэрэл цацарч байдаг. Муу санаатай хүнээс багир хардуу, үйлдвэрийн яндангийнх шиг утаа гардаг бол сайн санаатай хүнээс цагаавтар гэгээ цацардаг” гэжээ.... Бөхөө нойрсъё гэвэл хөнжилдөө цэвэр сэтгэл авч ор...

Урсгал

Эх оронтойгоо бид сэтгэлийн түмэн шижмээр холбоотой. Өр зүрх минь энд шархирахад өндөр Алтайн цас тэнд нурж байдаг гэж би нэг удаа бичсэн. Учир шалтгаан, логик холбоо гэдэг ийм нарийн. Эх нутагтаа газардсан нисгэгчээс асуухад, “Буянт-Ухаагийн салхи намрын гүүний айраг шиг байдаг” гэж хэлж байсныг санаж байна. Яруу найрагч хүн хэлмээр үг байгаа биз. Манай агаар усны зохицолдоо үнэхээр гайхамшигтай. Өөр газарт бол хавар эрт ургавч ямар ч үнэргүй. Нас ахих тусам энэ бүгдийг мэдрээд, ямар азаар Монголд төрөв өө гэж ухаардаг юм.

Илтгэл нь:



Эх орноосоо салсан хүн намар модноосоо тасраад унаж байгаа навч шиг, хөдөөний хүмүүсийн ярьдгаар үнсэнд хаягдсан шалз шиг болчихдог юм билээ. Аль эрт гадаадад гарчихсан Дамдинсүрэн гэдэг хүн амралтаараа ирчхээд “Манай энэ тэнэг эхнэр явахгүй гээд байна, үлдвэл үлдэг. Би буцаж явна. Гадаадад үнэхээр сайхан. Баячуудын нохойг 50 доллараар салхилуулна, тэр байтугай нохойдоо өгсөн юмнаас нь шомбодоод, илүүчлээд хэрэглээд байна” гэж билээ. Энэ бол ухаан нь мунхарсан нохойн амьдралтай хүний үг юм. Уул нь нүдэн дээр, цэцэг нь өлмий доор, тэнгэр нь толгой дээр цэнхэртэж байдаг ийм нутаг дэлхий дээр олон үлдсэнгүй.

Хэл сэтгэхүй хоёр нарийн холбоотой. Монгол хүний сэтгэлгээ ахуйгаасаа бүрддэг. Хэл бол ахуйн тусгал. Миний багад зүйр цэцэн үгс, түргэн хэллэг зөндөө байлаа. Тоглоомдоо хүртэл цэцэн үг хэлнэ. Мэнд мэдэхдээ ч цэцэн цэлмэг ярина. Одооны шиг “Юу байна даа? Юмгүй ээ” гэхчлэн дандаа уруудах, доройтох ёр үг хэлдэггүй байлаа.

“Жаварт тэнгэр салхилнам гэлээ

Жалгын ногоо сэргэнэм гэлээ

Жаргалтай суугаад зовлонтой гэвэл

Зовлон тэрнээс чинь ирдэг” гэж ноён хутагт Д.Равжаа хэлсэн.

Манай хэл цаглашгүй баян. Ц.Дамдинсүрэн гуайн хөрвүүлсэн зарим орчуулга уг эхээсээ ч сайхан болсон гэмээр байдаг. Хэлээ сайн мэдэхгүй хүн орчуулгыг сэтгэлд хүртэл буулгахгүй.... Хэнхдэг цээжинд байдаг их өв соёлоо авч үлдэж, монгол төрхөөрөө байсан цагт цэцтэй ярьж чадна.

“Цэцгийн толгой тасалдаггүй үртэй байхыг хүснэ, би

Цэцдийн толгой авдаггүй төртэй байхыг хүснэ, би” гэж Ц.Хулан хоёр л “толгой” хэлсэн. Монгол түүх соёлоо мэдэж байж л ингэж хэлнэ дээ.

“Эмнэг морийг ууланд алдахад

Эргүүлж барих уурга байдаг.

Эхнэр түүний минь сэтгэл хулжихад

Эргүүлж барих уурга байдаггүй” шүлэгт “уурга” хоёр гараад байгаа мөртөө ямар яруу бууж байна вэ?. “Яруу сэтгэлээр бичсэн зохиолыг яруу найраг гэнэ” гэж Цахар гэвш Ц.Лувсанцүлтэм хэлсэн.

Монгол хэл гэдэг ийм ариусалтай, яруусалтай юм. Залуус минь, монгол хэл сэтгэхүй, ёс заншил соёлоо мэддэг, мэндчилгээнээсээ эхлээд монгол хүн байгаасай.... Үндэсний өв соёлоо эзэмшсэн хүн даяарчлалын эрхшээлд орохгүй.

“Халуу дүүгсэн галд түлээ шаржигнан ноцох нь

Харваас модны үхэл, галын амьсгал аа

Хан хорвоод түүнчлэн бид дараах үеийн төлөө нөгчиж

Хаврын ногооны тулд намрын өвс гандана” гэж би бичсэн.

Дээрх эхийн

- “Монгол цэцэн билиг гэж сайхан юм байна”
- “Эх оронтойгоо бид сэтгэлийн түмэн шижмээр холбоотой”
- Манай хэл цаглашгүй баян” гэсэн 3 цогцолборын санааг тус бүрт сонирхолтой баримт жишээгээр баяжуулан дэлгэрүүлснийг харж болно. Цагийг нь олсон оновчтой хошин өнгө аяс, сэтгэлийн мэдрэмж ч бас чухал. **“Өөрийг чинь ойлгохгүй байж болохгүйгээр ярь”** (Квинтилон)

Нэрт уран илтгэгч Жорж Коуэн **“Салах ёс хийхдээ ямагт инээсэн хүмүүсийг ардаа үлдээж бай”** гэж зөвлөсөн байдаг.

Олон жилийн өмнө хөдөөний хүүхэд би уулан дээр гараад, холыг мөрөөддөг байлаа. Тэр мөрөөдөл маань намайг өдий хүртэл дагуулж ирсэн. Тэрүүхэн зууртаа сэтгээд байсан бол хонхортоо хонь хариулж, өдийд найр хэссэн, архинд дуртай өвгөн байхгүй юу. Тэмүүлэл мөрөөдөл ямагт урагш хөтөлдөг юм. Мөрөөд, тэмүүл, тэгж байж л чи урагшаа хөдөлнө. (Ш.С)

5. Төгсгөл бол хамгийн утга учиртай хэсэг юм.

“Дуусга, гэхдээ төгсөж байна гэдэг талаар битгий ярьж бай” гэсэн онол байдаг. Төгсгөлдөө:

- үйл ажилд уриалах
- сэтгэлээсээ найрсаг үг хэлэх
- инээлгэх
- шүлгийн мөр хэлэх
- эш татсан үг хэллэг оруулах гэх мэт аргыг ашигладаг.

Аргыг үнэн

- Бид ярих эрдмийг төгөлдөр эрдэм гэдэг.
- Бид үгийг тунгаан бясалгаж, шүтэн барилдлагатайгаар хэлдэг.
- Ярих эрдмийн гол мөр нь орой руу нь ортол хэлж сэнхрүүлэх
- Ярих эрдмийн сүнс нь үгэндээ нягт, утгандаа уужим байх

Аргыг үнэн

- Бид илтгэх урлагийг төгс урлаг гэдэг.
- Бид үгийг цэгнэн бодож, нягт уялдлагатайгаар хэлдэг.
- Илтгэх урлаг нь төрөл, зарчим, арга зүйтэй байдаг.
- Илтгэх урлагийн гол хөтөлбөр нь мянга мянган хүний зүрх сэтгэлийг эзэмдэх
- Илтгэх урлагийн уриа нь ятган ухуулж, итгүүлэн үнэмшүүлэх

Ярих урлагийн онолд “оргил үе бол хэлэх үгээ төгсгөх алдартай арга” гэж үздэг.



Дараах хэлц хэллэгийг уншаад, юуны тухай өгүүлсэн, яагаад хоёр хэсэгт ангилсныг ярилцаж, дүгнэлт гаргая.

- “Үг бол хүмүүсийг залж жолоодох урлаг мөн” *М.Платон*
- “Уран үг ямар ч зэвсгээс үнэтэй”
Египет
- “Хүнийг өөртөө татдаг гол шинж бол сайхан ярьдаг чадвар” *Энэтхэг*
- “Үнэн үг уран гоё байдаггүй” *Хятад*
- “Үгийг бусдад хэлэхийн урд өөртөө хэлж бай” *А.Сэнек*
- “Үг бүхэн үнэн байх ёстой, үнэн өөрөө уран ярууг илэрхийлдэг” *Европ*

- “Найрагч байх нь заяаных, илтгэгч болох нь зүтгэлийнх” *Ром*
- “Эхлээд мэндэлж сур, дараа нь ярьж дад, эцэст нь илтгэж чад”
Монгол
- “Мэдлэг ухаан хоёр дээр суурилсан хөдөлмөр бол илтгэх урлаг мөн” *Ром*
- “Ярианы урлаг бол хамгийн гайхамшигтай, хамгийн гайгамшигтай хоёрыг нэгэн зэрэг агуулдаг” *А.Гор*

Илтгэлийн шаардлага

Илтгэл ярианы чанар, үр өгөөж нь хэлний ба хэлний бус найруулгын шаардлагад хэр нийцсэн байхаас шалтгаална. Тиймээс ярианы соёлын үндсэн чанаруудыг эзэмшсэн байх хэрэгтэй.

1. **Зөв байх:** Зөв дуудах болон хэл зүйн хэм хэмжээг баримтлах
2. **Оновчтой байх:** Илтгэлийн сэдэв, зорилго, агуулга, дэвшүүлсэн асуудал нь гол санаатай тохирч байх
3. **Учир шалтгааны хувьд зөв байх:** Ярих зүйлийн бүтэц, дэс дараалал зөв, учир шалтгааны уялдаа холбоо цэгцтэй байх
4. **Цэвэр ариун байх:** Үг хэллэгийн сонголт зөв, найруулга нь энгийн байх
5. **Яруу сонсголонтой байх:** Ярих зүйлийн үнэлэмж, өнгө аяс, хандлага зэрэг зөв байх
6. **Зохистой, тодорхой, ойлгомжтой байх:** Ярьж буй зүйл сонсогчдын сэтгэлд нийцсэн, ойлгоход хялбар, энгүүн байх
7. **Баялаг, төгөлдөр байх:** Эх хэлнийхээ үгийн сангаас төгс чадварлаг эзэмшсэн байх (дүрслэл бий болгогч хэллэг, бүхэл бүтэн зураглал бүтээх үгээр яриагаа баяжуулах)

- Та нар 128-134-р хуудсыг уншлаа. Эндээс юуны тухай уншиж, юу ойлгож мэдсэнээ дүгнэж ярина уу.

Эртний Грекийн сэтгэгч М.Т.Цицерон “... Илтгэх урлаг гэдэг нь:

1. Шинийг санаачлах
2. Дур сонирхолтой байх
3. Урнаар илтгэх
4. Цээжлэн тогтоох
5. Зөв дуудах зэрэг 5 ухааныг агуулж байдаг агуу урлаг юм” гэжээ.

Илтгэл гэдэг нь аливаа нэг сэдвийн хүрээнд судалж буй асуудлын мөн чанарыг өөрийн үзэл бодлын үүднээс үндэслэл нотолгоотой, тодорхой зорилго, алхам дараалалтай илэрхийлсэн, ихэвчлэн нийтлэлийн болон эрдэм шинжилгээний найруулгаар илэрдэг, аман ба бичгийн хэлбэртэй, харьцангуй бүрэн төгс эргэцүүлсэн эх юм.

Илтгэлд:

- Тодорхой жишээ, тоо баримтаар нотлон өгүүлэхийн зэрэгцээ, төгсгөлд нь дүгнэлт хийдэг.
- Сонсогчидтой харилцахад ярианы найруулгын хэрэглүүрийг хязгаартай, зохистой ашиглаж болно.
- Мэдээ, баримт, эшлэлийг үндэс болгоно.



Дасгал 81

а. Эхийг уншаад, асуултад хариулаарай.

Этгээд хэл

“... ийм болов” хэмээсний үндэслэл юу вэ?

*Үг нь монгол, өгүүлбэр нь орос
Үзэхэд этгээд сонин хэл
Өв соёлоо үл тоомсорлон
Өнөөгийн байдал ийм болов.*

Өгүүлэгчийн үзэл бодол, хандлагыг юу гэж ойлгож болох вэ?

*Зуун түмэн үгтэй хэлд
Зуд туссаныг үнэмшихүйеэ бэрх
Харийн үгээр далайлгагчдыг
Хамгийн боловсорсон гэхэд үнэхээр бэрх
Гадаадын үгээр гайхуулагчдыг
Гарамгай эрдэмтэн гэхэд бас бэрх.*

“хар дарсан”-ы шалтгаан, уран дүрслэлийн аргыг тайлбарлаарай.

*Хэвлэл сонин уншсан үдэшдээ
Хэлний шинжлэлтний нойр хулжаад
Хэвтэвч сэтгэлд эвгүй үг
Хэнхдэг дээр чулуу дарах мэт
Харь үгийн бүлхэнд хахаж
Харанхуй шөнө хар дарах мэт*

Б.Ринчен

б. Үндэслэлийг баримт нотолгоогоор дэлгэрүүлэн, өөрийн үзэл бодлоо илэрхийлсэн, ятган сэнхрүүлсэн, эх хэлээ хайрлахыг уриалсан өнгө аястай эх зохион бичээрэй.

- Бэлтгэлийн явцад ярих зүйлийнхээ сэдэвтэй холбоотой олон баримт цуглуулж, түүнээсээ хамгийн чухал, амьд үнэмшилтэй мэдээллийг сонгон, боловсруулах нь илтгэгчийн ур чадвартай холбоотой.
- Ярих урлагийг эзэмшихэд зөвхөн өндөр мэдлэг, үгийн баялаг хангалттай биш, үгийг зөв дуудаж түүнийг чадамгай хэрэглэдэг байх ёстой.

Эртний сургаалд ариун ёсыг:

1. Багшийн хэл ариун
2. Шавийн сэтгэл ариун
3. Номын мөр ариун хэмээсэн бол

гэмийг:

1. Номын суудалд суувч чихээр үл сонсох
2. Чихээр сонсовч буруу тогтоох
3. Зөв тогтоовч утгыг үл ухаарах гэжээ.



Дасгал 82

Дараах эхийг 2-3 удаа чанга дуугаар дуудан уншихдаа:

- Үг хэллэгийг алдаагүй зөв хэлэх.
- Амьсгалаа зөв хуваарилан түгдрэлгүй дуудах.
- Хэмнэл, нугалааг зөв тохируулах.
- Сургамжит санааг бүлэглэх.

“Эрдмийг олонтоо сонсовч, номлохуйд эс мэргэжвээс
 Эмээр хоосрон гуцуудсан мэргэн сайн эмч мэт
 Эгнэгт тэмцэхүйд мэргэн ч туурвих ёсыг эс мэдвээс
 Элдэв зуун хэлтэн болж өгүүлэвч, хэлгий балай мэт

Зохион туурвихуйд сайн боловч бичгийн дадал муу аваас
 Зориг хүчит их баатар боловч гар мухар мэт
 Бичиг зохиохуйд үг үсгийг ёсоор эс найруулбаас
 Билгүүн сайн эрдэмтэн авч сонжуурлагдахын гэмт

Үг үсэг алдаагүй ч яруу хэллэг төгөлдөр бус аваас

Үзэсгэлэнт эхнэр чармай нүцгэн гүйсэн мэт

Илт өгүүлэхүй хуучин дохио үгээр эс чимбээс

Эгнэгт бүдүүлэг хар үг холилдох тул мэргэд орхивоос зохист” Агваандандар



“ҮЗЭЛ БОДОЛ” - төлөвшиж тогтсон санаа.

“Үзэл” - ямар нэг юмны талаар хатуу баримталсан санал бодол

“Бодол” - хүний оюун санааны илэрхийлэл

(“Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг” Монсудар Уб., 2009)

Илтгэлийн бүтцийг задлан тайлбарлая



Үзэл бодлоо илэрхийлсэн эхийг уншаад, даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Өршөөлт ноёд, энэрэлт хатагтай нар аа!

Арван нэгдүгээр сарын есны өдөр, алс буйдхан жижигхэн хотод амьдран суугаа надад Шведийн Академийн шийдвэрийн тухай утсаар мэдэгдсэн юм. Хэр баргийн юманд сэтгэл минь хөдөлдөггүй миний хувьд чин үнэнийг хэлэхэд энэхүү мэдээ нь амьдралд минь тохиолдсон хамгийн хүчтэй сэтгэгдэл байлаа. Утга зохиолын эл шагнал нь зохиолчийн хөдөлмөрийг үнэлсэн эрхэм дээд соёрхол ... билээ. Алдар нэр гэдгийг ихэнх хүмүүс, олон зохиолч хүсдэг нь үнэн. Түүний нэгэн адилаар уул соёрхлыг нэр хүндтэй, шударга шагнал хэмээн сэтгэл дүүрэн гардан авахад миний бие бэлэн байна.

Гэвч арван нэгдүгээр сарын есны өдөр би зөвхөн амин хувийнхаа л тухай бодож байв уу? Үгүй ээ. Энэ бол дэндүү амиа бодсон хэрэг төдийгүй анхны баярын цахилгаан утас аваад л сэтгэл шаналж гүйцэв. Шведийн Академийн шийдвэр, түүний учир утгын тухай анир чимээгүйд шөнийн турш ганцаархнаа бодов. Нобелийн шагнал эрхлэх хороо нь уул соёрхлыг эх орноосоо хөөгдсөн хүнд олгохоор шийджээ. Ингэхэд би хэн сэн билээ? Эх орноосоо хөөгдсөн, Францад толгой хоргодож байгаа миний хувьд энэ их ач тусыг мартаж ёсгүй.

Шведийн Академийн гишүүд ноёд оо, намайг болон зохиол бүтээлүүдийг минь үл хэрэгсэхийг хүсээд, та нарт дахин баярласнаа илэрхийлмээр байна. Хорвоо ертөнцөд хэнээс, юунаас ч хамааралгүй, халдашгүй дархан зүйл гэж байдаг. Тийм ч учраас энд олон янзын үзэл бодол, шашин, гүн ухааны төлөөлөгчид цугларсан нь дамжиггүй. Бодож сэтгэх, шүтэж бишрэх эрх чөлөө л биднийг итгэлтэйгээр нэгтгэн нийлүүлдэг. Зохиолч хүн бүрийн хувьд энэхүү эрх чөлөө ус агаар мэт хэрэгтэй бөгөөд тэр нь тогтсон номлол, нотолгоогүй үнэн мэт байх ёстой.

Академийн гишүүд ноёд оо, танай академийн энэхүү шийдвэр нь эрх чөлөөг дээдлэн эрхэмлэх нь Швед үндэстний жинхэнэ бахархал гэдгийг нотолж байна. Миний бие, танай эх орон, ард түмэн, утга зохиолыг тань өндрөөр үнэлж ирснээ үгийнхээ төгсгөлд тэмдэглэе.... Энэ улсын Цог Жавхлант Вантанд, чин зоригт ард түмэнд Шведийн Академийн соёрхлыг хүртсэн эх орон өөр ч, эрх чөлөөт зохиолч миний бие зүрх сэтгэлээсээ гүн хүндэтгэлтэйгээр ёслон мэхийж буйг минь болгоон соёрхоно уу. ... *Иван Бунин*

- а. Эхээс өгүүлэгчийн үзэл бодлыг тодруулна уу.
- б. Сонсогчдын анхаарлыг татах өгүүлбэрээс онцолно уу? Яагаад
- в. Төгсгөл хэсгийн “академийн энэхүү шийдвэр нь эрх чөлөөг дээдлэн эрхэмлэх нь Швед үндэстний жинхэнэ бахархал гэдгийг нотолж байна”, “Шведийн Академийн соёрхлыг хүртсэн эх орон өөр ч, эрх чөлөөт зохиолч миний бие...” зэрэг эшлэл ямар сэтгэгдэл төрүүлж байна вэ?
- г. **“Амьд байвал үхсэн ч яахав?”** эшлэл үгийг эхийн агуулгатай холбон тайлбарла.
- д. “Би Монгол хүний саруул ухаанд итгэдэг” (С.Зориг) гэсэн сэдвээр итгэл үнэмшил, урам зоригийг сэрээсэн бадрангүй өнгө аястай эх зохион бичээрэй.



Үндэслэл нотолгоотой ятгасан эхийг уншаад, задлан шинжлээрэй.

Г.Мэнд-Ооёогийн бүтээл “Гэгээнтэн” баримтат романы тухай

Соёлын гавьяат зүтгэлтэн, зохиолч яруу найрагч Г.Мэнд-Ооёо “Гэгээнтэн” романаа олны хүртээл болгоод даруй нэг жил болжээ. Энэ зохиолыг олон жил бодож төлөвлөж байж бичсэн ажгуу. Би тэр жил төрийн шагналт зохиолч Л.Түдэвийн “Оройгүй сүм”, С.Эрдэнийн “Занабазар” романыг уншиж, сэтгэлийн цэнгэл эдэлж байснаа санаж байна. Монгол улсын утга соёлын их мастеруудын нэгэн болсон Г.Мэнд-Ооёогийн “Гэгээнтэн” романы зохиомж өөрөө нийгмийн захиалгатай, жамаараа цаг нь ирж төрсөн түүхэн баримтат бүтээл гэж ойлгож байна. Түүний энэ бүтээл ийнхүү хүний сэтгэл татагдтал бичигдсэнд гайхах юм алга. Би амьдралынхаа турш бас ч үгүй нэлээд олон сонгодог ном уншсан. Гэвч энэ мэт цагаа олсон шинэ бүтээлийг уншиж танилцах үед өнө эртний сайн нөхөртэй уулзсан мэт, амьдрал дунд байдаг олон асуултын хариуг нэгэн зэрэг авах мэт болж байв.

Миний хувьд, хүүхэд ахуй цагаасаа эхлэн Г.Мэнд-Ооёогийн бүтээлүүдийг амтархан уншиж ирсэн.

Говийн догшин хутагт Данзанравжаагийн тухай энэ гайхамшигт роман хүмүүсийн оюуны эрэлт хэрэгцээг хангасан дорвитой бүтээл болжээ. Буддизм, соёл шинжлэх ухааны хувьд ихээхэн дэвшлийг харуулсан зохиол аж. Хутагт хүний амьдралыг баримт түшиж ийнхүү чадварлаг туурвисан зохиол тийм ч олон биш байх аа. Энэ хүний зохиол бүтээл туурвидаг тэр агуу их номын өргөөнд олон жил орж гарч явсан. Тэр увдист номын агаарт ариусаж явснаа их хувь завшаан хэмээн ойлгодог. Өмнө нь “Алтан-Овоо” хэмээх нутаг усны магтуу болсон алдартай зохиолыг нь олон удаа уншсан.

“Гэгээнтэн” зохиолыг дахин дахин уншаад баймаар санагдах аж. Равжаа хутагтын тэр их олон шад мөр шүлгийг нэгэн номоос энгийн аргаар утга төгс мэдэрч авах боломжийг олгосонд уншигч би бээр ихэд таатай хүлээн авсан. Энэ сайхан номын авшиг болсон “соронзон орон”-ы таталцлаас гармааргүй санагдаж, ахин дахин уншмаар байлаа. Намайг хүүхэд ахуй үеэс номын амтанд хөтөлсөн энэ эрхэм хүний дэргэд байхад ярих үгээ товчлох, бага ярьж ихийг сонсож мэдэх, аливаад бие сэтгэлээ бэлэн байлгах ийм л хүмүүжлийг олж авч билээ.

Ингээд агуу хутагтын нэгэн насны амьдралыг нүдэнд харагдтал, амьдарч байсан үеийг уран сайхнаар, баримтад түшиж гаргасан тухайн үед амьдарч яваа мэт номын ариун агаарт хөвж байв. Ийнхүү эгэл бус хутагт хүний амьдралыг ингэж харуулах тийм амар гэж үү?

Энэхүү роман олон хүний ширээний ном болсон нь дамжиггүй. Хэдэн ч удаа уншсан уйдахааргүй, аливаа эрэл хайгуулч хүн өөрөө өөртөө нээлт хийхэд зүг чиг болмоор уран сайхны баримтат зохиол болжээ. Энэ бүтээлд олон эрдэмтэн, зохиолч, уншигчид өөрийн санал, дүгнэлтийг өгөх нь дамжиггүй. Эхнээсээ түүний цахим хуудсанд санал сэтгэгдэл, номын тухай бичээд эхэлчихжээ. Баярлалаа танд, уран бүтээлийн эрэлч хайгуулч мэдрэмж тань улам төгс гэгээрлийг олох болтугай.

Б.Эрдэнэбаяр

а. Жишээ олж бичнэ үү.

Үндэслэл шалтгаан	Баримт нотолгоо	Зохиогчийн хандлага	Зохиогчийн сэтгэл хөдлөл	Зохиогчийн үзэл бодол
.....
.....

б. 4-5 дахь догол мөрийг дахин уншаад, өгүүлэгчийн үг хэллэгийг ялган тэмдэглэж, өнгө аясыг нь тодруулаарай.

в. Дээрх эхийг дахин уншаад, уран зохиолын хичээлээр үзэж судалсан, өөрт таалагдсан уран бүтээлийн талаар үзэл бодол, сэтгэгдлээ илэрхийлсэн эх бэлтгэж, ярина уу.



Дасгал 85

Үзэл бодлоо өвөрмөцөөр илэрхийлсэн зургийг сайтар ажиглаад, асуултын дагуу хэлэлцүүлэг өрнүүлээрэй.



Пикассогийн 1937 онд зурсан аварга том “Герника” хэмээх зураг нь ... 6000 хүн амтай байсан Герника хотын түүхийг хүүрнэжээ.

- а. Зурагт юу дүрслэгдсэнийг тоочин бич, юуг төсөөлж байна вэ?
- б. Зургийн сэдвийг тодорхойлно уу. Хариултаа зургийн үйл явдлаар нотлон тайлбарлаарай.

а Байгалийн гамшиг

б Дайн

в Амьдрал

в. Зургийн үйл явдлыг хар цагаан гэсэн 2 өнгөөр илэрхийлжээ. Яагаад?

г. Зураач үзэл бодлоо илэрхийлсэн арга нь юу вэ?

д. Энэ зурагтай холбоотой нэгэн гайхалтай баримтыг дурдвал: 1940 онд

Пикассог Парист дуудан ирүүлж, “Та үүнийг зурсан уу?” гэж асуужээ.

Харин хариуд нь Пикассо: “Үгүй, та нар үүнийг хийсэн” гэж хэлсэн байдаг.

Эндээс ямар дүгнэлт хийж болох вэ?

- 1937, 1940 онууд нь түүхийн ямар цаг үе байсныг санаарай.

Дасгал 86

а. Мэдрэмж, сэтгэгдэл, үзэл бодлоо баримт нотолгоотой илэрхийлсэн эхийг уншаарай.

**Бие сэтгэл төөрөм
 биегүй манан дунд
 буга эврээ гээнэм.** *Д.Нямдорж*

Мэдэж мэдэршгүйг мэдрэх ... Д.Нямдоржийн гурван мөрт шүлгүүдийг уншсаны эцэст яруу найргийг ингэж тодорхойлмоор санагдав. Тэгэхлээр энэ нь хязгаарлашгүйн агшныг илтгэнэ. Энэ агшнаас хүн болгон өөрийн зөн мэдрэмжийн хэрээр утган уудалж болно. Эсвэл юу ч олж харахгүй ч байж болно. Газрын нүдэн булаг шавхагддаггүй атлаа дундардаггүй шиг.

*Бие сэтгэл төөрөм
 биегүй манан дунд
 буга эврээ гээнэм.*

Юу ч гэсэн, хамгийн гадна талаас нь ажихад дундаа цэг, таслал, том үсэггүй нэг л өгүүлбэр. Зохиогч өөрөө ч иймэрхүү маягаар өрж байршуулж.

Уг нь бяцхан байгалийн зураглал юм уу гэж бодмоор. Яруу сайхныг яриад яах вэ, ярих ч боломжгүй. Түүний тулд энэ мөрүүдийг олсон эгшин рүү хэд дахин орж гарах хэрэгтэй?!

Хаа нэгтээ их хөвчийн манан дунд бугын эвэр гуужиж. Гэтэл тэр манан нь “бие сэтгэл төөрөм” юм. Энэ чинь арай бидний амьдрал биш биз дээ. Бидний амьдрал “биегүй манан” мөн үү?! Зарим талаараа мөн шүү дээ. Бид яах гэж энэ хорвоод ирж, эргэцсэн юм? Юуны төлөө амьд яваа юм? Хэнийхээ төлөө амьдрах юм? Хэзээ, хаашаа явж байгаа юм? Яах гэж, юугаа булаалдан цуугилдсан юм? Тэгээд хаа хүрэх юм, юунд тулах юм? Яг дээр хэлсэн “бие сэтгэл төөрөм биегүй манан” шиг. Энэ “биегүй манан” дунд юун түрүүн сэтгэл минь төөрдөг өө. Сэтгэл төөрөхлөөр бие дагаад л төөрнө шүү дээ. Нэмээд хэлэхэд, тэр хоёроо дагаад хэл минь төөрч, сүүлдээ бүр ээрч муурч гүйцнэ. Үгээ ч олоод хэлчхэж чадахаа болино. ... Тэгээд энэ дүлий манан дундаас гардаг аргагүй, юм юмаа л гээнэ дээ. Буга ч яах вэ, эврээ гээчхэж. Энэ бол байгалийн жам. Бугын эвэр тугалмайлна. ... дахиад л гуужна... дахиад л... Харин бид юугаа гэсэн бэ? ... *С.Дулам*

б. Дараах жишээг ялган тэмдэглээрэй.

- Бодит байдал - үндэслэл
- Сэдэв - агуулга
- Дэвшүүлсэн асуудал
- Баримт, нотолгоо
- Шийдэл – гол санаа
- Зохиогчийн үзэл бодол

в. “Харин бид юугаа гэсэн бэ?” гэсэн асуултад баталсан буюу үгүйсгэсэн нотолгоо бүхий тайлбар, дүгнэлт хийж, мэтгэлцээн зохиогоорой.

.....

.....

.....

.....

.....

.....



а. Дараах эшлэлүүдэд юуны тухай өгүүлснийг ажиглаарай.

Хүмүүжил хүнийг бүтээдэг

- Хүн болох багаасаа
Хүлэг болох унаганаасаа *Зүйр үг*
- “Хүн төрдөг юм биш ээ. Буй болдог юм” *Мэргэн үг*
- “Хүний хүмүүжил түүний төрсөн цагаас эхэлдэг. Нялх хүүхэд хэдийгээр ярихгүй, сонсохгүй байдаг ч аль хэдийнээ суралцаж эхэлдэг” *Ж.Ж.Руссо*
- “Хүүхдийн шулганах дуунаас илүү ялгуугсан сүлд дуулал гэж ертөнцөд үгүй” *В.Хюго*
- “Хүмүүжил бол агуу их үйл хэрэг. Түүгээр хүний хувь тавилан шийдэгддэг”.
В.Г.Белинский
- “Хүмүүжил хүнийг өөрийг нь бүтээдэг” *А.Сент-Экзюпери*
- “Хүнийг харахад хөлөөрөө явж буй мэт боловч ухаанаараа явдаг юм шүү дээ”
Хөдөлмөрийн баатар Ц.Намхайнямбуу
- “Журам ёсоор хэрэглэвэл чулуу ч эрдэнэ,
Журам дэглэм алдагдвал үр ч дайсан” *Н.Ишданзанваанжил*
- “Зан суртахуун засрахаасаа эвдрэх нь амархан” *Вовенарг*
- “Сайхан мэдрэмж бүхий хүмүүжилгүйгээр өв тэгш хүнийг өсгөн бойжуулж болохгүй” *Р. Тагор*
- “Хэнээс төрсөн нь бус, хэнтэй нийлдэг нь чухал” *М.Сервантес*
- “Нэг эцэг зуун багшаас илүү” *Жорж Херберт*
- “Хүмүүс бол сайн арчилж тордохгүй бол ургадаггүй ургамал” *Ш.Монтескьё*
- “Хүмүүсийг өөрчлөхийн тулд тэднийг хайрлах хэрэгтэй” *И. Песталоцци*
- “Хүн бүр сүүлчийнхээ өдрийг хүртэл өөрийгөө хүмүүжүүлж байх ёстой”
М.Адзельо
- “Өөдгүй муу хүмүүсээс хүнийг найдвартай хамгаалдаг зүйл бол зөв хүмүүжил” *Ф.Честерфильд*
- “Бүх бүтээлээс хамгийн гайхамшигтай сайхан нь сайхан хүмүүжил олсон хүн байдаг” *Эпиктет*

б. Дээрх эшлэлүүдийг агуулгаар нь эхлэл, гол, төгсгөл гэсэн хэсэгт ангилан бүлэглээрэй.

в. Асуудал дэвшүүлсэн ярианы эх бэлтгэж, илтгэх дадлага хийгээрэй.



1. Хэнд зориулах вэ?
2. Ямар зорилготой вэ?
3. Хандлагаа хэрхэн илэрхийлэх вэ?
4. Анхаарлыг нь яаж татах вэ?
5. Итгэл үнэмшлийг бий болгох арга юу вэ?

Илтгэл бичье



Дасгал 88

“Эх хэл” сэдвийн хүрээнд эшлэл ашиглан илтгэл бичье. Сурах бичгийнхээ 74-86 дугаар талд байгаа хэрэглэгдэхүүнийг ашиглаарай.

... Бороотой үдшээр тулганд ноцсон түлээний чимээ эх хэл минь
Ороо салхинд тачигнасан тугны чимээ эх хэл минь
Оддын туяатай, галын амьсгалтай эх хэл минь ... О.Дашбалбар

Алхам 1: Ямар асуудал дэвшүүлж болох вэ?

Монголчууд бид мянга, мянган жилээр аж төрөн сууж, өвөг дээдсээ онголсон ашдын заяаны нутагтай, аялгуу сайхан хэлтэй, түүндээ зохицсон үндэсний бичиг соёлтой ард түмэн билээ.

- а. Цогцолборын онцолсон санаа нь юу байна вэ?
- б. “Хэл, хил, мал гуравтайгаа байхад хэн баян Монгол баян” гэсэн З.Дорж найрагчийн үгийг чи юу гэж ойлгож байна вэ?
- в. Яагаад эх хэлний талаар ярьж, 2018 оны 6-р сард Монгол улсын хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс бүх нийтээр даган мөрдөх “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь”-ийг гаргав? Саналаа солилцоорой.
- Даалгаварт: “Эх хэлний өнөөгийн байдал” агуулгын хүрээнд мэдээлэл цуглуулж ирээрэй. Бид эх хэлээ хэр сайн мэддэг вэ? гэсэн асуултыг өөрөөсөө асуугаад, тунгааж бодоорой.

Алхам 2: Үндэслэлийг ямар баримтад тулгуурлан батлах вэ?

1. “Түүх соёлоосоо тасарсан ард түмэн амархан мөхдөг”
Л.Н.Гумилёв
2. Эх хэл эвдрэхийн дэргэд эдийн засаг хямрах зэрэг бол юу ч биш.
3. “Орших уу, эс орших уу”
Гамлет

- а. Эшлэлийн санааг дэлгэрүүлэн, баримт дэлгэн ярилцаарай.
- б. Дэлхийд хэдэн орны биеэ даасан хэчнээн хэл байдгийг сурвалжлан мэдэж ирээрэй.
- в. Хэл яагаад мөхдөг юм бол.? Хэдэн хэл мөхөж устаж байгааг мэдэж аваарай.



- “Санаагаа зөв илэрхийлсэн хийгээд хаана, яаж байрлуулах эсэх тухай огт бодолгүй ноороглох;
- Хоёр дахь удаагаа хуулан бичихдээ илүү зүйлийг хасаж, санаануудаа байх ёстой газрыг нь олж байрлуулах;
- Гурав дахь удаагаа хуулан бичихдээ санаагаа зөв илэрхийлсэн эсэх дээр ажиллах” *Л.Н.Толстой*

Хэрэглэгдэхүүнээс үр жимсийг нь олох нь маш чухал шүү!

Алхам 3: Үзэл бодлоо хэрхэн илэрхийлэх вэ?

1. Монгол хэл бол хүн төрөлхтний оюуны соёлын нэг хэсгийг тээж ирсэн эртний том хэл.
2. Эх хэлээ цэвэр ариун байлгах, баяжуулах нь хэлний экологийн гол асуудал бөгөөд эх хэлээ харь хэлний зохисгүй нөлөөнөөс хэрхэн хамгаалах вэ гэдэг өнөөгийн тулгамдсан асуудал.
3. “Харь хэлнээс орчуулахдаа үйл үг өргөн хэрэглэж байгаарай. Үйл үг чинь монгол хэлийг аялгуу сайхан байлгахыг хөглөж өгдөг юм...” *Б.Ринчен*

- а. “Монгол үг, хэл бол монгол хүний биеэс... амьд биеэс ундран гарч буй татаж бас түлхэж байдаг эрчим хүч ажээ” (*Ц.Сүхбаатар*) хэмээх өгүүлбэрийн үг бүрийн утгыг тайлаарай.
- б. Хүмүүс хэлээ хэрхэн “эвдэж” байна вэ? Жишээ гарган ярилцаарай.

Даалгаварт:

- Гэртээ харих замдаа дэлгүүр, албан газар, хаяг, зар сурталчилгааны самбар зэргийг ажиглаад, хэдэн үгнээс хэд нь гадаад үг байгааг тооцон нягтлаарай.
 - Аль нэг цайны болон зоогийн газар ороод, хоолны цэсийг ч харж болно.
- в. “Хэл бол үхсэн хүний үлдээсэн өв” хэлц ямар утгатай вэ?

Алхам 4: Ямар шийдэлд хүрэх вэ?

1. Нэгэн харь үсэг танивал даруй монгол бичгээ басамжлан “үгээр санаа бүртгэн гаргаж яахан чадна” хэмээн шүүмжлэх нь далайн усанд биеэ угаагаад, далайн усыг гүехэн гэж хэлэх лүгээ адил. *В.Инжаннаши*
2. “Үг сонгож зөв найруулах нь нарийн өрлөг шаарддаг чимхлүүр ажил юм” *Ч.Онгоодой*
3. “Эх хэлнийхээ үг, эх орныхоо чулуу бүрийг хамгаалах цаг болсон” *Ш.Чоймаа*
4. Монгол монголоороо байхад монгол хэл л аварна.

- а. Дээрх хэлцүүдийн ерөнхий санааг нэгтгэн тодорхойлоорой.
- б. Аль нэг өгүүлбэрийг нь сонгон, утгыг дэлгэрүүлэн яриарай.
- в. Илтгэл бичихэд бэлтгэж, ярилцсан зүйлээ дүгнэн “Эх хэл минь” гэсэн эх зохиогоорой.

Ашиглаж болох баримт, эшлэл.....

- Өдгөө манай дэлхийн хүн ам 6000 орчим хэлээр харилцаж байна гэдэг.
- Зарим хэл ядууран устаж үгүй болох аюул нүүрлэж байдаг. Ийм аюул тулгараад байгаа 1300 гаруй хэл байдаг тухай мэдээ бий.
- Монгол улсын Их хурлаас 2003 оны 05-р сарын 15-ны өдөр “Төрийн албан ёсны хэлний тухай хууль” баталсан.
- Гадаад үг нэвтэрч үгийн санг баяжуулах нь аль ч хэлэнд байдаг үзэгдэл боловч тодорхой хэм хэмжээтэй байх ёстой. Аливаа хэлний үгийн сангийн 7-8 хувь нь гадаад үг байвал хэвийн гэж үздэг ажээ. Гэтэл
- Судалгаагаар аж ахуйн нэгж байгууллагын нэрийн 60-70 хувь нь гадаад үгээр бичигдсэн байна.
- Төрийн албан ёсны хэлний тухай хууль-ийн 5.18-д “төрийн албан хэлэнд дүйх үг нэр томьёо байхад гадаад үг хэрэглэхийг хориглоно” гэжээ.



Дасгал 89

Асуудал дэвшүүлж, үзэл бодлоо илэрхийлсэн эх бичээрэй.

- “Хүүхдийн тоглоомоор улс орны ирээдүйг шинждэг” гэсэн гарчгийн санаанаас үүтгэж, өнөөгийн хүүхдүүдийн тоглоомны талаар ярианы эх бэлтгэнэ үү.
- Сэдэвтэй холбоотой эх сурвалжийг олж уншаад, мэдээлэл цуглуул.
- Эх бэлтгэхдээ “бүгдийг нь бус чухлыг нь” гэсэн санааг баримтал.
- Дараах төлөвлөгөөг ашиглаж, санаа аваарай.

ЭХЛЭЛ ХЭСЭГ

“Хүнийг таних гэвэл нөхрийг нь хар, хүүхдийг таних гэвэл тоглоомыг нь үз” гэсэн мэргэн үг бий” гэсэн эшлэлийг хөтөч өгүүлбэр болгож, санаагаа дэлгэрүүл.

ҮНДСЭН ХЭСЭГ

- Тоглоом гэж юу вэ? (асуудал)
- Тоглоомын хэрэглээ ба хэрэгцээ
- “Хүүхдийн тоглоомд асар гүн гүнзгий утга бий” гэсэн Ф.Шиллерийн үгийг батлах баримт
- Чиний дүү яг одоо ямар тоглоомоор тоглож байна вэ?
- Өнөөгийн хүүхдүүдийн тоглож буй түгээмэл тоглоом, тэдгээрийн эерэг ба сөрөг тал, чанар, өгөөжийг баримтаар нотол.

ТӨГСГӨЛ ХЭСЭГ

- Улс орны ирээдүйг хүүхдээр нь Хүүхдийн ирээдүйг тоглоомоор нь шинждэг.
- Ач холбогдол, анхаарах зүйл
- Тоглонгоо хөгжицгөөе.
- Өөрийн хандлага, үзэл бодлоо дүгнэ.



А. М.Горький хүү Максимдаа Капри арлаас: “Эх хэлээ төрүүлсэн эх шигээ л хайрлах хэрэгтэй. **Өөрийнхөө санаа бодлыг хүнд хэлэх хэрэг тохиолдоход энгийн тодорхой хэлдэг байхын тулд сайхан ярьж чаддаг байгаарай.** Хүмүүсийг, тэдний санаа бодлыг ойлгодог байвал амьдрахад чинь ч хөнгөн, бас улам ч ухаажна, чамайг ч хүн бүхэн ойлгоно. Чи өөрийгөө эвсэг, сайхан хүмүүс тойрон хүрээлж байгаасай гэж хүсдэг бол тэдэндээ чи эелдэг, энэрэнгүй, халамжтай хандахыг чармай. Тэгвэл бүгд сайн сайхан болно. Амьдралд бүх юм чамаас, өөрөөс чинь л хамаарна, надад итгээрэй” гэж бичжээ.

Бүтээлч даалгавар

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04 сарын 14-ний өдрийн 63 дугаар зарлигаар “Мод тарих үндэсний өдөр”-тэй болсон билээ. Тиймээс “Мод” гэсэн сэдвээр илтгэл бичье.

- Хэт ерөнхий сэдэв авахаас зайлсхийх хэрэгтэй.
- Үндэслэлтэй тодорхой асуудал дэвшүүлсэн байх хэрэгтэй.



Мод олон наст модлог [ургамал](#). Бусад ургамалтай харьцуулахад хэдэн зуу, хэдэн мянган жил насалдаг өвөрмөц, үнэт баялаг юм.

Мод нь [үндэс](#), [их бие](#), [иш мөчир](#) болон [навч](#) гэсэн 4 гол зүйлээс бүрдэнэ.

Хамгийн эрч хүчтэй үгийг эх хэлнийхээ эрдэнэсийн сангаас сонгоно.

1. Сэдвийнхээ бүтэц, агуулга, утга санааг илэрхийлэх баримт нь:

- Албан ёсны, үндэслэлтэй байх
- Нийтийн эрх ашигт нийцсэн, шинэлэг байх
- Олон төрлийн, ойлгомжтой байх.

Илтгэл яриа нь хүмүүсийн ахуй амьдрал, ажил хэргийн танилцуулга мэдээлэл, сургамж зөвлөгөө, нийгэм улс төрийн ухуулга сурталчилгаа, шинжлэх ухаан танин мэдэхүйн шинжтэй байдаг. Иймээс илтгэл нь аман болон бичгийн хэлний дундын найруулгатай байна.

Баримт: 1

Мод нь [нүүрстөрөгчийг](#) шингээн авч, [хүчилтөрөгч](#) ялгаруулна. Одоогоор 100,000 төрлийн мод бүртгэгдээд байгаа нь дэлхий дээрх нийт амьд ургамлын 25%-ийг эзэлж байна.

Баримт: 2

Сүүлийн 30 гаруй жилд ойн нөөц түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдэх, хууль бусаар их хэмжээний мод бэлтгэсэн зэргээс болж улсын хэмжээнд 1.4 сая.га - аар хорогдсон тооцоо гарсан. Манай орны ой дэлхийн усны гурван том ай савын хагалбарыг дагаж ургасан бөгөөд гол мөрний усны нөөцийг зохицуулан хамгаалах, цэвэршүүлэх, хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, амьтан, ургамал, бичил биетний амьдрах тааламжтай орчныг бүрдүүлэх, мөнх цэвдгийг тогтоон барих зэрэг экологийн чухал ач холбогдолтой. Дэлхийн байгалийн баялагт ус, ой хоёр ордог.

Баримт: 3

Ой мод нь дэлхийн шим мандлын салшгүй хэсгийг бүрдүүлж, манай гаргийн дулаарлын явцыг сааруулж хөрс, усыг тогтвортой байлгахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Манай орны ой мод нь Төв Азийн хуурай, гандуу уур амьсгалын нөлөөгөөр харьцангуй удаан ургадаг, нөхөн сэргэх чадвар сул, түймэр, хортон шавж, өвчин, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөнд маш их өртсөн эмзэг ой юм.



Баримт: 4

Манай орны ойн сан 18,3 сая га бөгөөд ой модоор бүрхэгдсэн талбай нь 12,9 сая га буюу нутаг дэвсгэрийн 8 хүрэхгүй хувийг эзэлдэг тул ойн нөөцөөр хомс орны тоонд багтдаг.

Хэрлэн, Онон, Туул, Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон гол мөрнүүд хэдэн зуун мянган жил тасралтгүй урссаар ирсний эх үүсвэр нь ой мод юм.

Баримт: 5

Хуурай газрын бүх амьтан ургамлын 80%-ийн амьдрах орчин нь болдог. Ой модны экологийн ач холбогдол нь ус цуглуулах, усыг жигд барьж хуваарилах, тунадсыг нэмэх зэргээр усны горимыг зохицуулдаг. Ойг хамгаалснаараа бид цэнхэр гаргийнхаа хуурай газрын бүх ургамал амьтдын 2/3 хувиас ч илүүг нь хамгаалж чадна.

Баримт: 6

Дэлхий дээр бүх нөөцийн 53% нь Бразил, Хятад, Канад, ОХУ, АНУ зэрэг тавхан оронд бий. Агаарын бохирдлыг багасгадаг байгалийн хамгийн чухал цэвэрлэх байгууламж бол ой мод юм. Ой мод бол хүчилтөрөгчийн үйлдвэр.

Дэлхий дээр ойн гаралтай 5000 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг.

Баримт: 7

- 16 насанд хүрсэн иргэн бүр нэг,
- аж ахуйн нэгж, байгууллага таваас доошгүй мод тарьж ургуулах, услах, арчлах (Ойн хуулиас)

Баримт: 8

Монгол орны ойгоор бүрхэгдсэн талбай



Баримт: 9

Дэлхийн ойн сан жилд 0.6%-аар багасаж байна.

Баримт: 11

Ойн хомсдолын 90% нь хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй.



Баримт: 12


Монгол оронд сүүлийн 5 жилд 100-200 мянган га газрын ой устаж байна.

Баримт: 13

Ойн нэг га талбай жилд 10 гаруй тэрбум шоометр хүчилтөрөгч ялгаруулдаг гэдэг.

Баримт: 10

Нэг мод огтолсон бол буцааж хоёр мод тарих журамтай.




Баримт: 14

- Нийт ойн нөөцийн 36% нь анхдагч ойгоос бүрддэг.
- 2000 оноос хойш анхдагч ойгоос 40 сая га нь аж үйлдвэрийн хөгжлийн шаардлагаар хэрэглэгдэн устсан байна.
- Өнөөдөр дэлхий дээр өдөрт 130 зүйл устаж байгаа нь байгалийн өөрийн хуулиас 1000 дахин илүү хурдтай байна.
- Монгол улсын ойн сан 140 гаруй зүйлийн мод сөөгөөс бүрдэнэ.
- Бүх нийтээр мод тарьснаар Туул голын усны татралт 20 хувь буурчээ.

(2018 оны 02 сарын 22)

Монгол орны байгалийн ойн талбай /модны төрлөөр/



Баримт: 15

2011 оны 01-р сарын 01-ний байдлаар Монгол улсын ойн сан бүхий газар 18565.6 мян.га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.87 хувийг эзэлж байна. Ойн сангийн талбайн 75,1 хувийг шилмүүст, навчит ой, 24.9 хувийг заган ой эзэлж байна.

Баримт: 16

50 гаруй жилийн настай нэг мод амьдралынхаа турш:

- 38 125 000 орчим төгрөгөөр үнэлэгдэх хүчилтөрөгч ялгаруулж,
- 75 640 000 орчим төгрөгийн агаар цэвэршүүлэх экологийн үйлчилгээ үзүүлж,
- 45 750 000 орчим төгрөгөөр үнэлэгдэх усыг эргэлтэд оруулж,
- 38 125 000 орчим төгрөгөөр үнэлэгдэхүйц хөрсний эвдрэлийг хамгаалах үйлчилгээ үзүүлж байдаг байна.

ИНГЭХЭЭР ГАНЦХАН МОД

197 640 000 орчим төгрөгөөр үнэлэгдэх ёстой ажээ.

ИЛТГЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Илтгэл гэдэг нь аливаа нэг сэдвийн хүрээнд судалж буй асуудлын мөн чанарыг өөрийн үзэл бодлын үүднээс тодорхой зорилго, алхам дараалалтай илэрхийлсэн, ихэвчлэн нийтлэлийн болон эрдэм шинжилгээний найруулгаар илэрдэг, аман ба бичгийн хэлбэртэй, харьцангуй бүрэн төгс эргэцүүлсэн эх юм.

Илтгэлд:

- Тодорхой жишээ, тоо баримтаар нотлон өгүүлэхийн зэрэгцээ, төгсгөлд нь дүгнэлт хийдэг.
- Сонсогчидтой харилцахад ярианы найруулгын хэрэглүүрийг хязгаартай, зохистой ашиглаж болно.
- Мэдээ баримтыг үндэс болгоно.

2. Эмхлэн цэгцлэх, сонгох, баримтыг үнэлэх

- Дээрх салангид олон баримтаас зайлшгүй чухал мэдээллийг сонгох
- Үндэслэл, түүний учир шалтгааны дарааллыг зөв тогтоох
- Итгэл үнэмшил төрүүлэх баримт, нотолгоог зөв сонгох
- Ярих бичих төлөвлөгөөний дараалалд оруулах
- Илүү сонирхолтой, чухал мэдээлэл ч олж болно шүү дээ. Учир нь байгаль, эх дэлхийгээ хамгаалах олон хөтөлбөр байдаг.
- Сэтгэл хөдөлгөсөн эшлэл, уран дүрслэл ашиглах
- Өөрийн үзэл бодлоо цэгцтэй, ойлгомжтой, нээлттэй илэрхийлэх
- Асуудлыг шийдэж болох ямар нэгэн арга замыг санал болгох
- Сонсогчдыхоо сэтгэлийг татах, байгаль эх дэлхийгээ хайрлах сэдэл, мэдрэмжийг сэрээсэн өнгө аясыг олох

3. Гол санааг төлөвлөх нь:

Байшингийн зохион байгуулалтыг аваад үзье. Барилгачин эхлээд барих гэж байгаа байшин ямар хэлбэр маягтай байх, хэдэн өрөө тасалгаатай байх, хэдэн давхар байх, ямар хэмжээтэй байхыг төсөөлөн бодно. Тэгээд уг байшингийн зургийг төлөвлөж зурна. Байшингийн доторх хэсэг бүрийн хэмжээ, байршлыг нарийн тооцож зурна. Зөв зурсан эсэхийг дахин дахин нягталж шалгана. Зураг төсөв бэлэн болсны дараа хэрэгцээтэй бүх материалыг бэлтгэж, барьж эхэлнэ. Илтгэл бичих гэдэг яг ийм дарааллаар хэрэгжинэ.

Илтгэлийн сэдэв ба цуглуулсан мэдээллээс хамаарч, ямар аргаар бичих вэ гэдгийг тогтооно. Жишээлбэл, түүхэн үйл явдалтай холбоотой бол түүхийн он дарааллаар эмхлэх ёстой болно. Эсвэл бусдыг шууд тодорхойлж байгаа нэг санаа, хэрэг явдал, түүний шалтгаан, үр дагаврыг ашиглаж болох юм. Бас гол санааг гаргах үйл явдлын товчоон, нарийвчлан үзүүлэх шалтгаан, үр дагаврын аргыг хослуулан ашиглаж болно. Гол санааг нарийн төлөвлөх нь цуглуулсан мэдээллийг хялбархан цэгцлэхэд туслах төдийгүй судалгааны сайн хөтөч болно.